



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ГАЗАР

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2026 оны 06 дугаар сарын 05-ны өдөр, Баасан гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1-2
Хуралдааны товч тэмдэглэл:	2-37
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	38-157

Өргөн мэдүүлсэн төслийн талаар мэдээлэх	38-39
1. Хуулийн төслүүдийг эцэслэн батлах	40-42, 147-148
2. Бизнесийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2026.06.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, яаралтай хэлэлцэх эсэх, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д заасны дагуу/	42-42
3. Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг нарын 19 гишүүн 2026.05.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжилнэ/	43-43
4. Улсын нисэхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2026.04.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	44-56
5. Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай нарын 10 гишүүн 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	56-78, 148-156
6. “Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улс болон Бүгд найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.06.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/	78-82, 146-147
7. Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2026.05.21-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	82-109, 144-146
8. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төсөл /Засгийн газар 2026.05.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	110-127, 144
9. Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа нарын 19 гишүүн 2026.05.21-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	128-144
10. Баталсан хууль, тогтоолын эцсийн найруулгыг сонсох	156-157

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
06 дугаар сарын 05-ны өдөр /Баасан гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 65 гишүүн хүрэлцэн ирж, 51.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 06 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.¹

Томилолттой: М.Бадамсүрэн, Б.Бейсен, Х.Болормаа, Д.Бум-Очир, Г.Ганбаатар, М.Ганхүлэг, Г.Дамдинням, Х.Жангабыл, Ц.Идэрбат, Б.Найдалаа, Ч.Номин, Н.Номтойбаяр, Б.Пүрэвдорж, Ц.Сандаг-Очир, Л.Соронзонболд, А.Ундраа, Д.Үүрийнтуяа, Да.Цогтбаатар, М.Энхцэцэг;

Чөлөөтэй: Ж.Баясгалан, Ц.Даваасүрэн, Б.Жавхлан, М.Нарантуяа-Нара, О.Номинчимэг, Л.Оюун-Эрдэнэ, Г.Тэмүүлэн, Н.Учрал;

Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Ганбаатар, Л.Мөнхбаясгалан, Д.Энхтуяа, Р.Эрдэнэбүрэн;

Тасалсан: Д.Амарбаясгалан;

Хоцорсон: Ж.Алдаржавхлан-01 минут, О.Алтангэрэл-12 минут, С.Амарсайхан-2 цаг 03 минут, Т.Аубакир-55 минут, Ц.Баатархүү-28 минут, Э.Бат-Амгалан-02 минут, Д.Батбаяр-18 минут, Ж.Батсуурь-16 минут, Х.Баттулга-04 минут, Б.Батцэцэг-21 минут, П.Батчимэг-40 минут, Ж.Бат-Эрдэнэ-02 минут, Э.Болормаа-2 цаг 36 минут, Д.Ганбат-13 минут, П.Ганзориг-07 минут, Л.Гантөмөр-53 минут, Т.Доржханд-10 минут, Б.Дэлгэрсайхан-03 минут, Д.Жаргалсайхан-2 цаг 36 минут, Б.Заяабал-48 минут, Ц.Мөнхтуяа-08 минут, Б.Түвшин-16 минут, Ч.Ундрэм-46 минут, Г.Уянгахишиг-45 минут, Д.Цогтбаатар-48 минут, Б.Чойжилсүрэн-03 минут, Ж.Энхбаяр-5 цаг 18 минут.

Өргөн мэдүүлсэн төслийн талаар мэдээлэх

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт Монгол Улсын Засгийн газраас 2026.06.04-ний өдөр өргөн мэдүүлсэн Бизнесийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Эдийн засгийн байнгын хороонд;

Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ нарын 17 гишүүн 2026.06.04-ний өдөр өргөн мэдүүлсэн Ойн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон холбогдуулан боловсруулсан хууль, тогтоолын төслүүдийг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд;

Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа нарын 8 гишүүн 2026.06.04-ний өдөр өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд тус тус хуваарилсныг мэдээлэв.

Нэг.Хуулийн төслүүдийг эцэслэн батлах

¹ Хуралдаан даргалагч ирцийг танилцуулах үед 2 гишүүн ирцэд нэмэгдсэн.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам нар байлцав.

С.Бямбацогт: 1.БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 68

Татгалзсан: 8

Бүгд: 76

89.5 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

2.Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 61

Татгалзсан: 15

Бүгд: 76

80.3 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдсангүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

С.Бямбацогт: Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53

Татгалзсан: 24

Бүгд: 77

68.8 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Хуулийн төслүүдийг эцэслэн батлах асуудлаар Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Ж.Батжаргал үг хэлж, 14:00 цаг хүртэл завсарлага авах тухай мэдэгдэж, Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт 14:00 цаг хүртэл завсарлага өгөв. /10:20/

Хоёр.Бизнесийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2026.06.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, яаралтай хэлэлцэх эсэх, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д заасны дагуу/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул нар байлцав.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт Монгол Улсын Засгийн газраас үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан Бизнесийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан

хуулийн төслүүдийг яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлснийг танилцуулав.

С.Бямбацогт: Бизнесийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 48
Татгалзсан: 32
Бүгд: 80
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслүүдийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 10 цаг 24 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг нарын 19 гишүүн 2026.05.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, **хэлэлцэх эсэх, үргэлжилнэ/**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул нар байлцав.

Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

С.Бямбацогт: Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 50
Татгалзсан: 31
Бүгд: 81
61.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн:

Үндэсний их баяр наадмын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 56
Татгалзсан: 25
Бүгд: 81
69.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 10 цаг 26 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Улсын нисэхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2026.04.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Батлан хамгаалахын сайд Д.Батлут, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганхуяг, мөн яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Э.Гансүх, мөн газрын Улсын нисэхийн хэлтсийн шинжээч С.Билэгтборзаяа, Төрийн захиргааны удирдлагын газрын ахлах шинжээч Г.Энхболд, Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга С.Ганбямба, мөн штабын Зэвсэгт хүчний агаарын цэргийн командлагч Б.Мөнх-Ирээдүй нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны зөвлөх С.Дунжидмаа, референт Б.Гандиймаа нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин, Б.Жаргалан нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар, Батлан хамгаалахын сайд Д.Батлут, Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга С.Ганбямба нар хариулж, тайлбар хийв.

Улсын нисэхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Улсын нисэхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төслийн талаар:

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дэмжсэн санал:

С.Бямбацогт: 1.Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар, М.Бадамсүрэн, Б.Батбаатар, Н.Батсүмбэрэл, П.Наранбаяр, Х.Тэмүүжин, Л.Энхнасан /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “, түүнтэй” гэснийг “Зэвсэгт хүчний тухай хууль, Иргэний нисэхийн тухай хуультай” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 55

Татгалзсан: 29
Бүгд: 84
65.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.9 дэх заалтын “олон улсын сургууль, хамтарсан болон бие даасан” гэснийг “нисэх багийн” гэж өөрчилж, мөн зүйлийн 4.1.2, 4.1.7, 4.1.11, 4.1.14, 4.1.16 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.2.“аюулд нэрвэгдсэн агаарын хөлөг” гэж агаарын хөлөг нислэг үйлдэх, хөөрөх, буух, явгалах үед агаарын хөлөг гэмтэж, агаарын хөлөг болон зорчигчдод аюул учирч, аргагүйдсэн нөхцөлд буулт хийсэн, эсхүл бүрэн эвдэрсэн хөлгийг;

4.1.7.“олон улсын нислэг” гэж улсын агаарын хөлгөөр Монгол Улс, гадаад улс хооронд үйлдэх нислэгийг;

4.1.11.“улсын агаарын хөлөг” гэж төрийн цэргийн, хууль сахиулах болон төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлэгч байгууллагын нисэх онгоц, нисдэг тэрэг бусад агаарын хөлгийг;

4.1.14.“цэргийн зориулалттай нисгэгчгүй нисэх хэрэгсэл” гэж цэргийн байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдах нисгэгчгүй болон зайнаас удирдах агаарын хөлгийг;

4.1.16.“Улсын нисэхийн багц дүрэм” гэж энэ хуулийн 11 дүгээр зүйлд заасан харилцааг зохицуулах эрх зүйн баримт бичгийг,” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 60
Татгалзсан: 25
Бүгд: 85
70.6 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5 дугаар зүйл.Монгол Улсын Их Хурлын бүрэн эрх

5.1.Монгол Улсын Их Хурал улсын нисэхийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтооно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 66
Татгалзсан: 20
Бүгд: 86
76.7 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн “улсын нисэхийг хөгжүүлэх төсөл, хөтөлбөрийг батлах,” гэсэн 6.1.4 дэх заалтыг хасаж, мөн зүйлийн 6.1.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.1.3.улсын нисэхийн аэродром байгуулах, өөрчлөх, шилжүүлэх, татан буулгах, хамтран ашиглах асуудлыг цэргийн мэргэжлийн дээд удирдлагын байгууллагын санал болгосноор Зэвсэгт хүчний ерөнхий командлагчтай зөвшилцөн шийдвэрлэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 63
Татгалзсан: 23
Бүгд: 86
73.3 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалтын “нисэхийн” гэсний дараа “хяналтын” гэж нэмж, мөн зүйлийн 7.1.2 дахь заалтын “шинжээч (байцаагч)-ийг томилох,” гэснийг “шинжээчийг томилох, чөлөөлөх” гэж, мөн зүйлийн 7.1.5 дахь заалтын “цагийн хөлсний үнэлгээний тусгай норм, зэрэг, зэрэглэлийг” гэснийг “цагийн үнэлгээ, зэрэг, зэрэглэлийн нэмэгдлийг” гэж тус тус өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 7.1.3, 7.1.4 дэх заалт нэмэх:

“7.1.3.улсын нисэхийн нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах комиссын дүрмийг батлах;

7.1.4.улсын нисэхийн нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах комиссыг томилох;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 66
Татгалзсан: 21
Бүгд: 87
75.9 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.2.4 дэх заалтын “мэргэжлийн үнэмлэх,” гэсний дараа “нислэгт тэнцэх чадварын” гэж нэмж, мөн зүйлийн 8.2.3 дахь заалтын “хөтлөх” гэснийг “бүрдүүлэх” гэж өөрчилж, мөн зүйлийн 8.2.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8.2.5.улсын нисэхийн аэродромыг бүртгэх, гэрчилгээжүүлэх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 67
Татгалзсан: 21
Бүгд: 88
76.1 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлийн 9.1.6 дахь заалтын “хуулийн” гэсний дараа “8.2 дугаар зүйлийн” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 66
Татгалзсан: 22
Бүгд: 88
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 10.1.1, 10.1.2 дахь заалт болгох:

“10.1.1.нислэгийн үйл ажиллагааг хариуцсан нэгжтэй байх;
10.1.2.шалгагч зэрэглэлтэй нисгэгч, инженерийг томилох, чөлөөлөх;”
гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 70
Татгалзсан: 18
Бүгд: 88
79.5 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 10.1.3 дахь заалт болгох:

“10.1.3.Улсын нисэхийн багц дүрэм болон агаарын хөлгийн үйлдвэрлэгчээс гаргасан дүрэм, зааврын дагуу нислэгийн үйл ажиллагааг гүйцэтгэх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 67
Татгалзсан: 21
Бүгд: 88
76.1 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийн 10.1.5 дахь заалтын “улсын агаарын хөлөг,” гэсний өмнө “энэ хуулийн 4.1.3-т зааснаас бусад” гэж нэмж, мөн зүйлийн 10.1.4 дэх заалтын “тасралтгүй” гэснийг, мөн зүйлийн 10.1.5 дахь заалтын “заавал” гэснийг тус тус хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 10.1.6 дахь заалт нэмэх:

“10.1.6.энэ хуулийн 14.1.2, 14.1.3, 14.1.4-т заасан нислэг үйлдэхэд зорчигчийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийн даатгалыг гэрээ байгуулагч тал хариуцах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 68
Татгалзсан: 20
Бүгд: 88
77.3 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшингийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 10.4 дэх хэсэг нэмэх:

“10.4.Улсын агаарын хөлгийн засвар, техникийн үйлчилгээ болон нисэх баг, инженер техникийн бүрэлдэхүүний сургалтын тодорхой хэсгийг эдийн засгийн үр ашиг, чанар, аюулгүй байдлыг харгалзан дотоодын болон гадаадын гэрчилгээжсэн хувийн хэвшлийн байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно. Энэ тохиолдолд тавигдах шаардлага, журмыг Улсын нисэхийн багц дүрмээр тогтооно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 65

Татгалзсан: 23
Бүгд: 88
73.9 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалтын “бүртгэлийн гэрчилгээ нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ олгох, сунгах, түдгэлзүүлэх, цуцлах,” гэснийг “хасах, нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ олгох, сунгах, түдгэлзүүлэх, цуцлах, хүчингүй болгох;” гэж, мөн зүйлийн 11.1.11 дэх заалтын “хэрэгслийг бүртгэх,” гэснийг “хэрэгсэл, түүний удирдлагын системийг бүртгэх,” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 66
Татгалзсан: 22
Бүгд: 88
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийн “заасны дагуу” гэсний дараа “улсын агаарын хөлгийн бүртгэлд” гэж, мөн хэсгийн “бүртгүүлээгүй,” гэсний дараа “нислэгт тэнцэх чадварын гэрчилгээгүй улсын” гэж тус тус нэмж, мөн зүйлийн 12.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 12.3 дахь хэсэг болгох:

“12.3.Улсын агаарын хөлөг нь нислэгийн аюулгүй ажиллагааны нөхцөлийг хангасан нислэгт тэнцэх чадварын гэрчилгээтэй байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 66
Татгалзсан: 22
Бүгд: 88
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлийн “Улсын агаарын хөлгийг бүртгэх, бүртгэлээс хасах, нислэгт тэнцэх чадварыг тодорхойлох, гэрчилгээ олгох, сунгах, цуцлах үйл ажиллагааг Улсын нисэхийн багц дүрмээр зохицуулна.” гэсэн 12.6 дахь хэсэг, мөн зүйлийн “Энэ хууль болон Улсын нисэхийн багц дүрмийг зөрчсөн тохиолдолд агаарын хөлгийн бүртгэлийн гэрчилгээг түдгэлзүүлэх, эсхүл хүчингүй болгоно.” гэсэн 12.7 дахь хэсгийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 70
Татгалзсан: 19
Бүгд: 89
78.7 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 12.8 дахь хэсэг нэмэх:

“12.8.Энэ хуулийн 10.1.5-д заасан даатгалыг улсын төсвийн санхүүжилтээр шийдвэрлэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 65
Татгалзсан: 24
Бүгд: 89
73.0 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13.3.Агаарын хөлгийн дарга нислэгийн аюулгүй байдалд аюул тулгарсан тохиолдолд улсын агаарын хөлөгт байгаа зорчигчдын амь насыг аврах зорилгоор нислэгийн төлөвлөгөө болон нислэгийн хөдөлгөөний удирдагчийн өгснөөс өөр шийдвэр гаргах эрхтэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 69
Татгалзсан: 21
Бүгд: 90
76.7 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 13 дугаар зүйлийн 13.6 дахь хэсгийн “үүрэг гүйцэтгэж” гэснийг “ажиллуулж” гэж өөрчилж, мөн зүйлийн 13.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13.7.Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гэрээгээр ажиллах гадаад улсын иргэн, хуулийн этгээдэд улсын агаарын хөлгөөр нисэх, техник үйлчилгээ хийх эрхийг дараах шаардлагыг үндэслэн олгоно:

13.7.1.мэргэжлийн үнэмлэх, гэрчилгээ нь хүлээн зөвшөөрөгдсөн байх;
13.7.2.үндэсний аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ болон шалгалт хийгдсэн байх;

13.7.3.улсын агаарын хөлгийг эзэмшигч байгууллагатай төрийн нууцын хууль тогтоомжийн дагуу нууцын баталгаа, нууц хадгалах гэрээ байгуулсан байх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 68
Татгалзсан: 22
Бүгд: 90
75.6 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 14 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 14.6 дахь хэсэг нэмэх:

“14.6.Энэ хуулийн 14.1.2-т заасан нислэгийн аюулгүйн хамгаалалтыг хангах асуудлыг цэргийн мэргэжлийн дээд удирдлагын байгууллага болон төрийн тусгай хамгаалалтын байгууллагын хамтарсан журмаар зохицуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 68
Татгалзсан: 22
Бүгд: 90

75.6 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн “аэродром ашиглах үйл ажиллагаа, түүнд тавигдах шаардлагыг” гэснийг “ашиглах, түүний бэлэн байдлыг” гэж өөрчилж, мөн зүйлийн “Цэргийн зориулалттай нисэхийн аэродром байгуулах, өөрчлөх, шилжүүлэх, татан буулгах, түүний бэлэн байдал, түүнд тавигдах шаардлагыг тогтоох асуудлыг цэргийн мэргэжлийн дээд удирдлагын байгууллагын санал болгосноор Зэвсэгт хүчний ерөнхий командлагчтай зөвшилцөн Засгийн газар шийдвэрлэнэ.” гэсэн 16.2 дахь хэсэг, мөн зүйлийн “Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь улсын нисэхийн аэродром байгуулах, түүний бэлэн байдал, түүнд тавигдах шаардлагыг тогтоох тухай саналыг боловсруулж Засгийн газраар шийдвэрлүүлнэ.” гэсэн 16.3 дахь хэсэг, мөн зүйлийн “Улсын нисэхийн аэродромын бүртгэлийг батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага эрхэлнэ.” гэсэн 16.5 дахь хэсгийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 67

Татгалзсан: 23

Бүгд: 90

74.4 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 18 дугаар зүйлийн “Улсын нисэхийн аюулгүй байдлын хяналтыг энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан байгууллага хэрэгжүүлнэ.” гэсэн 18.2 дахь хэсгийг хасаж, мөн зүйлийн 18.3 дахь хэсгийг 18.2 дахь хэсэг болгох гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 66

Татгалзсан: 24

Бүгд: 90

73.3 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 18 дугаар зүйлийн 18.3.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 18.2.1, 18.2.2 дахь заалт болгох:

“18.2.1.эрх бүхий албан тушаалтнаас олгосон албаны үнэмлэх, хувийн дугаар бүхий тэмдэг хэрэглэх;

18.2.2.албан үүргээ гүйцэтгэхтэй холбоотой албан шаардлага, зөвлөмж, дүгнэлт гаргах, хэвлэмэл хуудас хэрэглэх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 65

Татгалзсан: 25

Бүгд: 90

72.2 хувийн саналаар дэмжигдлээ.

22.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 18 дугаар зүйлийн “дээрх заалтын дагуу хийгдэх үйлдэл, байцаагчийн үүрэг даалгаврыг гүйцэтгэх хугацаа болон бусад нэмэлт зохицуулалтыг Улсын нисэхийн багц дүрмээр нарийвчлан зохицуулна.” гэсэн 18.3.6 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 66
Татгалзсан: 24
Бүгд: 90
73.3 хувийн саналаар дэмжигдлээ.

23.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 18 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 18.4 дэх хэсэг нэмэх:

“18.4.Цэргийн зориулалттай нисгэгчгүй нисэх хэрэгслийг энэ хуулийн 11.1.11-д заасан шаардлага хангаагүй тохиолдолд ашиглахыг хориглоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 66
Татгалзсан: 24
Бүгд: 90
73.3 хувийн саналаар дэмжигдлээ.

24.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“19.1.Хуульд өөрөөр заагаагүй бол улсын нисэхийн аюулгүйн хамгаалалтыг хангах чиглэлээр зорчигчийн бие, ачаа тээшинд агаарын хөлгийг эзэмшигч болон мэргэжлийн байгууллага холбогдох дүрмийн дагуу үзлэг, шалгалт хийнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 67
Татгалзсан: 23
Бүгд: 90
74.4 хувийн саналаар дэмжигдлээ.

25.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 19 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 19.4 дэх хэсэг нэмэх:

“19.4.Улсын нисэхийн үйл ажиллагаанд ашиглагдах мэдээллийн технологи, навигаци, хяналт, нислэгийн удирдлагын систем нь кибер аюулгүй байдлын шаардлагад нийцсэн байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 69
Татгалзсан: 21
Бүгд: 90
76.7 хувийн саналаар дэмжигдлээ.

26.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсгийн “Эрэн хайх” гэсний өмнө “Улсын агаарын хөлгийг” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 65
Татгалзсан: 25
Бүгд: 90
72.2 хувийн саналаар дэмжигдлээ.

27.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсгийн “эрлийн ажлыг зогсоох шийдвэрийг уг агаарын хөлгийг эзэмшигч байгууллагын саналыг үндэслэн” гэснийг “мэргэжлийн комиссын саналыг үндэслэн эрлийн ажлыг зогсоох шийдвэрийг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 66
Татгалзсан: 24
Бүгд: 90
73.3 хувийн саналаар дэмжигдлээ.

28.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 22 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 22.2, 22.5, 22.6, 22.7, 22.8 дахь хэсэг нэмэх:

“22.2.Улсын нисэхийн нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагаа нь осол, зөрчлийг дахин давтагдахаас урьдчилан сэргийлнэ.

22.5.Улсын нисэхийн аюулгүй байдлын хяналт, осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагаанд оролцох албан тушаалтан нь агаарын хөлгийг эзэмшигч байгууллагын агаарын хөлгийг худалдан авахтай холбоотой ажиллагаанд шууд болон шууд бус ашиг сонирхлын зөрчил үүсэхээр бол худалдан авах ажиллагаанд оролцохоос татгалзана.

22.6.Улсын нисэхийн нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагаанд оролцох ерөнхий шинжээч, комиссын гишүүд нь улсын агаарын хөлгийг үйлдвэрлэгч болон засвар, техникийн үйлчилгээг хариуцах байгууллагатай ашиг сонирхлын зөрчилгүй эсэх талаар эрх бүхий албан тушаалтанд мэдэгдэнэ.

22.7.Улсын нисэхийн нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааны талаарх баримт, мэдээллийг устгах, өөрчлөх, нуун дарагдуулах, задруулахыг хориглоно.

22.8.Улсын нисэхийн нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааны нууцад хамаарахаас бусад мэдээлэл олон нийтэд нээлттэй байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 68
Татгалзсан: 22
Бүгд: 90
75.6 хувийн саналаар дэмжигдлээ.

29.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 23 дугаар зүйлийн гарчгийн “бүрэн эрх, чиг үүрэг” гэснийг “эрх, үүрэг” гэж, мөн зүйлийн 23.1 дэх хэсгийн “бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэснийг “эрхтэй” гэж, мөн хэсгийн 23.1.2 дахь заалтын “хүн” гэснийг “албан тушаалтан” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 23.1.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“23.1.1.албан үүргээ гүйцэтгэхдээ улсын агаарын хөлгийг эзэмшигч байгууллага болон шаардлагатай бусад газарт саадгүй нэвтрэх,” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 65
Татгалзсан: 25
Бүгд: 90
72.2 хувийн саналаар дэмжигдлээ.

30.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 23 дугаар зүйлийн 23.2.3 дахь заалтын “дүрмийг батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээр батлуулах” гэснийг “дүрмийн төслийг боловсруулах” гэж өөрчилж, мөн зүйлийн “улсын агаарын хөлгийн нислэг-техникийн осол, зөрчлийн шалтгааныг үнэн зөв тогтоох, шаардлагатай мэдээ, судалгаа, бусад баримт бичгийг холбогдох этгээдээс шаардан гаргуулж авах.” гэсэн 23.1.6 дахь хэсэг, мөн зүйлийн “улсын нисэхийн нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах комисс томилуулах тухай саналаа батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулж, шийдвэрлүүлэх,” гэсэн 23.2.4 дэх заалтыг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 68
Татгалзсан: 22
Бүгд: 90
75.6 хувийн саналаар дэмжигдлээ.

31.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 24 дүгээр зүйлийн гарчгийн “комисс, түүний бүрэн эрх” гэснийг “комиссын чиг үүрэг” гэж, мөн зүйлийн 24.1 дэх хэсгийн “, түүний бүрэн эрх” гэснийг “дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.” гэж, мөн зүйлийн 24.1.1 дэх заалтын “зүйлст хяналтаа тогтоох” гэснийг “зүйлсийг хяналтад авах” гэж, мөн зүйлийн 24.1.5 дахь заалтын “болсон” гэснийг “улсын” гэж, мөн зүйлийн 24.3 дахь хэсгийн “уг осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ” гэснийг “осол, зөрчил гаргахгүй байх талаар холбогдох байгууллагад зөвлөмж хүргүүлнэ.” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 64
Татгалзсан: 26
Бүгд: 90
71.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Найруулгын санал:

С.Бямбацогт: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “зохицуулалт,” гэсний дараа, 8 дугаар зүйлийн 8.2.6 дахь заалт, 13 дугаар зүйлийн 13.2, 13.4 дэх хэсгийн “агаарын” гэсний өмнө, 21 дүгээр зүйлийн гарчгийн “нэрвэгдсэн” гэсний дараа “улсын” гэж тус тус нэмж, төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.13 дахь заалтын “цогцолбор” гэснийг “цогц” гэж өөрчилж, төслийн 24 дүгээр зүйлийн 24.3 дахь хэсгийн “гарсан” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 68
Татгалзсан: 22
Бүгд: 90
75.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Зэвсэгт хүчний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дэмжсэн санал:

С.Бямбацогт: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн "... 9.1.1, 9.1.2-т..." гэснийг "9.1.2, 9.1.6-д" гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 67

Татгалзсан: 23

Бүгд: 90

74.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Гурав.Найруулгын саналын талаар:

С.Бямбацогт: 1.Ажлын хэсгийн гаргасан, Улсын нисэхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Улсын нисэхийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хууль, Зэвсэгт хүчний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зарчмын зөрүүтэй саналын томъёоллууд дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн зүйл, хэсэг, заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх, агуулга зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, найруулгын шинжтэй засвар хийх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 69

Татгалзсан: 21

Бүгд: 90

76.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын нисэхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 11 цаг 14 минутад хэлэлцэж дуусав.

Хуулийн төсөл татан авах талаар танилцуулах

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай нарын 10 гишүүнээс 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн Хөдөө аж ахуйн хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих тухай хуульд нэмэлт оруулах тухай, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг татан авах тухай албан бичгийг Улсын Их Хуралд ирүүлснийг уншиж танилцуулав. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3-т заасны дагуу хууль санаачлагч хуулийн төслөө татан авсанд тооцов./11:16/

Тав.Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай нарын 10 гишүүн 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хуулийн хэлтсийн дарга Ч.Раднаабазар, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын шинжээч Ц.Мөнхнасан, Хөдөө аж ахуйн их сургуулийн Сургалт эрхэлсэн проректор А.Буянбаатар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, зөвлөх Бад.Баярмаа, референт Б.Бадралт нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин, Ц.Туваан, С.Эрдэнэбат, Б.Жаргалан, С.Ганбаатар, Ч.Ундрэм, О.Цогтгэрэл нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ, М.Мандхай нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./12:27/

Зургаа. “Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улс болон Бүгд найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.06.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Амарсайхан, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Батбямба, мөн яамны Олон улсын гэрээ, гадаад хамтын ажиллагааны газрын дарга Ч.Нарантуяа, мөн газрын шинжээч Х.Дөлгөөн, Цагдаагийн ерөнхий газрын дарга Ж.Болд, мөн газрын Хуулийн хэлтсийн дарга Б.Батзориг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны референт Б.Гандиймаа нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Амарсайхан, хуулийн төслийг хэлэлцсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Тулга нар танилцуулав.

Улсын Их Хурлын дэд дарга Ж.Бат-Эрдэнэ 12 цаг 30 минутаас хуралдааныг даргалав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяагийн тавьсан асуултад Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Амарсайхан хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./12:42/

Үдээс өмнөх хуралдаан 2 цаг 36 минут үргэлжилж, 12 цаг 42 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 14 цаг 00 минутад эхлэв.

Хуулийн төсөл татан авах талаар танилцуулах

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай нарын 10 гишүүнээс 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Баяжуулсан хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ерөнхий боловсролын тухай хуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Органик бүтээгдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хүүхэд харах үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг татан авах тухай албан бичгийг Улсын Их Хуралд ирүүлснийг уншиж танилцуулав. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3-т заасны дагуу хууль санаачлагч хуулийн төслөө татан авсанд тооцов./14:03/

Долоо.Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2026.05.21-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Батбаяр, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Бат-Өлзий, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын газрын дарга Б.Мөнх-Эрдэнэ, мөн газрын Ногоон санхүүжилтийн бодлогын хэлтсийн дарга С.Пүрэвсүрэн, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Санхүүгийн зах зээл, олон улсын хамтын ажиллагааны хэлтсийн дарга Б.Амарбаясгалан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Энхгэрэл нар байлцов.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Амарсайхан, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт, Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин, Д.Пүрэвдаваа, Б.Батбаатар, С.Одонтуяа, Б.Уянга, Д.Ганмаа, С.Ганбаатар, Ч.Ундрэм, Г.Лувсанжамц нарын тавьсан асуултад Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Батбаяр, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Бат-Өлзий, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын газрын дарга Б.Мөнх-Эрдэнэ нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Ж.Баярмаа нар үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./15:36/

Найм.Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төсөл /Засгийн газар 2026.05.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Орон нутгийн удирдлага, зохицуулалтын газрын дарга П.Зоригтбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Батбаяр, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Г.Эрдэнэбулган, мөн газрын Нийтийн эрх зүйн хэлтсийн дарга Д.Энхтөр, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын дарга А.Энхманлай, Багануур дүүргийн Засаг дарга С.Даваасүрэн, Налайх дүүргийн Засаг дарга Д.Наянбаяр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, мөн газрын Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн дарга Ц.Болормаа, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ц.Баянмөнх нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Амарсайхан, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин, Д.Пүрэвдаваа, П.Сайнзориг, О.Цогтгэрэл, Ц.Туваан, Н.Наранбаатар нарын тавьсан асуултад Хууль зүй, дотоод хэргийн сайд

С.Амарсайхан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Орон нутгийн удирдлага, зохицуулалтын газрын дарга П.Зоригтбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Батбямба, Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт, Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг нар үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./16:42/

Ес.Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа нарын 19 гишүүн 2026.05.21-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монголбанкны Ерөнхий эдийн засагч Н.Батсайхан, мөн банкны Хуулийн газрын Гэрээ, эрх зүйн нийцлийн хэлтсийн захирал Ө.Мөнх-Ундарга, Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга Т.Цэрэнбадрал, мөн хорооны Банк бус санхүүгийн байгууллагын газрын дарга Б.Итгэлсүрэн, Үнэт цаасны газрын дарга Б.Дөлгөөн, Даатгалын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч З.Батболд, Компанийн засаглал, комплайнсын хэлтсийн дарга А.Авир, Хяналт шалгалт, зохицуулалтын газрын ахлах зөвлөх А.Баянмөнх, Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн Б.Нандин-Эрдэнэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх Б.Нарангэрэл нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин, С.Эрдэнэбат, Ж.Баярмаа, Х.Ганхуяг, С.Ганбаатар нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа, Монголбанкны Ерөнхий эдийн засагч Н.Батсайхан нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан үг хэлэв.

С.Бямбацогт: Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Татгалзсан: 28
Бүгд: 93
69.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн:

1.Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 66
Татгалзсан: 27
Бүгд: 93
71.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 68
Татгалзсан: 25
Бүгд: 93
73.1 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 67
Татгалзсан: 26
Бүгд: 93
72.0 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 68
Татгалзсан: 25
Бүгд: 93
73.1 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 66
Татгалзсан: 27
Бүгд: 93
71.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 17 цаг 35 минутад хэлэлцэж дуусав.

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

С.Бямбацогт: Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53
Татгалзсан: 40
Бүгд: 93
57.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн:

“Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53
Татгалзсан: 40
Бүгд: 93
57.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 17 цаг 39 минутад хэлэлцэж дуусав.

Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

С.Бямбацогт: Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 65
Татгалзсан: 28
Бүгд: 93
69.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн:

1.Агаарын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 62
Татгалзсан: 31
Бүгд: 93
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Автозамын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 64
Татгалзсан: 29
Бүгд: 93
68.8 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 72
Бүгд: 93
22.6 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжээгүй тул хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах тухай Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцов./17:42/

4.Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 67
Татгалзсан: 26
Бүгд: 93
72.0 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 67
Татгалзсан: 26
Бүгд: 93
72.0 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Гамшгаас хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 63

Татгалзсан: 30
Бүгд: 93
67.7 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Олон улсын гэрээний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17
Татгалзсан: 76
Бүгд: 93
18.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжээгүй тул хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах тухай Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцов./17:43/

8.Тариалангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 64
Татгалзсан: 29
Бүгд: 93
68.8 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 65
Татгалзсан: 28
Бүгд: 93
69.9 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Статистикийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 28
Татгалзсан: 65
Бүгд: 93
30.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжээгүй тул хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах тухай Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцов./17:46/

11.Эрчим хүчний хэмнэлтийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 63
Татгалзсан: 30

Бүгд: 93
67.7 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 62
Татгалзсан: 31
Бүгд: 93
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 17 цаг 46 минутад хэлэлцэж дуусав.

“Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улс болон Бүгд найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг батлах санал хураалтаар үргэлжлэв.

С.Бямбацогт: “Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улс болон Бүгд найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 69
Татгалзсан: 24
Бүгд: 93
74.2 хувийн саналаар хууль батлагдлаа.

“Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улс болон Бүгд найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг эцэслэн баталсанд тооцов.

Уг асуудлыг 17 цаг 52 минутад хэлэлцэж дуусав.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах санал хураалтаар үргэлжлэв.

С.Бямбацогт: Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 61
Татгалзсан: 32
Бүгд: 93
65.9 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдсангүй.

Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаагийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

С.Бямбацогт: Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 56
Татгалзсан: 37
Бүгд: 93
60.2 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

С.Бямбацогт: Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 65
Татгалзсан: 28
Бүгд: 93
69.9 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

Холбогдуулан боловсруулсан:

2.Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 63
Татгалзсан: 30
Бүгд: 93
67.7 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдсангүй.

Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргалын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

С.Бямбацогт: Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргалын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 63
Татгалзсан: 30
Бүгд: 93
67.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

С.Бямбацогт: Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 65
Татгалзсан: 28
Бүгд: 93
69.9 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

Уг асуудлыг 18 цаг 00 минутад хэлэлцэж дуусав.

Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн талаар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дэмжсэн санал:

С.Бямбацогт: Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ, Д.Жаргалсайхан, С.Замира, С.Лүндэг, Н.Наранбаатар, Р.Сэддорж /цаашид “ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.1.Энэ хуулийн зорилт нь төрөөс хөдөө аж ахуйг тогтвортой хөгжүүлэх бодлогын дэмжлэгтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 66
Татгалзсан: 27
Бүгд: 93
71.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Малын тоо толгойн албан татварын хууль” гэсний өмнө “Гамшгаас хамгаалах тухай хууль,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 66
Татгалзсан: 27
Бүгд: 93
71.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн “өртгийн” гэснийг “үйлдвэрлэлийн” гэж өөрчлөн, цаашид тохиолдол бүрд өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 66
Татгалзсан: 27
Бүгд: 93
71.0 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“хөдөө аж ахуйн үйлдвэрлэл” гэж хөдөө аж ахуйн газарт байгалийн болон биологийн нөөцөд тулгуурлан мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэл дагнан, эсхүл хослуулан эрхлэх үйл ажиллагааг;

4.1.2.“мал аж ахуйн үйлдвэрлэл” гэж мал, амьтныг өсгөн үржүүлж, тэдгээрээс гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг бэлтгэн нийлүүлэх, үйлдвэрлэх үйл ажиллагааг;

4.1.3.“тариалангийн үйлдвэрлэл” гэж Тариалангийн тухай хуулийн 16.1-д заасныг;

4.1.4.“бэлчээрийн мал аж ахуй” гэж мал сүргийг бэлчээрт жилийн туршид улирлын хуваарьтайгаар идээшлүүлэн маллаж, ашиг шимийг нь хүртдэг, нүүдлийн өв соёлыг хадгалсан уламжлалт мал аж ахуйн үйлдвэрлэлийг;

4.1.5.“эрчимжсэн мал аж ахуй” гэж Тариалангийн тухай хуульд 3.1.7-д заасныг;

4.1.6.“хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн” гэж хүнсний болон аж үйлдвэрийн зориулалтаар ургамал, мал, тэжээвэр амьтны аж ахуйгаас үйлдвэрлэсэн түүхий эд, бүтээгдэхүүнийг;

4.1.7.“агро-ойн аж ахуй” гэж ойжуулалтыг хөдөө аж ахуйн үйлдвэрлэлтэй зориудаар хослуулсан, нийгэм, эдийн засаг, байгаль орчны ашиг тустай аж ахуйн зохион байгуулалтыг;

4.1.8.“хөдөө аж ахуйн аялал жуулчлал” гэж мал аж ахуй, газар тариалан, уламжлалт нүүдлийн ахуйн хэв маяг, үндэсний соёл, өв уламжлалыг хадгалах, сурталчлан таниулах аялал жуулчлалын төрлийг;

4.1.9. хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгч” гэж энэ хуулийн 4.1.1-д заасан үйл ажиллагааг эрхэлж, эдийн засгийн өгөөж хүртэж байгаа хувь хүн, хуулийн этгээдийг;

4.1.10.“тогтвортой хөдөө аж ахуй” гэж хүн, байгаль орчинд ээлтэй, нийгмийн хариуцлагатай, байгалийн нөөцийн зохистой ашиглалт, эдийн засгийн өгөөжтэй, урт хугацаанд үргэлжлэх, бүтээмжтэй хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг;

4.1.11.“хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн сүлжээ” гэж Хөдөө аж ахуйн түүхий эд, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, бэлтгэн нийлүүлэх, анхан шатны боловсруулалт хийх, хадгалах, тээвэрлэх, борлуулах цогц үйл ажиллагааг.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 64

Татгалзсан: 29

Бүгд: 93

68.8 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн “хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн тогтвортой хөгжлийг хангах,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 63
Татгалзсан: 30
Бүгд: 93
67.7 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн 5.2.4 дэх заалтын “инновац, дэвшилтэт шинэ технологи” гэснийг “инновацыг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 65
Татгалзсан: 28
Бүгд: 93
69.9 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн 5.2.5 дахь заалтыг “хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд” гэснийг, 5.2.6 дахь заалтын “хөдөө аж ахуйн хөдөлмөрийн үнэлэмж,” гэснийг, 5.2.7 дахь заалтын “түүхий эд” гэсний өмнөх “хөдөө аж ахуйн” гэснийг, 5.2.8 дахь заалтын “залгамж халааг тасралтгүй бэлтгэх тогтолцоог бэхжүүлэх” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 66
Татгалзсан: 27
Бүгд: 93
71.0 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн 5.2.9 дэх заалтын “хувийн хэвшил,” гэснийг “хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан,” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 66
Татгалзсан: 27
Бүгд: 93
71.0 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалтын “тариалан” гэсний өмнө “газар” гэж, 6.3 дахь хэсгийн “тариалангийн” гэсний өмнө “газар” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 64
Татгалзсан: 29
Бүгд: 93
68.8 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн 6.2.5, 6.2.6 дахь заалтыг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 63
Татгалзсан: 30
Бүгд: 93
67.7 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн 6.4, 6.5 дахь хэсгийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 63
Татгалзсан: 30
Бүгд: 93
67.7 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7 дугаар зүйл.Хөдөө аж ахуйг төрөлжүүлэн хөгжүүлэх

7.1.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд газар зүйн байршил, экологийн онцлог, дэд бүтцийн хөгжил, хүн амын нягтрал болон биологийн бусад нөөц, зах зээлийн эрэлтэд тулгуурлан төрөлжүүлэн хөгжүүлнэ.

7.2.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг төрөлжүүлэн хөгжүүлэх тэргүүлэх чиглэлд бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуй, тэжээл үйлдвэрлэл, жимс жимсгэнэ, хүнсний ногоо, үр тариа хамгаалагдсан хөрсний тариалан, үржлийн аж ахуй, агро-ойн аж ахуйг хөгжүүлэх асуудлыг тусгайлан хамааруулна.

7.3.Хөдөө аж ахуйг төрөлжүүлэн хөгжүүлэх асуудлыг Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тодорхойлж, орон нутгийн хөгжлийн бодлого, Засаг даргын мөрийн хөтөлбөрт тусган хэрэгжүүлнэ.

7.4.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг хоршоо, кластерын зохион байгуулалтаар болон хөдөө аж ахуйн захиалгат бүтээгдэхүүн үйлдвэрлэлээр төрөлжүүлэн хөгжүүлж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 65
Татгалзсан: 28
Бүгд: 93
69.9 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8 дугаар зүйл.Хөдөө аж ахуйн түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоо

8.1.Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг төвлөрүүлэх, хадгалах, чанар хамгаалалт хийх, худалдан борлуулах төвийг аймаг, суманд байгуулна.

8.2.Энэ хуулийн 8.1-д заасан төвийн үйл ажиллагааг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлнэ.

8.3.Энэ хуулийн 8.1-д заасан төвд нийлүүлж, худалдан борлуулж байгаа түүхий эд, бүтээгдэхүүний талаарх мэдээлэл нь хөдөө аж ахуйн биржийн болон энэ хуулийн 10.1-д заасан цахим сантай холбогдсон байна.

8.4.Энэ хуулийн 8.1-д заасан төв нь түүхий эд, бүтээгдэхүүнийг худалдан авах, холбогдох стандарт, техникийн зохицуулалтын шаардлагын дагуу чанараар ангилах, шаардлагатай анхан шатын тордолт хийж, багцлах, савлах, шошголох, хадгалах, худалдан борлуулах үйл ажиллагааг хариуцан гүйцэтгэнэ.

8.5.Энэ хуулийн 8.1-д заасан төвийг байгуулах санхүүжилтийн эх үүсвэрийг улсын болон аймаг, сумын төсөв, хувийн хэвшлийн санхүүжилтээр шийдвэрлэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	65
Татгалзсан:	28
Бүгд:	93

69.9 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлийг доор дурдсанаас өөрчлөн найруулах:

“9 дүгээр зүйл.Хөдөө аж ахуйн түүхий эд, бүтээгдэхүүний чанарын үнэлгээ, баталгаажуулалт

9.1.Хөдөө аж ахуйн түүхий эд, бүтээгдэхүүний чанарыг холбогдох стандартын дагуу үнэлж, баталгаажуулна.

9.2.Аймаг бүр хөдөө аж ахуйн гаралтай хүнсний бус түүхий эд, бүтээгдэхүүний чанарыг шинжлэн судалдаг зориулалтын тоног төхөөрөмж, мэргэшсэн шинжээч бүхий лабораторитой байна.

9.3.Хөдөө аж ахуйн гаралтай хүнсний эрүүл ахуй, чанарын шинжилгээг холбогдох хуулиар зохицуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	63
Татгалзсан:	30
Бүгд:	93

67.7 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“10 дугаар зүйл.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн сүлжээний бүртгэл, мэдээлэл

10.1.Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хүнсний бүтээгдэхүүний, зөвшөөрлийн мал аж ахуй, газар тариалангийн, малын генетик нөөц, мал, амьтан, ургамлын эрүүл мэндийн, түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүслийн, дотоодын болон олон улсын худалдаа, үйлчилгээний цахим сан /цаашид “цахим сан” гэх/-тай байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 64
Татгалзсан: 29
Бүгд: 93
68.8 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12 дугаар зүйл.Тогтвортой хөдөө аж ахуйн төлөвлөлт

12.1.Тогтвортой хөдөө аж ахуйг хөгжүүлэх Хөгжлийн зорилтот хөтөлбөртэй байна.

12.2.Хөдөө аж ахуйн хөгжлийн зорилтот хөтөлбөрт дараах асуудлыг тусгана:

12.2.1.хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг төрөлжүүлэн хөгжүүлэх;
12.2.2.хөдөө аж ахуйн үйлдвэрт шаардагдах мэргэшсэн хүний нөөцийн хэрэгцээг мэргэжил, мэргэшлийн түвшнээр тодорхойлж, хангах арга хэмжээ;

12.2.3.дотоодын хүнсний хангамж, экспортын бүтээгдэхүүн нийлүүлэлт, борлуулалт;

12.2.4.түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлт;
12.2.5.хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн экспортын зах зээлийг судалж, экспортын голлох бүтээгдэхүүн тус бүрээр бодлого, стратеги;

12.2.6.хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг ашигтай эрхлэх зах зээлийн болон нийгмийн таатай орчин бүрдүүлэлт.

12.3.Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн энэ хуулийн 12.1-д заасан зорилтот хөтөлбөрийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэн батлуулж, хэрэгжилтийг хангана.

12.4.Хөдөө аж ахуйн салбарт хэрэгжүүлж байгаа олон улсын төсөл, хөтөлбөрт энэ хуулийн 12.1-д заасан хөгжлийн зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр тусгана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 64
Татгалзсан: 29
Бүгд: 93
68.8 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 13 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13 дугаар зүйл.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн газар

13.1.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх баталгааг дэмжих зорилгоор төрөөс холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчид газрыг ашиглах, эзэмших нөхцөлийг бүрдүүлнэ.

13.2.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах уст цэг, худгийн хоорондох зайг усны нөөц, уст цэгийн хайгуулын дүн, бүс нутгийн газар зүйн онцлогт үндэслэн аймаг, нийслэлийн Засаг дарга тогтооно.

13.3.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хэрэгцээний усны нөөц, уст цэгийн хайгуул, судалгаа хийх хэрэгжүүлэхтэй холбогдох харилцааг Усны тухай хуулиар зохицуулна.

13.4.Хөдөө аж ахуйн газрын ангиллыг өөрчлөх, ангилал шилжүүлэх тохиолдолд Газрын тухай хуулийн 23.2.9-д заасныг баримтлах бөгөөд улсын хөгжлийн бодлогын зайлшгүй шаардлагатайгаас бусад тохиолдолд хөдөө аж ахуйн газрыг нэгдмэл сангийн өөр ангилалд шилжүүлэхгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 63
Татгалзсан: 30
Бүгд: 93
67.7 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн “Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хүний нөөц” гэсэн 14 дүгээр зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 60
Татгалзсан: 33
Бүгд: 93
64.5 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 15 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“15 дугаар зүйл.Хөдөө аж ахуйн судалгаа ба хөгжүүлэлт

15.1.Хөдөө аж ахуйн судалгаа ба хөгжүүлэлтийн тогтолцоо нь дэвшилтэт технологи, инновацыг нэвтрүүлэх, оюуны өмчөөр хамгаалагдсан мэдлэгийг эргэлтэд оруулах, зах зээлд гарах, энэ хуулийн 12.1-д заасан зорилтот хөтөлбөрт тусгасан судалгаа, хөгжүүлэлтийг гүйцэтгэхэд чиглэнэ.

15.2.Хөдөө аж ахуйн салбарын шинжлэх ухаан, технологи, инновацын судалгааны үр дүнг нэвтрүүлэх, зөвлөх үйлчилгээ үзүүлэх, сургалт, сурталчилгаа зохион байгуулах чиг үүрэгтэй төрийн үйлчилгээний байгууллага хөдөө аж ахуйн

асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд ажиллана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 61
Татгалзсан: 32
Бүгд: 93
65.6 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 16 дугаар зүйлийг доор дурдсан өөрчлөн найруулах:

“16 дугаар зүйл.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн эрсдэл, түүнээс урьдчилан сэргийлэх

16.1.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээний нэгдсэн удирдлагыг хэрэгжүүлнэ.

16.2.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн эрсдэлийг доор дурдсан ангиллын дагуу үнэлэх, урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

16.2.1.байгаль орчны;
16.2.2.эдийн засгийн;
16.2.3.нийгмийн;

16.3.Энэ хуулийн 16.2.1-д заасан нөлөөллийн эрсдэлд бэлчээрийн болон тариалангийн газрын доройтол, усны хомсдол, генетик нөөцийн төлөв, уур амьсгалын өөрчлөлт, хүлэмжийн хийн ялгаруулалт, хог хаягдлын менежмент хамаарна.

16.4.Энэ хуулийн 16.2.2-т заасан нөлөөллийн эрсдэлд хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэр, бүтээмж, өрсөлдөх чадвар, эдийн засгийн өгөөж, түүхий эд, бүтээгдэхүүний үнийн хэлбэлзэл, санхүүжилтийн хүртээмж, төрийн дэмжлэгийн үр дүн хамаарна.

16.5.Энэ хуулийн 16.2.3-т заасан нөлөөллийн эрсдэлд хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчийн тогтвортой ажлын байр, ажиллах орчны аюулгүй байдал, нийгмийн баталгааны өөрчлөлтөд дасан зохицох чадамж хамаарна.

16.6.Хөдөө аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах, байгалийн эрсдэлээс сэргийлэх, хамгаалах арга хэмжээг Засгийн газар, бүх шатын Засаг дарга авч хэрэгжүүлж, биелэлтийг хангаж ажиллана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 63
Татгалзсан: 30
Бүгд: 93
67.7 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 18 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“18 дугаар зүйл.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн дэмжлэг

18.1.Хөдөө аж ахуйн дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, импортыг орлох болон экспортын баримжаатай түүхий эд, бүтээгдэхүүн үйлдвэрлэх бодлогын хүрээнд төрөөс дараах дэмжлэгийг үзүүлж болно:

- 18.1.1.шууд болон шууд бус татаас;
- 18.1.2.тарифын болон тарифын бус зохицуулалт;
- 18.1.3.хөнгөлөлттэй зээл, зээлийн хүүгийн хөнгөлөлт;
- 18.1.4.бусад.

18.2.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжлэг үзүүлэх үйлдвэрлэлийн сүлжээний оролцогч нь дараах шаардлагыг хангасан байна:

- 18.2.1.зохистой дадал нэвтрүүлсэн, баталгаажуулсан;
- 18.2.2.стандарт, техникийн зориулалтын дагуу зохицуулалтын шаардлага хангасан, баталгаажуулсан;
- 18.2.3.чанараас хамаарсан үнийн тогтолцоог нэвтрүүлсэн;
- 18.2.4.үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлсэн байх;
- 18.2.5.импортыг орлох, экспортын баримжаатай үйлдвэрлэл байх;
- 18.2.6.нэмүү өртөг шингээсэн байх.

18.3.Энэ хуулийн 18.2-т заасан шаардлагыг хангасан эсэхийг тодорхойлоход мэргэжлийн холбоодын оролцоог хангана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 61
Татгалзсан: 32
Бүгд: 93
65.6 хувийн саналаар дэмжигдлээ.

22.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 19 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“19 дүгээр зүйл.Хөдөө аж ахуйн салбар дахь төрийн удирдлага, зохицуулалт

19.1.Хөдөө аж ахуйн салбарын төрийн бодлого нь төвлөрсөн байх бөгөөд улсын хэмжээнд хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлд хүнс, хөдөө аж ахуйн асуудлыг хариуцсан төрийн захиргааны байгууллага, сум, дүүрэгт хөдөө аж ахуйн тасаг болон бусад харьяа байгууллагаас бүрдэнэ.

19.2.Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний эрхлэх асуудлын хүрээнд мал, таримал ургамлын генетик нөөц, ургамлын болон мал, амьтны эрүүл мэнд, гений сан, малын эм үйлдвэрлэл, лаборатори, аймаг дундын отрын бэлчээр, шинжлэх ухаан, инновац, судалгаа, шинжилгээ, нэвтрүүлэлт хариуцсан төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний байгууллага, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд тус тус ажиллана.

19.3.Аймаг, нийслэлийн хүнс, хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, хөдөө аж ахуйн тасгийн бүтцийг Засгийн газраас тогтоосон орон тооны хязгаарт багтаан хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

19.4.Энэ хуулийн 19.2, 19.3-т заасан байгууллага нь энэ хуульд болон холбогдох бусад хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	64
Татгалзсан:	29
Бүгд:	93

68.8 хувийн саналаар дэмжигдлээ.

23.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 20 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	51
Татгалзсан:	42
Бүгд:	93

54.8 хувийн саналаар дэмжигдлээ.

24.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 22 дугаар зүйлийн хуулийг дагаж мөрдөх хугацааг “2027 оны 01 дүгээр сарын 01” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	61
Татгалзсан:	32
Бүгд:	93

65.6 хувийн саналаар дэмжигдлээ.

25.Ажлын хэсгийн гаргасан, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах /6 дугаар зүйлийн 6.5 дахь хэсэгт “6.5.9.хөдөө аж ахуйн зорилтот хөтөлбөр.” гэсэн заалт нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	57
Татгалзсан:	36
Бүгд:	93

61.3 хувийн саналаар дэмжигдлээ.

26.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн нэр томьёог жигдлэх, зүйл, хэсэг, заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх, бүтэц найруулга, хууль зүйн техникийн засварыг хийх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	66
Татгалзсан:	27
Бүгд:	93

71.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 18 цаг 20 минутад хэлэлцэж дуусав.

Арав.Баталсан хууль, тогтоолын эцсийн найруулгыг сонсох

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул нар байлцав.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт баталсан хууль, тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Үүнд:

1.Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./18:21/

2.Эрүүгийн хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./18:21/

3.Конвенц соёрхон батлах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./18:21/

4.“Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 04 дүгээр дүгнэлтийн тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./18:21/

5.“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./18:22/

6.“Хуулийн төсөл буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./18:22/

Уг асуудлыг 18 цаг 22 минутад хэлэлцэж дуусав.

Бусад.Улсын Их Хурлын гишүүн С.Амарсайханы урилгаар Налайх дүүргийн ерөнхий боловсролын 100 дугаар сургуулийн 1996 оны төгсөгчид, нийслэлийн ерөнхий боловсролын “Шилдэг” сургуулийн багш, сурагчид, Улсын Их Хурлын

гишүүн Б.Түвшингийн урилгаар Завхан аймгийн Дөрвөлжин сумын ерөнхий боловсролын сургуулийн 1991 оны төгсөгчид, нийслэлийн ерөнхий боловсролын 30 дугаар сургуулийн 10^в ангийн багш, сурагчид, Завхан аймгийн Цэцэн-Уул, Сантмаргаз, Сонгино сумдын ерөнхий боловсролын сургуулийн 1993 оны төгсөгчид, Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэлийн урилгаар Өвөрхангай аймгийн Уянга сумын Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын төлөөлөл, нийслэлийн ерөнхий боловсролын 38 дугаар сургуулийн 9^з ангийн багш, сурагчид Төрийн ордон, Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаатай танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 10 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуралдаан зохион байгуулах газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 6 цаг 58 минут үргэлжилж, 126 гишүүнээс 94 гишүүн хүрэлцэн ирж, 74.6 хувийн ирцтэйгээр 18 цаг 22 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ж.БЯМБАДУЛАМ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ГАЗРЫН
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 06 дугаар сарын 05-ны өдөр, Баасан гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 06 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

С.Бямбацогт: Гишүүдийнхээ өглөөний амгаланг айлтгая. Чуулганы хуралдааны ирц хүрэх гэж байна. Өнгөрсөн 5 сард бас Улсын Их Хурлын үйл ажиллагаатай холбоотой зарим тоон мэдээллийг хүргэе.

Шинэ сар эхэлж байгаа. Өнгөрсөн сараа бас товчхон дүгнээд, гишүүддээ мэдээлэл өгье.

5 дугаар сард Улсын Их Хурал бас нэлээн өндөр ачаалалтай, чуулганы нэгдсэн хуралдаан зарим үедээ бас цаг сунган 22 цаг хүртэл хуралдсан. 19 хууль, 14 тогтоол, нийт 33 хууль, тогтоол баталсан байна. Үүнээс онцолж хэлэх юм бол Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай, Цусны донорын тухай, Гадаад зээлийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай гэсэн 3 анхдагч хууль болон Засгийн газраас өргөн барьсан Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, “Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолуудыг баталсан.

Түүнчлэн Шинжлэх ухаан, технологийн тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай зэрэг 10 гаруй хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, амьдралд бас илүү нийцүүлж сайжруулсан.

5 дугаар сард Улсын Их Хуралд 32 хууль, тогтоолын төсөл өргөн мэдүүлсний 19 нь гишүүдийн санаачилсан хууль байна. Энэ нь бас парламентын гишүүд хууль санаачлах бүрэн эрхээ идэвхтэй хэрэгжүүлж, манлайлан оролцож байгаагийн бас илэрхийлэл. Тухайлах юм бол парламентын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлэх, гишүүдийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх, хууль тогтоох үйл ажиллагааны чанарыг сайжруулах зорилготой хэд хэдэн хуулийг Улсын Их Хурлын нэлээд олон гишүүд санаачилж, өргөн мэдүүлж, хэлэлцэж эхлээд байгаа. Үүнийг энэ хаврын чуулгандаа багтаагаад батлах ийм зорилго тавьж ажиллаж байгаа. Энэ хуулиуд батлагдсанаар ардчилсан парламентын засаглалыг бэхжүүлэх, нэр хүндийг нь бас дээшлүүлэхэд чухал алхам болно гэж харж байгаа. Хуралдаа суудаггүй, ирцдээ орчхоод санал хураалтад оролцдоггүй, гараад явчихдаг гэх мэт жижиг зүйлүүд ч гэсэн засагдана гэж харж байгаа.

Улсын Их Хурлын ирц сайжирч байна. Өнгөрсөн 5 дугаар сарын ирцээр чуулганы хуралдааныг 1 ч таслаагүй, гадаад, дотоод томилолт, эмнэлгийн чөлөө аваагүй 39 гишүүн байна. 3 дугаар сарын ирцийг 4 дүгээр сартай харьцуулахад сайжирсан, 4 дүгээр сарыг 5 дугаар сартай харьцуулахад сайжирсан, 5 дугаар сард бас нэлээн сайжирсан ийм дүн харагдаж байгаа. Үүнтэй холбоотойгоор parliament.mn сайтад сайтад гишүүдийн ирцийн талаар бас нэлээн ойлгоход, үзэхэд, харахад хялбар бас авч түгээх боломжтой, ил тод мэдээллийг тавьдаг болсон өөрчлөлт орсон байгаа. Гишүүд бас сонирхож үзээрэй. 7 хоногийн

хугацаатай туршилтаар тавьсан байгаа. Сайжруулах саналууд байвал бас гишүүдийг өгөөрэй гэдгийг бас хэлье.

Өнгөрсөн 5 дугаар сард 100 хувийн ирцтэй, хурлаа 1 ч таслаагүй, 1 ч удаа хоцроогүй, гадаад, дотоод томилолт, эмнэлгийн чөлөө аваагүй 14 гишүүн байна.

Аюушийн Ариунзаяа, Батын Батбаатар, Ренчиндоржийн Батболд, Сандагийн Бямбацогт, Даваасамбуугийн Ганмаа, Тогтмолын Мөнхсайхан, Бөхчулууны Пүрэвдорж, Пүрэвжавын Сайнзориг, Мягмардашийн Сарнай, Лхагвасүрэнгийн Соронзонболд, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин, Доржсүрэнгийн Үүрийнтуяа, Доржзовдын Энхтуяа, Сүхбаатарын Эрдэнэболд нартаа талархал дэвшүүлье.

Мөн бас бага зэрэг хоцорсныг эс тооцох юм бол 31 гишүүн гадаад, дотоод томилолттой байснаас бусад үед чуулгандаа 1 ч хоцроогүй, 1 ч таслаагүй оролцсон 25 гишүүн байна.

Тэгээд Улсын Их Хурлын сахилга хариуцлага, эмх цэгц дээрээсээ эхлэх ёстой. Улсын Их Хурлын гишүүдийн ёс зүй, сахилга хариуцлагаас эхлээд бүх зүйл дээр бид бүхэн бас манлайлах ёстой.

Чуулганы хуралдааны ирц ирвэл зохих 126 гишүүнээс 64 гишүүн хүрэлцэн ирж, 51,6 хувийн ирцтэй, 65 гишүүн хүрэлцэн ирсэн байна. 2026 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдааныг нээснийг мэдэгдье.

7 хоногийн тов дараалалд тусгагдсан хэлэлцэх асуудлын тухай мэдээлэл өгье.

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд Засгийн газар 05 сарын 26-нд өргөн мэдүүлсэн, Эдийн засгийн байнгын хорооны 06 дугаар сарын 03-ны өдрийн хуралдааны явцад Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 31.5-д заасны дагуу хуулийн төслийг хэлэлцэхийг хойшлуулсан тул нэгдсэн хуралдааны хэлэлцэх асуудлаас хасагдсан.

Өнөөдрийн чуулганы хуралдаанд Отгоны Саранчулуун, Бат-Өлзийн Бат-Эрдэнэ, Лутаагийн Энхнасан, Наранцэцэгийн Алтаншагай, Мэндбаярын Мандхай нар 9 цаг 00 минутад хүрэлцэн ирсэн байна. Эртэч гишүүддээ бас баяр хүргэе.

Өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Дараах 10 асуудлыг хэлэлцэнэ.

1 дүгээрт нь хуулийн төслүүдийг эцэслэн батална. Нийт 3 төсөл байгаа.

2 дугаарт нь Бизнесийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг яаралтай хэлэлцэх эсэхийг шийдвэрлэнэ. Засгийн газар 06 дугаар сарын 04-ний өдөр яаралтай хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлсэн.

3 дугаарт нь Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг үргэлжлүүлэн явуулна.

4 дүгээрт нь Улсын нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

5 дугаарт нь Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

6 дугаарт нь Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэнэ.

7 дугаарт нь Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

8 дугаарт нь Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулна.

9 дүгээрт нь Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

10 дугаарт нь баталсан хууль, тогтоолын эцсийн найруулгыг сонсоно.

Ийм 10 асуудлыг өнөөдөр хэлэлцэнэ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 29.1-д “Улсын Их Хурлын дарга хууль санаачлагчаас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх Байнгын хороог, хэрэв тухайн төсөл хэд хэдэн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарахаар бол зөвлөлтэй зөвшилцөн холбогдох болон бусад Байнгын хороог тогтоож, нэгдсэн хуралдаанд мэдээлнэ.” гэж заасан.

Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн төслийг холбогдох Байнгын хороонд хуваарилсан талаар та бүхэнд танилцуулъя.

Бизнесийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Засгийн газар 2026 оны 06 дугаар сарын 4-ний өдөр өргөн мэдүүлснийг Эдийн засгийн байнгын хороонд;

Ойн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хууль, тогтоолын төслүүдийг Улсын Их Хурлын гишүүн Бат-Өлзийн Бат-Эрдэнэ нарын 17 гишүүн 2026 оны 06 дугаар сарын 04-ний өдөр өргөн мэдүүлснийг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд;

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын гишүүн Аюушийн Ариунзаяа нарын 8 гишүүн 2026 оны 06 дугаар сарын 4-ний өдөр өргөн мэдүүлснийг Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд тус тус хуваарилсан.

Хуулийн төслүүдийг эцэслэн батална.

Хэлэлцэх асуудалдаа орцгооё. Гишүүдийг бас танхимдаа ирээгүй гишүүд хүрэлцэн ирэхийг урьж байна.

БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслүүдийг эцэслэн батална.

Улсын Их Хурлын гишүүн Цэнгүүн нарын санаачилсан хуулийн төсөл байгаа. Хуулийн төслүүдийн эцэслэн батлах хувилбарыг холбогдох Байнгын хороо бэлтгэн гишүүдэд тараасан байгаа. Гишүүд санал хураалтдаа бэлтгэе. Чуулганы ирцэд 73 гишүүн байна. Ирцэд орсон, санал хураалтад бэлэн болсон 57 гишүүн байна. Бэлэн бус гишүүд хуруугаа уншуулж, ирцдээ бэлэн болно уу.

Норовын Алтанхуяг, Батын Батбаатар, Ренчиндоржийн Батболд, Энхбаярын Батшугар, Тогтмолын Мөнхсайхан, Эрдэнэбилэгийн Одбаяр, Ганбатын Очирбат, Отгоны Саранчулуун, Цэвэгдоржийн Туваан, Одонгийн Цогтгэрэл, Өлзийхүүгийн Шижир, Лувсанцэрэнгийн Энх-Амгалан, Баттөмөрийн Энхбаяр, Дашцэрэнгийн Энхтүвшин, Сүхбаатарын Эрдэнэболд нарын гишүүд. Эрдэнэболд гишүүн орчихсон байна. Туваан гишүүн одоогоор харагдаж байгаа. Ороогүй байна. 63 гишүүн болсон байна. 11 гишүүн Норовын Алтанхуяг, Батын Батбаатар, Энхбаярын Батшугар, Ганбатын Очирбат, Отгоны Саранчулуун, Буяагийн Тулга, Одонгийн Цогтгэрэл, Шижир гишүүн ирцдээ ороорой. Лувсанцэрэнгийн Энх-Амгалан, Баттөмөрийн Энхбаяр, Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн орж ирж байна. Батлут гишүүн ирцдээ орсон уу. Хуруугаа уншуулсан уу.

Ирц бүртгэлийн санал хураалт явуулъя. Ирц бүртгэлийн санал хураалт. Энэ татгалзсанд гарч байгаа 8 гишүүн манай Баттогтохын Чойжилсүрэн гишүүн байна. Мөнхтуяа гишүүн танхимд байна. Бусад гишүүд чуулгын танхимдаа ирж санал хураалтдаа бэлтгэнэ үү. Нөгөө ирцэд орчихоод, санал хураалтад оролцдоггүй гэдэг чинь энэ л болчихоод байгаа юм л даа. Санал хураалт явуулъя.

БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 76 гишүүн оролцсоноос 68 гишүүн буюу 89,5 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Баярбаатар гишүүн.

Б.Баярбаатар: Гишүүддээ өглөөний мэнд хүргэе. Сая санал хураалтаа дэмжиж санал өгөх гэж байгаад хоцорчихлоо. Уучлал хүсээд, саяын саналыг хүчингүй болгох горимын санал гаргаж өгөхийг хүсье.

С.Бямбацогт: Баярбаатар гишүүний саяын санал хураалтыг хүчингүй болгох горимын саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Баярбаатар гишүүний гаргасан горимын санал дэмжигдлээ. 77 гишүүнээс 53 гишүүн буюу 68,8 хувийн саналаар дэмжигдлээ. Саяын санал хураалт хүчингүй болгоё. Батжаргал дарга.

Ж.Батжаргал: Гишүүдийнхээ өглөөний амар амгаланг айлтгая. Хууль эцэслэн батлах санал хураалтыг жоохон хойшлуулах шаардлагатай байна дарга аа. Үдээс хойш 14 цагаас.

С.Бямбацогт: Хойшлуулах дэг байхгүй. Завсарлага авах л дэг байна. Батжаргал гишүүн, МАН-ын бүлгийн дарга

Ж.Батжаргал: 4 цагийн завсарлага авчихъя. 14 цаг хүртэл.

С.Бямбацогт: 14 цаг хүртэл завсарлага өглөө. Дараагийн хууль дээр бас дагасан 1 хууль байгаа. Холбогдуулан боловсруулсан энэ хамтдаа биз дээ. Хамтдаа гэж ойлголоо. /10:20/

Дараагийн асуудалдаа орёе.

Хуулийн төслийг яаралтай хэлэлцэх эсэхийг шийдвэрлэнэ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33.1-д “Засгийн газрын хуралдааны шийдвэрийг үндэслэн Ерөнхий сайд үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан хуулийн төслийг яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд бичгээр хүсэлт тавьсан бол Улсын Их Хурлын дарга төслийг чуулганаар яаралтай хэлэлцэх эсэхийг нэгдсэн хуралдаанаар оруулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ.” гэж заасан.

Засгийн газраас 2026 оны 06 дугаар сарын 04-ний өдөр Бизнесийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

Одоо хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлтгэе.

Бизнесийн эрх чөлөөний тухай хууль гээд өчигдөр өргөн мэдүүлээд бас нэлээн мэдээллүүд гарсан даа. Зөвшөөрлийн хууль. Өнөөдөр тараагдаж байгаа. Санал хураалтдаа бэлтгэе гишүүд ээ. Тэгээд байгаа дэгээрээ ингээд яаралтай хэлэлцэх санал хураагаад явчихдаг. Өөрчлөгдөх дэг дээр бол яагаад яаралтай хэлэлцэх болсон үндэслэлээ танилцуулж, энд танилцуулга хийсний дараа гишүүд дэмжих, дэмжихгүй саналаа өгөхөөр тийм зохицуулалт орж байгаа. Бидэнд бас зохицуулах, сайжруулах асуудлууд байна. Би тайлбар хэлж байна. Мэдээлэл өгөх үүрэгтэй би. Үүргээ биелүүлж байна. Гишүүд санал хураалтдаа бэлтгэсэн байна.

Бизнесийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 80 гишүүн оролцсоноос 48 гишүүн буюу 60 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Төслүүдийг Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Эдийн засгийн байнгын хороонд шилжүүллээ.

10.24 цаг.

Дараагийн асуудалдаа оръё.

Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг үргэлжлүүлнэ.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлт, хууль санаачлагчийн илтгэл болон хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан.

Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтдаа бэлтгэе. Санал хураалт явуулъя.

Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 81 гишүүн оролцсоноос 50 гишүүн буюу 61,7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн:

Үндэсний их баяр наадмын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 81 гишүүн оролцсоноос 56 гишүүн буюу 69,1 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүллээ.

10.26 цаг.

Дараагийн асуудалдаа оръё.

Улсын нисэхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Чинбаатарын Анар танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Ч.Анар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Улсын нисэхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2026 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгэхээр Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд шилжүүлсэн.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2026 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор дээрх хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Ч.Анараар ахлуулж, Улсын Их Хурлын гишүүн Бадамсүрэн, Батбаатар, Батсүмбэрэл, Наранбаяр, Тэмүүжин, Энхнасан нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулан ажилласан.

Ажлын хэсэг нийт 3 удаа хуралдаж улсын нисэхийн аюулгүй хамгаалалттай холбоотойгоор улсын нисэхийн үйл ажиллагаанд ашиглагдах мэдээллийн технологи, навигаци, хяналт, нислэгийн удирдлагын системийг кибер аюулгүй байдлын шаардлагад нийцүүлэх, улсын зарим агаарын хөлгийг даатгуулсан байх, улсын нислэг, техникийн осол, зөрчлийг шинэчлэн шалга, техник засварын үйлчилгээ болон худалдан авах ажиллагаанд оролцох албан тушаалтан нь ашиг сонирхлын зөрчилгүй байх. Мөн цэргийн зориулалттай нисгэгчгүй нисэх хэрэгслийг удирдлагын системд бүртгүүлээгүй, гэрчилгээжүүлээгүй, хяналтын шаардлага хангаагүй тохиолдолд ашиглахыг хориглох болон хууль зүйн нэр, томъёог жигдлэх, хууль хоорондын нийцлийг хангах үүднээс зарим зүйл, хэсэг, заалтыг өөрчлөн найруулж, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг бэлтгэсэн.

Улсын Их Хурлын гишүүн Энхтүвшин хуулийн төсөлд улсын агаарын хөлгийн засвар техникийн үйлчилгээг хувийн хэвшлийн байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх талаар зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг гаргасан болно.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2026 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн хуралдаанаараа хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулахдаа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцсэн бөгөөд ажлын хэсгээс бэлдсэн зарчмын зөрүүтэй 31 санал, найруулгын 2 санал, Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшингийн гаргасан зарчмын зөрүүтэй 1 саналын томъёоллыг нэг бүрчлэн хэлэлцэж, санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар олонхын санал авсан зарчмын зөрүүтэй саналын томъёолол болон анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Улсын нисэхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

С.Бямбацогт: Анар гишүүнд баярлалаа. Ажлын хэсэг танилцуулъя. Дамбын Батлут Батлан хамгаалахын сайд, Дагвадоржийн Ганхуяг тус яамны Төрийн нарийн бичгийн дарга, хошууч генерал, Эрхэмбаярын Гансүх тус яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, хурандаа, Сайнболдын Билэгтборзаяа тус яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын Улсын нисэхийн хэлтсийн шинжээч, хошууч, Гомбосүрэнгийн Энхболд тус яамны Төрийн захиргааны удирдлагын газрын ахлах шинжээч, хуулийн зөвлөх. Зэвсэгт хүчний жанжин штабаас Сүнрэвийн Ганбямба Зэвсэгт хүчний жанжин штабын дарга, дэслэгч генерал, Бямбасүрэнгийн Мөнх-Ирээдүй Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлагч, бригадын генерал.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21.24-д нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийж байгаа Засгийн газрын гишүүн, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орсон холбогдох албан тушаалтан үнэн зөв, бүрэн гүйцэт мэдээлэл өгөх үүрэгтэй. Нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийх, асуултад хариулах, тайлбар өгөх албан тушаалтан өөрийн танилцуулсан мэдээллийн үнэн зөвийг хариуцах бөгөөд мэдээллийг санаатайгаар нуун дарагдуулах, худал мэдээлэл өгөх, танилцуулах, Улсын Их Хуралд худал мэдээлэл ирүүлэхийг хориглоно. Чуулганы хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй, тайлбар өгөхөөс татгалзсан, хуралдаанд оролцсон этгээд хуралдааны дэг зөрчсөн бол парламентыг үл хүндэтгэсэн үйлдэлд тооцож тухайн этгээдэд Төрийн албаны тухай болон холбогдох бусад хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ гэж тус тус заасныг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд сануулъя.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна. Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн асуултаа асууя.

Д.Энхтүвшин: Улсын нисэхийн тухай хуулийн 2 асуудлыг хөндөж бас дэмжиж байгаа байр сууриа илэрхийлье гэж бодож байгаа. Одоогийн мөрдөгдөж буй хүчин төгөлдөр хууль буюу 2003 оны хуулиар энэ агаарын хөлгөөр арилжааны нислэг үйлдэж болохоор заасан байсан. Тэгээд энэ зохицуулалт нь бол олон улсын жишигт нийцдэггүй. Олон улсын иргэний нисэхийн байгууллагын Чикагогийн конвенцоор нисэхийг иргэний болон улсын гэж 2 хуваагаад, улсын нислэгээр төлбөртэй арилжааны нислэг хийхийг хориглосон ийм зохицуулалтууд байдаг. Тэгээд энэ зарчмыг зөрчиж байсан зүйл, заалтыг өөрчлөөд, шинэ хуулийн төслөөр зөвхөн захиалгат нислэг хийдэг ба арилжааны гэдэг нислэгийг өөрчлөөд захиалгат, өөрөөр хэлбэл гамшиг ослын буюу яаралтай үед хүний амь нас, эрүүл мэндийг аврах, тусгай үүрэг гүйцэтгэх чиглэлээр нислэг үйлдэхээр өөрчилж зохицуулсан байгаа. Тэгээд энэ нь бас төсвийн мөнгөөр агаарын хөлөг худалдаж аваад татвараас чөлөөлөгддөг иймэрхүү эрх зүйн орчинд бий болсон агаарын хөлгөөр дөнгөж өндийж байгаа хувийн хэвшлийн иргэний агаарын салбарт өрсөлдөхгүй байх энэ орчныг тодорхой болгож өгсөн зөв өөрчлөлт гэж бодож байгаа юм.

Тэгээд дээр нь бас энэ хуулийн өөрчлөлтөөр бас даатгалын тогтолцоог бас нэлээн тодорхой болгож өгсөн. Захиалгат нислэгтэй холбоотой энэ даатгалын төлбөрүүдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийн даатгалыг нь энэ захиалга хийж байгаа, захиалгат нислэг хийж байгаа иргэн, байгууллага нь өөрөө хариуцахаар ийм тодорхой болгож өгсөн. Тэгэхээр энэ хуулийн заалтыг зөв чиглэл рүүгээ явж байгаа, олон улсынхаа энэ жишиг рүүгээ нийцэж байгаа заалт болж байгаа гэж үзэж байгаа учраас дэмжиж байгаа.

Мөн бас энэ хуулийн 10.4 дүгээр заалт дээр зарчмын зөрүүтэй санал гаргаад, Байнгын хороо болон ажлын хэсэг дээр дэмжигдээд явж байгаа. Энэ нь болохоор улс өөрийн агаарын хөлгийнхөө засвар үйлчилгээ болон сургалтаа бүгд бүрэн өөрсдөө хариуцаж хийхээр ийм заалт байсныг өөрчилсөн байгаа. Тэгэхээр энэ нь зардал ихтэй, хөрөнгө оруулалтын өгөөж багатай, тэгээд ер нь бодит байдал дээрээ зарим үйлчилгээ, засвар үйлчилгээ болон сургалтыг олон улсын жишигт ч гэсэн хувийн хэвшлийн байгууллагууд дээр гүйцэтгүүлдэг ийм жишиг байгаа. Тэгэхээр энэ агуулгаараа энэ зарчмын зөрүүтэй санал дэмжигдэж орсон байгаа юм. Тэгээд нөгөө талаасаа бас нууцлалтай холбоотой асуудал байдаг учраас тодорхой хэсэг гээд энэ тодорхой хэсэг гэдэг нарийн зохицуулалтуудаа улсын нисэхийн багц дүрмээрээ зохицуулахаар ингэж оруулсан байгаа. Тэгээд ер нь бол энэ улсын нисэхийн хууль бол бас өмнө нь тодорхойгүй байсан хувийн хэвшилтэйгээ иргэний нисэхтэйгээ өрсөлдөх юм шиг иймэрхүү зохицуулалт байсныгаа өөрчилсөн зүйл заалтууд нэлээн сайжирсан учраас энэ хуулийн төслийг дэмжиж байгаа. Дэмжсэн үг хэллээ. Асуулт биш.

С.Бямбацогт: Дэмжиж үг хэллээ. Гишүүд ээ 34 санал хураалттай. Танхимдаа хүрэлцэн ирэхийг урья. Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүн асуултаа асууя. Алга байна. Батын Батбаатар гишүүн асуултаа асууя. Алга байна. Батбаярын Жаргалан гишүүн асуултаа асууя. Үүний дараа санал хураалттай шүү. Гишүүдийг танхимдаа урьж байна. Бүлгүүдийн ажлын алба, бүлгийн дарга, дэд дарга нар, Их Хурлын дэд дарга, Улсын Их Хурлын гишүүдийн зөвлөх, туслахууд гишүүдийг санал хураалтад ирүүлээрэй.

Б.Жаргалан: Улсын нисэхийн тухай хууль 20 гаруй жилийн дараа бас ийм шинэчилсэн найруулга хэлбэрээр орж ирж байна. Тэгээд яг энэ хуулийг шинэчлэн найруулах болсон учир шалтгааныг бас сонсмоор байна. Ер нь бол энэ батлан хамгаалахын салбартай холбоотой, үндэсний аюулгүй байдлын салбартай холбоотой ийм чухал хуулиуд дээр бол бид маш сонор сэрэмжтэй, анхааралтай байх ёстой байгаа. Тэгээд ер нь гол нь бас тогтвортой байдал их чухал гэж харж байгаа. Тэгэхээр шинэчилсэн найруулга хэлбэрээр энэ хуулийн өөрчлөлтийг оруулж ирж байгаа үндэслэлээ бас нэг тайлбарлахыг хүсье.

2 дугаарт өнгөрсөн хугацаанд энэ улсын нисэхэд хамаарах агаарын хөлгийн тоо бас нэмэгдэж байгаа гэсэн зүйл танилцуулга дээр байна. Тэгэхээр одоо яг улсын хэмжээнд бүртгэлтэй нийт энэ улсын нисэхэд хамаарах агаарын хөлгийн тоог яг байгууллага тус бүрийн харьяаллаар нь бас хэлж өгнө үү. Тэгээд энэ улсын нисэхэд хамаарах агаарын хөлгийг бол төрийн өндөр албан тушаалтнууд бас хөлөглөж зардал мөнгө гаргадаг гэсэн асуудлууд бас нэлээн гардаг. Тэгээд үүнтэй холбоотой бас ямар тайлбар байна. Ер нь энэ дээр бас ийм гарсан тоо судалгаанууд байна уу. Төрийн өндөр албан тушаалтнуудын хэрэглээг бас ил зарлаж болох уу гэсэн асуулт байна.

3 дугаарт нь улсын нисэхийн хүрээнд гадаадын мэргэжилтнүүдийг бас ажиллуулах нэг зүйл, заалт орсон байгаа. Тэгээд энэ гадаадын мэргэжилтнүүдийг яг ямар учир шалтгаанаар яагаад ажиллуулж байгаа вэ. Ер нь манай дотоодын боловсон хүчний нөөц бас яг энэ салбарт ямар байгаа вэ. Ер нь цаашид боловсон хүчин нөөцөө бэлтгэж байгаа асуудал дээрээ хэрхэн яаж хандаж байгаа вэ гэдэг дээр бас тодорхой асуулт байна.

Энэ улсын нисэхийн багц дүрмийг болохлоор Засгийн газар батална гэсэн байгаа. Энэ багц дүрмийг батлах тэр хэрэгцээ шаардлага нь бас ямар байгаад байгаа юм. Тэр багц дүрмийнхээ хүрээнд зохицуулах харилцаануудаа энэ хууль руугаа оруулж ирж болохгүй байсан уу. Ер нь бол бид нар бас шүүмжлээд байгаа шүү дээ. Жишээлэх юм бол хууль батлагдангуут араас нь дүрэм журам гээд захиргааны байгууллага дээр баахан эрх, үүрэг овоолчихдог. Тэгээд тэр нь болохоор ингээд асуудал дагуулаад байгаа гээд шүүмжлээд байгаа. Гэтэл энд бүхэл бүтэн хуулийн шинэчилсэн найруулга орж ирж байгаа хэр нь энэ багц дүрмийг нь бол ингээд тусад нь гаргаад хаячхаж байна гэдэг ийм зүйл ажиглагдаж байна. Тэгээд ер нь цаашдаа энэ улсын нисэхийн салбарын аюулгүй байдлын тал дээр ер нь ямар бодлого баримталж байгаа вэ гэдгийг бол яг Батлан хамгаалахын сайдаас өөрөөс нь асууя. Яагаад вэ гэхээр ер нь бол энэ аюулгүй байдалтай холбоотой, дээрээс нь энэ осол зөрчил гарч байгаа ийм зүйлүүд бас нэлээн яригддаг танай салбарын хүрээнд. Тэгэхээр яг энэ улсын нисэхтэй холбоотой ер нь сүүлийн жилүүдэд энэ осол хэдэн осол гарсан бэ. Ер нь цаашдаа энэ аюулгүй байдлыг хангаж, ослын тоог цөөрүүлэх тал дээр ямар нэгдсэн бодлого баримталж байгаа вэ гэдэг дээр Батлан хамгаалахын сайд бас өөрөө тайлбар хэлнэ үү гэж хүсье. Баярлалаа.

С.Бямбацогт: Ажлын хэсэг Анар гишүүн хариулъя. Ажлын хэсгийн ахлагч.

Ч.Анар: Жаргалан гишүүний асуултад хариулъя. Улсын Их Хурал 1999 онд бол Иргэний нисэхийн тухай хуулийг баталсан. Гэхдээ олон улсын иргэний нисэхийн тухай Чикагогийн конвенц буюу 1944 онд баталсан конвенцоор улсын агаарын хөлөг болон иргэний нисэхийг тусад нь зааглаж өгсөн учраас зайлшгүй энэ улсын нисэхийн тухай хууль батлах шаардлагатай болоод 2003 онд анх энэ улсын нисэхийн тухай анхдагч хууль батлагдсан байдаг юм байна. Гэхдээ тухайн үед зөвхөн Монгол Улсын төрийн цэргийн байгууллага болон хууль сахиулах хүчний байгууллагуудын хүрээнд зөвхөн цэргийн болон байлдааны зориулалттай нисэх хэрэгслүүд байсан. Гэхдээ өнөөдрийн нөхцөл байдал дээр бол ОБЕГ, Хууль зүйн яам, төрийн цэргийн байгууллагуудаас гадна төрийн болон хууль хүчний байгууллагууд дээр иргэний зориулалттай онцгой зориулалттай нисдэг тэрэг, ачаа тээврийн зориулалттай агаарын хөлгүүд нэвтэрч орж ирж байгаа. Үүнтэй холбогдолтойгоор хууль, эрх зүйн орчныг орчин үеийн цаг үетэйгээ нийцүүлж өөрчлөх шаардлагатай болсон. Энэ дээр бас нисгэгчгүй, цэргийн нисгэгчгүй нисэх хэрэгсэл буюу дроны зохицуулалтыг оруулж өгч байгаа. Тэгэхээр энэ зохицуулалтуудыг оруулж өгч байгаа.

Мөн улсын нисэхийн агаарын хөлгүүдийг даатгалд хамрагдуулах асуудлыг албан ёсоор хууль дээр оруулж өгсөн байгаа. Таны ярьж байгаа бас шүүмжлэлтэй холбогдолтойгоор түрүүн бас Энхтүвшин гишүүн ярьж байна. Захиалгат арилжааны нислэг гэдэг ойлголт улсын нисэхийн байгууллагуудад байхгүй. Арилжаа гэдэг маань өөрөө наймаа арилжаа хийх зорилгоор хийдэг. Тэгэхээр энэ бол захиалгат нислэг гэдэг асуудлыг улсын нисэхийн байгууллагууд нь хуучин зохицуулалтгүйгээр явж ирснийг энэ хуулийн 14 дүгээр зүйл дээр нарийвчлан заагаад, иргэний хүсэлтээр онцгой нөхцөл байдалд эрүүл мэнд, иргэний хамгаалалт, гамшгаас нөхөн сэргийлэх зорилгоор захиалга үйлдэхээр хууль дээрээ заалтаараа зохицуулж орж ирсэн байгаа. Төрийн тусгай захиалгат нислэг бол төрийн тусгай хамгаалалт, төрийн тусгай хамгаалалтын хуулийн зохицуулалтаараа зохицуулагддаг. Тэгэхээр төрийн тусгай, төрийн өндөр албан тушаалтан улсын болон иргэний нисэхийн

агаарын хөлгийг ашиглан захиалгат нислэг үйлдэхээр тохиолдолд Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн 24.5 дугаар зүйл заалтаар зохицуулсан зохицуулалтыг бас энэ хууль дээр шигтгэж өгсөн байгаа юм.

Багц дүрмийн асуудал дээр бас ажлын хэсэг бол анхнаасаа яг Жаргалан гишүүн таны байр суурьтай адилхан байр сууриар хуульд дүрэм журам багатайгаар хуульчилж өгье гэж саналтайгаар ажлын хэсэг хуралдсан. Гэхдээ улсын нисэх маань өөрөө цэргийн зориулалттай агаарын хөлөг байдаг. Дахиад тусгай чиг үүргийн нислэгүүд явагддаг учраас зарим цаг үеийн нөхцөл байдлаас болоод хууль дээр тэр болгоныг ил бичих боломжгүй байдаг юм байна лээ.

Тэгэхээр ажлын хэсэг бол яг газар дээр нь очиж уулзаж үзэж танилцаж тэр тодорхой хэмжээний дүрэм журам нь олон улсын чигтээ ч гэсэн ийм нийцтэй байх нь зөв юм байна гэдэг дээр санал нэгдсэн байгаа.

С.Бямбацогт: Зэвсэгт хүчний жанжин штабын дарга Ганбямба генерал хариулъя. Ажлын хэсэг 4 дүгээр микрофон.

С.Ганбямба: Жаргалан гишүүний асуултад хариулъя. Улсын агаарын хөлгийн тоо асууж байна. Тэгээд энэ маань бас нууцын зэрэглэлтэй байдаг. Тийм учраас өнөөдөр зэвсэгт хүчний агаарын цэрэг, ХХЕГ, ОБЕГ-т нийт 20 нэгж байлдааны зориулалттай болон тээврийн зориулалттай агаарын хөлөг байгаа гэж хариулъя.

С.Бямбацогт: Батлут сайд нэмж хариулъя.

Д.Батлут: Жаргалан гишүүний асуултад хариулъя. Сүүлийн 11 жилийн хугацаанд нисдэг тэрэгний 2 осол болсон. 2015 онд бол МИ-8 нисдэг тэрэг осолдсон. Энэ бол техникийн нөхцөл байдлаас шалтгаалсан осол байсныг ослын дараах үзлэгээр тодорхойлсон байгаа. 2022 онд онцгой байдлын албаны 1 нисдэг тэрэг осолдсон. Энэ бол гадаад нисгэгчтэй байсан. Нисгэгчийн буруутай үйлдлээс үүссэн гэдэг ийм тодорхойлолт гарсан байгаа.

Тэгэхээр өнөөдөр Улсын нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг өргөн барьж байна. Энэ бол улсын нисэхтэй холбоотой бүхий л харилцааг зохицуулах гэж, өнөө цаг үеийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэх гэж бид бүхэн бол хуулийн төслийг өргөн барьж байгаа. Энэ хүрээндээ энэ улсын нисэхийн аюулгүй байдал, нисгэгч бэлтгэх, онгоцны бэлэн бүтэн байдал турших .../минут дуусав/

С.Бямбацогт: Гүйцээж хариулъя.

Д.Батлут: Осол гэмтлээс урьдчилан сэргийлэхтэй холбоотой бүхий л харилцаа энэ хуулийн зохицуулалтад орж өгсөн байгаа. Тэгэхээр энэ хүрээнд бид бүхэн бол цаашлаад улсын нисэхийн хууль батлагдах юм бол энэ хуулийн хүрээнд болоод багц дүрмийн хүрээнд үйл ажиллагаагаа чиглүүлээд ажиллах боломжтой болно гэж ойлгож болно.

С.Бямбацогт: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Одоо Байнгын хорооноос санал хураалгахаар бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулна. Одоо хураана. Би түрүүн зарласан. Байнгын хороо санал хураахаар бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт

явуулна. Зарчмын зөрүүтэй саналыг тайлбарлаж түүнийг дэмжсэн эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж аль нэг нам эвслийн бүлэгт харьяалагддаг тус бүр 2 хүртэл гишүүн үг хэлж болно. Зарчмын зөрүүтэй 34 санал байна. Гишүүд санал хураалтдаа бэлтгэе. Санал хураалтдаа бэлдэцгээе гишүүд ээ. Хуруугаа уншуулаарай. Гишүүд ээ, танхимдаа санал хураалт. Гишүүдийн зөвлөх, туслахууд өрөөндөө байгаа гишүүдийг явуулаарай. Бас гишүүдийн зөвлөх, туслах чинь бас үүрэгтэй шүү дээ. Одоо хуульд орж байгаа шүү дээ. Хонхтой болно. Ирц бүртгэлийн санал хураалт явуулна. Ирц нь дэмжсэн гэж гарч байгаа хүмүүс бол ажлаа хийгээд танхимдаа сууж байна гэсэн үг. Дэмжээгүй, татгалзсан гэж гарч байгаа хүмүүс бол ажлаа хийхгүй, гараад явчихсан байна гэсэн үг шүү. Ирц нь орчихсон байна. Энэ Засгийн газраас өргөн барьсан хууль шүү дээ. Сайд нар яасан бэ. Ирц бүртгэлийн санал хураалт. Энэ татгалзсанд гарч байгаа гишүүд танхимдаа хүрэлцэн ирье. Сайд нар бас ажлаа хийцгээе. Чуулганы хуралдаанд сууж, өөрсдөө Засгийн газар өргөн барьчаад, өргөн барьсан хууль дээрээ тэгээд орж ирэхгүй хаяад явчихдаг байж болохгүй шүү. Асуудал оруулж ирсэн бол асуудлаа хэлэлцүүлээд батлуултал нь бас авч явах чадвартай байх ёстой шүү.

Нэг.Улсын нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн дараа талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дэмжсэн санал

1.Төслийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “, түүнтэй” гэснийг “Зэвсэгт хүчний тухай хууль, Иргэний нисэхийн тухай хуультай” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Анар, Бадамсүрэн, Батбаатар, Батсүмбэрэл, Наранбаяр, Тэмүүжин, Энхнасан. Цаашид “ажлын хэсэг” гэх. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 84 гишүүн оролцсоноос 55 гишүүн буюу 65,5 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

2.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.9 дэх заалтын “олон улсын сургууль, хамтарсан болон бие даасан” гэснийг “нисэх багийн” гэж өөрчилж, мөн зүйлийн 4.1.2, 4.1.7, 4.1.11, 4.1.14, 4.1.16 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.2.“аюулд нэрвэгдсэн агаарын хөлөг” гэж агаарын хөлөг нислэг үйлдэх, хөөрөх, буух, явгалах үед агаарын хөлөг гэмтэж, агаарын хөлөг болон зорчигчдод аюул учирч, аргагүйдсэн нөхцөлд буулт хийсэн, эсхүл бүрэн эвдэрсэн хөлгийг;

4.1.7.“олон улсын нислэг” гэж улсын агаарын хөлгөөр Монгол Улс, гадаад улс хооронд үйлдэх нислэгийг;

4.1.11.“улсын агаарын хөлөг” гэж төрийн цэргийн, хууль сахиулах болон төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлэгч байгууллагын нисэх онгоц, нисдэг тэрэг бусад агаарын хөлгийг;

4.1.14.“цэргийн зориулалттай нисгэгчгүй нисэх хэрэгсэл” гэж цэргийн байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдах нисгэгчгүй болон зайнаас удирдах агаарын хөлгийг;

4.1.16.“Улсын нисэхийн багц дүрэм” гэж энэ хуулийн 11 дүгээр зүйлд заасан харилцааг зохицуулах эрх зүйн баримт бичгийг;” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. Санал хураалтад 85 гишүүн оролцсоноос 60 гишүүн буюу 70,6 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

3.Төслийн 5 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5 дугаар зүйл.Монгол Улсын Их Хурлын бүрэн эрх

5.1.Монгол Улсын Их Хурал улсын нисэхийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтооно.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. Санал хураалтад 86 гишүүн оролцсоноос 66 гишүүн буюу 76,7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Хуралдаан зохион байгуулах газар ирцдээ орчхоод, ирээгүй сайд нарын нэрсийг гаргаад өг. Би уншиж танилцуулъя. Дуудъя.

4.Төслийн 6 дугаар зүйлийн “улсын нисэхийг хөгжүүлэх төсөл, хөтөлбөрийг батлах;” гэсэн 6.1.4 дэх заалтыг хасаж, мөн зүйлийн 6.1.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.1.3.улсын нисэхийн аэродром байгуулах, өөрчлөх, шилжүүлэх, татан буулгах, хамтран ашиглах асуудлыг цэргийн мэргэжлийн дээд удирдлагын байгууллагын санал болгосноор Зэвсэгт хүчний ерөнхий командлагчтай зөвшилцөн шийдвэрлэх.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. Санал хураалтад 86 гишүүн оролцсоноос 63 гишүүн буюу 73,3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

5.Төслийн 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалтын “нисэхийн” гэсний дараа “хяналтын” гэж нэмж, мөн зүйлийн 7.1.2 дахь заалтын “шинжээч (байцаагч)-ийг томилох,” гэснийг “шинжээчийг томилох, чөлөөлөх” гэж, мөн зүйлийн 7.1.5 дахь заалтын “цагийн хөлсний үнэлгээний тусгай норм, зэрэг, зэрэглэлийг” гэснийг “цагийн үнэлгээ, зэрэг, зэрэглэлийн нэмэгдлийг” гэж тус тус өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 7.1.3, 7.1.4 дэх заалт нэмэх:

“7.1.3.улсын нисэхийн нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах комиссын дүрмийг батлах;

7.1.4.улсын нисэхийн нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах комиссыг томилох;” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. Санал хураалтад 87 гишүүн оролцсоноос 66 гишүүн буюу 75,9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

6.Төслийн 8 дугаар зүйлийн 8.2.4 дэх заалтын “мэргэжлийн үнэмлэх,” гэсний дараа “нислэгт тэнцэх чадварын” гэж нэмж, мөн зүйлийн 8.2.3 дахь заалтын “хөтлөх” гэснийг “бүрдүүлэх” гэж өөрчилж, мөн зүйлийн 8.2.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8.2.5.улсын нисэхийн аэродромыг бүртгэх, гэрчилгээжүүлэх;” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал

хураалтад 88 гишүүн оролцсоноос 67 гишүүн буюу 76,1 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

7.Төслийн 9 дүгээр зүйлийн 9.1.6 дахь заалтын “хуулийн” гэсний дараа “8.2 дугаар зүйлийн” гэж нэмэх. Санал гаргасан. Ажлын хэсэг дэмжье гэсэн томъёоллоор. Санал хураалт санал. Хураалтад 88 гишүүн оролцсоноос 66 гишүүн буюу 75 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

8.Төслийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 10.1.1, 10.1.2 дахь заалт болгох:

“10.1.1.нислэгийн үйл ажиллагааг хариуцсан нэгжтэй байх;

10.1.2.шалгагч зэрэглэлтэй нисгэгч, инженерийг томилох, чөлөөлөх;” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. Санал хураалтад 88 гишүүн оролцсоноос 70 гишүүн буюу 79,5 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

9.Төслийн 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 10.1.3 дахь заалт болгох:

“10.1.3.Улсын нисэхийн багц дүрэм болон агаарын хөлгийн үйлдвэрлэгчээс гаргасан дүрэм, зааврын дагуу нислэгийн үйл ажиллагааг гүйцэтгэх;” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. Санал хураалтад 88 гишүүн оролцсоноос 67 гишүүн буюу 76,1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

10.Төслийн 10 дугаар зүйлийн 10.1.5 дахь заалтын “улсын агаарын хөлөг,” гэсний өмнө “энэ хуулийн 4.1.3-т зааснаас бусад” гэж нэмж, мөн зүйлийн 10.1.4 дэх заалтын “тасралтгүй” гэснийг, мөн зүйлийн 10.1.5 дахь заалтын “заавал” гэснийг тус тус хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 10.1.6 дахь заалт нэмэх:

“10.1.6.энэ хуулийн 14.1.2, 14.1.3, 14.1.4-т заасан нислэг үйлдэхэд зорчигчийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийн даатгалыг гэрээ байгуулагч тал хариуцах.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 88 гишүүн санал хураалтад оролцсоноос 68 гишүүн буюу 77,3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

11.Төслийн 10 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 10.4 дэх хэсэг нэмэх:

“10.4.Улсын агаарын хөлгийн засвар, техникийн үйлчилгээ болон нисэх баг, инженер техникийн бүрэлдэхүүний сургалтын тодорхой хэсгийг эдийн засгийн үр ашиг, чанар, аюулгүй байдлыг харгалзан дотоодын болон гадаадын гэрчилгээжсэн хувийн хэвшлийн байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно. Энэ тохиолдолд тавигдах шаардлага, журмыг Улсын нисэхийн багц дүрмээр тогтооно.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Энхтүвшин. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 88 гишүүн санал хураалтад оролцсоноос 65 буюу 73,9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

12.Төслийн 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалтын “бүртгэлийн гэрчилгээ нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ олгох, сунгах, түдгэлзүүлэх, цуцлах,” гэснийг

“хасах, нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ олгох, сунгах, түдгэлзүүлэх, цуцлах, хүчингүй болгох;” гэж, мөн зүйлийн 11.1.11 дэх заалтын “хэрэгслийг бүртгэх,” гэснийг “хэрэгсэл, түүний удирдлагын системийг бүртгэх,” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. Санал хураалтад 88 гишүүн оролцсоноос 66 гишүүн буюу 75 хувиар энэ санал дэмжигдлээ.

13.Төслийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийн “заасны дагуу” гэсний дараа “улсын агаарын хөлгийн бүртгэлд” гэж, мөн хэсгийн “бүртгүүлээгүй,” гэсний дараа “нислэгт тэнцэх чадварын гэрчилгээгүй улсын” гэж тус тус нэмж, мөн зүйлийн 12.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 12.3 дахь хэсэг болгох:

“12.3.Улсын агаарын хөлөг нь нислэгийн аюулгүй ажиллагааны нөхцөлийг хангасан нислэгт тэнцэх чадварын гэрчилгээтэй байна.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. 75 хувиар энэ санал дэмжигдлээ.

14.Төслийн 12 дугаар зүйлийн “Улсын агаарын хөлгийг бүртгэх, бүртгэлээс хасах, нислэгт тэнцэх чадварыг тодорхойлох, гэрчилгээ олгох, сунгах, цуцлах үйл ажиллагааг Улсын нисэхийн багц дүрмээр зохицуулна.” гэсэн 12.6 дахь хэсэг, мөн зүйлийн “Энэ хууль болон Улсын нисэхийн багц дүрмийг зөрчсөн тохиолдолд агаарын хөлгийн бүртгэлийн гэрчилгээг түдгэлзүүлэх, эсхүл хүчингүй болгоно.” гэсэн 12.7 дахь хэсгийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. 89 гишүүн санал хураалтад орсноос 70 буюу 78,7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

15.Төслийн 12 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 12.8 дахь хэсэг нэмэх:

“12.8.Энэ хуулийн 10.1.5-д заасан даатгалыг улсын төсвийн санхүүжилтээр шийдвэрлэнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. Санал хураалтад 89 гишүүн оролцсоноос 65 гишүүн буюу 73 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Энэ дахиад 15 байна шүү дээ. 16 биз дээ.

16.Төслийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13.3.Агаарын хөлгийн дарга нислэгийн аюулгүй байдалд аюул тулгарсан тохиолдолд улсын агаарын хөлөгт байгаа зорчигчдын амь насыг аврах зорилгоор нислэгийн төлөвлөгөө болон нислэгийн хөдөлгөөний удирдагчийн өгснөөс өөр шийдвэр гаргах эрхтэй.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. Санал хураалтад 90 гишүүн оролцсоноос 69 гишүүн буюу 76,7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

17.Төслийн 13 дугаар зүйлийн 13.6 дахь хэсгийн “үүрэг гүйцэтгэж” гэснийг “ажиллуулж” гэж өөрчилж, мөн зүйлийн 13.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13.7.Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гэрээгээр ажиллах гадаад улсын иргэн, хуулийн этгээдэд улсын агаарын хөлгөөр нисэх, техник үйлчилгээ хийх эрхийг дараах шаардлагыг үндэслэн олгоно:

13.7.1.мэргэжлийн үнэмлэх, гэрчилгээ нь хүлээн зөвшөөрөгдсөн байх;

13.7.2.үндэсний аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ болон шалгалт хийгдсэн байх;

13.7.3.улсын агаарын хөлгийг эзэмшигч байгууллагатай төрийн нууцын хууль тогтоомжийн дагуу нууцын баталгаа, нууц хадгалах гэрээ байгуулсан байх.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. Санал хураалтад 90 гишүүн оролцсоноос 68 гишүүн буюу 75,6 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

18.Төслийн 14 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 14.6 дахь хэсэг нэмэх:

“14.6.Энэ хуулийн 14.1.2-т заасан нислэгийн аюулгүйн хамгаалалтыг хангах асуудлыг цэргийн мэргэжлийн дээд удирдлагын байгууллага болон төрийн тусгай хамгаалалтын байгууллагын хамтарсан журмаар зохицуулна.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. Санал хураалтад 90 гишүүн оролцож 68 буюу 75,6 хувийн саналын санал дэмжигдлээ.

19.Төслийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн “аэродром ашиглах үйл ажиллагаа, түүнд тавигдах шаардлагыг” гэснийг “ашиглах, түүний бэлэн байдлыг” гэж өөрчилж, мөн зүйлийн “Цэргийн зориулалттай нисэхийн аэродром байгуулах, өөрчлөх, шилжүүлэх, татан буулгах, түүний бэлэн байдал, түүнд тавигдах шаардлагыг тогтоох асуудлыг цэргийн мэргэжлийн дээд удирдлагын байгууллагын санал болгосноор Зэвсэгт хүчний ерөнхий командлагчтай зөвшилцөн Засгийн газар шийдвэрлэнэ.” гэсэн 16.2 дахь хэсэг, мөн зүйлийн “Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь улсын нисэхийн аэродром байгуулах, түүний бэлэн байдал, түүнд тавигдах шаардлагыг тогтоох тухай саналыг боловсруулж Засгийн газраар шийдвэрлүүлнэ.” гэсэн 16.3 дахь хэсэг, мөн зүйлийн “Улсын нисэхийн аэродромын бүртгэлийг батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага эрхэлнэ.” гэсэн 16.5 дахь хэсгийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт.

Сайд нараас ирцэд орчхоод хуралдаа суухгүй байгаа сайд нарыг танилцуулъя. Бат-Амгалан, Дэлгэрсайхан, Мэндсайхан байна. Ирчихсэн байна шүү. Сая ороод ирсэн юм байна. Өнөөдөр хуралдаа ирээгүй сайд нар Энхбаяр сайд, Номтойбаяр сайд, Амарсайхан сайд, Ж.Энхбаяр сайд, Аубакир ирсэн байна. Номин сайд, Найдалаа сайд алга байна. Найдалаа сайд томилолттой байгаа. Сандаг-Очир сайд томилолттой, Дамдинням сайд томилолттой. Бусад сайд нар ирэх ёстой. Засгийн газрын оруулсан асуудал. Засгийн газар оруулсан асуудлаа дэмжээд бас хуралдаа хариуцлагатай суух хэрэгтэй. Сайд нар. Засгийн газар танхимаар ажилладаг. Танхимын зарчмаар.

20.Төслийн 18 дугаар зүйлийн “Улсын нисэхийн аюулгүй байдлын хяналтыг энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан байгууллага хэрэгжүүлнэ.” гэсэн 18.2 дахь хэсгийг хасаж, мөн зүйлийн 18.3 дахь хэсгийг 18.2 дахь хэсэг болгох. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. Санал хураалтад 90 гишүүн оролцсоноос 66 буюу 73,3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

21.Төслийн 18 дугаар зүйлийн 18.3.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 18.2.1, 18.2.2 дахь заалт болгох:

“18.2.1.эрх бүхий албан тушаалтнаас олгосон албаны үнэмлэх, хувийн дугаар бүхий тэмдэг хэрэглэх;

18.2.2.албан үүргээ гүйцэтгэхтэй холбоотой албан шаардлага, зөвлөмж, дүгнэлт гаргах, хэвлэмэл хуудас хэрэглэх; Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. Санал хураалтад 90 гишүүн оролцсоноос 65 буюу 72,2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

22.Төслийн 18 дугаар зүйлийн “дээрх заалтын дагуу хийгдэх үйлдэл, байцаагчийн үүрэг даалгаврыг гүйцэтгэх хугацаа болон бусад нэмэлт зохицуулалтыг Улсын нисэхийн багц дүрмээр нарийвчлан зохицуулна.” гэсэн 18.3.6 дахь заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. Санал хураалтад 90 гишүүнээс 66 буюу 73,3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

23.Төслийн 18 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 18.4 дэх хэсэг нэмэх:

“18.4.Цэргийн зориулалттай нисгэгчгүй нисэх хэрэгслийг энэ хуулийн 11.1.11-д заасан шаардлага хангаагүй тохиолдолд ашиглахыг хориглоно.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 90 гишүүнээс 66 буюу 73,3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

24.Төслийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“19.1.Хуульд өөрөөр заагаагүй бол улсын нисэхийн аюулгүйн хамгаалалтыг хангах чиглэлээр зорчигчийн бие, ачаа тээшинд агаарын хөлгийг эзэмшигч болон мэргэжлийн байгууллага холбогдох дүрмийн дагуу үзлэг, шалгалт хийнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 90 гишүүнээс 67 буюу 74,4 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

25.Төслийн 19 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 19.4 дэх хэсэг нэмэх:

“19.4.Улсын нисэхийн үйл ажиллагаанд ашиглагдах мэдээллийн технологи, навигаци, хяналт, нислэгийн удирдлагын систем нь кибер аюулгүй байдлын шаардлагад нийцсэн байна.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 90 гишүүнээс 69 буюу 76,7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

26.Төслийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсгийн “Эрэн хайх” гэсний өмнө “Улсын агаарын хөлгийг” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 90 гишүүнээс 65 буюу 72,2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

27.Төслийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсгийн “эрлийн ажлыг зогсоох шийдвэрийг уг агаарын хөлгийг эзэмшигч байгууллагын саналыг үндэслэн” гэснийг “мэргэжлийн комиссын саналыг үндэслэн эрлийн ажлыг зогсоох шийдвэрийг” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 90 гишүүнээс 66 буюу 73,3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

28.Төслийн 22 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 22.2, 22.5, 22.6, 22.7, 22.8 дахь хэсэг нэмэх:

“22.2.Улсын нисэхийн нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагаа нь осол, зөрчлийг дахин давтагдахаас урьдчилан сэргийлнэ.

22.5.Улсын нисэхийн аюулгүй байдлын хяналт, осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагаанд оролцох албан тушаалтан нь агаарын хөлгийг эзэмшигч байгууллагын агаарын хөлгийг худалдан авахтай холбоотой ажиллагаанд шууд болон шууд бус ашиг сонирхлын зөрчил үүсэхээр бол худалдан авах ажиллагаанд оролцохоос татгалзана.

22.6.Улсын нисэхийн нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагаанд оролцох ерөнхий шинжээч, комиссын гишүүд нь улсын агаарын хөлгийг үйлдвэрлэгч болон засвар, техникийн үйлчилгээг хариуцах байгууллагатай ашиг сонирхлын зөрчилгүй эсэх талаар эрх бүхий албан тушаалтанд мэдэгдэнэ.

22.7.Улсын нисэхийн нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааны талаарх баримт, мэдээллийг устгах, өөрчлөх, нуун дарагдуулах, задруулахыг хориглоно.

22.8.Улсын нисэхийн нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааны нууцад хамаарахаас бусад мэдээлэл олон нийтэд нээлттэй байна.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 90 гишүүнээс 68 буюу 75,6 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

29.Төслийн 23 дугаар зүйлийн гарчгийн “бүрэн эрх, чиг үүрэг” гэснийг “эрх, үүрэг” гэж, мөн зүйлийн 23.1 дэх хэсгийн “бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэснийг “эрхтэй” гэж, мөн хэсгийн 23.1.2 дахь заалтын “хүн” гэснийг “албан тушаалтан” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 23.1.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“23.1.1.албан үүргээ гүйцэтгэхдээ улсын агаарын хөлгийг эзэмшигч байгууллага болон шаардлагатай бусад газарт саадгүй нэвтрэх,” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 90 гишүүнээс 65 буюу 72,2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

30.Төслийн 23 дугаар зүйлийн 23.2.3 дахь заалтын “дүрмийг батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээр батлуулах” гэснийг “дүрмийн төслийг боловсруулах” гэж өөрчилж, мөн зүйлийн “улсын агаарын хөлгийн нислэг-техникийн осол, зөрчлийн шалтгааныг үнэн зөв тогтоох, шаардлагатай мэдээ, судалгаа, бусад баримт бичгийг холбогдох этгээдээс шаардан гаргуулж авах.” гэсэн 23.1.6 дахь хэсэг, мөн зүйлийн “улсын нисэхийн нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах комисс томилуулах тухай саналаа батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулж, шийдвэрлүүлэх,” гэсэн 23.2.4 дахь заалтыг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт 90 гишүүнээс 68 буюу 75,6 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

31.Төслийн 24 дүгээр зүйлийн гарчгийн “комисс, түүний бүрэн эрх” гэснийг “комиссын чиг үүрэг” гэж, мөн зүйлийн 24.1 дэх хэсгийн “, түүний бүрэн эрх” гэснийг “дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:” гэж, мөн зүйлийн 24.1.1 дэх заалтын “зүйлст хяналтаа тогтоох” гэснийг “зүйлсийг хяналтад авах” гэж, мөн зүйлийн 24.1.5 дахь заалтын “болсон” гэснийг “улсын” гэж, мөн зүйлийн 24.3 дахь хэсгийн “уг осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ” гэснийг “осол,

зөрчил гаргахгүй байх талаар холбогдох байгууллагад зөвлөмж хүргүүлнэ.” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 90 гишүүнээс 64 буюу 71,1 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Найруулгын санал:

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “зохицуулалт,” гэсний дараа, 8 дугаар зүйлийн 8.2.6 дахь заалт, 13 дугаар зүйлийн 13.2, 13.4 дэх хэсгийн “агаарын” гэсний өмнө, 21 дүгээр зүйлийн гарчгийн “нэрвэгдсэн” гэсний дараа “улсын” гэж тус тус нэмж, төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.13 дахь заалтын “цогцолбор” гэснийг “цогц” гэж өөрчилж, төслийн 24 дүгээр зүйлийн 24.3 дахь хэсгийн “гарсан” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 90 гишүүнээс 68 буюу 75,6 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

2.Зэвсэгт хүчний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дэмжсэн санал.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “... 9.1.1, 9.1.2-т ...” гэснийг “9.1.2, 9.1.6-д” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 90 гишүүнээс 67 буюу 74,4 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

3.Найруулгын санал.

1.Улсын нисэхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Улсын нисэхийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хууль, Зэвсэгт хүчний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зарчмын зөрүүтэй саналын томъёоллуудыг дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн зүйл, хэсэг, заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх, агуулга зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, найруулгын шинжтэй засвар хийх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 90 гишүүн оролцсоноос 69 буюу 76.7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллуудаар санал хураалт явуулж дууслаа.

Улсын нисэхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд шилжүүллээ.

11.14 цаг.

Одоо дараагийн асуудалдаа оръё.

Хөдөө, аж ахуйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1, 32.2-т заасны дагуу хуулийн төслөө татан авах тохиолдолд тухайн төсөл нь хэлэлцүүлгийн аль шатанд байгаагаас үл хамааран хууль санаачлагч хуулийн төслөө татан авах тухай албан бичгийг Улсын Их Хуралд ирүүлэх бөгөөд Улсын Их Хурлын дарга

нэгдсэн хуралдаанд энэ тухай танилцуулснаар хууль санаачлагч хуулийн төслөө татан авсанд тооцно. Улсын Их Хурлын гишүүн Мэндбаярын Мандхайгаас албан бичиг ирсэн байна.

Улсын Их Хурлын дарга Сандагийн Бямбацогт танаа

Хуулийн төсөл татан авах тухай

Монгол Улсын Их Хурлын гишүүн Мандхай нарын 10 гишүүнээс 2025 оны 6 дугаар сарын 19-ний өдөр Хөдөө, аж ахуйн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32.2 дахь хэсэгт заасны дагуу татан авах саналаа үүгээр уламжилж байна.

Мандхай, Батболд, Отгонбаяр, Соронзонболд, Хосбаяр, Энхнасан.

Дагасан 7 хуулийнхаа 3-ыг татаж байгаа юм байна. Ялгаад дагасан 7 хуулиас 3-ыг нь, үндсэн хууль бол хэвээр үлдэж байгаа юм байна. Бас тайлбарлаж хэлэхгүй бол гишүүд жоохон буруу ойлголттой байна. Тэр саяын хуулиудыг татаж авсанд тооцлоо./11:16/

Төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурлын дэд дарга Жадамбын Бат-Эрдэнэ танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Ж.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай нарын 10 гишүүнээс 2025 оны 06 дугаар сарын 19-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг 2025 оны 10 дугаар сарын 2-ны өдрийн нэгдсэн чуулганы хуралдаанаар хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлсэн болно.

Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах үүрэг бүхий ажлын хэсгийг Байнгын хорооны 2025 оны 22 дугаар тогтоолоор байгуулсан бөгөөд ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ миний бие, бүрэлдэхүүнд нь Улсын Их Хурлын гишүүн Д.Жаргалсайхан, С.Замира, С.Лүндэг, Н.Наранбаатар, Р.Сэддорж нар ажиллалаа.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2026 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн хуралдаанаараа хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу явуулж, хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцлээ.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг төвлөрүүлэх, хадгалах, худалдан борлуулах төвийг аймаг, сумд байгуулах, төр, хувийн хэвшлийн түншлэлээр хөгжүүлэх хөдөө аж ахуйн судалгаа, хөгжүүлэлт, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн дэмжлэг үзүүлэх талаар асуулт асууж, хариулт авлаа.

Ажлын хэсгээс хуулийн нэр томъёог тодорхой болгох, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд газар зүйн байршил, экологийн онцлог, дэд бүтцийн хөгжил, хүн амын нягтрал болон биологийн бусад нөөц, зах зээлийн эргэлтэд тулгуурлан төрөлжүүлэн хөгжүүлэх, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл чанараас хамаарсан үнийн тогтолцоог бүрдүүлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хүний нөөцийн бодлого, судалгаа, хөгжүүлэлтийг төлөвшүүлэх, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчид хөрөнгө оруулагчдыг дэмжих чиглэл, шалгуурыг тогтоох, бүртгэх ажлыг нэгдсэн сүлжээ бий болгох зэрэг асуудал яригдлаа.

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл дэх төрийн удирдлагын тогтолцооны цар хүрээг тогтоож, бүртгэл, хяналтын нэгдсэн цахим систем бий болгох харилцааг зохицуулах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, холбогдох зохистой дадал, стандарт, техникийн зохицуулалтыг мөрдөх, шаардлагыг хангуулах, чанартай уялдсан үнийн тогтолцоог хөгжүүлэх чиглэлийг төрийн дэмжлэг болгон ажиллах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн эрэлт, нийлүүлэлт, нөөц, ашиглалт, бүтээмжийн дүн шинжилгээ хийх, түүнд суурилсан тогтвортой хөгжүүлэх зорилтот хөтөлбөрийг баталж хэрэгжүүлэх, орон нутгийн түвшинд уг зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган хэрэгжилтийг зохион байгуулах, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл төсөл боловсруулах зэрэг нийт 26 зарчмын зөрүүтэй саналын томъёолол гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын гишүүд ээ,

Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэхийг хүсье. Баярлалаа.

С.Бямбацогт: Ажлын хэсгийн ахлагч Бат-Эрдэнэ гишүүнд баярлалаа. Номтойбаяр сайд гадаад томилолттой. Өнөөдөр бас Хятад улс руу томилолтоор явж байгаа юм байна. Номин сайд Дархан-Уул аймагт бас томилолттой өнөөдөр ажиллахаар чөлөө авсан байна. Түрүүн танилцуулсан сайд нараас.

Ажлын хэсгийг танилцуулъя. Чадраабалын Раднаабазар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хуулийн хэлтсийн дарга, Цэвэгмэдийн Мөнхнасан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын шинжээч, Авирмэдийн Буянбаатар ХААИС-ийн сургалт эрхэлсэн проектор. Ийм ажлын хэсэг хүрэлцэн ирсэн байна.

Улсын Их Хуралд хүндэтгэлтэй хандахыг Их Хурлын гишүүдийн асуултад үнэн зөв, бодитой мэдээлэл өгч хариулахыг та бүхнээс хүсье. Худлаа мэдээлэл, буруу мэдээлэл өгөхийг хориглодог болохыг сануулъя.

Ингээд Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн асуултаа асууя.

Д.Энхтүвшин: Би энэ үзэл баримтлалтай холбоотой нэг асуулт байгаад байгаа юм. Тэгэхээр яах вэ, энэ хуулийн төслийг харахаар илүү төрөөс дэмжинэ, тусална гэсэн. Тэгэхээр энэ Хөдөө аж ахуйн салбарыг ер нь өөрөөр нь ингээд явуулах бололцоо боломж байхгүй юу. Тэгээд энэ хувийн хэвшлийн зах зээлийн зарчмаар нь явуулах энэ талаар үзэл баримтлал дээр болохоор арай эсрэгээрээ л байх шиг байна л даа. Төрөөс дэмжинэ. Тэгээд зарим нэг бас оролцоонууд дээр бусад улсууд дээр бас жишээнүүд байна л даа. Шинэ Зеланд эд нар дээр 1980 хэдэн онд бол энэ бүтээгдэхүүний өртгийнх нь бараг 30 орчим хувь нь Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийх нь төрөөс өгч байгаа дэмжлэг, татаас байж байсныг нь бараг 4 хувь болгож буулгаад богино хугацаанд асуудалтай байсан ч гэсэн урт хугацаандаа Шинэ Зеландын хөдөө аж ахуйн салбар бол ингээд дэлхийд өрсөлдөх хэмжээтэй ийм чадвартай болж чадсан байгаа. Тэгэхээр сүүлийн жилүүдэд ч гэсэн яг энэ өртөгт эзэлж байгаа хөдөө аж ахуйн салбарын татааснууд олон улсын жишиг ер нь буураад байгаа. Тэгэхээр манайх бол эсрэгээрээ төрөөс дэмжинэ гэсэн нэлээн олон дэмжлэгийн тухай заалтууд тэгээд иймэрхүү л хууль яваад байна л даа хуулийн төсөлд. Тэгэхээр энэ агуулгын хувьд аль нь зөв, яах ёстой гэж бодож байгаа юм. Тэгэхээр хэрвээ энэ саяын хэлсэн агуулгаар бол дахиад энэ үзэл баримтлалыг өөрчлөх хэрэгтэй ингэж харагдах гээд байгаа юм. Өөр 1 асуудал нь болохоор энэ Зөвшөөрлийн тухай хуультай зөрчилдөхөөр гэх юм уу, энэ Засгийн газрын тэмдэглэл дээр байсан. Тэгэхдээ зүйл заалтуудыг нь өөрчилсөн юм шиг байна. Хуулийн төсөл дээр Засгийн газрын тэмдэглэл дээр үндэслээд. Тэгэхдээ энэ хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг бүс нутаг заагаад тэр бүс нутагт нь заасан дагнасан тэр бодлогынх нь хүрээнд л мал аж ахуй, хөдөө аж ахуй эрхлэх бололцоотой, өөр юу эрхэлж болохгүй гэсэн иймэрхүү агуулга бас уншигдаад байна. Тэгээд энэ 2 дээр хариулт хэлж өгөөч.

С.Бямбацогт: Хэн хариулах вэ. Ажлын хэсэг Бат-Эрдэнэ гишүүн хариулъя.

Ж.Бат-Эрдэнэ: Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн дэмжлэг гээд 18 дугаар зүйл дээр бас нэлээн томхон байсныг жоохон цэгцэлж оруулж ирж байгаа юм. Тэгэхээр өнөөдөр би бас ганц 2 удаа хэлсэн үгэндээ бас хэлээд л яриад л байдаг юм. Ер нь манай хөдөө аж ахуйн зэрлэг хөдөө аж ахуй л гэж би хувь хүнийхээ хувьд бол тодорхойлоод байгаа шүү дээ. Тэгээд энэ хөдөө аж ахуйн орон нутаг, тэр тусмаа орон нутагт хөгжүүлэхэд асуудал дээр төрийн захиргааны төв байгууллагаас гаргаж байгаа бодлого, дээрээс нь ер нь хөдөө аж ахуйг бид нар класстержсан байдлаар технологийн өндөр түвшинд ингээд жишээ нь та бол Шинэ Зеландыг дурдаж байна. Шинэ Зеландтай төстэй хэлбэрээр ч юм уу ингээд хөгжүүлэе гэхээр яг үндсэндээ орон нутаг дээр энэ маань явахгүй өчнөөн хугацаа өнгөрчихлөө. Тэр тусмаа сум дээр хөдөө аж ахуйн түүхий эдийг хүлээж авдаг, бүртгэдэг, хадгалдаг, тээвэрлэх энэ систем, энэ кластерын бүтэц маань ерөөсөө явж өгөхгүй байгаад байгаа юм. Жишээ нь, миний хувьд бол Булган дээр “Шинэ хөдөө” гэсэн хөтөлбөр хэрэгжүүлээд яг сум болгон дээр энэ кластерын системийг бий болгох гээд ингээд явдаг. Тэнд ерөөсөө л дэмжлэг, тодорхой хэмжээний дэмжлэггүйгээр бол аж ахуйн нэгжүүд маань өөрсдөө бие даагаад явж чадахгүй. Үндсэндээ суман дээр юу ажиллаж байна гэхээр

ердөө хэдэн ченжүүд л ажиллаж байгаа шүү дээ. Тэгээд эд нарыг дэмжээд дэмжээд, тодорхой хэмжээний дэмжлэг үзүүлэхгүй л бол эд нарыг ерөнхий системийг нь яриад, гадаадад ямар байдаг билээ, яаж хөгжвөл бид нар энэ хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнээ зөв зүйтэй авч явах билээ энэ тэр гээд ингээд мянга яриад нэмэр болохгүй л байна л даа.

Тэгэхээр тодорхой хэмжээнд төрийн захиргааны байгууллагаас гаргаж байгаа Хөдөө аж ахуйн яамнаас гаргаж байгаа бодлогынхоо хүрээнд яг орон нутаг дээр яаж хөгжүүлэх гэдэг зүйл дээр нь тодорхой дэмжлэг үзүүлээд, хавсраад явах нь зүйтэй гэж хараад өнөөдөр энэ дэмжлэг гэдэг зүйлийг шууд болон шууд бус татаас гэж л байна. Тарифын болон тарифын бус зохицуулалт гэж байна. Хөнгөлөлттэй зээл гэж л байна. Сая бол жишээ нь, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнтэй холбоотойгоор Монгол Улсын Ерөнхийлөгчөөс авсан арга хэмжээ байгаа шүү дээ. Хүнсний хувьсгал гээд. Энэ хүнсний хувьсгал дээр тодорхой хэмжээний зээл, хөнгөлөлттэй зээлүүдийг олгосон. Маш олон үйлдвэрлэл бий болсон. Маш олон үйлдвэрлэлүүд өшөө үйлдвэрлэлийнхээ хүртээмжийг сайжруулаад, бүтээмжээ сайжруулаад, хөл дээрээ босох боломж бололцоо гарсан. Наад зах нь өндөгний үйлдвэрлэлийн асуудлаар гэхэд бол өндөгний компаниуд маань ер нь Монгол Улсынхаа өндгийг дотоодоосоо хангах ийм бүрэн боломж бололцоо хангагдаад явчхаж байгаа юм. Энэ мэтчилэн тодорхой дэмжлэг байхгүй бол ер нь явж өгөхгүй байгаа юм. Яг өнөөдрийн нөхцөл байдал. Тэгээд 1 бол хөл дээрээ босчихсон хойно бол тодорхой өөрсдөд нь бүх асуудлуудыг нь даалгаад ингээд явах нь зүйтэй байх л гэж харагдаж байна.

С.Бямбацогт: Энхтүвшин гишүүн тодруулъя.

Д.Энхтүвшин: Тийм яах вэ, дэмжлэг өгөөд өгөөд бас явж байна уу гэдэг бас тэрийг дооз донжийг нь тааруулах хэрэгцээ л байгаад байна л даа. Дэмжлэг гэхээр тэгээд зарим талаар бас яг юундаа хүрэхгүй байна л даа. Яг зорилгодоо нийцэхгүй, хүрэхгүй тиймэрхүү дүр зургууд харагдаад байгаа юм. Яах вэ, үүнээс гадна би түрүүн асуусан нөгөө бүс нутгаар гээд хязгаарлачихаар зарим газар жишээлбэл зарим үйл ажиллагааг эрхэлж болохгүй, эрхлэхийн тулд хөдөө аж ахуйн үйл ажиллагаа явуулж болохгүй юм шиг иймэрхүү агуулга уншигдаад байгаа. Энэ бодлогынхоо хүрээнд кластер гээд тавьчихаар энэ талаар нэмж мэдээлэл өгөөч.

С.Бямбацогт: Хэн хариулах вэ. Ажлын хэсэг хариулъя.

Ж.Бат-Эрдэнэ: Ер нь бол Монгол Улсын өргөн уудам нутаг дэвсгэртэй Монгол Улсын хувьд бүсчилсэн хөгжлийг бас тодорхой хэмжээнд нь хөдөө аж ахуйтайгаа уялдуулахгүй бол болохгүй л харагдаад байгаа юм л даа. Одоо жишээ нь Хангайн бүсэд ямаршуу хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн байх юм. Газар тариалан нь ямар байх юм. Жишээ нь, газар тариалантай холбоотой асуудлаар бол тэгээд л Төв аймаг хүссэн, хүсээгүй Төв аймаг, Булган, Хөвсгөлийн наад талаар, тэгээд Сэлэнгэ гээд энэ бүс нутагт л жишээ нь газар тариалангаа хөгжүүлэхээс өөр аргагүй болчихоод байна. Энэ газар тариалангаа түшиглээд мал аж ахуй, тэр тусмаа сүү сүүн бүтээгдэхүүнийг ч байдаг юм уу, эсвэл тэжээлийн ургамал ч байдаг юм уу ингээд жоохон бүсчлээд явахаас өөр аргагүй л харагдаад байгаа юм. Ер нь бол бодлогууд чинь бас ингэж гарч байгаа. Хөдөө аж ахуйн яамнаас гаргаж байгаа бодлогын хүрээнд ч гэсэн нэг иймэрхүү байдлаар явахаас өөр аргагүй харагдаж байгаа. Жишээ нь, говийн бүсийнхэн дээр сүүний чиглэлийн кластер хөгжүүлье гээд явж

байна лээ. Яалт ч үгүй тэнд нь нөгөө тэжээлийн ургамлынх нь дутагдал бий болчихоод байгаа юм.

С.Бямбацогт: Мандхай гишүүн нэмээд хариулчихъя.

М.Мандхай: Тэгэхээр энэ татаастай холбоотой асуудал дээр бол Энхтүвшин гишүүнтэй санал 1 байгаа. Тийм учраас энийг ер нь бид нар олон урамшуулал, татаас олгож ирэхдээ нийт татаасыг дандаа үйлдвэрийн орц, орцод зориулж татаас олгож ирсэн байгаа. Тийм учраас өнөөдөр олгож байгаа татаас, урамшуулал 2015 онд байсан 20 хувийн бүтээмж өнөөдөр 2024 он гэхэд 6 хувь болж буурсан байгаад байгаа юм. Тэгэхээр энийг бид нар 50 хувь орцонд нь буюу дандаа ингэж үйлдвэрлэлийг эхлэх эргэлтийн хөрөнгө, гарааны бизнест нь олгож ирээд, цаад талд нь гарч байгаа гарц буюу нэмүү өртөг шингэсэн, нөгөө чанарт суурилсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл, сайжруулалтад нь ерөөсөө хяналт тавьж тэнд нь үр дүнд нь түшиглэсэн татаас урамшууллыг олгож ирэхгүй байсантай бас шууд холбоотой байгаад байгаа юм. Тийм учраас хөдөө аж ахуйг бид нар үнэхээр л эдийн засгийн эргэлтэд орсон болгоё гэж хөгжүүлье гэвэл .../минут дуусав/

С.Бямбацогт: Байж байгаарай. Энхтүвшин гишүүн тодруулж асууя. Хариултаа гүйцээчихье. Мандхай гишүүн.

М.Мандхай: Тэгэхээр та бизнесийн салбарын хүн учраас маш сайн ойлгож байгаа. Бүтээмжийг сайжруулах ёстой, үр дүн гаргах ёстой. Тэгэхээр энийг сайжруулахын тулд бид нар илүү нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн гаргадаг чанарт суурилсан үнийн тоо, бүтээмжийг сайжруулсан эдгээр үр дүн гаргасан үйлдвэр бүтээгдэхүүнүүд дээр нь бид нар энэ урамшуулал, одоо олгогдож байгаа татаас шууд болон шууд бус татааснууд хөнгөлөлт, тариф болон тарифын бус хөнгөлөлт гээд олгогдож байгаа ангиллуудаа хуваарилдаг байя гээд ийм зохицуулалтыг энэ хуульдаа бас оруулж өгснөөрөө бас онцлог байгаа юм гэдгийг хэлье.

С.Бямбацогт: Энхтүвшин гишүүн тодруулж асууя.

Д.Энхтүвшин: Би түрүүн нөгөө Зөвшөөрлийн хуультай холбоотой Засгийн газрын хуралдааны тэмдэглэл дээр болохоор ер нь бол Зөвшөөрлийн тухай хуулиар Зөвшөөрлийн хууль болон хуулиар хориглоогүй үйл ажиллагааг Монгол Улсад чөлөөтэй эрхлэх тухай ийм агуулгатай хууль байгаа. Тэгээд энэнтэй нийцэхгүй байна гэдэг асуудлыг Засгийн газрын хуралдааны тэмдэглэл дээр биччихсэн байж. Би тэр талаар нь л илүү ажлын хэсгээс Бат-Эрдэнэ гишүүн тэр дээр илүү дэлгэрүүлж хариулж хэлбэл. Яамнаас хариулах юм уу.

С.Бямбацогт: Хууль хоорондын зөрчил байгаа юм биш үү гэж асуугаад байна. Ажлын хэсэг хариулъя. Индрээс бэлдэж байгаарай. Хөдөө аж ахуйн яам. Ер нь Хөдөө аж ахуйн юм хариулчихъя. Ажлын хэсгийн 4 дүгээр микрофон.

Ц.Мөнхнасан: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын шинжээч Мөнхнасан. Энхтүвшин гишүүний асуултад тодруулж хариулъя. Хөдөө аж ахуйн тухай хуулийн одоогийн өргөн барьсан хувилбар дээр Зөвшөөрлийн тухай хуультай зөрчилдөж байгаа, шинээр

зөвшөөрлийн чанартай болон бүртгэлийн чанартай ямар нэгэн агуулга, заалт байхгүй ээ. Тийм учраас Зөвшөөрлийн тухай хуультай зөрчилгүй байна гэж хэлье.

С.Бямбацогт: Засгийн газрын өргөн барьсан санал, дүгнэлт дээр тийм байсан юм байна. Тэр нь тэгвэл хууль санаачлагч бас санал, дүгнэлтийг нь үзээд, өргөн барихдаа засаад, нийцүүлээд оруулчихсан юм байна гэж ойлголоо. Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүн асуултаа асууя. Алга байна. Одонгийн Цогтгэрэл гишүүн асуултаа асууя. Алга байна. Өлзийхүүгийн Шижир гишүүн асуулт асууя. Алга байна. Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн асуултаа асууя. Алга байна. Цэвэгдоржийн Туваан гишүүн асуултаа асууя.

Ц.Туваан: Энэ анхдагч хуулийн төслийг бол дэмжиж байгаа. Тэгээд орон нутагт ард иргэдтэй уулзаад явахад ялангуяа энэ салбарт хамаарч байгаа энэ малчид хууль хэрэгжихгүй байна. Малчны тухай хууль гээд сайхан хууль гарсан. Тэгээд огт хэрэгжихгүй байгаа тухай маш их зүйл ярьж байна. Тэгэхээр энэ шиг энэ хууль маань хэрэгждэггүй хуулийн тоог нэгээр нэмчих вий дээ гэж бас ингээд санаа зовж байна. Тийм учраас бас хэлэлцүүлгийн шатанд нь сайжруулаад, илүү амьдрал руу ойртуулаад батлаад явсан нь зөв байх гэж ингэж бодож байна.

Урамшуулалтай холбоотой асуудал дээр бол яах вэ, нэг их ноцтой юм алга. Тэгэхдээ хөдөө аж ахуйн салбар дэлхий дээр урамшуулалгүй явна гэж байхгүй. Ялангуяа манайд бол байхгүй. Хүн хоол, өмсөх хувцсаа бэлдэх зүйл рүүгээ дэмжиж, хангамжийг нь нэмэгдүүлэх, нийлүүлэлтийг нь нэмэгдүүлэхэд урамшуулалгүй явна гэж бол байхгүй. Тэгэхээр энэ дотор 1 заалт байна л даа. Энэ чанартай холбогдуулж урамшууллын асуудлыг нь авч үзнэ гээд. Энийг чинь далимдуулаад Засгийн газар наад хөдөө аж ахуйн салбарын бэлтгэж байгаа бүтээгдэхүүн юмыг чинь чанаргүй байна гэж хэлээд, урамшууллыг нь хасчихна шүү. Тэгэхээр нөгөө жоохон дэмжлэг болоод явж байсан зүйлээ арай жоохон тогтоод ирж байсан зүйлдээ бас хор хөнөөл учруулчих ийм зүйл болох вий гэж ингэж санаа зовж байна.

2 дугаарт нь энэ хөдөө аж ахуйн салбар, ялангуяа энэ мал аж ахуйн салбар дээр чинь залуу малчин гэж байхгүй болчихсон шүү дээ. Хэн мал дээр байна гээч хэдхэн бараг тэтгэврийн насны, насанд хүрч байгаа ийм л хүмүүс мал дээр байна. Залуу малчин байхгүй. Байгаа хэд нь гэр бүл байхгүй, ганц бие. Тэгээд л ерөөсөө гэр бүлтэй хэсгүүд нь нөгөө хүүхдүүдээ дагаад орчихдог. Ингээд энэ асуудал дээр бол нэлээн яах вэ, Малчны хуулиар зохицуулна гээд л ерөнхий ингээд тавиад орхичихсон байна. Нөгөө малчны хууль чинь хэрэгжихгүй байгаа шүү. Бусад тэр агрономи, малын эмч, малын зоо техник бүгдээрээ тэтгэврийн нас даваад явцгаачихсан. Дундаж наслалт нь. Энэ талаар ерөөсөө тийм бодитой оруулсан зүйл энэ Хөдөө аж ахуйн хууль дээр алга.

Сая бас ажлын хэсгийн ахлагч хэлж байна. Энэ хөдөө орон нутаг, суман дээр шүү дээ энэ түүхий эд бэлтгэлийн энд хууль дээр биччихсэн байгаа энэ тогтолцоонуудтай холбоотой 1 ч газар байхгүй. Склад байгуулаад, анхан шатны түүхий эдийн арчилгаа, тордлогоо хийгээд, давслаад ингээд чанар хангадаг байгууллага байхгүй. Муу хэлэгддэг нөгөө хэдэн ченжүүд чинь авсан болоод, үнэтэй, үнэгүй авсан болоод ингээд л явж байгаа. Тэгэхээр энэ чанартай холбогдуулан худалдан авалтыг хийнэ гэххэж байгаа юм. Чанартай түүхий эдээ ч бид нар авч чадахгүй байгаа. Яагаад гэхээр энэ хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг боловсруулах, түүхий эдийн үйлдвэр, арьс ширний үйлдвэр гээд

ярихаар улс төржөөд авторынх нь эсрэг улс төржиж байгаад унагаагаад явуулчихдаг. Үүний тод жишээ Дарханы арьс ширний цогцолбор. Тэрийг зогсоочихсон. Тэр болохгүй байгаа юм болов уу гээд харахаар хажуу талд нь жоохон газар аваад, дахиад шинээр үүсгээд явж байгаа байхгүй юу. Тэгээд одоо бүр сүүлдээ болиод Эмээлтийн гээд. Тэгээд би Эмээлтийг нь очиж бас харах гээд явсан. 1 л том хашаа, 1 байшин л байна лээ. Тэгэхээр энэ хууль ингээд амьдралгүй, энэ яг бодитой асуудал руугаа хандахгүй хууль болчих вий дээ гэж ингэж санаа зовж байна.

Тэгээд энэ хууль дотор хөдөө аж ахуйн төрлүүдээ ингээд ангилсан байна л даа. Энэ дээр бид нар хуучин туслах аж ахуй гэж нэрлэдэг байсан. Гахай, зөгий, тахианы аж ахуйнууд ер нь яг хаана нь орж байгаа вэ. Энэ төрлийн бодлогууд ер нь ямар байдлаар явж байгаа вэ.

С.Бямбацогт: Хариултын дараа юу. Ажлын хэсэг хариулъя. Бат-Эрдэнэ гишүүн.

Ж.Бат-Эрдэнэ: Хөдөө аж ахуйн асуудлаар нэлээн бас анхаарал хандуулан ажилладаг гишүүн Туваан гишүүн байгаа. Тэгээд бид бүхэн тэр тусмаа орон нутгаас сонгогдсон гишүүдийн хувьд бол энэ хөдөө аж ахуйг яаж хөгжүүлэх асуудал бол тэртээ тэргүй бид бүгдийг нь мэдээд байгаа байхгүй юу. Нэг ийм байвал болчих юм гээд хараад байгаа байхгүй юу даа. Мэдээд байгаа, мэдээд байгаа. Гэтэл яг энэ чинь орон нутагтайгаа яаж уялдах юм. Аж ахуй нэгжүүдтэйгээ яаж уялдах юм. Малчидтайгаа яаж уялдах юм гээд энэ дээрээ зохицуулсан тодорхой зохицуулалтаа бид нар бас цаасан дээр буулгахгүй бол болохгүй байгаад байгаа юм. Тэр утгаараа бол хөдөө аж ахуйн тухай хууль гээд л ямар ч л байсан цаасан дээр хэдүүлээ ингээд томьёолоод буулгачихъя гэдэг утгаар гаргаж байгаа юм.

Хэрэгжихгүй хууль байж магадгүй, болчхож магадгүй гэж бас санаа зовоод. Үнэндээ бол яг энэ өнцгөөс нь бол миний хувьд бас харсан. Жишээ нь тэр чанартай холбоотой асуудал, одоо хөдөө аж ахуйн дэмжлэг үзүүлэх үйлдвэрлэлийн сүлжээний дараах шаардлагыг хангасан байна гээд баахан шаардлагууд тавьчихаад байгаа. Магадгүй энэ шаардлага нь хангаагүй гээд хэн нэгэн албан тушаалтан хүнд суртал гаргаад явчих вий гэдэг өнцгөөс нь зөндөө харсан. Тэгээд л хэрвээ энийг нь бариад ингээд болохгүй юм байна, чанаргүй байвал дэмжлэг өгөхгүй юм байна эд нар гээд хасаад байвал ерөөсөө дэмжлэгийн тэр шаардлага маань 1 дүгээрт байхгүй болчих гээд байна.

2 дугаарт энэ шаардлагууд тодорхой хэмжээнд байж байж хөдөө аж ахуйд тодорхой хэмжээний бидний төсөөлөөд байгаа, бидний хүсээд байгаа тэр хэмжээнд нь бас цаашдаа, өнөөдөр энэ боломж бололцоо нээгдэхгүй ч гэсэн цаашдаа бол энэ боломж бололцоо нээгдээд явах ёстой юм гэдэг өнцгөөр нь энэ шаардлагуудыг бас гаргачхаж байгаа юм. Гагцхүү хэдүүлээ бас хяналт тавьж байх хэрэгтэй. Тэр утгаар нь хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага буюу Хөдөө аж ахуйн яамны энэ бодлогыг аймаг орон нутагт хүртэл нь нийтэд нь бүхэлд нь зангидна гэсэн бас үг үсэг энэ дотор нь оруулсан юм. Хяналтаа тавьдаг байя. Тэгэхгүй энд Идэрбат гээд 1 сайд яриад л байдаг, яриад л байдаг. Яг орон нутагт хэрэгждэг юм байхгүй. Түрүүний таны хэлсэнчлэн, миний хэлсэнчлэн сум дээр нөгөө нэг хэдэн ченжүүд чинь л ажиллаад л байдаг. Өөр ямар ч боломж бололцоо байхгүй.

Нөгөө техник технологи, нау хау, юу байдаг юм тэр чинь ерөөсөө орох боломжгүй болчихоод байна.

Залуу малчны хувьд үнэндээ залуу малчингүй болчих гээд байгаа шүү дээ. Тэгээд манайхан бол мал морийг нь уяж байвал тэнд нэг уягдаад байгаа юм шиг хэдэн залуу торгоогоод байгаа юм шиг л юм яриад байх юм. Энэ нэг өнцөг нь. Гэхдээ хамгийн гол нь энэ хөдөө аж ахуй чинь өөрөө ашигтай байж байж, хөдөө аж ахуй эрхлээд, мал аж ахуй эрхлээд, газар тариалан эрхлээд хүн амьдрах боломж бололцоотой байх, төдий хэмжээний орлого олдог болсон тохиолдолд тэнд залуу малчин бий болно шүү дээ. Энэ өнцгөөс нь л хэдүүлээ харах хэрэгтэй. Тэгэхийн тулд хөдөө аж ахуйгаа хөгжүүлэх, хөдөө аж ахуйгаас орлого олдог, мал аж ахуйгаасаа орлого олдог болох боломжийг нь хэдүүлээ л хайхгүй бол тэнд бас хүн тогтохгүй.

С.Бямбацогт: Хууль санаачлагч нэмж хариулъя.

М.Мандхай: Тэгэхээр Туваан гишүүний бас асуултад нэмээд хариулахад энэ хуулийн 12 дугаар зүйлд тогтвортой хөдөө аж ахуйн төлөвлөлт гэж орсон байгаа. Өнөөдөр манайд урт хугацааны бодлогын баримт бичиг буюу Алсын хараа 2050-д тогтвортой хөдөө аж ахуйг хөгжүүлнэ гэсэн зорилт бол дэвшүүлсэн байдаг. Тэгэхээр бид нар энэ зорилттой бас уялдуулж, энэ хөдөө аж ахуйн урт хугацааны бас хөгжлийг тодорхойлох зүйтэй. Тэгээд энд 12.2 дээр Хөдөө аж ахуйн хөгжлийн зорилтот хөтөлбөртэй байна гэдгийн ажлын хэсэг бол хуралдаад, яг энэ залуу малчин, малчдын залгамж халаа, нийгмийн асуудлыг ерөөсөө бид нар энэ хуульдаа тусгаж өгөхгүй бол болохгүй юм байна гээд хөгжлийн зорилтот хөтөлбөртөө энэ 12.2.6 дээр “Хөдөө аж ахуйн үйлдвэр хуулийг ашигтай эрхлэх зах зээлийн болон нийгмийн таатай орчин бүрдүүлнэ.” гэж бүр оруулж өгсөн байгаад байгаа юм. Энэ дээр бол бид нар ер нь зорилтот хөтөлбөртэй энэ залуу малчны залгамж халааг яаж урт хугацаанд авч явах вэ гэдгийг зорилтот .../минут дуусав/

С.Бямбацогт: Боломжгүй. Нэмж тодруулъя.

Ц.Туваан: Тэр туслах аж ахуй хаана орсон бэ гэдэг дээр хариулт авъя. Би та хэдэд ганцхан жишээ хэлчихье. Энэ туслах буюу энэ хөдөө аж ахуйн нэг салбар чинь маш хүнд цохилтод орсон. Ялангуяа энэ зөгийн аж ахуй. Сэлэнгэ аймгийн Шаамар сумд 100 бүл өвөлжөөнд хийсэн айл хоёрхон бүлтэй үлдсэн. 98 хувийн хорогдолтой. 50 бүл хийсэн, өвөлжүүлсэн айл юу ч үгүй, 1 ч бүл зөгийгүй болж хувирсан ийм өвчин гараад, ийм болсон. Тэгэхээр энэ энэ дээр тухайн айлын эрхэлж байгаа хүмүүсийн орлого энэ хэвээрээ бүр байхгүй болж байгаа. Энэ дээр энэ тэр гээд бодлого хэрэгтэй байгаа юм. Тэгэхээр энэ дээр хариулт авъя.

2 дугаарт энэ хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэ баталсан орон тоонд нь багтаан ингээд юуг батална ч билээ, нөгөө төлөвлөгөө билүү юу батална гээд ингээд 1 л захиргааны шинжтэй, нөгөө шүүмжлээд байгаа юм руугаа л орчихоод .../минут дуусав/

С.Бямбацогт: Хууль санаачлагч хариулъя. Мандхай гишүүн.

М.Мандхай: Мэдээж уламжлалт хөдөө аж ахуй бол явж байгаа. Малчид маань өөрийнхөө бас яг малаа борлуулаад, тодорхой хэмжээнд нөгөө ченжүүдэд малаа зараад, борлуулаад явж байгаа. Энэ өөрөө уламжлалт арга барил бол хэвээрээ

байгаа. Бид нар энийг Хөдөө аж ахуйн хуулиараа энэ эдийн засгийн эргэлтэд оруулж илүү боловсронгуй болгохоор ажиллаж байгаа. Тэгээд таны хэлж байгаа заалт бол энэ 4.1.6 дээр тодорхой оруулсан байгаа. Энэ хүнсний болон аж үйлдвэрийн зориулалтаар ургамал, мал, тэжээвэр амьтны аж ахуйгаас үйлдвэрлэсэн түүхий эд, бүтээгдэхүүнийг гэж тодорхой зааж оруулж өгсөн. Энэ дээр таны хэлж байгаа тахиа, шувуу, зөгийн аж ахуй бас энд хамаарч байгаа юм шүү гэдгийг бас тодорхой хэлье.

Тэгээд яамнаас болохоор энэ сая удирдлага зохион байгуулалттай холбоотой яг асуултаа тодруулаад өгчихвөл яамнаас бас энэ дээр хариулаад өгөөрэй.

С.Бямбацогт: Сүхбаатар Эрдэнэбат гишүүн асуултаа асууя.

С.Эрдэнэбат: Манай эдийн засгийн суурь салбар маань хөдөө аж ахуйн салбар. Тэгээд бид нар харамсалтай нь бас хөдөө аж ахуйн бас суурь салбараа хүний нөөцийнх нь бараг 30 орчим хувь ажиллах хүч шингээдэг ийм чухал салбар. Тийм учраас би энэ Хөдөө аж ахуйн хуулийг бол дэмжиж байгаа. Маш олон асуудлыг нэгдэж нийлж байж энэ хөдөө малчны тухай асуудлыг бол ярих хэрэгтэй юм байна лээ. Энэ дээр боловсролын асуудал орж ирнэ. Хүүхдийнх нь боловсролын асуудал, эрүүл мэндийн үйлчилгээний асуудал. Нөгөө залуу малчдыг чинь тогтоож барихад тэнд дэд бүтцийн асуудал, эмнэлэг үйлчилгээний асуудал, зах зээлийн асуудал гээд. Сая бид нар ганцхан махны асуудал дээр гэхэд л нэлээн том цохилт авлаа. Яг ингээд аваад үзэхээр малчид маань нэг их айхтар махыг үнэтэй зараад, ингээд л ашиг олоод байгаа юм ерөөсөө байхгүй юм байна лээ. Аль хэдийн намар 11 сард бол махаа 10 гаруй мянган төгрөгөөр аваачаад өгчихсөн. Тэгэхээр ченж гэдэг энэ тогтолцоог бол бид нар олон жил ярилаа.

Тэгэхээр ер нь яг энэ өөрийн чинь хууль дээр харж байхад саплай чэн буюу нийлүүлэлтийн тэр гинжин хэлхээсийг нь найдвартай, тодорхой, хэрэглэгчтэй нь шууд холбох гэдэг энэ замыг богиносгох энэ юмыг л хийж өгөх маш чухал байна. Түрүүн бас Бат-Эрдэнэ дарга хэллээ. Яг одоо бодлого юм нь байгаад байдаг. Тэнд хөдөө нь яг хийж хэрэгжүүлэх хүн байхгүй болчихоод байна гэж. Тухайлбал, зарим газар бол ирэх намар идшээ авах айлуудыг ийм насны, ийм үхрийг ийм тариагаар хийгээд бэлдэж байна. Тийм учраас бид нар энийг чинь идшинд нь гаргаад, хайрцаглаад, баглаад сав болгоод ингээд явна гэж. Тэгэхээр сумын төвүүд дээр гэдэг юм уу, махны жижиг хөөрхөн тийм цехүүдийг бий болгоод, тэрийг нь манай монголчуудын онлайн шопинг гэдэг шиг тийм юм руу л оруулмаар байгаа юм. Бид нар чинь хаа байсан Хятадаас янз бүрийн аппликэйшнээр дамжуулаад, бараа аваад 7 хоногийн дотор хүрч ирээд байдаг. Дотоодынхоо ийм зүйлийг бид бүхэн ингээд хийх тал дээр яг энэ хууль дээр яаж тусгасан зүйлүүд байгаа вэ гэдгийг 1 дүгээрт асуумаар байна.

Залуу малчин байхгүй болно гэдэг асуудал дээр бол яах аргагүй хүн ам зүйн бодлогын асуудлыг давхар оруулж ирэх ёстой байх. Суман дээр залуу хүмүүс очоод бий болгоход орон сууцын асуудал их чухал байна. Тэгэхээр энэ сум, хөдөө орон нутагт тэр орон сууцынх нь асуудлыг шийдэх энэ асуудал бас нэлээдгүй удаашралтай байгаад байна. Аргаа бараад энэ жилийн төсөв дээр шинэ боловсон хүчний байр гээд нэг ийм аж ахуйн аргаар барих хэмжээний 4 айлын орон сууцыг бариад, тэнд нь боловсон хүчин байртай байвал үлдэнэ гээд байгаа. Тийм учраас энэ дээр Мандхай гишүүнээс асуухад энэ хууль дээр яг энэ нийлүүлэлтийн хэлэхээс

тэр түүхий эдээ нөөцлөх, тээвэр нь үр ашигтай байх ёстой. Хүн болгон нэг портер дээрээ махаа тавиад, аймгийн төв рүү явах, эсвэл шууд ченжийн гар дээр л очиж унаж байна л даа. Тийм учраас энийг яг яаж нарийн зохицуулсан ийм хуулийн зохицуулалтыг хууль дээрээ тусгаж өгсөн бэ гэдгийг асуумаар байна.

С.Бямбацогт: Ажлын хэсэг хариулъя. Бат-Эрдэнэ гишүүн.

Ж.Бат-Эрдэнэ: 8 дугаар зүйл дээр хөдөө аж ахуйн түүхий эд, бүтээгдэхүүнийг бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоо гээд хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг төвлөрүүлэх, хадгалах, чанар хамгаалалт хийх, худалдан борлуулах төвийг аймаг, сумд байгуулъя гэсэн ийм байдлаар орж ирж байгаа. Тэгээд энэ төв нь санхүүжилтийг нь улсын болоод аймаг, сумын төсөв, дээрээс нь хувийн хэвшлийн санхүүжилтээр гээд ингээд шийдэхээр ингээд заагаад өгсөн юм.

Тэгэхээр энэ түүхий эд бүтээгдэхүүнийг малчны гар дээрээс авхуулаад ингээд явсаар байгаад боловсруулагдаад, үйлдвэрлэлийн сүлжээгээр ороод, тэгээд хэрэглэгч дээр очих хүртэл тогтолцоог л ер нь тодорхойлж өгөөд байгаа юм л даа. Тэгээд ямар ч байсан энэ тогтолцоогоо тодорхойлоод өгчихье. Тэгээд энэ дээр цаашаа хяналт тавих нь бол Хөдөө аж ахуйн яам болоод аймаг, орон нутаг өөрсдөө энэ хөдөө аж ахуйн бодлого гаргаж, бодлогынхоо дагуу. Сая эндээс хэллээ. Хөдөө аж ахуйн бодлого аль дивангарт гарчихсан байгаа гээд. Гарчихсан бодлого чинь өөрөө хэрэгжихгүй энэ цаасан дээр буугаагүй, хэн хянах нь, хэн хэрэгжүүлэх нь тодорхой, бүр 1 нэгнийхээ араас хөөдөг энэ тогтолцоо л байхгүй болчихоод байна шүү дээ. Тэгээд хэн санаачилгатай, сум, аймаг, орон нутгийн Засаг дарга нь аваад хэрэгжүүлээд явдаг, хэн санаачилгагүй нь хаячхаад, өөр боловсрол энэ тэр, эрүүл мэнд гэдэг ч юм уу өөр салбарыг анхаараад явчихдаг ингээд хаячхаад байгаа юм. Тэгэхээр энэ өнцгөөс нь бас хараад байгаа юм.

2 дугаарт залуу малчинтай холбоотой асуудлуудыг та бас ярилаа. Мэдээж боловсон хүчний асуудал бол нэлээн хүнд болчихоод байна. Тэгээд би олон зүйлийг л харж үзсэн. Мэдээж байртай, савтай болох асуудал нь 1 асуудал. Нийгмийн асуудлыг хангах асуудал 2 дахь асуудал. Хүүхдийнх нь боловсролтой холбоотой энэ Малчны тухай хуульд заасан заалтуудыг хэрэгжүүлэх гээд 2 дахь асуудал. Нийгмийн даатгалтай холбоотой асуудлуудыг нь шийдэх гээд 3 дахь асуудал. Гэхдээ эцсийн эцэст энэ мал аж ахуй, энэ газар тариалан, энэ хөдөө аж ахуй өөрөө санхүүжигдээд явдаг, өөрөө ашигтай байх, орлоготой болдог байх. Энийг эрхэлж байгаа иргэн, энийг эрхэлж байгаа аж ахуйн нэгж хөл дээрээ босдог, орлоготой, бидний хүсээд байдаг нөгөө дундаж давхарга руу орох ийм боломж бололцоотой аж ахуй байж байж л энэ өөрөө залуу малчдаа татна л даа.

Түүнээс биш бас нөгөө социализмын үе шиг бүгдийг нь сайхан сургаад бүгдийг нь надад зарим малчид санаачилга гаргаж л байдаг юм. Сайхан сургаад бэлдээд өгөөч гээд. Үгүй ээ, бэлдэж өгөөд тэд нар чинь тэгээд л боломж бололцоо нь байхгүй бол тэгээд л тэр сургалтын чинь ар дээр Улаанбаатар луугаа нүүгээд л явчихна шүү дээ. Тийм болохоор энэ хуулийн зорилго бол ерөөсөө энэ үйлдвэрлэлийн сүлжээ бий болгох, кластерыг бий болгох, тэгээд бас тодорхой чанарын түвшин дээр үйлдвэрлэл ажилладаг байх, ингээд орлоготой болдог байх, амьжиргааг авч явдаг ийм аж ахуй байх, ийм хөдөө аж ахуй байх гэсэн суурийг л гаргаж ирж байгаа. Гаргаж ирэх ёстой юм. Зорилго нь бол.

С.Бямбацогт: Батбаярын Жаргалан гишүүн асуултаа асууя.

Б.Жаргалан: Монгол Улс бол Хөдөө аж ахуйн улс орон, мал аж ахуйн улс орон. Тиймээс өнгөрсөн он жилүүдэд хэдэн зуунаараа, хэдэн мянганаараа бид нар бол энэ хөдөө аж ахуйн салбараа, мал аж ахуйн салбараа бол ингээд л хөгжүүлсээр л ирсэн. Нөгөө социализмын үед ч гэсэндээ мал маллахаа марксизмаар заалгахгүй гэдэг шиг элдэв янзын гоё нэртэй хуульгүйгээр бол бид нар энэ салбар оршин тогтносоор л ирсэн. Тэгээд Хөдөө аж ахуйн тухай хууль гээд ийм том салбарыг хамарсан ийм амбицтай нэртэй ийм хууль ороод ирчихсэн, одоо анхны хэлэлцүүлэг нь хийгдэж байгаа. Тэгээд хамгийн гол нь энэ нөгөө хуулийн төслийг ингээд бүхэлд нь харахаар ерөнхийдөө бас л ийм лоозонгийн шинж чанартай л болчихоод байгаа юм.

Тэгээд 1 дүгээрт нь гэх юм бол би бас үзэл баримтлалыг дэмжих эсэх хэлэлцүүлэг дээр бас хэлж л байсан. Энэ хөдөө аж ахуй, аж үйлдвэрлэлийн дэмжлэг гэдэг нэрийдлээр ингээд татааснуудыг татаас өгнө гээд хуульчилчихаж байгаа юм. Тэгээд хамгийн гол нь ингэж хуульчлахдаа өмнө нь өнгөрсөн 30 хэдэн жилийн хугацаанд олгосон, нэн ялангуяа сүүлийн 5, 10 жилийн хугацаанд олгосон МАН-ын эрх баригчдын, том дарга нарын санаачилсан энэ гоё гоё нэртэй төсөл хөтөлбөрүүдийн үр дүн ямар байсан бэ. Тэр дээр бид нар бас ийм бодит дүн шинжилгээ хийж байгаа юм уу. Яг үндсэн тэр нөгөө кластераараа хөгжүүлэх тэр зорилтууддаа энэ хөтөлбөрүүд чинь очсон юм уу. Яг малчдадаа ч юм уу, тариаланчдад яг тэр бодит зорилтот бүлгүүд дээрээ очиж байгаа юм уу. Эсвэл яг ийм улс төрийн лоозонгийн шинж чанартай улс төрийн санал худалдаж авах шинж чанартай ийм хөтөлбөрүүд болоод дуусчхав уу гэдэг асуудал дээр бас асуулт асууж л байсан.

Тэгээд яг үнэндээ энэ хуулийн төслийн танилцуулга юмыг нь харахаар өнгөрсөн хугацааны энэ баахан олгосон татаас, энэ хөтөлбөрүүд дээр бол дүн шинжилгээ хийсэн зүйл харагдахгүй байгаад байгаа юм. Тэгэхээр энэ асуудлаа яг хууль санаачлагч юу гэж харж байгаа юм бэ гэж асуумаар байна.

2 дугаарт нь энэ хүний нөөцийн асуудлыг бол гишүүд зөндөө ярилаа. Тэгээд энэ хуулийн төслийн 14 дүгээр зүйл.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хүний нөөц гээд энэ сургалт судалгаатай холбоотой асуудал ороод ирчихсэн байж байна. Гэлээ гэхдээ бас л яг ийм нөгөө бодит амьдрал дээр хэрхэн яаж хэрэгжих нь ойлгомжгүй. Энэ малчдын асуудлыг бол Малчны тухай хууль гээд хэрэгжихгүй байгаад байгаа учраас бид нар Их Хурал дээр сонсгол хийх гээд сууж байна шүү дээ. Тийш нь чихчихсэн. Тэгээд үнэндээ бол манай хөдөө аж ахуйн салбарт, мал аж ахуйн салбарт бид нар инновац хийе гэж зорьж байгаа бол, бүтээмжийг нэмэгдүүлье гэж зорьж байгаа бол энэ сургалт, судалгааныхаа асуудалд маш их анхаарал хандуулах ёстой байгаа юм. Гэтэл яг ийм бодит яг ямар арга, хэлбэрээр хүний нөөцөө бэлдэх юм, мэргэжлийн ажилтнуудаа бэлдэх юм гэдэг дээр бас нэг яг нэг тодорхой схем харагдахгүй байгаад байна. Тэгэхээр тэр схемээ яг юу гэж харж байгаа юм бэ гэдгийг бас асууя.

3 дугаарт нь бол манай мал аж ахуйн салбарын хамгийн тулгамдсан асуудал бол энэ малын халдварт өвчин байгаа. Одоо гэхэд л баруун аймгуудад шүлхий гарчихсан. Бас ийм асуудал үүсчихсэн л байж байгаа. Тэгэхээр яг энэ хуулийн төсөл дээр энэ малын халдварт өвчин, гоц халдварт өвчинтэй бас хэрхэн яаж тэмцэх юм.

Төрийн хамгийн сайн хийж чадах зүйл бол энэ байхгүй юу. Улсын хэмжээнд бас тэр вакцины асуудлыг шийдэх, энэ халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх нөхцөл байдлуудыг хангах зүйлийг бол төр зайлшгүй хийх ёстой байгаад байгаа шүү дээ. Гэтэл энэ асуу асуудал бас энэ хуулийн төсөлд хэрхэн яаж орж ирж байгаа нь бас тодорхойгүй байна. Бид нар энэ халдварт өвчний асуудлаа шийдээд, үндэсний хэмжээнд энэ вакциныхаа асуудлыг шийдэх юм бол цаашлаад экспортод гаргах, энд тэндхийн эрүүл ахуйн шаардлагуудыг хангасан манай бэлчээрийн мал аж ахуйн бүтээгдэхүүн чинь бол хамгийн сайхан органик ийм бүтээгдэхүүн байгаа. Тэгэхээр яг л нөгөө малчдын орлогыг нэмэгдүүлэх, тариаланчдын орлогыг нэмэгдүүлэх зүйл чинь бол энэ байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ асуудал дээр бас энэ хуулийн төсөлд ямар зүйл тусгагдсан байгаа вэ? Ер нь цаашид энэ асуудлыг яаж харж байгаа вэ гэдэг асуулт байна. Тэгээд тодруулъя.

С.Бямбацогт: Хассуурийн Ганхуяг гишүүн асуултаа асууя. Алга байна. Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн алга байна. Одоо хариулъя. Ажлын хэсэг хариулъя. Бат-Эрдэнэ гишүүн.

Ж.Бат-Эрдэнэ: Халдварт өвчинтэй холбоотой асуудлаас нь эхэлчихье. Одоо баруун талд нөгөө сат 1 гээд бүр цоо шинэ өвчин гарчхаад байна шүү дээ. Тэгээд би 1 бус удаа хэлж байсан. Та бүхэн маань бас дэмжих л хэрэгтэй, дэмжээч ээ л гэж хүсэж байна. Энэ малын халдварт өвчинтэй дайн зарлахгүй бол болохгүй. Дайн зарлахгүй бол болохгүй. Та бүгд энэ дээр санал 1 байх шиг байна. Бид ингэж байж гадаад экспортоо нэмэгдүүлнэ. Ингэж байж дотооддоо ядаж өөрсдөө эрүүл байна. Бид эрүүл л байх гээд эрүүл хүнстэй л байна гэж байгаа. Үүний чинь эх үүсвэр нь малд байж байна, махандаа байж байна. Тийм болохоор ерөөсөө дайн зарлахгүй бол болохгүй. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль гэдэг хуулиараа зохицуулагдаж байгаа. Тийм болохоор яг энэ хууль дотор эрүүл мэндтэй холбоотой асуудал бол яг нэг бүрчлэн заагдаагүй. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль гэдэг бол маш сайн хууль болсон. Ер нь тэгээд ер нь экспорт руу чиглэсэн маягийн ийм хууль болсон шүү. Тэгэхээр бид нар энэ хуулийг бас хэрэгжүүлэх хэрэгтэй.

2 дугаарт энэ лоозонгийн шинж чанартай гээд яах вэ бас тодорхой хэмжээний ийм зүйл байгаа. Энийг бол хүлээн зөвшөөрөхөд. Бид өөрсдөө нөгөө мал аж ахуйгаа мэддэг, хөдөө аж ахуйгаа мэддэг гэж ингээд бодоод байдаг. Одоо мал маллахаа социализмаар коммунизмаар заалгахгүй гээд бид нар чинь аль дивангараа л ярьдаг ийм үгтэй шүү дээ. Өөрсдөө болохоор мэдээд байдаг. Гэтэл яг өнөөдөр цаасан дээр буулгаад техник технологи, нау хау, технологи, тэр үйлдвэрлэлийн сүлжээ бүх юмыг нь ингээд яг буулгаад тэрийг нь хэн хэрэгжүүлээд, араас нь хөөгөөд бид нар гадаадад гарахаараа 1 сайхан хөдөө аж ахуй хараад л, 1 сайхан гоё кластер хараад л ийм л болгомоор байна. Гэхдээ манайх чинь нөгөө жишээ нь мал аж ахуй дээр бэлчээрийн мал аж ахуйгаа хослуулаад ч юм уу ингээд явах ёстой гэж хараад байдаг. Тэрийгээ яг нэг бүрчлэн ингээд араас нь хөөгөөд явах юм байхгүй болчихоод байгаа болохоор энэ хуулийг ямар ч байсан хэдүүлээ ингээд батлаад гаргачихъя. Энэ дотор бас нэлээн зүйлүүдийг оруулсан.

Дээрээс нь сая эндээс Баттулга гишүүн хэлж байна. Хөдөө аж ахуйн бодлого гарчихсан. Үгүй ээ, тэгээд яг энэ хөдөө аж ахуйн бодлогыг чинь хэн хэрэгжүүлэх гээд байгаа юм бэ. Ийм юм дутагдаад байгаа байхгүй юу. Би түрүүн хэлсэн шүү дээ. Тэндээс Идэрбат сайд маш сайхан бодлого яриад л байдаг. Тэрийг сонсож байгаа амьтан 1 ч байхгүй. Тэр доор хөдөө аж ахуйн асуудлаа хариуцсан тасгийн 3 хүн

байж байдаг. Суман дээр нөгөөдүүл чинь тэгээд хог цэвэрлээд л, нохой алаад л гүйж байгаа шүү дээ. Ямар ч бодлого хэрэгжүүлэх юм байхгүй. Тэндээс дээрээс гарч байгаа бодлого байхгүй.

Тийм болохоор би энэ хууль дээр 1 зүйлийг оруулж ирэх гээд бас ажлын хэсгийнхэн маань зөвшөөрөөгүй. Босоо удирдлагатай болмоор байгаа байхгүй юу. Тэгж байж тэр дээрээс гарсан бодлого, тэр дивангарын гарсан хөдөө аж ахуйн бодлогын чинь алхам тутамд нь чихийг нь мушгиж байж хэрэгждэг ийм систем рүү л ормоор байгаад байгаа юм. Тийм болохоор ямар ч л байсан энэ дээр лоозонгийн хэлбэртэй гэх маягтай араас нь хөөх ийм хэд хэдэн юмнууд орсон. Тэгээд энэ төсөл хөтөлбөрүүд дээр нэг зүйлийг ярихад “Шинэ хоршоо” гэдэг хөтөлбөрийг нэлээн шүүмжлэлтэй байгаа шүү. Гэтэл “Шинэ хоршоо” хөтөлбөр бол буцаад эргэн төлөгдөх нь хамгийн сайн төлөгдөж байгаа. 98 хувьтай гэсэн байх шүү. Дээрээс нь үүний үр нөлөө бол бас малчдад тодорхой хэмжээгээр очсон. Ямар ч байсан бөгж, машин болгоод л аваачаад л.../минут дуусав/

С.Бямбацогт: Мандхай гишүүн нэмж хариулъя.

М.Мандхай: Хөдөө аж ахуйн ер нь яах вэ дахиад нэг хууль гэж бас гишүүний зүгээс харж байх шиг байна. Өнөөдөр манай хөдөө аж ахуйн салбарт салбар хуулиуд буюу бараг 27, 28 хууль хэрэгжиж байгаа. Тус тусдаа. Ингээд энэ хуулиуд маань өөр өөрийнхөө салбар бүрдээ бол хөгжөөд явж байгаа. Гагцхүү яг ингээд хөдөө аж ахуй гэдэг ийм том малгай яг энэ салбар түвшинд нь өөрөө уялдаа холбоотой хэрэгжиж чадаж байна уу гэхээр учир дутагдалтай байгаа юм. Тийм учраас энийг бид нар хөдөө аж ахуйг илүү яг хөдөө аж ахуйг эдийн засгийн хөдөлгөх хүч болгож хөгжүүлэхийн тулд бид нар яах ч арга байхгүй ийм суурь зарчмын энэ хуулийг оруулахаас өөр арга байхгүй болчхоод байгаа юм. Тэгэхгүй бол дур зоргоороо өөрийн гэсэн стандарт, техникийн зохицуулалт, тодорхой ийм арга барилаараа явж ирсэн учраас өнөөдөр сүүлийн 30 жил таны хэлдгээр нөгөө 1 олгоод байгаа урамшуулал татаас өөрөө үр дүнгүй байна гэдэг асуудал хөндөгдөж байгаа юм. Тэгээд энэ улс орнуудыг харах .../минут дуусав/

С.Бямбацогт: Жаргалан гишүүн тодруулъя.

Б.Жаргалан: Тэгэхээр хууль санаачлагчдын зорилгыг бол ойлгож байна. Хөдөө аж ахуйн салбарынхаа олон салангид хуулиудыг бас нэг дор нэгтгээд, ийм малгай хууль санаачлаад явж байгааг бол ойлгож байна. Тэгэхээр 1 ийм бас зарчмын санал байна л даа. Тэр хэлээд байгаа 20 хэдэн хувь л энэ салбарт байгаа юм байна. Тэр хуулиудынхаа бас хоорондын уялдаа холбоог хангах, нэн ялангуяа бас хүмүүсийн шүүмжлээд байгаа энэ хэрэгжихгүй байгаа, огт ажиллахгүй байгаад байгаа хуулиудыг бас амь оруулах тэр чиглэлээр энэ хуулийнхаа төслийг дагалдуулаад бас Их Хурлын тогтоолд ч юм уу санаачлаад, тэгээд яг энэ салбарынхаа бүх хуулиудын уялдааг хангасан тийм арга хэмжээ бас авбал яасан юм бэ гэсэн тодорхой санал байгаад байна. Тухайлах юм бол саяын миний асуугаад байгаа энэ Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн хэрэгжилт. Үүний хүрээнд бид бас юу хийж чадах вэ. Тэгээд ер нь энэ хөдөө аж ахуйн бодлогоо илүү зангидсан байдлаар явуулах чиглэлээр энэ Их Хурал ямар арга .../минут дуусав/

С.Бямбацогт: Санал хэлчихлээ. Сайнхүүгийн Ганбаатар гишүүн асуултаа асууя.

С.Ганбаатар: Монгол орон хөдөө аж ахуйн орон. Түүнийгээ хэзээ ч мартаж болохгүй. Бид үйлдвэрлэгч юм уу эсвэл ямар нэгэн инновацаар дэлхийг гаргадаг бараа бүтээгдэхүүн юу ч байхгүй ийм ард түмэн. Сүүлийн 30 жил газраа ухаж гаргадаг. Эндээс олсон мөнгөө хамгийн чухал гэж бодож байгаа бол бид бас алдаа. Мэдээж хулгайлуулчихгүй шиг авах хэрэгтэй. Тэгээд энэ дээр гол анхаарах зүйл гэвэл 20 гаруй хууль хөдөө аж ахуй дээр хэрэгжиж байгаа боловч яг ерөнхий суурь харилцааг зохицуулсан хууль ерөөсөө өнөөдрийг хүртэл байхгүй учраас энэ хуулийг би дэмжиж байгаа. Мэдээж ерөнхий суурь харилцааг зохицуулж байгаа учраас маш их лоозонгийн чанартай юм шиг зүйлүүд орж ирж байгааг ойлгоод, энэ дээр ганцхан зарчмыг л би байнга хэлж байгаа. Маш их мөнгө хөдөө аж ахуйд өгч байгаа. Маш их зээл, тусламж, дэмжлэг үзүүлээд байгаа мөртөө яг эзэндээ очих дээрээ муу. Өөрөөр хэлбэл энэ хуулийн цаад гол логик нь тариаланчид, малчид, хөдөө аж ахуйн салбарт яг татвар бүрдүүлээд, ажлын байр бий болгож байгаа энэ улсуудын оролцоог хангах нь л хамгийн чухал шүү. Ерөөсөө бид чинь ерөөсөө л сайд дарга нар, яам, улс төрчид хамгийн ухаантай, би яаж хэрэгжүүлэх вэ гэж л яваад байгаагаас болж Монгол сүйрч байгаа шүү дээ. Тэгэхээр миний хэлэх гээд байгаа зүйл гэвэл хуулийн 5.2.9-д төр, хувийн хэвшил, эрдэм шинжилгээ, иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагааны оролцоог хангах гээд ийм лоозон орчихсон байгаа. Окэй орж болно. Үүний цаана хувийн хэвшил, эрдэм шинжилгээний байгууллагуудыг шийдвэрт оролцуулна шүү. Тэдэнд мэдээллээ өгнө шүү. Тэгэхгүй 1 аймаг дээр юм уу, эсвэл яаман дээр 1 дарга сандайлж суучхаад л билет таслаад суучихдаг шүү. Тэгээд л мафи болдог. Бүх төслүүдийг унагадаг. Мэдээж сайхан сэтгэлтэй, ухаантай хүн байж л таараа. Тэгэхдээ 30 жил ингэж бид алуулж байна даа цаана чинь. Энэ санаа л энэ дотор баймаар байна. Лоозон хэдий ч гэсэндээ тэр журамдаа, салбар, хуулиуддаа энийг анхаараарай гэдгийг протоколд тэмдэглэж байгаа юм шүү. Протоколд тэмдэглүүлж би үлдээж байна.

2 дугаарт нарийвчилсан асуултуудыг асууя. Энэ 18.3-т гээд орчихсон байна. Энэ зарчмын энэ саналууд дээр 18 дугаар зүйлийн хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжлэг гэдэг дотор 18 дугаар зүйлийн 3-д 18.2-т заасан шаардлагыг гэж байгаа юм. Нөгөө шууд болон шууд бус татаас, тарифын зохицуулалт, хөнгөлөлт, хүүгийн хөнгөлөлт гээд энэ олон гоё юмнуудыг чинь өгөхдөө дарга шийдэхгүй шүү. Тэр хөдөө аж ахуйн салбарынхантай ярилцаж байж шийднэ шүү гэдгийг энэ томьёолохдоо заасан шаардлагыг хангасан эсэхийг тодорхойлоход мэргэжлийн холбоодын оролцоог хангана гэж байгаа юм. Нэг асуусан болоод, тэгээд л халти өнгөрөөд л, дарга билет таслаад явчих вий гэдгийг энэ дээр тайлбар өгөөч. Зөвшилцөх үү. Би уг нь зөвшилцөх гэж санал оруулсан. Зөвлөлдөх гэвэл зүгээр зөвлөлдсөн болоод л хаядаг. Энийг тодруулаад, протоколд заавал ч үгүй тэр салбарын хөдөө аж ахуй, мал аж ахуй, тариалангийн салбарын тэр жинхэнэ нуруун дээрээ хүнд ачааг үүрээд явж байгаа хүмүүсийг шийдвэрт оролцуулна шүү гэдгийг би сонсмоор байна.

2 дугаарт 9.3-д аймаг бүр хөдөө аж ахуйн гаралтай хүнсний бүтээгдэхүүний шинжээч бүхий лаборатори байна гэж байгаа. Нийслэл, хот тосгон яах вэ. Хаягдсан байна. Энийг хуульдаа яаж оруулах вэ. Хаана нь явж байгаа вэ.

3 дугаар асуулт өнөөдөр энэ хууль дээр 3 газар их олон шүү дээ. Үндэсний хөдөө аж ахуйн салбарынхныг үндэсний компаниудыг дэмжинэ гэдэг үг байхгүй. Дандаа гадаадын хөрөнгө оруулалтад, гадаадынханд таатай нөхцөл бүрдүүлнэ гэж 3 газар заасан. Үгүй ээ, гадаадынхан хөдөө аж ахуй дээр орж ирвэл сайн л байна.

Заавал ч үгүй тэгээд тэр өөрийн хүүхдүүдээ тэгж ад үзэх ямар хэрэг байна. Энэ дээр үндэсний ажиллаж байгаа тэр компаниудад яг гадаадынхантай адилхан энэ давуу/минут дуусав/

С.Бямбацогт: Үндэсний компаниуд гаднынхантай адилхан давуу байдалд тэгш хандаач гэсэн асуулт асуусан шүү. Боломж энэ хуульд орсон уу гэж. Хариулъя. Ажлын хэсэг хариулъя.

Ж.Бат-Эрдэнэ: Ганбаатар гишүүний Байнгын хороон дээр яг үндсэндээ гишүүний саналаар энэ 18.3-ыг оруулж ирсэн юм. Энэ хуулийн 18.2-т заасан шаардлагыг хангасан гээд нөгөө дэмжлэг, бололцоо, дэмжлэг туслалцаа, татаас бүх зүйлүүдийг заасан шаардлагыг хангасан эсэхийг тодорхойлоход Мэргэжлийн холбоодын оролцоог хангана гэж оруулж ирж байгаа юм. Энэ бас чухал заалт гишүүн оруулж ирсэн л дээ. Энийг бид нар зөвшөөрөөд оруулсан. Тэгээд оролцоог нь хангана гэдэг маань өөрсдөө оролцох боломжоор оролцоод саналаа хэлэх үйл ажиллагаанд нь оролцох энэ бололцоог л хангачихлаа гэж үзэж байгаа юм бид нар. Яах вэ, та хамтран ажиллана эд нар гээд, хамтран ажиллах эсвэл хангах эд нар гээд зүгээр судалж үзнэ ч гэдэг юм уу ингээд хаячихсан бол өөр хэрэг байх гэж бодсон юм. Тийм болохоор хангана. Ер нь оролцоог нь хангана, байлгана. Одоо сүүлийн үед ер нь тэр янз янзын хөдөө аж ахуйн орон нутгийн асуудлууд дээр бас хувийн хэвшлээс иргэдээс хүмүүсийг оролцуулаад, тодорхой шийдвэрүүдийг нь гаргаад ингээд явж байгаа шүү дээ. Жишээ нь ЖДҮ-лэлийг хөгжүүлэх зээл олгоход тэр чинь 20 хэдэн бүрэлдэхүүнтэй, тэр дотор нь иргэдийг шууд оролцуулаад явчхаж байгаа юм. Тэгэхээр энэ заалт бол үндсэндээ бас болчхож байгаа заалт гэж би харж байгаа юм.

2 дугаарт лабораториудыг аймаг, сум, нийслэл, аймаг, сум орон нутаг гээд явчхаж байгаа байх. Тэр дээр ямар ч л байсан бид нарын өнөөдөр дутагдаад байгаа аймаг, орон нутгийн хүрээнд энийг нь дэмжчихье. Улаанбаатар хотын хувьд бол энэ лабораториуд ерөнхийдөө болчхоод байгаа шүү дээ. Болоод байгаа. Ганцхан лаборатори тэр орон нутаг дутагдчихаад байгаа байхгүй юу. Тийм болохоор орон нутаг зайлшгүй лабораторитой байна гэдгийг зааж өгөхөөс өөр аргагүй болчхоод байгаа юм.

Нөгөөтээгүүр энэ бол ерөөсөө л дотооддоо харьцсан, дотооддоо хандсан л хууль. Би тэгж ойлгож, тэгж уншиж, тэгж тодорхой хэмжээнд найруулгыг нь засаж залах зүйлийг нь хийгээд л явж байгаа. Гаднын тусламж дэмжлэг гэсэн бид яах вэ дээ Азийн хөгжлийн банк энээ тэрээ гээд л газруудаас бид нар тодорхой хэмжээний хөдөө аж ахуйг хөгжүүлэх тусламж дэмжлэг эд нар авдаг шүү дээ. Энэ хүрээнд л яригдаж байгаа болохоос биш яг аж ахуйн нэгжүүд бол дотоодын аж ахуйн нэгжүүд гэдэг дээрээ л заавал яг дотоодын дотоодын гэж үг заагаагүй ч гэсэн ер нь бол гол логик агуулга бол ерөөсөө өөрсдөө л бид нар хийнэ шүү дээ. Би бол тэр өнцгөөс л харж байгаа. Ерөөсөө миний толгойд бол жишээ нь, хууль санаачлагчийн толгойд бол гадаад гэж ороогүй байх гэж би бодож байгаа. Зүгээр миний уншаад дотор нь ажлын хэсэг ажиллахад ер нь өөрсдийнх нь аж ахуйн нэгж, нүдэнд тэр нөгөө ченжүүдээ яаж өөрчлөх вэ, тэр нөгөө урьд өмнө малчидтай ажиллаж байсан хүмүүсээ яаж хөл дээр нь босгох вэ, яаж тэд нарыг дэмжих вэ, энэ өнцгөөс хараад л, энэ өнцгөөс л энэ хууль бол боловсруулагдсан гэдгийг хэлэхээр байна.

С.Бямбацогт: Баярлалаа. Чинбатын Ундрэм гишүүн. Ганбаатар гишүүн тодруулъя.

С.Ганбаатар: Энэ хууль бас амин чухал хууль учраас би бас байр сууриа хэлээд байгаа юм. Тэгээд дэмжиж байгаа. Ер нь бол уул уурхай руугаа бүгд анхаараа, тэгээд ер нь хөдөө аж ахуйгаа хаях тал руугаа орчихсон ард түмэн шүү дээ бид чинь. Тэгээд салбарын автономи гэж байдаг юм шүү. Салбарын тусгаар тогтнол. Өөрөөр хэлбэл улс төрчдөөс өөрсдийгөө хамгаалж, тэр мал аж ахуй, тариалан, тэр хөдөө аж ахуйн тэр оролцогч нартайгаа хувиараа хөдөлмөр эрхлэгч байна уу, компаниудтайгаа хамтаараа энэ салбараа яаж босгох вэ гэдэг тэр хэлэлцээрийг хийдэг. Би түрүүн тэр 5 дугаар зүйлд заасан хамтын ажиллагааг оролцуулна гэдэг ийм нарийвчилсан зүйлийг протоколд тэмдэглэж байгаа юм шүү. Тэгэхгүй манайхан чинь ингээд улсаас дэмжлэг аваад, мөнгө авчхаад тэгээд л сайд дарга нар, улс төрчид, тэр дарга нар чинь зүгээр өндгөө хамгаалж байгаа юм шиг тэврээд хэвтчихнэ шүү дээ. Нөгөө салбарынхны оролцоог бол зүгээр тэгээд энэ оролцож байгаа гэдэг үгийг чинь бол тоохгүй дээ. Нэг асуусан дүр үзүүлээд л давхичихна.

С.Бямбацогт: Ажлын хэсэг хариулъя. Бат-Эрдэнэ гишүүн.

Ж.Бат-Эрдэнэ: Ганбаатар гишүүн ээ, тантай бол санал яг 1 байгаа. Энэ өнгөрсөн хугацаанд хөдөө аж ахуйтай нэлээн ноцолдсоны хувьд, зовлон жаргалыг нь миний хувьд бүр үзээд одоо бүр тулчхаад байна. Тийм болохоор яг таны наад хэлээд байгаа өнцгөөс би хараад байгаа юм. Хаана, хэн хүнд суртал гаргачхаж болох вэ. Аймаг дээр ямар хүнд суртал гарч болох вэ, сум дээр ямар хүнд суртал гарч болох вэ, сум дээр энэ бодлогыг хэрэгжүүлэх яг тэр сонсож байна уу, үгүй юу. Эсвэл тэр бид нарын яриад байгаа, бид нарын хүсээд байгаа хөдөө аж ахуйн бодлого гээд гаргачихсан бодлогыг хэрэгжүүлж байна уу, үгүй юу гэсэн юм байхгүй болчих гээд. Тэгээд санаа зовоод яг тантай адилхан өнцгөөс хараад байгаа юм. Яг одоо өнөөдрийг харахад яаж нөгөө хэдэн ченжүүдээ жинхэнэ энэ үйлдвэрлэгчийн сүлжээн дотор оруулах вэ л гэж хараад байгаа байхгүй юу. Жишээ нь, тэд нарыг яаж хөрөнгөтэй болгох вэ, тэд нарыг яаж тэр түүхий эдээ хадгалдаг складтай болгочих вэ, тэд нарыг яаж цас борооноос ядаж л хамгаалдаг, давсалдаг тэр саравчтай болгочих вэ, яаж тээвэртэй болгох вэ, яаж өмхийрүүлэхгүй хадгалаад явуулчих вэ гэдэг өнцгөөс нь л хараад байгаа юм шүү.

С.Бямбацогт: Баярлалаа. Чинбатын Ундрэм гишүүн асуултаа асууя.

Ч.Ундрэм: Хөдөө аж ахуйн салбар бол манай улсын хамгийн чухал салбар. Хүнсний аюулгүй байдал талаасаа харсан ч тэр, мөн хүн амын дийлэнх хэсэг нь энэ салбараас, энэ салбарт ажиллаж, амьдарч байгаа. Тэгээд салбарыг зохицуулдаг 27, 28 хуулийн дээр 1 ийм малгай хуультай байх нь бол бас зөв гэж миний хувьд дэмжиж байгаа. Тэгээд өнгөрсөн хугацаанд бид нар Хүнсний хувьсгал, Цагаан алт, Шинэ хоршоо гээд том том хөдөлгөөнүүдийг улс орон даяар хийгээд, үүнийхээ дагуу Улсын Их Хурлын тогтоолыг батлаад, төсвөө бас энэ рүүгээ чиглүүлээд ингээд ажилласан. Хүнсний хувьсгалын тогтоолыг боловсруулах ажлын хэсгийг та бараг ахалж байсан байх Бат-Эрдэнэ гишүүн. Би бас ажлын хэсэгт орж ажиллаад, тэгээд үүний үндсэн дээр нэлээд амжилтад бол бид нар хүрсэн. Гэхдээ яг бидний хүсээд зориод байсан тэр амжилтад бол хараахан хүрч амжаагүй байгаа. Тэгээд одоо

ингээд эргээд харахаар бидний зарим урамшуулал нь байгаа олж байна уу, үгүй юу. Тэр хөнгөлөлттэй зээл нь яг бас байгаа болж байна уу, үгүй юу.

Энийг бас эргээд харах ёстой юм шиг санагдаад байгаа юм. Жишээлэх юм бол сүүний урамшуулал бид нар өгч байгаа. Гэтэл тэр нь зөвхөн энэ улсын үйлдвэрүүдэд сүүгээ хямдхан үнээр тушаасан тохиолдолд тухайн малчинд олгогдоод байгаа байхгүй юу. Тэгэхээр зарим хоршоод болохоор би тийшээ өгөхөөр ингээд хамаагүй бага үнээр авах гээд байгаа учир өөрөө очоод Дарханы зах дээр зарж байна сүүгээ ч гэдэг юм уу ийм асуудал яриад байгаа юм. Тэгэхээр бид нар энэ урамшуулал өгч байгаа тогтолцоо маань буруу байгаад байгаа юм шиг. Магадгүй энэ сүүний үйлдвэр чинь бас хөнгөлөлттэй зээл аваад сүүний үйлдвэр барьсан байж болно. Тэгээд нөгөө талаас дахиад малчдынхаа сүүг хямдхан авах тийм хөшүүрэг болгоод байгаа байхгүй юу ашиглаад. Ногооны урамшуулал бид нар олгож байгаа. Саяхан бас Ерөнхий сайдтай Сэлэнгэ аймгийн Орхон сум дээр очиж ногоочидтойгоо уулзсан л даа. Тэд маань одоо юу хэлж байна вэ гэхээр тэгэхээр баярлалаа ногооны урамшуулал өгдөг болсон та бүхэн. Гэхдээ бид нарт хамгийн том асуудал бол зоорины асуудал. Тэгэхээр бараг үүнийхээ оронд зоорины зээл гээд хөнгөлөлттэй зээл яг өгчихвөл бүх ногоочид маань өөрсдийнхөө хүчээр илүү хямдхан үнэтэй ийм зоорь барьчих юм гээд. Тэгээд үнэхээр өөрсдөө жишээлбэл би Сэлэнгэ аймагт 7, 8 зоорь бариулж байгаа. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар. Гэтэл өөрсдөө барьсан зоорь нь хамаагүй илүү чанартай, илүү хямдхан байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр бид нарт зүгээр зоорины зээл өгөх нь илүү зөв юм гэсэн асуудал ярьж байна.

2 дугаар асуудал бол бид нарт төлөвлөлт маш чухал байна энэ салбарт. Одоо жишээлбэл манай тариаланчид улаан буудайгаа тариад эхэлчихсэн л дээ. Гэхдээ намар хэдэн төгрөгөөр зарахаа мэдэхгүй байгаа шүү дээ. Тэгэхээр бид нар хэдий хэмжээний улаан буудай тарих юм, тэр нь ямар үнэ өртөгтэй байх юм гэдгээ .../минут дуусав/

С.Бямбацогт: Асуултдаа гүйцээгээд асуучихъя. 1 минут.

Ч.Ундрам: Түрүүлж мэдэж байж бас ашиг орлогоо, зардлаа, бүх юмаа тооцоолно. Ногоочид маань ч гэсэн зарим жил бүгдээрээ төмс тариад, тэгээд нөгөө төмс нь илүүдэлтэй болоод шатчихдаг асуудал ч байдаг.

Дараагийн 1 чухал асуудал Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль байна л даа. Тэгээд энэ мал, амьтны эрүүл мэндийг шинжлэх ухаанд суурилж бид нар ер нь хийдэг болмоор байна. Одоо манай мал бэлчээрийн доройтлоос болоод нөгөө уураглаг ургамал нь ургах нь багасчихсан учраас шим тэжээлийн дутагдалд ороод, тэрнээсээ үүдээд үс ноос нь чанар муутай, арьс шир нь чанар муутай болоод, тэгээд нөгөө Италийн мундаг арьс ширний үйлдвэрүүд чинь танай малын арьс нь коллаген багатай учраас будаг авахгүй байна, сунахгүй байна гээд асуудал яриад байна. Тэгээд энэ дээр бид нар ХААИС-ийг яг цөмд авчирмаар байгаа юм. Энэ хөдөө аж ахуйн салбарынхаа. Тэгээд энэ дээрээ суурилад бас .../минут дуусав/

С.Бямбацогт: Ажлын хэсэг хариулъя. Бат-Эрдэнэ гишүүн.

Ж.Бат-Эрдэнэ: Хүнсний хувьсгал дээр та бид нар ажлын хэсэг байгуулаад ажиллаж байсан. Ер нь бол Хүнсний хувьсгал үр дүнгээ өгсөн . Сая би 1 аж ахуйн

нэгжтэй уулзаж байхад яг Хүнсний хувьсгал шиг ийм хувьсгалаа яг тогтсон аж ахуй руу нь та нар өгөөч ээ. Тэгвэл наадах чинь үр дүн өгөх юм байна лээ гээд байгаа байхгүй юу.

2 дугаарт хүнсний хувьсгал дээр бид нар 1 алдсан зүйл бол хүртээмжийг дээшлүүлэе гэж байсан шүү дээ. Шинэ аж ахуйн нэгжүүдийг бий болгоё. Тэгж байж орон нутагт хөл дээрээ босно. Орлого бий болно. Нөгөө дунд давхарга бий болно. Тийм болохоор хүртээмж сайжруулъя гэж гэж байсан. 1 хийгдээгүй юм бол ерөөсөө энэ дээр байгаа аж ахуйн нэгжүүдээ тусдаа дэмжээд явчихсанаас биш, шинэ аж ахуйн нэгжүүд бий болгох дээр бол маш дутагдалтай бий болчихсон. Дутагдалтай. Та бас энийг л хэлээд байх шиг байна. Тэгэхээр би энэ хууль дээр босоо удирдлага оруулж ирэх гээд байсан юм. Яагаад гэхээр эндээс ингээд бодлого гарч байдаг. Монгол Улсын Ерөнхийлөгч нь 1 аягүй сайхан санаачилга гаргаад ингээд явж байдаг. Хөдөө аж ахуйн бодлого гээд 1 юм гаргаж ирээд, сая Баттулга сайд сайд байхдаа гаргаж байсан хөдөө аж ахуйн бодлого байгаа гээд байгаа шүү дээ. Энэ чинь тэгээд цаасан дээр үлдчихээд байгаа байхгүй юу. Энийг хэн хэрэгжүүлж байна гэх гэхээр энүүхэн хэн хөдөө аж ахуй руу анхаарал хандуулдаг Засаг дарга, Иргэдийн Хурал нь сөхөж авч үздэг, бусад нь үздэггүй яг орон нутгийнхаа проблемыг шийдээд, цаашаа хараад явчихаад байна шүү дээ. Түрүүн тэндээс хэлсэн шиг хөдөө аж ахуйг бол бид нар мэднэ гэдэг шиг ингээд өөрөөр нь явуулаад байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ хууль дээр түрүүний оруулж ирсэн бодлого нэгдмэл байна. Энэ бодлогыг улсын хэмжээнд хэрэгжүүлнэ гээд Хөдөө аж ахуйн сайд дээр жоохон хариуцлага өлгөөд, тэр хүн нь улирал тутамд таны хэлж байгаа төлөвлөлт гэж байна шүү дээ. Тэр төлөвлөлтийг чинь орон нутагт мэддэг хүн байхгүй. Орон нутгаас ямар төлөвлөлт хийх гээд, тэр нөгөө газар тариалангийнхан чинь ямар шатад явж байгаа, яаж байгаа, ийж байгааг нь 1 давхиж очиж, мэдээлэл авч байгаа болохоос биш, яг тэд нарыг газар дээр нь ингэж удирдан зохион байгуулж, тусалж дэмжиж байгаа юм байхгүй болчихоод байгаа байхгүй юу даа. Тэгэхээр цаашдаа энэ босоотой хэмжээнд явдаг ийм бодлого хүрдэг л болох шаардлагатай л болчихоод байгаа юм. Яг үнэндээ энэ хэдэн жил ноцолдсоны ганц алдаа нь бол бид нар энэ бодлогоо хэрэгжүүлж чадахгүй ийм юунд л оччихоод байгаа юм. Энийг л засахын тулд ямар сайндаа босоо бодлого, босоо тогтолцоо гээд би оруулж ирэх гээд яваад байгаа юм.

Ногоотой холбоотой асуудал дээр ганц асуудал чинь дахиад л зоорины асуудал байгаад байгаа шүү дээ. Тэр зооринд чинь хамгийн чухал асуудал чинь зоорь байхад тэрийг өнөөдөр бид нар зоориор хангачхаж чадахгүй л яваад байгаа байхгүй юу. Тэгээд харин энэ хууль дээр таны саяын хэлсэн санал оруулж ирсэн шүү дээ. ХААИС болоод бусад мэргэжлийн нау хау гаргадаг шинжлэх ухааны бүх байгууллагуудыг татаж оруулъя. Яршиг энэ хөдөө аж ахуйд нь өгчихье. Тэгэхгүй болохоор тэгээд 1 хэсэг нь болохоор тийшээ Боловсролын яам руу очоод, 1 хэсэг нь болохоор шинжлэх ухааныхаа байгууллага руу оччихоод, тэгээд энд нөгөө гар хөлгүй тэгээд сайхан амаараа ярьдаг л ийм байдал бий болчихоод байгаа байхгүй юу даа. Санал 1 байна тантай.

С.Бямбацогт: Баярлалаа. Одонгийн Цогтгэрэл гишүүн асуултаа асууя.

О.Цогтгэрэл: Хөдөө аж ахуйн тухай ярьж байна. Хөдөө аж ахуйтай холбоотой бараг одоогийн байгаа нөхцөл байдлыг илэрхийлбэл, дүгнэвэл хоёрхон тоо л байгаа. Хөдөө аж ахуйн салбарын эдийн засагт эзэлж байгаа хувь хэмжээ 10 хувь, Монгол Улсын ажиллах хүчний 30 хувь нь энэ салбарт ажиллаж байгаа. Зөвхөн энэ

2 тооны харьцаа олон зүйлийг илэрхийлэх байх. Үндсэндээ тэнд ажиллаж байгаа, хөдөө аж ахуйн салбарт ажиллаж байгаа хүмүүсийн бүтээмж 3 дахин бага байна л гэсэн үг. Олж байгаа орлого нь улсын дунджаас 3 дахин бага байна л гэсэн үг. Эдийн засагт ажиллаж байгаа, салбарт ажиллаж байгаа 30 хувь, эдийн засагт эзэлж байгаа хэмжээ нь 10 хувь. Тэгэхээр үүний цаана олон олон яг үнэхээр тийм зарчмын болоод олон зүйлүүд үүний цаана нэг илрэл жишээ нь энэ хавар үүсэж байгаа махны хомсдол. Энэ бол нийлүүлэлтийн л хомсдол. Монгол Улсын экспорт нь нэмэгдээгүй, хүмүүсийн 1 хүний иддэг махны хэмжээ нь нэмэгдээгүй. Гэтэл энэ зүгээр санамсаргүй биш. Миний бодлоор бол яг Монгол улсад тэр нөгөө Голланд өвчин гээд онол номынх нь түвшинд ярьдаг зүйл Монгол Улсад яг бодитойгоороо илрээд эхэлчихсэн. 1 салбараас хараат, уул уурхайн салбар гэдэг салбар эдийн засгийн зонхилох хэмжээг эзэлдэг. Олж байгаа орлого валютын дийлэнх хэсгийг эзэлдэг, бусад салбарууд нь шахагдаж, уул уурхайгаас орж ирсэн доллар валютаараа ханшаа барьчихдаг. Энэ нь өөрөө Монголын дотоодын үйлдвэрлэл, бизнесийн өрсөлдөх чадварыг хумьж эхэлж байгаа. Үүний 1 тод илрэл нь хөдөө аж ахуй жилээс жилд тэр салбарт ажилладаг хүн, амьдардаг хүн, олдог орлого нь байхгүй болж одоо бараг 10-аас доош хувь орж байна уу ДНБ-д эзэлж байгаа хувь хэмжээ.

Тэгэхээр энэ хуулийг үзэл санаа, олон зүйлийг харахад би хуулийг уншаад тэр тандан судалгаа олон зүйлүүдийг нь бас эргүүлж харлаа. Тоогоор илэрхийлсэн зорилго ерөөсөө байхгүй юм. Тоогоор илэрхийлсэн зорилт. Саяын тэр эдийн засгийн тоо хэмжээ, эзлэх хэмжээг нэмэгдүүлэх юм уу. 1 малчны, 1 хүний олж байгаа орлогыг яаж нэмэгдүүлэх, энд ийм тоон зорилго, зорилтууд талаар мэдээлэл өгөөч. Дахиад ийм тоон зорилго, зорилтгүй л болохоор асуудал чинь тэгээд ерөнхий энийг яаж ч тайлбарлаж болно, яаж ч бид нар хэмжиж чадахгүй бол гэдэг дээр тодорхой хариултууд бас өгөөч. Ямар төсөөлөлтэй байгаа юм. Хууль санаачлагчид болоод энэ ажлын хэсэг нь. Яг өнөөдөр ер нь нийтдээ Монгол Улсын эдийн засагт тэр Голланд өвчин гээд л бид нар бас энд тэнд ярьдаг, тэр зүйл аль хэдийн илрээд эхэлчихсэн. Бусад дотоодын үйлдвэрлэл ажлын байр 1 салбар уул уурхайн салбарт бараг 15, 20 мянган хүн л ажиллаж байгаа. Бусад салбарт ажиллаж байгаа хүмүүсийн, бизнесүүдийн, иргэдийн оролцоо гэдэг зүйл энэ эдийн засагт чинь ингээд явсаар байгаад орлогын ялгаа руу, орлогын ялгаа бий болоод удаан хугацаанд үүний цаана манайх л болсон хойно .../минут дуусав/

С.Бямбацогт: Мандхай гишүүн, хууль санаачлагч хариулах уу. Хэн хариулах вэ. Ажлын хэсэг хариулъя.

Ж.Бат-Эрдэнэ: Ёстой нөгөө гижигдсэн газар маажна гэдэг шиг өнөөдөр эдийн засагт нөлөөлж байгаа нөлөөлөл уртаашаа 10 хувь гэж байна шүү дээ. Бид энийгээ ерөөсөө хийж чадахгүй л болчихоод байна шүү дээ. Загатнасан газар маажив гэдэг шиг. Тэрэн шиг энэ хар даа жишээ нь махны хомсдол. Бид нар зах зээлд ороод 1990 оноор гээд тооцох юм бол 36 жил болчихлоо. Энэ хөдөө аж ахуй чинь байдгаараа л байж л байгаа байхгүй юу даа. Махны хомсдол гэхээр чинь бид нар яагаад өнөөдөр намар болонгуут л баахан нядалгаа хийж хаячхаад, нөгөөдхөө зоорилж хаяж байгаад, тэгээд л нөгөөдхөө идээд, тэгээд л хавартаа золгодог. Тэгээд л хавраас хойш дахиад махгүй байж байж байгаад, зун махтай золгодог. Тэгээд борц руугаа ордог. Үгүй ээ, энийг яагаад бид нар тэгвэл жилийн 4 улиралд энийгээ бэлддэг байх ийм бололцоог өнөөдрийн 36 жилд хангаж чадаагүй юм бэ. Миний нөгөө яриад байгаа зэрлэг мал аж ахуй гэдэг чинь энийг л хэлээд байна шүү дээ. Зөвхөн намар нь нядалгаа хийж байдаг. Уг нь жилийн 4 улиралд нойтон мах иддэг энэ тогтолцоо

руу бид нар орох л ёстой л юм байгаа шүү дээ. Тэгэхээр энэ хууль дотор тэрийг оруулж байгаа зүйл нь бол үйлдвэрлэлийн кластер, үйлдвэрлэлийн сүлжээ, малчнаасаа авхуулаад нөгөө нойтон мах хэрэглэгч дээр очдог байх, жилийн 4 улиралд очдог байх гэсэн энэ зүйлийг л ерөнхийд нь л томъёолоод байгаа юм.

Түүнээс биш яг тоон үзүүлэлтээр хуульд заана гэдэг бол мэдэхгүй. Хууль зүйн бүтцээрээ бол судалгаа хэсэгт ... түүнээс биш хуульд тэр нь бас орохгүй байх гэдгийг та мэдэх байх. Тэгвэл Мандхай гишүүн хариулъя.

С.Бямбацогт: Мандхай гишүүн нэмээд хариулчихъя.

М.Мандхай: Тоон судалгаа байгаа. Яг би бол тантай санал нэг байна. Ялангуяа манай хөдөө аж ахуйг дэмжих, төрөөс үзүүлж байгаа бодлого сүүлийн 2020-2024 онд бол 836 тэрбум төгрөгийн татаас олгосон байгаа юм. 2015-2019 оны нийт татааснаас 4,6 дахин өндөр байгаа боловч сүүлийн 5 жилд хөдөө аж ахуйн бүтээмж дунджаар -1,9 хувиар буурч байгаа. Тэгэхээр энэ юу хэлж байна гэхээр өнөөдөр 2015 онд байсан 20 хувийн бүтээмжтэй ажиллаж байсан хөдөө аж ахуйн салбар өнөөдөр 7 хувь ороод буурчихсан байгаад байгаа. Тэгэхээр бид нар татаасны хэмжээ өсөөд байх хэмжээгээр бүтээмж буураад байна гэсэн үг. Тэгэхээр энэ нь өөрөө дотоодын нийлүүлэлт, дээрээс нь өнөөдөр бид нар малчдын махны үнэ өссөн асуудал бол таны хэлээд байгаа наад Голланд өвчлөл чинь бол бодитой хэрэгжээд байгаа юм.

Тэгээд Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль бид нар ирэх 10 жил хөдөө аж ахуйн салбарыг яаж хөгжүүлэх юм бэ гэтэл өөрөө хөдөө аж ахуйн салбарын бодлого нь тэндээ тусгагдаагүй байгаад байгаа юм. Тийм учраас бид нар .../минут дуусав/

С.Бямбацогт: Тодруулж асууя. Тэгээд хариулъя.

Ц.Туваан: Тэгээд тэр Голланд өвчин гээд байгаа чинь 1 салбар нь давамгайлаад, бусад салбараа үндсэндээ яг одоо Монголд илрэл нь гарч байна. Үндсэндээ ингээд бусад салбарт бүтээмж бага, тэр тусмаа хөдөө аж ахуйн салбар чинь улсын дунджаас 3-5 дахин бараг доошийгоо орчихсон. Яг одоо ингээд нөхцөл байдлууд, бусад салбарын баланс алдагдаж, энэ чинь өөрөө явсаар байгаад орлогын ялгаа болж хувираад, энэ орлогын ялгаа чинь сүүлд нь нийгмийг үндсэндээ бараг хувьсгалд уриалан дуудаж эхэлдэг. Тэгэхээр энэ өвчлөл яг энэ нөхцөл байдал Монголд аль хэдийн ингээд эхний байдлаар маш гүнзгий илрээд эхэлчихсэн. Тэгэхээр энэ Хөдөө аж ахуйн салбарт авах арга хэмжээ гэдэг бол үнэхээр чухал. Тэгээд энэ хууль дээр бол надад бас ингээд минут дуусаж байх шиг байна. Ярьж хэлэх зүйлүүд их асар олон байна л даа. Үндсэн шалтгаан бол хөдөө аж ахуй тэр бизнес, эрдэм шинжилгээ, сургалт, хөдөө аж ахуйн мэргэжилтэн гэдэг энэ зүйлийг экосистемээр нь л харахгүй бол аль нэг .../минут дуусав/

С.Бямбацогт: Харин тийм ээ. Санал хэлчихлээ. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Энэ хууль чухал. Өнөөдрийн хэлэлцэж байгаа энэ асуудал маш чухал асуудал. Сая Цогтгэрэл гишүүний ярьж байгаа үнэхээр энэ газар тариалан эрхэлж байгаа тариаланчдаа, мал маллаж байгаа малчдаа дэмжсэн энэ махны нийлүүлэлтийг,

төмс, хүнсний ногооны нийлүүлэлтийг дэмжсэн, борлуулалтыг нь дэмжсэн, тарьж ургуулахыг нь, өсгөж үржүүлэхийг нь дэмжсэн бодлого бидэнд хэрэгтэй байна. Өсдөг үрждэг энэ салбар ул нь. Уул уурхайтай адилхан ухдаг, дарагддаг, дуусдаг биш, байнга бас төлөөрөө, тариалангаараа өсөж байдаг, үржиж байдаг.

Энэ жил бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт ард иргэдийн амьдралд маш том цохилт өгч байгаа. Хамгийн их үнэ өсөж байгаа. Өсөж байгаа бүтээгдэхүүнүүд ерөөсөө махны үнэ, төмс, хүнс, ногооны үнэ. Хөдөөдөө малчид нь орлого багатай байгаад байдаг, тариаланчид нь орлого багатай. Тэгсэн мөртөө хамгийн их өсөж байгаа бүтээгдэхүүн нь тариаланчдын тарьж байгаа төмс, хүнсний ногоо, малчдын өсгөж үржүүлж байгаа мал, махны үнэ. Тийм болохоор төрийн маш том бодлого, маш том зохицуулалт хэрэгтэй байна. Энэ дээр л бид анхаармаар байна.

Өнгөрсөн жил харьцангуй шатахуун тогтвортой байх үед энэ үнийн өсөлт бий боллоо. Энэ хавар бид маш томд нэрвэгдэж байна. Том цохилт болж байна. Энэ жил чинь дэлхий даяараа шатахууны үнийн өсөлтөөс хамаараад бүх бараа бүтээгдэхүүн дэлхий даяараа өсөх ийм нөхцөл бүрдчихсэн байгаа. Шатахуун, эрчим хүч бүх үйлдвэрлэл, үйлчилгээний гол орц нь. Шатахууны үнэ, эрчим хүчний үнэ өсөхөөр бүх бараа бүтээгдэхүүн үнэ өсөх суурь нөхцөл болно.

Тийм болохоор энэ жилийн бас тариалалт дуусаагүй байна. Тариалалтдаа анхаарч, яаж арвин ихийг улаан буудайгаа тарьж, ургуулах вэ, төмс, хүнсний ногоо тарьж байгаа ард иргэдээ, тариаланчдаа яаж дэмжих вэ, мал сүргээ бас өсгөх гээд үржүүлж байгаа малчдаа яаж дэмжих вэ. Энэ дээр тодорхой том цогц яаралтай бодлого явуулж байж, ирэх намар бид нар мал сүрэг маань өсөж, махны нийлүүлэлт нэмэгдэнэ. Ирэх хавар өсөхгүй. Газар тариалангийн салбарт бас гурилын үнэ өсөхгүй, төмс, хүнсний ногоо нь өсөхгүй байх суурь бүрдэнэ. Ийм суурийг бүрдүүлэх тал дээр одоогоос бид нар маш сайн анхаармаар байна. Энэ хуулиа яаралтай хэлэлцээд, батлаад явъя. Бидэнд бас баталсан хууль тогтоомж олдохгүй биш, цөөдөхгүй биш олон байгаа. Урьд нь баталсан хууль тогтоомжууд тухайлах юм бол шинэ хөдөө маань хэр зэрэг хэрэгжив. Зөв байв уу. Шинэ хоршоо. Хүнсний хувьсгал, Цагаан алт гээд хөтөлбөрүүд Их Хурал баталсан. Энэ хөтөлбөрүүдийн үр өгөөж хүрч байна уу. Яагаад хүрч байна, яагаад хүрэхгүй байна. Маш их дэмжлэг үзүүлээд байхад яагаад энэ салбар өсөж өндийхгүй байна. Махны үнэ буурахгүй байна. Төмс, хүнсний ногооны үнэ буурахгүй байна. Тариалалт нэмэгдэхгүй байна вэ гэдэг дээр бид нар дүгнэлт хийх ёстой. Энэ хавар өсөж байгаа төмс хүнсний ногооны үнэ дээр бид нар Засгийн газарт эрх өгчихсөн байж байгаа. 04 сарын 15-аас 08 сарын 01 хүртэл хугацаанд энэ төмс, хүнсний ногооны импортоор орж ирж байгаа татварыг бид нар бууруулчхаж болно. 15 хүртэл бууруулах бололцоо байж байгаа. Тэглэхчхэж болно. Татваргүй болчих юм бол төмс, хүнсний ногооны үнэ өсөхөө больчихно. Ийм бас бодлогын зохицуулалт хууль, эрх зүйн орчин бүрдүүлээд өгчихсөн байхад яагаад Засгийн газар хийж, хэрэгжүүлэхгүй байна вэ. Энэ дээр Засгийн газраас анхааралдаа ав. Одоо бас 08 сарын 01 хүртэл төмс, хүнсний ногооны үнэ өсөх байх. 07 сарын 01 хүртэл махны үнэ бас нийлүүлэлт хомсдолтой байх байх. Тэгээд ирэх намраас биш, одоо энэ газар тариалан эрхэлж байгааг дэмжихгүй бол ирэх хавар гурилын үнэ өсөх, төмс, хүнсний ногооны үнэ өсөх, ирэх хавар махны үнэ дахиад өсөх ийм эрсдэлүүд байгаа. Тийм болохоор Засгийн газар бас энд онцгой анхаарч ажиллах ёстой.

Бид ч гэсэн бас энэ баталсан хуулиудаа хэрэгждэг байх, хэрэгжилт нь бас үнэлгээ хийж илүү бас уялдуулах, илүү бас тариалан эрхлэгчдээ дэмжсэн, малчдаа дэмжсэн бодлогыг нь илүү сайн оруулж өгөх тал дээр анхаарцгаая.

Ингээд зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалтуудыг үдээс хойш 16 цагаас явуулъя.

12.27 цаг.

Дараагийн асуудалдаа оръё.

“Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай” Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах хуулийн төслийг хэлэлцэнэ.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Сайнбуянгийн Амарсайхан танилцуулна. Таныг индэрт урьж байна.

С.Амарсайхан: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас Монголчууд ихээр зорчиж амьдарч, мөн ажил хөдөлмөр, бизнес эрхлэх, суралцаж буй улс орнуудын хууль сахиулах байгууллагуудтай манай улсын цагдаагийн байгууллагаас шууд харилцаа холбоо тогтоож, хамтран ажиллах эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгын хүрээнд Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээрийг байгуулж байна.

Энэхүү хэлэлцээрийн зорилго нь гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, гэмт этгээдийг олж тогтоох, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, нийтийн хэв журмыг сахиулахад эрх бүхий байгууллагууд өөр хоорондоо стратегийн болон ажиллагааны талаарх мэдээллийг солилцох, шууд харилцах хэлбэрээр хамтын ажиллагааг гүнзгийрүүлэн бэхжүүлэхэд оршиж байна.

Хэлэлцээрийн төслийг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаар тус тус хэлэлцэж, гарын үсэг зурах эрхийг Засгийн газарт олгосноор Монгол Улсын Ерөнхийлөгчийн Бүгд Найрамдах Чех Улсад хийсэн төрийн айлчлалын үеэр талууд 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдөр Прага хотноо гарын үсэг зурсан болно.

Хэлэлцээр нь 5 хэсэг, 29 зүйл хавсралтаас бүрдэж байгаа бөгөөд дараах харилцааг зохицуулахаар тусгасан. Үүнд:

1 дүгээрт 2 улсын эрх бүхий байгууллагууд гэмт хэргийн зохион байгуулагч, тэдгээрийн холбоо хамаарал, бүтэц, зохион байгуулалт, гэмт хэрэг үйлдэхэд ашигласан арга техник, мөн террорист бүлэглэл, тэдгээрийн үйлдсэн гэмт хэрэг, цогцост шүүх, шинжилгээний байгууллагаас хийсэн үзлэг, шинжилгээний дүгнэлт, криминологийн судалгаа, мөрдөн шалгах ажиллагааны арга тактик, түүнчлэн цагдаагийн байгууллагын бүртгэл мэдээллийн сангийн мэдээллийг харилцан

солилцохоос гадна талуудын хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлж, зөвлөгөө өгч ажиллах чиг үүрэг бүхий офицер, зөвлөх мэргэжилтнүүдийг харилцан илгээхтэй холбоотой харилцааг зохицуулсан.

2 дугаарт Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах шатад 2 улсын цагдаагийн байгууллагын мөрдөгчид эрх зүйн туслалцааны хүсэлт гаргах замаар гэрч, шинжээч, сэжигтэн, яллагдагч болон бусад этгээдээс тайлбар мэдүүлэг авахаас гадна талууд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нууцад хамаарах баримт бичиг, мэдээлэл, нотлох баримтыг харилцан солилцох боломжтой болох юм.

3 дугаарт талуудын эрх бүхий байгууллагуудын алба хаагчид хэлэлцэн тохирогч нөгөө улсын нутаг дэвсгэрт ажиллагаа гүйцэтгэх, ингэхдээ өөрсдийн биедээ авч ирсэн галт зэвсэг, сум, бусад тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл, агаарын хөлөг, албаны нохой, уналга, морь зэргийг ашиглах боломжтой ба талуудын эрх бүхий байгууллагууд гамшгийн үеийн хохирогчийг тодорхойлох багийг нөгөө улсад нутаг дэвсгэрт харилцан томилох замаар тодорхой төрлийн үйл ажиллагааг гүйцэтгэхтэй холбогдох харилцааг мөн зохицуулсан.

4 дүгээрт талууд сургалтын чиглэлээр хамтран ажиллах буюу хамтарсан сургалт семинар, дадлага сургуулалт, хэлний сургалт зохион байгуулах, мэргэжилтнүүдийг сургах ба үүнд тодорхой ажилтныг томилон оролцуулах, сургалтын агуулга, хөтөлбөрийг боловсруулахад шинжээчдийг харилцан оролцуулах, дадлага сургуулалтад ажиглагчдыг оролцуулах зэрэг асуудлыг зохицуулахаар тусгаад байна. Иймд энэхүү хэлэлцээр нь олон улсын гэрээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх заалт, 1.4 дэх заалтад заасны дагуу соёрхон батлах олон улсын гэрээнд хамаарч байгаа тул “Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай” Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг холбогдох журмын дагуу хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Хуулийн төслийн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Буяагийн Тулга танилцуулна. Индэрт урьж байна.

Б.Тулга: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 05 дугаар сарын 26-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 78 дугаар зүйлд заасны дагуу Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2026 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн хуралдаанаар хэлэлцлээ.

Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг баталснаар эрүүгийн хэрэг мөрдөн шалгах тодорхой ажиллагааг Чех Улсын

нутаг дэвсгэрт гүйцэтгэх боломжтой болох бөгөөд энэ нь эрүүгийн хэргийн шийдвэрлэлтийг нэмэгдүүлэх, гэмт хэрэгтэй үр дүнтэй тэмцэх, өөрийн улсын иргэд, хуулийн этгээдийн хууль, ёсны эрх ашгийг хамгаалах, хангах нөхцөлийг бүрдүүлэхийн зэрэгцээ зохион байгуулалттай гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, гэмт хэргийн зохион байгуулагчийг олж тогтоох чиглэлд талуудын хамтын ажиллагааг хөгжүүлэн бэхжүүлж, олон нийтийн аюулгүй байдал, хэв журам зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлд 2 улсын эрх бүхий байгууллагууд өөр хоорондоо шууд харилцаж, түргэн шуурхай хамтран ажиллах боломж бүрдэнэ.

Хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ж.Энхбаяр Бүгд Найрамдах Чех Улсад манай улсын хэчнээн иргэн байнга оршин сууж, хөдөлмөр эрхэлж байгаа, өнгөрсөн хугацаанд гэмт хэрэгт холбогдсон талаарх судалгаа мэдээлэл байгаа эсэх талаар асуулт асууж, хариулт авсан бөгөөд Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдээс үг хэлээгүй болно.

“Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай” Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай” Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, хуулийн төслийг эцэслэн баталж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Ажлын хэсгийг та бүхэнд танилцуулъя.

Сайнбуянгийн Амарсайхан Хууль зүй, дотоод хэргийн сайд, Баттулгын Батбямба Тус яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Чойжанцангийн Нарантуяа тус яамны Олон улсын гэрээ, гадаад хамтын ажиллагааны газрын дарга, Хишигтөмөрийн Дөлгөөн тус яамны Олон улсын гэрээ, гадаад хамтын ажиллагааны газрын шинжээч, Жамсранжавын Болд Цагдаагийн ерөнхий газрын дарга, Дотоодын цэргийн командлагч, хошууч генерал, Баатарсүрэнгийн Батзориг тус газрын Хуулийн хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21.24-д нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийж байгаа Засгийн газрын гишүүн, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орсон холбогдох албан тушаалтан үнэн зөв, бүрэн гүйцэд мэдээлэх үүрэгтэй. 21.25.Нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийх, асуултад хариулах, тайлбар өгөх албан тушаалтан өөрийн танилцуулсан мэдээллийн үнэн зөвийг хариуцах бөгөөд мэдээллийг санаатайгаар нуун дарагдуулах, худал мэдээлэл өгөх, танилцуулах, Улсын Их Хуралд худал мэдээлэл ирүүлэхийг хориглоно. 21.31.Чуулганы хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй, тайлбар өгөхөөс татгалзсан, худалдаанд оролцсон этгээд хуралдааны дэг зөрчсөн бол парламентыг үл хүндэтгэсэн үйлдэлд тооцож тухайн этгээдэд Төрийн албаны тухай болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэх гэж байгаа. Та бүхэнд энэ хуулийн заалтыг танилцууллаа.

Ингээд хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүдийн нэрсийг авъя. Аюушийн Ариунзаяа гишүүн.

А.Ариунзаяа: Ер нь би мэдээж дэмжиж байгаа. Энэ чинь нөгөө гарын үсэг гэрээ байгуулчихсан шүү дээ. Тэгээд бид нар соёрхон баталж байгаа байхгүй юу. 64 хүнээр эцсийн үе шат гэсэн үг. Тэгээд би юу гэж энэ үгийг авсан бэ гэхээр яасан их уддаг юм бэ. Бүр жилийн өмнө энэ чинь гарын үсэг зурсан гэрээ шүү дээ. Тэгээд дөнгөж одоо орж ирээд, бүр Алтангэрэлийн очиж байгуулсан гэрээ шүү дээ. 2025 оны 3 сард. Тэгээд тэр дор нь оруулмаар байгаа байхгүй юу. Энэ аль газар нь хариуцаад ингэж байнга удаагаад Улсын Их Хурлын гишүүд бүр марттал нь ингэж удаадаг юм бэ гэдгийг 1 талдаа асуумаар байна. Гадаад харилцааны яам юм уу, Засгийн газар юм уу. Хэн юм. Өөр ийм мартагдсан байгуулчихсан байгаа хэлэлцээр соёрхон батлаагүй асуудлууд байгаа юу, үгүй юу гэдгийг 1 талдаа асуухлаар надаа хариулж өгөх хүн байгаа юм болов уу. Байхгүй юм болов уу. Энийг анхаармаар байна нөхөд өө. Бид нар чинь олон улсын өмнө хүлээсэн үүргээ байнга мартдаг, удаадаг, ач холбогдлыг нь бууруулдаг ийм л нөхцөл байдалтай болчихоод байна. Уг нь Монголын Засгийн газар ч тэр, хэн нь ч сайд байсан бэ, хэн нь ч Ерөнхий сайд байсан бай 1 л Монгол Улс. Улсын Их Хурал ч гэсэн адилхан шүү дээ. Тэгэхээр энэ гадагшийгаа харьцаж байгаа энэ асуудлуудаа, хэлсэн үгэндээ шуурхай, хурдан хүрдэг баймаар байна гэдгийг нэг талдаа хэлье.

2 дахь нь болохлоор энэ хэлэлцээр ямар нэгэн мөнгөн дүн заасан ч юм уу, төсөв дээр ямар ч ачаалал үүссэн харилцаа байхгүй юм байна. Бид нар ч гэсэн ямар нэгэн байдлаар санхүүгийн дэмжлэг авах гээд байгаа асуудал огт байхгүй юм байна шүү дээ. Зүгээр л хоорондоо мэдээлэл солилцох, хамтран ажиллах юу гэдэг юм эдгээр асуудлуудтай 15 чиглэлээр гүйцэтгэх ажиллагаа гэдэг юм уу, мэдээлэл солилцохоор байгаа бол үүн дээрээ харилцан туслалцаа үзүүлэх асуудал байгаа юм байна.

Дээрээс нь яах вэ өөрсдийнхөө албан хаагчдынхаа ажлын туршлага гэдэг юм уу энэ сургалтуудыг бас харилцан мэдээллээ солилцож болно гэсэн ийм заалт байгаа юм байна. Гэрээ нь бол хугацаагүй байгуулагдсан юм байна гэж харж харлаа. Тэгээд бас энэ ташрамд минутаа ашиглаад Хууль зүйн сайд, хууль зүйн салбарт юу гэж хандаж хэлмээр байна вэ гэхээр Хүний эрхийн комиссын энэ жилийн 25 дугаар илтгэл дээр шүүх шинжилгээний байгууллагын тулгамдсан асуудлын талаар ийм тусгайлсан бүлэг байгаа. Уншаарай. Шүүх шинжилгээний салбартаа анхаарч өгөөрэй. Сайд болгон л өөрийн гэсэн онцлогтой байдаг шүү дээ. Таны хувьд яг энэ шүүх шинжилгээний ажлаа бас анхаарч, энэ шүүх шинжилгээний салбарыг хөгжүүлсэн ийм сайд байгаасай гэж хүсэж байна. Яагаад гэвэл энэ бол өөрөө эргээд Монгол Улсын яг энэ гэмт хэрэг болон өвчлөл илрүүлэх бүхий л энэ асуудлууд дээр чинь маш чухал салбар. Бид энэ салбараа ердөөсөө хөгжүүлэхгүй зүгээр л нэг ийм дайвар салбар юм шиг орхигдуулж ирсэн нь бас бодлогын алдаа юм.../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Асуултад хариулъя. Хэн хариулах вэ. Амарсайхан сайд хариулъя.

С.Амарсайхан: Иргэн төвтэй эрх зүйн шинэчлэл реформыг хууль зүйн салбарт эхлүүлж байгаа.

1 дүгээрт сая Ариунзаяа гишүүний ярьсан хүний эрхийн асуудал. Мэдээж Хүний эрхийн Үндэсний Комисс, олон улсын гэрээ, конвенц мөн хэм хэмжээ фактуудад заасан асуудлуудыг дотоодын хууль тогтоомжтой уялдуулах, олон улсын жишгээр хүний эрхийн асуудлуудыг хөнддөг байх, зохицуулдаг байх тогтолцоог илүү бэхжүүлэхэд анхаарч ажиллаж байгаа. Энэ чиглэлээр хууль зүй, дотоод хэргийн салбарт хүний эрхийн бодлого, зохицуулалтын, тэр дундаа салбарын хүний эрхийн асуудлуудыг зохицуулах, мөн дэмжлэг үзүүлж үндэсний комисстой хамтарч асуудлууд дээр дүн шинжилгээ хийх, дэмжлэг үзүүлж ажиллах ийм бүтэц зохион байгуулалтыг хийж байгаа гэдгийг хэлье. Энэ өөрөө бас олон талт хамтын ажиллагаа дээр үндэслэсэн асуудал.

2 дугаарт бид олон улсын өмнө хүлээсэн үүрэг НҮБ болон бусад улс орнуудтай хийсэн олон улсын гэрээ хэлэлцээрийн хэрэгжилт, түүний тайлан, цаг хугацаатай холбоотой анхаарах асуудлууд бий. Нэгэнт зурсан бол цаг алдалгүй хэрэгжүүлж эхлэх хэрэгтэй. Хэрэгжүүлж эхэлсэн бол үр дүн, тайланг нь зохих хугацаанд нь тайлагнадаг, дотооддоо төдийгүй гадаадын олон улсын байгууллагуудад хүргүүлэхээс гадна бодлого шийдвэртээ тусгаж ажилладаг байх нь бидний хамгийн чухал асуудал.

3 дугаарт энэ хэлэлцээр өөрөө олон чиглэлээр гэмт хэрэг гаралт, сэдэлт нарийсаж байгаа улс үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг, террорист бүлэглэлүүд, түүний хор уршгууд ихээхэн дэлгэрч байгаа энэ нөхцөлд бид хамтын ажиллагааг олон улсад улам өргөжүүлэх шаардлагын хүрээнд хийгдэж байгаа ажил. Энэ дээр заасан 5 зүйл, заалт бүхий үндсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд бодлогын болон үйл ажиллагааны уялдаа холбоог салбарын хэмжээнд хангах, түүний үр дүнг цаг тухай бүрд нь тооцож явах ажлууд, үүнтэй холбоотой тандан судалгааны ажлууд хийгдсэн байгаа. Зардлын тооцоонууд гарсан байгаа Үр нөлөөний судалгаа хийгдсэн байгаа. Үзэл баримтлал нь батлагдсан байгаа. Цаашлах юм бол энэ хэлэлцээр тодорхой дэлгэрэнгүй мэдээллүүдийг бас энэ танилцуулгад бэлдсэн байна. Өнөөдрийн байдлаар манай улсын 15 мянган иргэн Чех улсад ажиллаж, амьдарч байна. Тэдний эрхийг хамгаалах, мөн эрх зүйн орчныг бүрдүүлэх, харилцан гэрээ, эрх зүйн туслалцааны гэрээний үйл ажиллагааны хүрээнд хамтарч шийдвэрлэх олон асуудлууд байна гэж үзэж байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: Хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой санал хураалтыг үдээс хойш 14 цагаас санал хураалт явуулна. Ингээд үдээс өмнөх чуулганы хуралдааныг 14 цаг хүртэл завсарлуулж байна.

12.42 цаг.

ЗАВСАРЛАГА.

С.Бямбацогт: Үдээс хойших чуулганы нэгдсэн хуралдаанаа эхлүүлье. Хууль татах бичгээ өгчих үү. Энэ биш биз дээ.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32.3.Энэ хуулийн 32.1, 32.2-т заасны дагуу хуулийн төслөө татан авах тохиолдолд тухайн төсөл нь хэлэлцүүлгийн аль шатанд байгаагаас үл хамааран хууль санаачлагч хуулийн төслөө татан авах тухай албан бичгийг Улсын Их Хуралд ирүүлэх бөгөөд Улсын Их Хурлын дарга нэгдсэн хуралдаанд энэ тухай танилцуулснаар хууль

санаачлагч хуулийн төслөө татан авсанд тооцно. Үүний дагуу Улсын Их Хурлын гишүүн Мэндбаярын Мандхай

Монгол Улсын Их Хурлын дарга Сандагийн Бямбацогт танаа

Хуулийн төсөл татан авах тухай

Улсын Их Хурлын гишүүн Мандхай нарын 10 гишүүнээс 2025 оны 06 дугаар сарын 19-ний өдөр Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Баяжуулсан хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Органик бүтээгдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хүүхэд харах үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32.2-т заасны дагуу татан авч байгааг уламжилж байна.

Их Хурлын гишүүн Мандхай, Батболд, Отгонбаяр, Сайнзориг, Үүрийнтуяа, Чинбүрэн, Энхнасан гэсэн бичгийг уншиж танилцууллаа. Хуулийн төслийг татан авсанд тооцлоо./14:03/

Дараагийн асуудалдаа орё.

Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Сайнбуянгийн Амарсайхан танилцуулна. Таныг индэрт урьж байна.

С.Амарсайхан: Эрхэм Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 05 дугаар сарын 22-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төслийг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 06 дугаар сарын 03-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэх эсэхийг хэлэлцэн дэмжсэн болно.

Монгол Улс уур амьсгалын өөрчлөлтөд хамгийн эмзэг орны 1 болоод байгаа бөгөөд сүүлийн 80 гаруй жилийн хугацаанд манай орны агаарын дундаж температур 2,5 хэмээр нэмэгдэж, ган, зуд, үер, шороон шуурга зэрэг гамшигт үзэгдлийн давтамж, эрчим эрс өсөж нэмэгдэж байна. Зөвхөн 2023-2024 оны зудын улмаас 9,1 сая толгой мал хорогдож, эдийн засагт ихээхэн хохирол учруулж, энэ хүрээнд 2,8 их наяд төгрөгийн хохирол учирсан нь уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны төдийгүй эдийн засаг, хүн амын амьжиргаа, үндэсний аюулгүй байдлын томоохон асуудал болсныг харж байна.

Монгол Улс НҮБ-ын уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенц болон Парисын хэлэлцээрийн хүрээнд олон улсын өмнө хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх, Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтоо хангах, ногоон шилжилтийг эрчимжүүлэх шаардлагатай тулгарч байна.

Гэвч өнөөг хүртэл уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой харилцааг салангид бодлого, салбарын хуулиудаар зохицуулж ирсэн бөгөөд нэгдсэн эрх зүйн орчин бүрдээгүй байгаа нь асуудлыг шийдвэрлэхэд хүндрэлтэй орчныг бий болгож байна.

Иймд энэхүү хуулийн төсөл нь уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, даван туулах бодлого, арга хэмжээг нэгдсэн тогтолцоонд оруулах, хүлэмжийн хийн хэмжилт, тайлагнал, баталгаажуулалтын тогтолцоог бүрдүүлэх, ногоон санхүүжилт болон нүүрстөрөгчийн зах зээлийн эрх зүйн орчныг бий болгоход чиглэж байгаа билээ.

Түүнчлэн Монгол Улс 2026 онд НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх тухай конвенцын талуудын 17 дугаар бага хурал буюу Коп 17-г эх орондоо зохион байгуулах гэж буй энэ цаг үед уур амьсгал, цөлжилт, газрын доройтол, тогтвортой хөгжлийн асуудлаарх үндэсний манлайллаа бэхжүүлэх, олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх, ногоон хөрөнгө оруулалт татах эрх зүйн суурийг бүрдүүлэх, өөрөө стратегийн ач холбогдолтой асуудал юм.

Хуулийн төсөл батлагдсанаар уур амьсгалын өөрчлөлтийн засаглал, салбар дундын зохицуулалт сайжирч, олон улсын санхүүжилт болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт нэмэгдэх, карбон зах зээлийн эрх зүйн орчин бүрдэх, орон нутгийн дасан зохицох чадавх бэхжих, урт хугацааны тогтвортой хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх суурь нөхцөл бүрдэх юм.

Иймд Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэн дэмжиж өгөхийг Улсын Их Хурлын эрхэм гишүүд та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

С.Бямбацогт: Амарсайхан сайдад баярлалаа. Төслүүдийн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Салдангийн Одонтуяа танилцуулна. Таныг индэрт урьж байна.

С.Одонтуяа: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 05 дугаар сарын 21-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх асуудлыг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2026 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, тогтвортой хөгжлийн зорилтод нийцсэн уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, түүнд дасан зохицох болон даван туулах бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэх цогц судалгаа, мэдээллийн санг бүрдүүлэх, ногоон санхүүжилтийн тогтолцоог хөгжүүлэх, төрийн

байгууллагын чиг үүрэг бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох, салбар дундын уялдаа холбоог зохицуулах эрх зүйн үндсийг бүрдүүлэх зорилгоор уг хуулийн төслийг боловсруулсан байна.

Хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор хуулийн этгээд, иргэн, төрийн байгууллага болон улсын төсөвт нэмэлт зардал үүсэхгүй бөгөөд хуульд заасан хүлэмжийн хийн үндэсний тооллого, бүртгэл, уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, тайланг боловсруулах үйл ажиллагааг батлагдсан орон тоо, төсвийн хүрээнд тухай бүрд нь шийдвэрлэх боломжтой гэж төсөл санаачлагч гэж үзжээ.

Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг D-parliament.mn цахим хуудаст байршуулж, иргэд олон нийтийн саналыг авч байна.

Хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар үндэсний зохицуулагч байгууллагын үйл ажиллагааны үр дүн, 2 талт болон олон талт карбон зах зээлийн хүрээнд хэрэгжих төсөл хөтөлбөрүүдийн судалгааг хийсэн эсэх, газартай холбоотой карбон кредитийн зохицуулалтыг хэрхэн шийдвэрлэх талаар асуулт асууж, хариулт авлаа.

Хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж байгаагаа илэрхийлээд, хэлэлцүүлгийн явцад төслийн нэр, томъёог жигдлэх зүйл, хэсэг, заалтын дугаарыг нийцүүлэх, эрдэмтэн судлаачдын саналыг тусган сайжруулахад анхаарах талаар санал хэлсэн болно.

Уур амьсгалын өөрчлөлтийн тухай болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Агаарын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Тариалангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Олон улсын гэрээний тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрчим хүч хэмнэлтийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Гамшгаас хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Статистикийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

С.Бямбацогт: Одонтуяа гишүүнд баярлалаа. Гишүүдийг чуулганы хуралдааны танхимдаа хүрэлцэн ирэхийг урьж байна. Чухал асуудал хэлэлцэж байгаа. Өнөөдөр бол Дэлхийн байгаль орчны өдөр. Энэ жил дэлхий нийтээрээ уг өдрийг дохио нэгэнт

тодорхой боллоо. Дараагийн алхам биднээс шалтгаална гэсэн уриа дор тэмдэглэн өнгөрүүлж байгаа. Энэхүү уриа нь уур амьсгалын өөрчлөлт, газрын доройтол, усны хомсдолын эсрэг улс орон цаг алдалгүй шийдвэртэй алхам хийхийг бидэнд хатуу сануулж байгаа.

Өнөөдөр байгаль орчны асуудал экологийн хүрээнээс салж, эдийн засаг, хүнсний аюулгүй байдал, иргэдийн эрүүл мэндтэй салшгүй холбогдсон хөгжлийн тулгуур болсон. Манай Улсад нутаг дэвсгэрийн 70 гаруй хувь нь цөлжилтөд өртсөн, усны нөөц хомсдож байгаа нь байгаль хамгааллын эрх зүйн орчныг эрс шинэчлэхийг биднээс шаардаж байгааг та бүхэн бас анзаарч байгаа байх. Энэ утгаараа Монгол Улс НҮБ-ын цөлжилттэй тэмцэх коп-17 олон улсын бага хурлыг эх орондоо 8 дугаар сар зохион байгуулах гэж байгаа. Энэ бол бас ногоон санхүүжилт хөрөнгө оруулалт татах түүхэн томоохон үйл явдал гэж бид бас харж байгаа.

Монгол Улсын Их Хурал ч гэсэн бас байгаль орчны эрх зүйн шинэчлэлд онцгойлон анхаарч ажиллаж байгаа. 2026 оны хаврын чуулганаар бид Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийг хэлэлцэж, эцэслэн баталсан.

Одоо Уур амьсгалын өөрчлөлтийн тухай анхдагч хуулийг чуулган хэлэлцэж эхлээд байна. Мөн бас өчигдөр Ойн тухай хуулийг хэлэлцэхээр өргөн барьж, Их Хуралд мэдүүлж, ирэх 7 хоногоос хэлэлцэж эхэлнэ. Тийм болохоор бас энэ байгалийн баялгийн зохистой ашиглалт, нөхөн сэргээлтийг шинжлэх ухааны үндэстэй хэрэгжүүлэх, иргэдийнхээ амьдралын чанар, хүнсний аюулгүй байдлыг баталгаажуулахын төлөө бас байгаль орчноо хамгаалахын төлөө Монголчууд Их Хурал бас илүү санаачилгатай байхыг эрхэм гишүүдээсээ хүсэж байна.

Асуулт асуух гишүүдийн нэрсийг өгье.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Байгаль орчин, уур амьсгалтын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Шүрэнчулууны Батбаяр, Батчулууны Бат-Өлзий, Байгаль орчин, уур амьсгалтын өөрчлөлтийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Батхишигийн Мөнх-Эрдэнэ Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга, Саруулын Пүрэвсүрэн Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын Ногоон санхүүжилтийн бодлогын хэлтсийн дарга, Батбаатарын Амарбаясгалан Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Санхүүгийн зах зээл, олон улсын хамтын ажиллагааны хэлтсийн дарга. Ийм ажлын хэсэг хүрэлцэн ирсэн байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанд оролцож байгаа Засгийн газрын гишүүн, холбогдох албан тушаалтан, ажлын хэсгийн гишүүд Улсын Их Хуралд, Их Хурлын гишүүдийн асуултад үнэн зөв, бодитой мэдээлэл өгч хариулт өгөх, худлаа мэдээлэл өгч болохгүй. Улсын Их Хурлын үйл ажиллагаанд хүндэтгэлтэй хандахыг бас сануулж байна. Холбогдох бас хуулийн хариуцлага тооцдог шүү гэдгийг сануулж байна.

Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн асуултаа асууя.

Д.Энхтүвшин: Хуулийн төслөөс 1, 2 асуулт байна.

19.4 дээр нь энэ Монгол Улсын нутаг дэвсгэрт хэрэгжсэн үйл ажиллагаанаас бий болсон, олон улсад шилжээгүй, холбогдох журмын дагуу баталгаажсан сааруулалтын үр дүнг талуудын тохиролцооны үндсэн дээр үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтын биелүүлэлтэд тооцно гээд. Өөрөөр хэлбэл энэ NDC-г хангахын тулд хувийн хэвшлүүдийн бий болгосон энэ сааруулалтын үр дүнг жишээлбэл ямар нэгэн байдлаар зах зээлийн ч юм уу, тодорхой ямар үнэлгээгээр авах юм гэдэг юм нь байхгүй. Өөрөөр хэлбэл олон улсын зах зээл дээр зарах бололцоотой энэ кредитийг нь тохиролцооны үндэс дээр засагтай ч хувийн хэвшил тохиролцоход аягүй хэцүү. Дээр нь энэ байгууллага байгаль орчны уур амьсгалын өөрчлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын гол үүрэг нь яг энэ зах зээлийг карбон зах зээлийн үйл ажиллагааг удирдах энэ сааруулалтын үр дүн үүсэх, төсөл хөтөлбөр татгалзахгүй гэсэн тодорхойлолт өгөх, зөвшөөрсөн гэсэн тодорхойлолт өгөх. Өөрөөр хэлбэл бүхэлд нь ингээд базаж байгаа. Тэгэхээр хэрвээ ийм тохиролцооны гэдэг ч юм уу ийм ерөнхий заалтууд оруулаад ирэхээр олон улсад ч гэсэн ийм байдаггүй зах зээлийн үнээр гэсэн шийдлүүд байдаг. Тэгэхээр энэ хувийн хэвшлийн зах зээл чинь хөгжихгүй юм биш үү. Тэгэхээр энэ заалт чинь ийм тодорхой бүрхэг байгаа. Энийг яагаад ийм бүрхэг оруулсан юм бэ гэдэг 1 дүгээр асуулт байна.

Хоёрдугаарх нь энэ орон нутгийн оролцоо бас аягүй өндөр заалтууд байна. Тухайлбал 23.3.5 дээр нь орон нутгийн өөрөө удирдах байгууллагын дэмжсэн тогтоол, тэгээд 3.8 дээр нь болохоор орон нутгийн иргэдтэй урьдчилан зөвлөлдөж санал авсан байх. Тэгээд 24.2 дээр нь энэ үүссэн карбон кредитийн эзэмших эрхийг нь бас төсөл хэрэгжүүлсэн орон нутгийн төлөөлөл нь бас хамтран эзэмшихээр иймэрхүү заалтууд орсон байна л даа. Тэгэхээр энэ жишээлбэл яг карбон кредит ч юм уу энэ утаа бууруулах, цөлжилттэй тэмцэх, энэ мод тарих гэдэг төслүүдийн чинь гол үр дагаврыг нь хүртэх хүмүүс нь өөрсдөө орон нутгийн иргэд байтал тэгээд эндээс баахан зөвшөөрөл бид нар уул уурхайн төслүүдийг мэднэ шүү дээ. Ингээд энэ төслүүдийг явуулахгүй байх хувийн хэвшлийн санал, санаачилгуудыг хэрэгжүүлэхгүй байх ийм сөрөг хүчин зүйлүүд, хязгаарлалтууд байгаад байна л даа.

Тэр үнийн худалдан авах зохицуулалтууд дээр ч гэсэн энэ орон нутгийн ч гэсэн иймэрхүү зохицуулалтууд байгаад байна. Тэгэхээр энэ хуулийн төсөл маань бүхэлдээ зүгээр NDC буюу яг улсын тэр зорилгыг биелүүлэхийн төлөө л хийж байгаа хууль юм шиг л харагдаад байна л даа. Тэгэхээр энэ дээр тодруулалтууд авмаар байна.

Тэгээд өнгөрсөн хугацаанд ч гэсэн яг энэ улсын зорилгодоо бид нар бас NDC-тэй ач холбогдол өгч байгаа юм уу гэхээр зүгээр өнгөрсөн 3 жил 2021 онд жишээлбэл энэ аргачлалын хувьд алдаа байж магадгүй 56,4 сая тонн нүүрсхүчлийн хий ялгаруулсан бол 3 жилийн дараа 98,7 болж бараг 2 дахин нэмэгдсэн байгаа байхгүй юу. Тэгээд бид нарын зорилт болохоор 54,8 сая тонн нүүрсхүчлийн хийгээр энэ ялгаруулалтаа хязгаарлана гэсэн зорилт байгаад байдаг. Тэгээд уг нь энэ хуулийг гаргаснаараа ач холбогдлыг нь бол ойлгоод байна л даа. Энэ Монгол Улсад хэрэгтэй төслүүдийн санхүүжилт эх үүсвэр талдаа ч юм уу эсвэл бусад дэмжлэг талаасаа бол ашиглаж болохоор ийм дүр зураг байгаад байгаа юм. Тэгэхдээ яг энэ хуульд орж ирсэн заалтууд нь яг тийм агуулгатай биш, засаг өөрийнхөө NDC-ээ биелүүлэхийн тулд л шахсан ийм дүр зургуудад харагдаад байна л даа. Энэ дээр тайлбар өгөөч.

С.Бямбацогт: Ажлын хэсэг 4 дүгээр микрофон.

Ш.Батбаяр: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам Батбаяр. Гишүүний асуултад хариулъя.

1 дүгээр асуултын хувьд хувийн хэвшилд бол ямар нэгэн дарамт учруулахгүй. Яагаад гэхээр энэ зах зээл маань өөрөө шинэ тутам байгаа, хэрэгжүүлэгч байгууллага, мэргэжилтэн, боловсон хүчнүүд маань бас дутмаг байгаа энэ үед бас төрийн оролцоо байж, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны дэргэдэх Цаг уур орчин шинжилгээний газраас энэ бүх хэмжилтийн багаж тоног төхөөрөмжүүд маань тэнд суурьшсан байдаг. Тэгээд тэр үүднээс 1 дүгээрт, 2 дугаарт төсөвт ямар нэгэн дарамт учруулахгүй, орон тоо нэмэхгүй байх үүднээс энэ цаг уурын байгууллагын хувьд байгаль орчны дэргэд байгаа байгууллагыг оруулна гэж үзэж хуулийн төсөлд оруулсан.

Зөвшөөрөл олгох зохицуулалт нь бол зах зээлийг хязгаарлах биш харин Монгол Улсын үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилт болон бусад үндэсний эрх ашгийг хамгаалах зорилготой зарим сааруулалтын үр дүнг Монгол Улс өөрийн үндэсний хувьд тодорхойлсон хувь нэмэртээ оруулах, 2 дугаарт нөгөө олон улсын жишигт байдаг давхардсан бүртгэлийг л ер нь урьдчилсан сэргийлэх зорилгоор энэ хэлэлцээр хийж оруулна гэж оруулсан байгаа юм.

2 дугаар асуултын хувьд орон нутгийн иргэдийн оролцоо их байна гэж гишүүний асуулт байна. Тэгэхээр энэ бас иргэдээс ирүүлсэн санал, олон улсын туршлага дээр бас энэ карбоны зохицуулалттай холбоотой олон маргаан Арбитрын шүүхүүдээр явдаг юм байна лээ. Ялангуяа энэ карбон шингээлттэй холбоотой ой болон малын бэлчээр дээр бас их маргаанууд үүсдэг. Тэгэхээр энэ газар, бэлчээр дээр карбон шингээлтийг хийх үйл ажиллагааг заавал тухайн орон нутгийн Засаг даргаас тогтоолоор зөвшөөрөл аваад, мөн орон нутгийн иргэдэд танилцуулж мэдээлэл өгч авах ажлыг зохион байгуулж байгаа. Үр шимээс бас орон нутгийн иргэдэд хувь хүртээх энэ 3 зохицуулалтыг оруулж өгсөн байгаа. Энэ нь бол олон улсын түншлэгч байгууллагуудаас хуулийн төслийг боловсруулах үед бидэнд өгсөн зөвлөмжийн дагуу хийгдсэн ажил байгаа.

С.Бямбацогт: Энхтүвшин гишүүн тодруулж асууя.

Д.Энхтүвшин: Хувийн хэвшилд дарамтгүй гээд байгаа. 19.4 дээр чинь олон улсад жишээлбэл энэ зах зээлийг энэ агентлаг чинь өөрөө зохицуулж байгаа, хянаж байгаа, тэгээд олон улсад зарах бололцоотой энэ сувгийг чинь яг энэ хаалгыг нь барьж байгаа хүн чинь энэ агентлаг чинь байгаа. Тэгээд тохиролцооны үндсэн дээр үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтын биелэлтэд тооцож болно гээд. Жишээлбэл улсынхаа NDC-дээ тооцъё гээд авчихъя гэвэл яаж тооцох гэж байгаа аргачлал нь байхгүй. Тэгэхээр чинь энэ тохиролцсоны аргаар гэдэг чинь төртэй тохиролцоно гэж байхгүй. Тэгэхээр шууд өөрийнхөө энэ зорилтдоо улс тооцуулахаар авахад ямар нэгэн хамгаалалт, зорилт байхгүй. Нөгөө талд нь яах вэ өмчлөл нь байна гэж оролцогч талууд тэр карбон кредитээ өмчлөх эрх нь байгаа гэж байгаа боловч яг энэ эдийн засгийн харилцаанд орох үед бол тохиролцоо гээд энэ ерөнхий заалт чинь олон улс дээр энийг чинь дуудлага худалдаагаар ч гэдэг юм уу, олон улсын жишиг үнээр ч гэдэг юм уу иймэрхүү зүйл байдаг байтал ч энэ дээр чинь тохиролцоо гэдэг чинь өөрөө ингээд хаачхаж байгаа байхгүй юу.

С.Бямбацогт: Ажлын хэсэг хариулъя. 4 дүгээр микрофон.

Ш.Батбаяр: Энэ хуулийн заалт нь бол хувийн хэвшлийн зах зээлийг дахин хэлэхэд зах зээлийг хязгаарлах бус, тэгээд яг үндэсний тодорхойлсон хувь нэмэртээ аль нь орох юм бэ, аль нь орохгүй вэ гэдгийг зөвшөөрлийг нь л өгч байгаа. Зарим тохиолдолд саяын хэлсэнчлэн давхардсан бүртгэл орох гээд байдаг. Тэгэхээр талуудын тохиролцоо гэдэг нь бол төр хувийн хэвшлийн бий болгосон сааруулалтын үр дүнг нэг талын байдлаар үндэсний тодорхойлсон хувь нэмэрт тооцохгүй гэдгийг нь бас оруулж өгч байгаа юм. Тэгэхээр танай энэ үүсгэсэн кредит маань энд манай үндэсний тодорхойлсон хувь нэмэрт орохгүй гэдэг л ойлголцолд 2 талаас хүрнэ гэдэг баталгаажуулалтыг хийж өгч байгаа юм. Хэрэв ийм зохицуулалт байхгүй болохоор 1 сааруулалтын үр дүнг хувийн хэвшил зах зээлд ашиглаад, төр нөгөөдхийг нь үндэсний тодорхойлсон хувь нэмэртээ бүртгэх эрсдэл үүсээд байгаа. Тэгээд тэр нь дараа нь бол нэлээн том асуудал үүсэх нь манай олон улсад хэлэлцээрээр хүлээсэн үүрэгт маань бас тодорхой хариуцлагын асуудал яригдах учраас энийг бол заавал ч үгүй тусгах үүрэгтэй. Бүр .../минут дуусав/

С.Бямбацогт: Дахиж тодруулъя. Хариулт хангалтгүй л байгаад байна даа.

Д.Энхтүвшин: Өөр хүн хариулах юм уу. Асуулт ойлгохгүй байна. Сая асуултад хариулсан хүн бол асуудлаа сайн мэдэхгүй хүн байна шүү дээ. Өөр хүн хариулт өгмөөр байна. Мэддэг хүн байвал. Мэдэхгүй бол мэдэхгүйгээ хэлчих.

С.Бямбацогт: Ажлын хэсэг 4 дүгээр микрофон.

Б.Бат-Өлзий: Байгаль орчны яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Бат-Өлзий. Гишүүний асуултад хариулъя. Яг хувийн хэвшилд мэдээж үндэсний тодорхойлсон хувь нэмэр дээрээ бид нар Монгол улс олон улстай нөгөө амлалт өгчихсөн. Тэр амлалтаасаа хэрвээ кредит болгоод гаргаад зарчих юм бол тэр амлалтдаа хүрээгүй буюу бид нар буцаагаад нөгөө хүрэх ёстой амлалтаасаа хасагдана гэсэн үг. Тэгэхээр энэ давхар тооллогыг заавал ... тэгэхээр карбон кредитийн хувьд бол үндэсний гэж байгаа. Олон улсынх, улс хоорондынх байгаа. Олон талт байгаа нэмэх нь нөгөө Вера Гоулд буюу сайн дурын зах зээл гэж байгаа. Сайн дурын зах зээлийн үнэ бол яг тэр тухайн мөчөөрөө явж байгаа. Үндэсний .../минут дуусав/

С.Бямбацогт: Энхтүвшин гишүүний асуултад бичгээр хариулт өгье. Хариулт хангалтгүй байна. Хариулт тодорхой бус байна. Тэгээд гоё нэртэй чухал хууль гээд оруулаад ирдэг. Оруулж ирсэн хуульдаа төрдөө давуу байдал бий болгоод, хувийн хэвшил, иргэд, аж ахуйн нэгжээ дарамталсан, хүнд суртал бий болгосон, давуу байдал олгосон ийм тэгш бус байж болохгүй. Тийм болохоор энэ хуулиуд дээр бас Энхтүвшин гишүүний ярьж байгаа үнэхээр иргэд, аж ахуйн нэгжүүддээ ямархуу ээлтэй бодлого байгаа юм. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийг шийдэхэд бүх нийтийн оролцоо хэрэгтэй. Энэ тал дээр бүх нийтийг оролцуулах тал дээр яаж урамшуулж хөшүүрэг байгаа юм. Бичгээр хариултыг гүйцээж өгөөрэй.

Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Сайнбуянгийн Амарсайханы урилгаар нийслэлийн Налайх дүүргийн ерөнхий боловсролын 100 дугаар сургуулийн 1996 оны төгсөгчид, Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Төрийн ордонтой танилцаж байгаа, төгсөлтийнхөө 30 жилийн ойг

тэмдэглэж байгаа нийт төгсөгчдөдөө Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүн асуултаа асууя.

Д.Пүрэвдаваа: Ажлын хэсгийнхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Ерөнхийдөө хуулийн төслийг бол дэмжиж байгаа. Хэд хэдэн тодруулах асуудлууд байна.

1 дүгээрт энэ хуулийг хэрэгжүүлэхэд санхүүжилтийн эх үүсвэрийг аягүй сайн тодорхойлоод өгөөч. Хэр их төсөвт дарамт үзүүлэх юм бэ.

2 дугаарт жилийн дунджаар сүүлийн 10-аад жилийн хугацаанд 2 градусаар ингээд Монгол Улсын температур өссөн гэж байгаа. Үүнтэй уялдуулаад энэ цөлжилтийн асуудал ер нь яаж явагдаад байдаг юм бэ. Жишээгээр бол энэ Өмнөговь аймгийн Ханбогд сум. Тэнд бол усны асуудал нь хүндрээд байдаг. Оюутолгой нь нөлөөлдөг юм уу, нөлөөлдөггүй юм уу. Эсвэл энэ уур амьсгалын өөрчлөлтөөс болоод асуудал нь болоод байдаг юм уу.

Тэгээд өмнө нь би бас танай энэ байгаль орчинтой холбогдуулсан асуудал ороод ирэхээр зэрэг асууж байсан. Энэ байгаль орчны дүгнэлт, нөлөөллийн дүгнэлтийг хараат бус байх асуудлыг та хэд маань яаж ер нь ирээдүйг харж байгаа юм бэ. Уул уурхайн компаниуд нь өөрсдөө санхүүжилтийг нь өгөөд, тэгээд дүгнэлтээ гаргадаг. Тэгээд Оюутолгой дээр усны асуудал яригддаг. Тэр Завханы Дөрвөлжинд 1 алтны. уул уурхай байдаг. Тэгээд тэр нөгөө цианитээ алдаад, мал, хүн, байгаль орчин хордсон гэдэг. Тэгэнгүүтээ л нөгөөдөх нь өөрсдөө алтны компани нь өөрсдөө санхүүжүүлчихдэг учраас нөлөөлөлгүй гээд л гараад ирдэг. Тэгэхээр зэрэг та хэд маань ямар судалгааны аргачлал хэрэглэсэн юм. Ер нь ирээдүйг юу гэж харж байгаа юм. Энэ уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй нөлөөллүүд юу байна. Уул уурхайгаас үүдэлтэй нөлөөлөл юу байна. Тэрийг аягүй сайн ард түмэндээ тодорхой болгож өгөх ёстой юм болов уу гэж харж байгаа юм.

Дээрээс нь энэ аж ахуйн нэгжүүдэд нэмэлт тайлагнал, зардал чирэгдлийг нэмэгдүүлэх вий. Дахиад л энэ хууль санаачлаад л ороод ирэхээр зэрэг үйл ажиллагаа явуулж байгаа нөхдүүддээ бас нөгөө талд нь хүндрэл үүсгэх гээд байдаг. Энийг яаж тооцсон бэ гэдгийг асууя. Тэгээд тодруулъя.

С.Бямбацогт: Ажлын хэсэг хариулъя. 4 дүгээр микрофон.

Ш.Батбаяр: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам Батбаяр. Гишүүний асуултад хариулъя. Санхүүжилтийн эх үүсвэр төсөвт дарамт үзүүлэх тал дээр бол Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хууль нь бол төсөвт ямар нэгэн дарамт үзүүлэхгүй. Олон улсын жишгээр уур амьсгалын өөрчлөлтийн хуулийг санаачлан баталснаар тухайн орны уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой, ногоон технологитой холбоотой гаднын хөрөнгө оруулалтын хэмжээ 2-3 дахин нэмэгддэг гэдэг тооцоо судалгаа байгаа. Тэгэхээр энэхүү хуулийг батлагдсанаар гадаадын хөрөнгө оруулалт, ногоон зах зээлийн эрэлт, дотоодод оруулж ирэх гадаадын валютын хэмжээ бол 2-3 дахин өснө гэж тооцож байгаа.

Цөлжилтийн асуудал хэрхэн явагдаж байгаа тал дээр одоогийн газар нутгийн 76 хувь нь ямар нэгэн байдлаар цөлжилт нь нэрвэгдсэн гэдэг цөлжилтийн зураглал

маань 2020 онд гарсан зураглал байгаа. Энэ жил буюу 2026 онд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас цөлжилтийн зураглал буюу атласаа шинээр гаргаж ирж байгаа. Тэгэхээр энэ дээр бол тодорхой цөлжилтийн явц аль аль газар нутгуудаар их байна, аль уул уурхайн бүс нутгаар ямар хэлбэртэй явж байгаа гэдэг 2 дахь зураглал гарч ирснээр бид бол бас тодорхой дүгнэлтүүдийг хийх боломжтой байгаа.

Байгаль орчны үнэлгээний хараат бус байдал дээр бол саяын үнэлгээний тухай хуулийн шинэчлэл дээр бид нэлээн томоохон өөрчлөлтүүдийг оруулж чадсан гэж бодож байгаа. Орон нутгийн иргэдийн буюу нөлөөллийн бүс тухайн төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа газар нутгийн нөлөөллийн бүсийн иргэдийн 70-аас дээш хувийг энэхүү үнэлгээ хийж байгаа компани маань саналыг авч, саналыг тусгах заалт орж өгсөн байгаа. Тэгэхээр энэ дээр бол хараат бус байдал, иргэдийн оролцоо нэлээн өндөр хэмжээнд явж байгаа. Шаардлагатай тохиолдолд орон нутгийн иргэдийн Хурлаар энэ асуудлыг хэлэлцүүлэх асуудал нээлттэй үлдсэн байгаа.

Хуультай холбоотой нэмэлт тайлагдал чирэгдэл бол үүсэхээргүй байгаа. Харин түрүүн хэлсэнчлэн давхар тооцоолол, давхар бүртгэл мөн хуульд заагдаагүй, өмнө нь тусгагдаагүй аль нэгэн хууль, эрх зүйн байдалд тусгагдаагүй байсан олон асуудлууд тодорхой болж байгаа. Засгийн газраар хэлэлцэн батлах 4 журам, яамны хэмжээнд хийх 3 журам аргачлал байгаа. Энэ дээр бол ямар нэгэн хүнд суртал, төлбөр тооцооны асуудал яригдахгүй байгаа. Зөвхөн зах зээлээ зохицуулах, орчноо тодорхой болгох л асуудлууд тусгагдаж байгаа.

С.Бямбацогт: Пүрэвдаваа гишүүн тодруулж асууя.

Д.Пүрэвдаваа: Асуулт гэхээсээ илүү үг хэлчихье дээ. Ер нь бол хуулийн төслийг уншиж танилцахаар зэрэг олон улсаас ирэх дэмжлэг нэмэгдэнэ гэж харж байгаа. Гэтэл манай өнөөдөр төрийн үйл ажиллагаа маань яг олон улсынхаа жишигтэйгээ тийм нийцэхүйц тунгалаг ил тод байж чадахгүй байна гэдгийг та хэд маань анхаараарай.

Олон улсад бол бүх зүйл, ялангуяа энэ байгаль дэлхийдээ маш ээлтэй болж эхэлж байгаа. Европын орнууд, ер нь бүх л орнууд. Хөрш орон Хятад орон гэхэд хүртэл маш тийм байгальд ээлтэй орон болж хувирсан. Монгол Улс яг үүнтэй уялдаж ажиллах ёстой. Ялангуяа салбар хоорондын уялдаа холбоог та бүхэн маань анхаарч хуульдаа маш сайн тусгаж өгөөрэй гэж хэлэх байна. Баярлалаа.

С.Бямбацогт: Үг хэллээ. Улсын Их Хурлын гишүүн Батын Батбаатар гишүүн асуултаа асууя.

Б.Батбаатар: Энэ хуулийг зарчмын хувьд дэмжиж байгаа. Байгаль орчны сайд, дараа нь Эдийн засаг, хөгжлийн сайд, Байгаль орчны сайдын хамтарсан, эргээд Байгаль орчны сайд, эргээд Их Хурлын дарга, тэгээд Ерөнхий сайд гээд ингэж энэ шат дамжлагыг туулж явсаар байгаад өнөөдөр Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар орж ирж байгаа.

Уур амьсгалын өөрчлөлтийн анхдагч хуулийг батлуулахын ач холбогдол юу вэ гэхээр бид нар дэлхийтэй хөл нийлүүлж эхлэх юм. Байгаль орчин гэдэг бол хил

хязгаар тусдаа улс гэдэг ойлголт байхгүй шүү дээ. Дэлхий нийтээрээ үргэлжилж байдаг ганцхан бөмбөрцөг байгаа. Энэ зүйл дээр өнөөдөр бид нар бодож энэ хуулийг яаралтай баталж, ажил хэрэг болгох нь зүйтэй.

Хуульгүй казино Монголд явж л байсан. Хуульгүй койн явж л байсан. Тэр болгоноос тодорхой хэсэг бүлэг юм уу, түрүүлж хуульгүй орчинд нь үйл ажиллагаа явуулсан хүмүүс ашиг олоод, энгийн иргэд алдаад, хохирдог. Тийм болохоор Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулиа гүйцэд ойлгоогүй дэлхий нийтэд ингэж байнга өөрчлөгдөж, шинэчлэгдэж байгаа зүйлийг өнөөдөр Монгол Улсад орж ирээд карбон кредитийн наймаа хийх гэж байгаа сонирхлын, бизнесийн бүлэглэлүүдийн танилцуулж байгаа танилцуулгаар ойлгож, энэ хуульд халдвал энэ өөрөө буруу болоод явчихна. Уур амьсгалын өөрчлөлтийн хууль дээр хэдүүлээ бас арай өөр байдлаар хандаж, энийг илүү сайн мэдэж байгаа. Мэдээж Их Хурлын гишүүд 126 бол бүгдээрээ бүх юмыг мэддэг, өөр өөрсдийнхөө салбарын асуудлуудыг ойлгоно, мэднэ. Өөр өөрсдийнхөө салбарын өнцгөөс асуудалд хандаад эхэлбэл энэ хууль өөрөө буруу эвдэрвэл ашиг тустай хууль биш болно. Тийм болохоор түрүүн тэр тохиролцоогоор энэ тэр гээд Энхтүвшин гишүүн асуугаад байна лээ. Энэ чинь бас тодорхой хэмжээнд эндээсээ 3 буюу үндэсний тодорхойлсон хувь нэмрээ 3.0 манайх батлаад, НҮБ-ын 80 дугаар чуулганаас өмнө Ерөнхийлөгч очиж чуулганд орохоос өмнө олон улсад бид нар нээлттэй зарлаад, энэ амлалт үүргээ авчихсан. 30,3 хувиар хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах энэ зорилт авчихсан.

Хэрвээ замбараагүй карбон кредитийн чиглэлээр бизнесийн болоод орон нутгийн эрх ашиг гэдгээр хэтэрхий сул тавивал эргээд Монгол Улс зарснаасаа 10 дахин илүү өндөр үнээр карбон кредит худалдаж авах үүрэг хүлээж эхлэх юм. 2035 онд 30,3 хувь болгоно. Тийм болохоор энэ зохицуулалтууд хуульд орж байгаа гэдгийг бодож ойлгож бас явахгүй бол нөгөө ажлын хэсгийнхнийг ажлаа мэдэж байна, мэдэхгүй байна гэдгээр хэлээд байвал нөгөө бид нар өөрсдөө энд Их Хурлын гишүүд бүгдээрээ энэ уур амьсгалын өөрчлөлтийн анхдагч хуулийг мэдэхгүй шүү дээ. Дэлхий нийтийн хандлага, байгаль орчны байгууллагууд хэрхэн дүгнэж, яаж оролцож байгаа, алдаа оноо нь юу байсан юм. Тэр болгонд суурилж засвар зөвлөмж авч ингэж хийгдсэн хууль гэдгийг хэлмээр байна. Тийм болохоор та бүхэн бас үүн дээрээ анхаарч явахгүй бол буруу хандлагаар явчих вий гэдэгт бас санаа зовж байна. Баярлалаа.

С.Бямбацогт: Байгаль орчны сайд асан Батбаатар гишүүн үг хэллээ. Салдангийн Одонтуяа гишүүн, Байгаль орчны сайд асан.

С.Одонтуяа: Маш чухал хууль. Тэгээд намайг бас сайд байхад бид бас энэ үзэл баримтлалыг нь боловсруулаад, ажиллаж байсан. Батбаатар сайдын хувьд бас энэ дээр нэлээд анхаарч ажилласан. Ялангуяа бид нар энэ коп-ын хурлын өмнө энэ Уур амьсгалын өөрчлөлтийн хуулиа батлаад авбал тун чухал ийм үйл ажиллагаа болно. Би 5 асуулт асуух гэсэн юм.

Ер нь энэ Парисын хэлэлцээрийн хүрээнд үндэсний тодорхойлсон хувь нэмэр урт хугацааны бага ялгарал, хөгжлийн бодлого, үндэсний засан зохицох төлөвлөгөө гээд бид нар олон баримт баталсан юм. Тэгэхээр эдгээрийг нь хэрэгжүүлэх институт, тайлагналт, санхүүжилт, карбон зах зээлийн асуудал нь ингээд бүгд салангид зохицуулагдаж ирсэн байхгүй юу. Тэгэхээр энэ хуулийн төсөл эдгээрийн

нэгтгэсэн, нэгтгэсэн шүү суурь эрх зүйн орчныг бүрдүүлж байгаа гэж ойлгож болох уу.

2-т энэ Парисын хэлэлцээрээр олон улс орнууд энэ карбон зах зээлийн үндэсний тогтолцоогоо байгуулаад байгаа. Тэгэхээр манай улсын хувьд энэ давхар тоололгүй бүртгэл, тэр харгалзах тохируулга, үндэсний бүртгэлийн асуудлыг энэ хууль хэр хэмжээнд шийдэж байгаа вэ. Бүрэн шийдэж чадахаар байна уу.

3 дахь нь болохоор энэ санхүүжилтийн бүлэг гээд байна. Санхүүжилтийн бүлэг нь Монгол Улсын хөрөнгө татах гол энэ улс орнуудын институт, тайлагналд таксономын тогтолцоотой байх тэр шаардлагыг нь биелүүлж чадаж байгаа юу гэдэг асуулт. Олон асуулт учраас бүгдийг нь сайхан биччихсэн.

4 дэх асуулт. Манай улс хүлэмжийн хийн ялгарлаар дэлхийд бага хувь эзэлдэг боловч уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөлд өндөр өртөмтгий орны 1. Тэгэхээр энэ утгаараа хуулийн төсөлд дасан зохицох асуудлыг энэ сааруулалтын асуудалтай нь тэнцвэртэй авч үзсэн гэж ойлгож болох уу.

5 дахь асуулт нь болохоор сүүлийн 10 гаруй жил уур амьсгалын асуудлыг салбарын бодлого, хөтөлбөрөөр хэрэгжүүлж ирсэн. Гэтэл дэлхийн чиг хандлага нь болохоор тусгайлсан клаймэт ченж акт буюу уур амьсгалын суурь хуультай болох энэ чиглэл рүү ингээд яваад байгаа юм. Тэгэхээр манай улсын хувьд шинэ шатад гаргана гэж та бүгд үзэж байна уу.

Сүүлийн асуулт бол малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуультай холбоотой. Энэ хууль батлагдахаар ингээд л хоорондоо баахан булаацалдах юм гарч ирэх үү. Энэ чинь нөгөө бэлчээрийг сайжруулах харилцааг бас нэлээд эвтэйхэн зохицуулсан хууль байгаа шүү дээ. Тэгэхээр энэ дээр нэг хүний өмч, манай бүлэг хүний өмч гэдэг ч юм уу малчдын холбооны өмч гээд иймэрхүү энэ карбон кредиттэй холбоотой энэ асуудал нь ингээд хоорондоо маргаад явах уу гэдэг асуулт байна.

Мөн манай төрийн өмчит том компаниуд бас үлгэр дуурайлал үзүүлээд, энэ томоохон ялгаруулагчид бол заавал тайлан тавьдаг байдал руу оруулмаар санагддаг юм. Бусад орнууд бол ерөөсөө энэ том том компаниуд бол яг энэ чиглэлээр энэ тайлангаа тавиад байгаа юм. Тэгэхээр энэ хэдэн асуултад хариулт аваад, тэгээд тодруулъя.

С.Бямбацогт: Ажлын хэсэг 4 дүгээр микрофон.

Б.Бат-Өлзий: Гишүүний асуултад хариулъя. Хамгийн чухал гол заалт буюу энэ хуулийн нэгдсэн тогтолцоо, салангид зорилтуудыг биелүүлэхэд энэ хууль бол бүрэн нэгдсэн тогтолцоог хангаж чадах уу гэдэг дээр бол тэгж чадна. Энэ дээр яагаад вэ гэхээр хамгийн гол заалт нь бол энэ MRV буюу хэмжилт, тайлагнал, баталгаажуулалтын тогтолцоог маш тодорхой зааж өгсөн. Энэ дээр бол олон улсын жишигтэй адилхан нэгдсэн үндэсний тооллогын платформ гэж байгуулагдана. Үндсэн энэ платформоор дамжаад салбар бүрийн тооллогын болон баталгаажуулалтын өгөгдлийг нэгдсэн шугамаар өгөгдөл хооронд солилцож авна. Үүнийгээ олон улсын байгууллагуудын олон улсын энэ платформуудтай өгөгдөл яг нээлттэй, ил тод байдлаар байнгын солилцсоноороо энэ нь өөрөө олон улсад

итгэлцлийг төрүүлнэ. Итгэлцэл ихэссэний хэрээр олон улсын хөрөнгө оруулалтууд нэмэгдэх боломж нь бүрдэнэ. Яг энэ дээр бол карбон кредит болон энэ ногоон санхүүжилттэй олон улсын компаниудын ганц асуудаг зүйл нь танай энэ тоо баримтууд чинь хөндлөнгийн хяналтаар баталгаажуулсан уу гэдэг ийм байдаг. Тэгэхээр хөндлөнгийн хяналтаар баталгаажуулсан зөвхөн тоо баримтууд нь энэ MRV систем платформ дээрээ ингээд ороод явна.

Хуулийн төсөл эдгээр нэгдсэн суурь эрх зүйн орчныг бүрдүүлж байгаа юу гэдэг дээр яг бид нар бас олон улсын яг адилхан хуулиудыг судалж үзээд, одоогоор бол маш ойролцоо 50 улсын хууль бол ер нь гарсан байгаа. Уур амьсгалын өөрчлөлтийн суурь хууль болж 50-аад улс бол ашигладаг юм байна лээ. Тэгэхээр үүний дагуу бид нар судалж үзээд, маш олон заалтыг бол ойролцоо авсан байгаа.

С.Бямбацогт: Тодруулж асууя. Одонтуяа гишүүн.

С.Одонтуяа: Нөгөө малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуультай холбоотой юм асуусан. Энэ хуулиар чинь нөгөө бэлчээр сайжруулах харилцааг зохицуулчихсан байгаа. Тэгэхээр энэ бэлчээрийг сайжруулах замаар олох карбон нь 1 хүний өмч юм уу, бүлэг хүмүүсийнх юм уу гээд маргаан гарах уу. Тэгэхээр энийг яаж зохицуулж байгаа вэ.

С.Бямбацогт: Ажлын хэсэг 4 дүгээр микрофон.

Ш.Батбаяр: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Батбаяр. Гишүүний асуултад хариулъя. 2024 онд батлагдсан Малчин өрхийн анхдагч холбооны хуультай бол нягт холбогдож ажиллах ёстой байгаа. Тэгэхээр юуны өмнө бэлчээр маань өөрөө төр нийтийн өмч байгаа. Тэгэхээр тухайн бэлчээр дээр мал маллаж байгаа иргэдтэй бол гэрээгээр харьцаагаа зохицуулах шаардлагатай болж байгаа юм. Тэгэхээр төрийн өмч дээр явагдаж байгаа аливаа үйл ажиллагааг бол иргэд бол шууд өмчлөх эрхгүй байгаад байгаа юм. Тэгэхээр энэ утгаараа бид бол түрүүний яригдсан орон нутгийн иргэдээс саналыг авна. Дараа нь шударга хэлбэрээр үр ашгийг хуваарилна гэдэг заалтууд энэ үндсэн дээр орж ирсэн байгаа. Тэгэхдээ ер нь цаашид нөгөө Засгийн газрын батлах 4 журам дээр энэ харилцааг илүү тодорхой зааж өгөх байгаа.

Мөн энэ хуулийн 25.3, 25.4 дээр бол энэ төрийн нийтийн өмчийн газарт хэрэгжүүлсэн төслөөс үүсэх сааруулалтын үр дүн, кредитийн өмчлөл, ашиглалт .../минут дуусав/

С.Бямбацогт: Тодруулж асууя Одонтуяа гишүүн.

С.Одонтуяа: Ойлголоо. Тэгэхээр энэ бэлчээр бол төрийн нийтийн өмч гэдгээр энэ хууль зохицуулагдаж байгаа юм байна. Тийм ээ. Тэгээд шаардлагатай тохиолдолд энэ гэрээнүүдийг хийж ажиллах юм байна гээд хуульд орчихсон байгаа юу. Тэгвэл болж байна. Хариулт хангалттай байна.

1 асуулт асуусан. Энэ нөгөө төрийн өмчийн компаниуд энэ томоохон ялгаруулагчид ингээд тайлан гаргадаг байвал ямар вэ гэсэн асуулт.

С.Бямбацогт: Ажлын хэсэг хариулъя. 4.

Ш.Батбаяр: Олон улсын чиг хандлагаар бол томоохон компаниуд, ялангуяа төрийн өмчит компаниуд экспорт хийх ESG шаардлага хангах хэрэгцээтэй байгууллагууд бол хүлэмжийн хийн ялгарлаа ил тод тайлагнах шаардлагатай болж байгаа. Тэгэхдээ яг өнөөдрийн нөхцөлд манай оронд түрүүн хэлсэнчлэн яг энэ карбон кредитийн зах зээл шинэ тутам мэргэжил, мэргэжилтэн дутагдалтай байгаа учраас тухайн хувийн хэвшил болон төрийн өмчит байгууллагуудад болоод санхүүгийн нэлээн том дарамт учирна гэдэг тооцоо судалгаа гарч байгаа.

Тэгэхээр энэ үүднээс эхний зохицуулалт дээр бол яг заавал гэж тусгаж өгөөгүй байгаа. Цаашдаа бол зах зээл тогтворжоод эхэлсний дараа тухайн төрийн өмчит компаниудыг бол үүрэг болгох боломжтой. Засгийн газраас чиглэл өгөөд явах боломжтой гэж хуульд бол тусгаагүй байгаа.

С.Бямбацогт: Зочин танилцуулъя. Нийслэлийн ерөнхий боловсролын “Шилдэг” сургуулийн Тамир багштай 7^с ангийн сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Төрийн ордонтой танилцаж байгаа хүүхэд, багачууддаа сурлагын өндөр амжилтыг хүсэн ерөөе. Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс.

Болдын Уянга гишүүн асуултаа асууя.

Б.Уянга: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамныхандаа талархал илэрхийлмээр байгаа юм.

Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хууль байх ёстой байх. Тэгээд орж ирж байна. Энэ дээрээ бүгдээрээ тал талаас нь ярилцаад, түрүүний гишүүдийн асуусан, санаа зовсон зүйлүүдийг нь яг бүрэн гүйцэд яаж суулгах вэ гэдэг дээр нь хамтраад явах ёстой байх. Тэгээд яах вэ, зүгээр яг өнөөдөр ярилцаж байгаа энэ хуулийн төслийн гол асуудлыг нь бол хуулийн үзэл баримтлал дээр гаргаад ирээд тавьчихсан байгаа шүү дээ. Тэгэхдээ судалгаа бол тийм хангалттай бас байгаагүй гэдгийг хэлье.

Температурын өсөлт, ган, зудын давтамж нэмэгдээд байн. Тэрийгээ ойлгочих. Нуур, мөсөн голын талбай эрс багаслаа. Ингээд хот руу шилжилт хөдөлгөөн нэмэгдсэн. Улаанбаатар хотын ачаалал өссөн гэх мэт бүх асуудлуудаа ингээд зоогоод тавьж байгаа юм. Ингээд яг тэгвэл цаашаагаа энэ хууль гарснаар яах юм бэ гэнгүүт ирээдүй рүү чиглэсэн тийм прогноз, датанууд, судалгаанууд дутуу байгаад байна лээ. Тэгээд магадгүй ерөөсөө байхгүй байж магадгүй. Тийм уур амьсгалын өөрчлөлт явагдаад байгаа учраас ирээдүйг хол харж чадахгүй байгаа байх. Тэгэхдээ яах вэ манай Монгол Улсад уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг бодлого гарч ирээд, зохицуулалт, тэгээд карбон зах зээл, ногоон санхүүжилтийн үндсэн эрх зүйн тогтолцоог энэ хуулиараа бий болгох гэж байна гэж үзвэл зүгээр миний хувь хүний өнцөг нь салбар хоорондын уялдаа манайд их бага байдаг шүү дээ. Тэрийгээ яаж хангах вэ л байна. Тэгэхээр үзэл баримтлалын хүрээнд энэ дээр асуухад хөдөө аж ахуйн салбар, эрчим хүч, барилга, тээвэр, хог гээд эдгээр бүх салбарууд тус тусынхаа өөрийн хуулиар, өөрийн бодлоготойгоор ингээд зохицоод явна. Аль нэг салбар нь түрүүлээд яваад зарим нь хоцрох ч магадлалтай. Тэгэхээр яг энэ уур амьсгалын өөрчлөлтийн хууль бүрэн хэрэгжих дээр энэ салбар хоорондын уялдааг хэрхэн анзаарч суулгасан байгаа вэ.

Тэгээд мэдээллийн сангийн асуудлыг угаасаа та хэд хүлээн зөвшөөрсөн байгаа шүү дээ. Энэ хүлэмжийн хийн тооллого мэдээллийн сан хангалтгүй гээд. Тэгэхээр энэ хуулийг хэрэгжүүлэхийн тулд мэдээж 1 суурь дата сан энэ тэр бий болох ёстой байх л даа. Энэ дээрээ ямар ажлууд төлөвлөж байна. Энэ хууль бол мэдээж коп болох гэж байгаатай холбоотой гишүүд нэлээн сууж байгаад, тэгээд батлахыг эрмэлзэж ажиллах байх. Гэхдээ хэрэгжүүлж эхлэхэд мэдээж дата, мэдээллийн сан нь бэлэн байх ёстой байх. Тэгээд салбар хоорондын уялдаа нь хангагдсан байх ёстой. Тэгээд яг энэ 2 дээр хуулийн төслийн хамрагдаж байгаа байдал нь цаашид анхаарах асуудал нь юу байгааг мөн дагаж гаргах хуультай холбоотой бусад хуулиудад юу, юу орж байгааг ерөнхийд нь тайлбарлаад өгөөч.

С.Бямбацогт: Ажлын хэсэг хариулъя. 4 дүгээр микрофон.

Б.Мөнх-Эрдэнэ: Эдийн засаг, хөгжлийн яам Мөнх-Эрдэнэ. Гишүүний асуултад хариулъя.

Миний хувьд салбар хоорондын уялдааг яаж хангах вэ гэдэг дээр хариулъя. Энэ хууль бол өөрөө анхдагч хуулийн төсөл учраас зөвхөн байгаль орчны салбар биш сүүлийн үеийн эдийн засаг, санхүүгийн дэлхий дахины зах зээл дээр байгаа гол салбар юм гэж бусад судалгаануудаас үзсэн байгаа. Тэгэхээр энэ хуулийн төсөл дээр бол эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь салбар хоорондын уялдааг хангах, тэр дундаа богино, дунд, урт хугацааны хөгжлийн төлөвлөлтдөө оруулах, дээрээс нь төсвийн хүрээний мэдэгдэлтэй бас тооцооллыг оруулах, цаашлаад төсвийн хүрээний мэдэгдлийг салбар салбараар нь төлөвлөж сайжруулсан тохиолдолд энэ уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг оруулах талаар энэ хуульд бол заавал үүрэг болгон тусгаж байгаа.

Мөн дээрээс нь улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр буюу томоохон төсөл хөтөлбөрүүдийг Их Хурлаар 5 жилийн төлөвлөгөөнд төлөвлөхдөө энэ асуудлыг заавал харгалзан үзэх байдлаар томъёолж байгаа. Байгаль орчинтой холбоотой хэсгийг нь Байгаль орчны яам хариулна.

Ш.Батбаяр: Мэдээллийн нэгдсэн сан бий болгож байгаа юу. Мэдээлэл мэдээж манай байгаль орчны нэгдсэн сан буюу EIC дээр маань бас мэдээллүүд бас дутмаг байдаг. Салбар хоорондын уялдааг нэгтгэх, орон нутгаас ирүүлж байгаа мэдээллийн энэ давтамжийг хуулиар хүлээсэн үүргийг биелүүлэх зэрэг ажлууд байгаа.

Яг энэ хууль дээр бол салбаруудын мэдээллийг нэгтгэсэн үндэсний платформ байгуулна гэж заагдсан байгаа юм. Тэгэхээр одоо бол усны мэдээллийн сан, ойн мэдээллийн сан, хүлэмжийн хийн мэдээлэл, тэгээд карбон төслийн мэдээллүүд бол тус тусдаа салбарынхаа агентлагууд, яам, эдийн засгийн яам ч гэдэг юм уу, манай Усны газар, Ойн газар дээр ингээд тусдаа байгаа энэ мэдээллүүдийг нэгтгээд, Үндэсний нэгдсэн платформ байгуулж, дата мэдээллээ нэгтгээ гэдэг зүйл заалтууд орж ирж байгаа. Тэгэхээр үүнээс бол түрүүн яриад байгаа давхардсан тооллого болон мэдээлэл зөрөх олон улсын тайлан гаргахад үүсэх хүндрэлүүд бол харьцангуй буурна гэж үзэж байгаа.

Мөн сая яригдсан салбар хоорондын уялдаа гэдэг дээр бол бид Үндэсний тодорхойлсон хувь нэмэр буюу зорилт 3.0-ийг батлахдаа нэлээн өргөн хүрээний

салбар хоорондын хамтын ажиллагааг эхлүүлж бас тодорхой хэмжээний туршлагатай болсон. Яг уур амьсгалын өөрчлөлтийн асуудал дээр манай Хүнс, хөдөө аж ахуйн яам, Уул уурхайн яам, Байгаль орчны яам, Эдийн засгийн яам, Сангийн яам гээд маш олон өргөн бүрэлдэхүүн дээр Статистикийн газар ч гэдэг юм уу бүгд хамтарч ажиллаад, Зам, тээврийн яам гээд энэхүү үндэсний тодорхойлсон хувь нэмрийг боловсруулан батлуулж чадсан. Тэгээд энэ үндсэн туршлага дээрээ бол цаашдын үндэсний платформоо байгуулж, ажиллагааг бүрэн хангаж болно гэж үзэж байгаа. Уур амьсгалын өөрчлөлтөд ямар хариу .../минут дуусав/

С.Бямбацогт: Болсон уу. 4 минутдаа багтаагаад хариулаад сурчхаарай.

Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Банзрагчийн Түвшиний урилгаар Завхан аймгийн Дөрвөлжин сумын ерөнхий боловсролын сургуулийн 1991 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Төгсөлтийнхөө 35 жилийн ой тэмдэглэж байгаа юм байна. Та бүхэндээ Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс амьдралд нь аз жаргал, эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Манай тойргийн иргэд байна шүү.

Даваасамбуугийн Ганмаа гишүүн асуултаа асууя.

Д.Ганмаа: Энэ хуулийг цөмөөрөө зөвхөн байгаль орчны хууль гэхээсээ илүүтэйгээр бас арай өөрөөр харвал яадаг юм гэж бодлоо. Би нөгөө ийш тийшээ яваад олон улсын уулзалт зөвлөгөөн дээр ярьж байхад Монгол Улс бол дэлхийн уур амьсгалын өөрчлөлттэй бол гол буруутан биш. Тэгэхдээ ингээд гол хохирогч нь болоод байна гэдгийг аягүй олон гаднынхан ч ярьдаг. Тиймээс энэ хууль нь зөвхөн ялгарлыг бууруулах тухай биш харин алсуураа Монгол Улс олон улсаас уур амьсгалын санхүүжилт, карбон зах зээлд яаж өөртөө гэх үү дээ эсвэл хамгийн их өртөөд байгаа малчдад орон нутгийн хүмүүсийн амьжиргааг дээшлүүлж хамгаалуулах хууль болгох боломжтой вэ гэдэг талаас нь яривал их зүгээр байгаа юм.

Тэр утгаараа ер нь олон газраас ч гэсэн ийм саналууд бас Монгол Улсад уг нь ирдэг юм байна лээ. Маш бага хувийг эзлээд байгаа мөртөө энэ малчид, тэгээд орон нутгийн хүмүүс уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөнд хамгийн их өртөөд, малаа, бэлчээрээ, газар нутгаа алдаад ийм асуудлууд байгаад байгаа учраас бид нар жишээлбэл энэ түрүүний миний нэрлэсэн гаднын улсуудаас энэ хуулийг баталснаар жишээлбэл Ногоон уур амьсгалын сан ч гэдэг юм уу, эсвэл Парисын хэлэлцээрийн тэр санхүүгийн механизмуудаас ч гэдэг юм уу жил болгон хэдий хэмжээний санхүүжилт татах боломж бүрдэх вэ. Энэ тал дээр тоо ч юм уу, баримт байгаа юу. Үүнийгээ хэмжих тодорхой шалгуур үзүүлэлт ч юм уу, зорилт байгаа юу. Энийг хүртлээ гэхэд энэ нь төрд үлдэх үү, малчдад очих уу, орон нутгийнханд очих уу, яг хэнд очих вэ. Орон нутагт малчдад энэ ашгийг хэрхэн хүргэх вэ гэдэг дээр тийм хүлээлт бас байгаа байх гэж би бодож байна.

2 дугаарт энэ карбон кредит тэгээд карбон зах зээлийн тогтолцоог бий болгохоор хуульдаа тусгасан бас их чухал механизмууд энд оруулж ирсэн байна л даа. Сайшаалтай заалтууд байна. Гэхдээ ой бэлчээр, газар ашиглалттай холбоотой төслүүдээс бий болох энэ кредит карбонаа яг яаж тодорхойлох вэ. Одоо дэндүү их журам, дүрэм ч юм уу ингээд регуляцад ингээд орхихгүй, яг хууль дээрээ

нарийвчлан тусгасан ийм заалтууд нь шууд харагдахаар зүйлүүд нь яг юу юу байгааг хэлж өгөхгүй юу.

С.Бямбацогт: Ажлын хэсэг хариулъя. 4 дүгээр микрофон.

Ш.Батбаяр: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам Батбаяр. Гишүүний асуултад хариулъя. Гишүүний хэлж байгаа тоо баримт бол үнэн. Монгол Улс дэлхийн нийт хүлэмжийн ялгарал ердөө 0,09 хувийг л эзэлдэг. Тиймээс бид бол гол энэ уур амьсгалын өөрчлөлтийн хохирогч болчихоод байгаа. Тийм учраас бид Уур амьсгалын өөрчлөлтийн хуулийг боловсруулж, зах зээлээ тодорхой болгож, гадаадын хөрөнгө оруулалтыг татах зорилго тавиад байгаа. Энэ хуулийн гол зорилго нь бол малчдад шинэ татвар ноогдуулах биш, харин бэлчээрийн доройтлыг бууруулах, усан хангамжийг сайжруулах, зудын эрсдэлийг бууруулах, бэлчээрийн менежментийг сайжруулахад олон улсын санхүүжилтийг татах зорилготой байгаа.

Түрүүн хэлсэнчлэн хуульд бол тухайн орон нутгийн иргэдэд шударга зарчмаар энэ карбоны орлогыг хуваарилна гэсэн заалт туссан байгаа. Энүүгээр бол тооцогдож байгаа гэж үзэж байгаа. Энэ төслийг хэрэгжүүлэхдээ тухайн орон нутгийн өөрөө удирдах нэгжээс тогтоол гаргуулж, төслөө эхлүүлнэ. Мөн иргэдэд санал тавьж, саналыг нь төслийнхөө явцад тусгах ёстой ийм заалттай байгаа. Тэгэхээр энэ хүрээндээ орон нутагтайгаа тохиролцож, иргэдтэйгээ тохиролцож, тухайн газраа ашиглуулж байгаа, бэлчээрээ ашиглуулж байгаа иргэдтэй гэрээ хийж, ашгаа хуваарилна гэсэн үг.

Ой бэлчээрийн газар ашиглалттай холбоотой заалтууд бол үндэсний тодорхойлсон зорилт буюу үндэсний тодорхойлсон хувь нэмэртэй голцуу энэ ойтой холбоотой, бэлчээртэй холбоотой яагаад гэхээр хоёулаа төрийн өмч байгаа. Тэгэхээр энэ заалтаараа бол үндэсний тодорхойлсон хувь нэмэртэй ихэнх энэ зах зээлийн юу маань орчих юм.

С.Бямбацогт: Ганмаа гишүүн тодруулъя.

Д.Ганмаа: Зүгээр нэмэлт асуулт. Энэ бүс нутгийн энэ онцлогоос хамаараад ямааны тоо толгойг захиргааны аргаар буюу энэ бол хязгаарлалт гэсэн үг шүү дээ. Тогтоох гэж орсон байна шүү дээ. Тэгвэл энэ чинь нөгөө Үндсэн хуулиар хамгаалагдсан малчин дундаа хариулах малтай болох эсвэл иргэний хувийн өмчлөх эрх гэж байдаг байх. Эдгээртэй нь хууль хоорондоо зөрчилдөж байгаа юу. Эсвэл ямар механизмаар энийг шийдэж байгаа юм бол.

С.Бямбацогт: Хэн хариулах вэ. Хариулъя. 4 дүгээр микрофон.

Ш.Батбаяр: Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төсөлд бол малын төрөл, тэр дундаа ямааны тоо толгойд хязгаарлах тоо тогтоох заалт бол байхгүй байгаа. Үр нөлөөний судалгаа дээр бол ямаа сүргийн тоо ихэссэнээр бэлчээрийн даац хэтэрч байгаа талаар бол тодорхой тайлан мэдээллүүд байгаа.

С.Бямбацогт: Ганзоригийн Лувсанжамц гишүүн асуултаа асууя. Алга байна. Хассуурийн Ганхуяг гишүүн асуултаа асууя. Алга байна. Сайнхүүгийн Ганбаатар гишүүн асуултаа асууя.

С.Ганбаатар: Энэ хуулийн талаар бас Байнгын хороо дээр нэлээн ярьсан. Тэгээд Төрийн нарийн бичгийн дарга Батбаяр даргын бас танилцуулгад маш чухал чухал мэдээллүүд орсон байсан. Энэ бол зүгээр нэг уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны тухай хууль ч биш. Монгол орны эдийн засгийн тухай, өрсөлдөх чадварын тухай, хамгийн гол нь өөрийгөө өмөөрөх чадваргүй, боломжгүй байгаа амьжиргааныхаа төлөө өдөр, шөнөгүй зүтгэж байгаа малчин, хөдөө аж ахуйн салбарын ажилтнуудын, иргэдийн, компаниудын тухай хууль юм.

Монгол оронд 25,1 тэрбум долларын ДНБ гэж тоо гарсан байгаа. 2025 оны мэдээгээр. Энэ хууль батлагдаж, энэ карбон кредитийн талаар арга хэмжээ авснаараа манай эдийн засаг, ДНБ бас давуу байдалтай болно. 15 мянгаас 25 мянган ажлын байр бий болно л гэж байгаа. Тэгэхээр энэ хуулийг бол би дэмжиж байгаа. Тэгээд тодруулж асуух хэдхэн зүйл байгаа.

Энэ техникийн хувьд өөрчилж болох уу. Хуулийн 19.2-т Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтын хэрэгжилтийн ил тод байдлын тайланг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн арга, аргачлалын дагуу боловсруулж, тогтоогдсон хугацаанд тухайн асуудлыг хариуцсан ОУБ-д хүргүүлнэ гэж байгаа юм. Энэ дээр би бүүр тодорхой нэр усыг нь асуух хэрэгтэй байгаа. Протоколд тэмдэглүүлэх ёстой. Хэн гэдэг байгууллага, ямар байгууллага зөвшөөрөгдсөн арга, ажиллагааг хэн тодорхойлдог юм. Ямар байгууллага дээр ингээд тухайн асуудлыг хариуцсан ОУБ-д хүргүүлнэ гэдэг энийг 1 дүгээрт асууя. Энэ бидэнд их чухал байгаа.

Дараагийн 2 дугаар асуулт. 26.2-т хуудас 22 дээр сааруулалтын үр дүнгийн баталгаажуулалт нь урьдчилсан баталгаажуулалт болон үр дүнгийн баталгаажуулалтаас бүрдэх бөгөөд баталгаажуулалтыг холбогдох олон улсын болон үндэсний стандартын дагуу итгэмжлэгдсэн хараат бус хөндлөнгийн этгээдээр гүйцэтгүүлнэ гэж байгаа. Монгол оронд чинь ер нь тэгээд л бүх юм хараат шүү дээ. Улс төрчдөөс, дарга нараас, сайд нараас хараат. Энэ хэнээс хараат бус гэж гаргаад байгаа юм бэ. Монголд бол ард түмнээс л бүх юм хараат бус. Мөнгө төгрөг. Тэгэхээр энэ хараат бус гэдгийг би тодруулмаар байна. Миний ойлголтоор бол энэ асуудлыг улс төрчид буюу мөнгөнд дуртай сайд нараас хараат бус байдлаар шийдэхийн тулд оруулж ирсэн гэж би ойлгож байна. Энэ дээр би тодруулга авъя.

Дараагийн асуулт. 30.1.Үндэсний тодорхойлсон хувь нэмрийг зорилтыг хангах зохицуулалтыг карбон кредитийг энэ хуулийн 8.2-т гэж энэ яамыг хэлж байгаа юм. Заасан байгууллагын зөвшөөрсөн тухай тодорхойлолтгүйгээр худалдах, арилжих гэж байгаа. Зөвшөөрөл, тодорхойлолт 2 юугаараа ялгаатай вэ. Миний асуулт их ойлгомжтой байх гэж бодож байна. 30.1 дээр заасан байгууллагын зөвшөөрсөн тухай тодорхойлолтгүйгээр худалдах гэсэн байгаа юм. Тодорхойлолт гэж бас нэг зөвшөөрөл гараад ирсэн юм уу гэж би ойлгохгүй байна. Энэ дээр би хариулт авъя.

С.Бямбацогт: Ажлын хэсэг хариулъя.

Ш.Батбаяр: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам Батбаяр. Гишүүний асуултад хариулъя.

Энэ 19.2-т заасан нь бол яг шинэ аргачлал зохиож байгаа асуудал биш. Парисын хэлэлцээрийн хэрэгжилтийн хүрээнд НҮБ-ын уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенцын талуудын бага хурлаас баталсан ил тод байдлын сайжруулсан

тогтолцоо буюу ETF аргачлалын удирдамжид үндэслээд, энэхүү аргачлалаар явна. Өөрөөр хэлбэл тайланд нь хүлэмжийн хийн үндэсний тооллого, үндэсний тодорхойлсон хувь хүний хэрэгжилтийн ахиц, дасан зохицох арга хэмжээ, санхүүжилт, технологи, чадавх, бэхжүүлэлтийн мэдээлэл зэрэг олон мэдээллийг багтаасан тайлагналын форматын дагуу бид хийх юм байгаа юм.

2 дахь асуулт. Хараат бус хөндлөнгийн байгууллага гэж хэн бэ гээд. Тэгэхээр хараат бус хөндлөнгийн этгээд дээр бол яг тухайн төсөл, байгууллага, үйл ажиллагааг хэрэгжүүлэхээс санхүүгийн болон ямар нэгэн хэлбэрээр хамаарал бүхий биш аж ахуйн нэгж буюу аудитын газруудыг л хараат бус гэж энэ дээр бид ойлгож, томьёолж байгаа. Т

Тодорхойлолт гэдэг дээр бол гишүүнд нөгөө манай хэрэгжүүлэгч байгууллага маань тухайн төслийн хэрэгжүүлж буй, үүсгэж буй шингээлт нь үндэсний тодорхойлсон хувь нэмэрт хамаарахгүй гэдгийг тодорхойлсон ийм зөвшөөрлийг өгч байгаа юм. Энэ бол манай Засгийн газрын хүлээсэн үүрэгт хамаарахгүй гэдэг тодорхойлолтыг өгнө гэсэн үг товчхондоо.

С.Бямбацогт: Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн алга байна. Цэндийн Баатархүү гишүүн алга байна. Чинбатын Ундрам гишүүн асуултаа асууя.

Ч.Ундрам: Миний хувьд энэ хуулийг бол дэмжиж байгаа юм. Монгол орны хэмжээнд сүүлийн 10 жилд 132 нуур ширгэсэн байна. Тэгээд маш олон мөсөн голын талбай багассан гэх мэтчилэн уур амьсгалын өөрчлөлтөд маш хурдтай өртөж байгаа. Тэгээд бид нар чинь хөдөө аж ахуй, мал аж ахуйн орон. Тэгэхээр маш ийм хүнд нөхцөл байдалд байгаа учраас энэ хууль харин ч оройтож ингэж орж ирж байна гэж бодож байна. Тэгэхээр энэ гол мөрөн ширгээд байгаатай холбоотой ер нь сүүлийн үед Байгаль орчны яаманд хөв цөөрөм байгуулах ажил дээр хэр анхаарч байна. Би жишээлбэл Сэлэнгэ аймгийнхаа Сант сумд Эрин голын далан сэргээж байгуулаад, 1 хөв цөөрөм байгуулсан. Тэгээд маш их хэрэгтэй юм байна лээ. Нутгийн ногоочид, тариаланчид тэндээс усалгааны системтэй болсон. Мал, ан амьтан хүртэл очоод уух устай болж байна. Тэгэхээр иймэрхүү ажил Байгаль орчны яаман дээр явж байгаа юу гэдгийг 1 дүгээрт асуумаар байна.

2 дугаарт бас сая Ганмаа гишүүн ч хэлээд байна. Бид нар бол бусад аж үйлдвэржилт нь аль дээр үеэс хөгжчихсөн улс орнуудын гаргасан энэ карбонд өртөөд байгаа ийм улс орон. Тэгэхээр бид нар энэ хуулийг мэдээж нэг талаас байгаль хамгаалах хууль боловч нөгөө талаас улс орондоо, орон нутагт манай улсын компаниуд хөрөнгө татах тийм эх үүсвэр болгож ашиглах ёстой гэж бодож байгаа юм. Тэгээд сая судлаад үзсэн чинь 2025 онд карбон үнэ тогтоох тогтолцооноос дэлхийд 107 тэрбум ам.доллар энэ тогтолцоонд эргэлдсэн байгаа байхгүй юу. Тэгэхээр бид нар олон улсын уур амьсгалын сангууд байна шүү дээ. Green Climate Fund, Global Environment Facility ч гэдэг юм уу энэ байгууллагууд руу хандсан төсөл, хөтөлбөр бичээд хөрөнгө оруулалт санхүүжилт авсан ч юм уу, авах гээд яригдаж байгаа ийм зүйлс ер нь байна уу. Тэгээд энэ хууль батлагдсанаар ер нь бидэнд хэр хэмжээний орлого, хөрөнгө босгох бололцоо үүсэх юм бэ.

3 дугаар асуулт нь болохоор Сэлэнгэ аймаг бол “Тэрбум мод” хөдөлгөөнд хамгийн их нэгдэж, айл өрхүүд, аж ахуйн нэгж бүгд л энд оролцоод явж байгаа. Тэгээд бас өмнө нь ч гэсэн бид нар Тужийн нарс гээд ой хөвчөө бас сэргээгээд

тарьсан ийм туршлага байдаг. Тэгэхээр яг энэ хуулийн дагуу энэ карбон кредит тогтолцооноос яг орон нутагт хэр хэмжээний санхүүжилт, дэмжлэгүүд орж ирэх юм бэ. Түүгээрээ орон нутаг цаашдаа энэ хууль батлагдсанаар өөрсдөө захиран зарцуулаад, өөрсдийнхөө асуудлыг шийдээд, уур амьсгалын өөрчлөлттэйгөө тэмцэх, бусад юмандаа зарцуулаад хогтойгоо тэмцэх ч юм уу ийм ажилд зарцуулаад явах боломж бүрдэх үү.

4 дүгээрт малчид яг яаж үр ашгийг нь хүртэх юм бэ. Би яг тодорхой малчин өрх бол ийм хэмжээний ашиг орлого энэ хуулийн дагуу хүртэх боломжтой гэсэн тийм тооцоо судалгаа байна уу.

С.Бямбацогт: Хариулъя. Ажлын хэсэг 4 дүгээр микрофон.

Ш.Батбаяр: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлт яам Батбаяр. Гишүүний асуултад хариулъя. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас хөв цөөрөм байгуулах, усны нөөцийн судалгаа хийх, ундны усны хэрэгцээг тодорхойлох зэргээр олон ажлуудыг төлөвлөн ажиллаж байгаа. Ирэх жилийн хувьд улсын хэмжээнд 7 сумын усны эх үүсвэрийн хайгуул судалгаа, нөөц тогтоох ажилд бол 7,15 тэрбум төгрөгийг тусгахаар бид бас улсын хөгжлийн төлөвлөгөөндөө тусгаад явж байгаа. Гол бидний хамгийн түрүүнд хийх ёстой хэрэгтэй ажил бол усныхаа нөөцийг тодорхойлох, тогтоох явдал байгаа. Тэгэхээр энэ хүрээнд бол ажлууд хийгдэж байгаа. Өнөөдрийн байдлаар 100 гаруй сумдын улсын хэмжээнд нөөцийг тодорхойлсон байгаа. Ойрын хугацаанд яаралтай говийн бүсийн 50 сумын усны нөөцийг тогтоох хэрэгтэй байгаа. Хөв цөөрөм байгуулах ажил дээр бол 2027 онд улсын төсөвт бол 5 хөв цөөрмийг улсын төсвийн хөрөнгөөр байгуулахаар төлөвлөж байна. Гэхдээ яамны зүгээс аж ахуйн нэгжийн татварын хөнгөлөлтөд энэхүү ажлыг тусгаад, тодорхой орон нутгуудад ТЭЗҮ, зураг төсөл нь бэлэн болчихсон байгаа төслүүдийг аж ахуйн нэгжүүдэд санал болгох ажлыг эхнээсээ зохион байгуулаад явж байгаа. Ингэснээрээ бол хувийн хэвшлийн хөрөнгө зардлаар хөв цөөрмийг байгуулах ажил бол эрчимтэй явагдана гэж тооцож байгаа.

Уур амьсгалын өөрчлөлтийн хууль батлагдсанаар түрүүн хэлсэнчлэн ногоон санхүүжилт бол 2-3 дахин өссөн гэдэг олон улсын судалгаа байгаа. Өнгөрсөн 10 жилийн хугацаанд манай улс уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой ногоон технологитой холбоотой 1,5 орчим тэрбум долларын гадаадын хөрөнгө оруулалтыг татсан юм байна лээ. Тэгэхээр энэ хөрөнгө оруулалтыг л дараагийн 10 жилд 2-3 дахин өсгөнө гэсэн тооцоо судалгаатай байгаа.

Яг хуульд бол орон нутагт бол төслөөс санхүүжилт оруулна гэсэн заалт бол байхгүй. Түрүүн хэлсэнчлэн тухайн бүс нутагт хэрэгжүүлж байгаа төслөөс олсон ашгаас шударга хувилбараар хуваарилна. Гэрээнд заасан хэлбэрээр хуваарилна л гэж байгаа юм. Тэрнээс биш орон нутаг бол карбон шингээлтийн төслийг хэрэгжүүлэхгүй. Тус орон нутаг дээр хэрэгжүүлж байгаа гаднын болон дотоодын төсөл хөтөлбөрүүдээс ашиг хүртэх гэрээгээ байгуулаад явна гэж ойлгож болно.

Малчид бас яг мөн адил бэлчээрээ ашиглуулаад, карбон шингээлтийг хийгээд олсон карбоны орлогоос бол хувь хүртдэг энэ хэлбэрээр бол манай улсад хэд хэдэн сумд туршилтын файлет төслүүд хэрэгжээд, иргэд, малчид маань малынхаа тоог цөөрүүлэх, бэлчээрийн даацаа бууруулах, нөхөрлөл байгуулах зэргээр ингээд хамтын ажиллагааны коммунити үүсгээд ашиг хүртсэн бас туршлага байгаа.

Хамгийн сүүлийн жишээгээр бол 1,5 сая төгрөгийн орлогыг 1 жилд өрх олсон гэсэн судалгааг бол би авсан. Баярлалаа.

С.Бямбацогт: Ганзоригийн Лувсанжамц гишүүн асуултаа асууя.

Г.Лувсанжамц: Та бүхэндээ өдрийн мэнд хүргэе. Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хууль орж ирж байгаад их баяртай байна. Үзэл баримтлалыг бол дэмжиж байна. Ганц 2 зүйлийг тодруулж асуух хэрэгтэй байна. Байгаль орчны яамны боловсруулснаар Засгийн газар батална гэж байна. 7.1.8 дээр хүлэмжийн хийн ялгарлыг хэмжих, тайлагнах, баталгаажуулах журам гэж байгаа. Энэ журмыг манай Байгаль орчны яам маань өөрсдөө боловсруулах гэж байна уу. Эсвэл олон улсад ашиглагддаг аргачлалыг ашиглах гэж байна уу. MRV буюу Measurement, Reporting, and Verification гээд. Энийгээ бид нар яг зөв хийхгүй бол бүх аргачлалаа өөрсдөө боловсруулаад явах юм бол бүртгүүлтлээ энэ бол маш олон жил болдог. Дор хаяж 1, 2 жил болдог. Тэгэхээр 2, 3 гаргалгаа байгаа.

Эхнийх нь болохлоор олон улсын Голд стандарт мөн Вера гэсэн 2 олон улсын байгууллагууд байгаа. Та бүхэн маань мэдэж байгаа болов уу. Тэгэхээр энэ 2 байгууллагын хүлээн зөвшөөрсөн MRV аргачлал нь байх юм бол шууд аваад ашигладаг байх нь зүйтэй.

2 дугаарт нь 2 улсын хооронд бид нар хэлэлцээрүүд хийж байгаа. Японтой JCM буюу Joint Crediting Mechanism байна. Сингапуртай сая санамж бичиг байгууллаа. Тухайн улсууд өөрсдөө ашигладаг MRV аргачлал гэж байгаа. Энэ аргачлалыг нь бас үндэснийх дээрээ шууд ашиглаад л явах нь бид нарт цаг хугацаа ч хожно, аргачлал нь зөв байна. Карбон кредит гээд байгаа манай малчдын маань газар тариалан эрхэлж байгаа хүмүүс маань гол нь байшин, гэрээ дулаалаад, сэргээгдэх эрчим хүчинд шилжиж байгаа өрхүүдийн маань жилд гаргаж байгаа 15 тонн CO₂ байгаа. Тийм ээ. Тэр дээрээ бид нар орлого олоод, төвлөрүүлээд явах боломжтой болов уу гэж бодож байна. Ерөнхий сайдын дэвшүүлж байгаа энэ сэргээгдэх эрчим хүчийг чөлөөлье гэсэн бодлоготой энэ бол маш уялдаж явах ёстой зүйл гэдгийг та бүхэн маш сайн ойлгож байгаа болов уу. Тэгэхээр энэ аргачлалуудаа та бүхэн маань яаж тооцож байгаа вэ гэдэг эхний асуулт.

Төсөл болгон дээр аргачлал өөр байдаг. Салбар болгон дээр бас үндэсний болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аргачлалууд байгаа. Мэдээж энэ дээр бичсэн байгаа та бүхний маань үндэсний платформын үйл ажиллагааг бол яам нь удирдаад явна гэж байна. Энийг бол дэмжиж байна. Ийм зүйл байх ёстой. Шууд нээлттэй, ил тод харагддаг байх ёстой. Гол нь энэ ил тод байх ёстой гэдэг нь хамгийн чухал шүү дээ. Давхар тооцож байна уу, үгүй юу. Энийгээ сайн олон нийтэд нээлттэй байлгахгүй бол яг энэ уур амьсгалын энэ арга хэмжээ, бодлого 10 гаруй жилийн өмнө олон улсад хэрэгжээд, мөнгө угаах асуудал ингээд хаа сайгүй үүсээд, 1 удаа зогсчихсон, алдчихсан бодлого байгаа. Тэгэхээр Монгол Улсын хувьд бол анх удаагаа энийг хийгээд явах гэж байгаа учраас яг энэ дээр алдаа гаргахгүйгээр явах нь зүйтэй болов уу гэж бодож байна.

2 дугаарт сая хөдөө аж ахуйн асуудлуудаар бусад гишүүдээс асуудлууд асууж байна. Манай 60, 70 сая малтай болдог хамгийн их үедээ. Тухайлбал үхэр дээр жишээ аваад үзье хэдүүлээ. Тугалаас нь бяруу, шүдлэн, гуна болтол нь тэжээж байгаад, нядлахад CO₂ гарахын хэмжээ маш өндөр байгаа. Гэхдээ бид нар тугалаас

нь бяруу болгоод, бяруу дээр нь жинг нь их байхаар зөв эрчимжүүлсэн мал аж ахуйгаа хэрэгжүүлээд явах юм бол тэр үлдсэн 2 жил илүү тэжээхтэй харьцуулахад хэмнэсэн CO₂ –оосоо малчдын орлого бас тооцогдох боломжтой байгаа. Энэ дээр та бүхний маань тусгасан бас нэг чухал зүйл байна л даа. Орон нутгийн өөрөө удирдах байгууллагын дэмжсэн тогтоолд үндэслэсэн байх гэж байгаа. Энэ дээр бас яамны оролцоо байх ёстой болов уу гэж бодож байна. Ялангуяа энэ MRV хэмжих, тайлагнах, баталгаажуулах аргачлал. Энэ аргачлал дээр та бүхэн маань ямар бодолтой байгаа вэ.

3 дахь асуулт нь болохлоор уур амьсгалын өөрчлөлтийн мэргэжилтэнтэй байхыг салбарын хэмжээнд байлгана гэж байна. Энэ яам болгон дээр ийм мэргэжилтэнтэй болох гээд байгаа агуулга уу. Эсвэл ямар зорилготой бүтэц, орон тоог нэмж өгч байгаа вэ гэсэн 3 асуулт асууя.

С.Бямбацогт: Ажлын хэсэг хариулъя. 4.

Ш.Батбаяр: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам Батбаяр. Гишүүний асуултад хариулъя. 7.1.8 дээр заасан журам бол мөн адил түрүүний шинэ аргачлал зохиохгүй байгаа. Бид харин олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аргачлалуудыг Монгол Улсад хэрэглэх нөхцөл, шалгуур, бүртгэл, баталгаажуулалтын асуудлыг зохицуулахаар байгаа. Голд Вера зэрэг стандартын баталсан аргачлалуудыг Монгол Улс ч гэсэн олон улсын зах зээлд хүлээн зөвшөөрөгдөхийн тулд ийм стандартуудыг дагаад явна.

Засгийн газрын хэлэлцээрийн хувьд бол Сингапур, Швейцар зэрэг улсуудтай хийсэн хэлэлцээрүүд дээрээ тохиролцоно. Хэний аргачлалыг хүлээж авах вэ, аль аргачлалаар явах вэ, тухайн улсын аргачлалаар явна гэдгийг бол Засгийн газар шийдэх байгаа. Тэгэхээр энэ дээр бол хуульд яг тодорхой зааж өгөөгүй учраас Засгийн газар тухайн үедээ Монгол Улсдаа төсөвтөө ашигтайгаар энэ асуудлыг шийднэ гэж ойлгож болно.

Малын гаргаж буй карбон шингээлт, юутай холбоотой асуудал дээр бол бас стандартын асуудлууд хөндөгдөж байгаа. Манай малын тоог тоолоод дэлхийн стандартаар том хэмжээний, өндөр жинтэй үхрийн стандартаар яваад байдаг. Энэ ажлыг бид бас олон улсын хэмжээнд ярьж, манай улсын хэмжээнд тэжээгдэж байгаа дундаж үхрийн хэмжээ, ялгаруулж байгаа нүүрсхүчлийн хэмжээг бол шинэчлэн тогтоолгох ажлыг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас бол хийж, хэрэгжүүлж байгаа. Ингэснээр манай нийт карбоны 50 хувийг эзэлж байгаа шүү дээ хөдөө аж ахуйн салбарт. Тэгэхээр эндээс нэлээн бууралт гарна гэж бид тооцоолж байгаа. Энэ ажлыг бол бид эхлүүлээд судалгааны ажлуудаа хийгээд явж байгаа.

Хуулиар бол бүтэц, орон тоо улсын төсөвт бол ямар нэгэн дарамт байхгүй. Одоо байгаа бүтэц дээрээ ЦУОШГ дээр энэ ажлыг хэрэгжүүлж явна. Бүрэн боломжтой гэж үзэж байгаа.

С.Бямбацогт: Лувсанжамц гишүүн тодруулъя.

Г.Лувсанжамц: Баярлалаа. Ер нь чиглэл бол зөв байгаа юм байна. Энийгээ бас бэлэн байдлыг нь хангаад явчихад асуудалгүй ойрын хугацаанд, энэ жилээс

эхлээд бас хэрэгжих боломжтой аргачлалууд нэвтрэх юм байна гэж хүлээлттэй байна.

Мэдээллийн чанартай 2 зүйл хэлье. Монгол Улсад яг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн MRV зохиогоод батлуулж байгаа Юрика гээд байгууллага байгаа. Байшинг дулаалах, гэрийг дулаалснаар сэргээгдэх эрчим хүчинд шилжүүлээд CO₂ -ын бууралтын хэмжээг нь олон улсын голд стандартаар батлуулчихсан байгаа. Тэгэхээр энэ бол бэлэн төсөл, аргачлал байгаа учраас энэ дээр та хэд маань хамгийн түрүүнд анхаарлаа хандуулахыг хүсэж байна. Ингэснээрээ бид нар Улаанбаатар гэлтгүй орон нутагтаа ч гэсэн агаарын бохирдлыг бууруулах боломж нь бүрдэж байгаа. Тэгэхээр энийгээ та бүхэн сая 2027 оны хөгжлийн төлөвлөгөөнд туссан байгаа. Байгаль орчны яамны харьяанд айл өрхийн сэргээгдэх эрчим хүч, байшин, гэрийн дулаалгыг хэмжих дээр би санал оруулаад дэмжигдсэн. Тэгэхээр төсөв өргөн барихдаа энэ дээрээ та хэд минь бас маш анхааралтай ажиллаасай гэж хүсье. Амжилт хүсье.

С.Бямбацогт: Үг хэлчихлээ. Гишүүд асуулт асууж дууслаа. Би бас 1 асуулт асуугаадахъя. Сая бас олон сайд нар би ч санаачилж байсан юм, би боловсруулж байсан, олон хүнээр дамжсан, маш сайн хууль болсон гээд яриад байна. Сая хэлэлцүүлэг хийж байх, 2 цагийн орчим хэлэлцүүлэг хийлээ бид нар. 1 цаг гаруй. Ингэж байхад бас нэг тийм тодорхой ойлголт авч чадсангүй. Тэгээд би авч чадахгүй байна гэдэг чинь Их Хурлын гишүүд авч чадахгүй байгаа байх. Цаад талд нь иргэд, олон нийт бас авч чадахгүй байгаа байх. Тийм болохоор иргэд, олон нийтэд энгийн, ойлгомжтой, товч тодорхой энэ хууль батлагдсанаараа үнэхээр Монгол Улсын байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлт маань өнөөдөр ямархуу байдалтай байгаа нь яаж сайжрах юм. Энэ хууль батлагдсанаар сая карбон кредит баахан ярьчихлаа. Үүнтэй холбоотой сэргээгдэх эрчим хүчний төслүүд яаж хэрэгжээд, айл өрхүүд, ард иргэд, аж ахуйн нэгж, байгууллага хувийн хэвшил энэ салбар луу илүү анхаарал тавьдаг, хөрөнгө оруулаад, түүнээс үр өгөөжийг нь хүртээд, энэ агаарын бохирдол, орчны бохирдол яаж буурах юм. Яг энэ хууль батлагдсанаараа иргэдэд, олон нийтэд, аж ахуйн нэгж, хувийн хэвшилд ямар үр өгөөжтэй байх юм. Энийг энгийн, ойлгомжтой үгээр тайлбарлаад, базаад 1 хэлээдхээч. Тэгээд 3 минут дотор ингээд хэлж чадаж байвал тэгээд тэрийг чинь иргэд ойлгож байвал, аж ахуйн нэгжүүд ойлгоод дэмжиж байвал энэ их чухал хууль байна гэж ойлгоно. Тэгэхгүй ингээд л болох ч юм шиг, болохгүй ч юм шиг, зөв ч юм шиг буруу ч юм шиг баахан л ерөнхий л юм яриад байдаг. Хэрэгтэй, чухал гээд л. Ёстой хэрэгтэй хууль шүү дээ, ёстой хэрэгтэй байна шүү дээ гээд л. Тэгээд яг иргэдэд наалдуулаад, энийг л Монгол Улс даяар иргэдэд явуулахад бас үнэхээр дэмжих юм байна. Ойлгох юм байна гэсэн хуулийнхаа төслийн зорилго, ач холбогдол, үр өгөөжийг яриадхаач. Ямар үр дүн гарах юм. 4 дүгээр микрофон.

Ш.Батбаяр: Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийг баталснаар, энэ хууль батлагдсанаар бол маргаашаас бол агаар сэрүүцчихнэ, цөлжилт буурчихна гэсэн үг биш. Харин усны хомсдол, ган, зуд, үер зэрэг эрсдэл Монгол Улсад илүү бэлтгэлтэй оролцох боломжийг бүрдүүлнэ. Төсвөөс зарцуулж байгаа хөрөнгө мөнгийг бууруулна. Уур амьсгалын өөрчлөлт, бэлчээрийн доройтол, ган зудын эсрэг төсвийн мөнгө, татвар төлөгчдийн мөнгөнөөс гарч байгаа зардлыг эрс бууруулна. Энэ чиглэлээр гадаадын хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөрүүдийг Монгол Улсдаа татах боломж бүрдэж байгаа.

Иргэнд бол илүү товчоор тайлбарлах юм бол гамшгийн эрсдэл буурах давуу тал үүсэж байна. Усны нөөцийг хамгаалах давуу тал үүсэж байна. Хүнсний аюулгүй байдал сайжрах давуу тал үүсэж байгаа. Товчхондоо малчин, хөдөлмөрчдөд бол бэлчээр хамгаалах хөрөнгө оруулалтыг гадаадын болон хувийн хэвшлийн санхүүжилтээр хийх боломж гарч байгаа. Одоо бол зөвхөн малчид бэлчээрээ өөрсдөө л хайрлаж хамгаалах орон нутгийн төсвөөр энэ ажил хийгдэж байгаа.

Ус хангамжийн төслүүд бол шинээр хийгдэж эхэлнэ. Гадаад, дотоодын төсөл хөтөлбөрөөр. Зудын эрсдэлийг бууруулах санхүүжилтийг бол мөн гадаадын хөрөнгө оруулалтаар татах боломжтой.

Нийслэл хотын агаарын бохирдлыг бууруулахад бол томоохон хувь нэмэр оруулна. Гэр хорооллын айл өрхүүдийг сэргээгдэх эрчим хүч буюу ногоон эрчим хүчээр дулаан, цахилгааны асуудлыг шийдэх боломж бүрдэнэ. Энэ боломжийг гадаад, дотоодын томоохон төсөл хөтөлбөрүүдээр хэрэгжүүлнэ гэж үзэж байгаа. Улсад бол карбон зах зээлээс олох орлогын үүд нээгдэнэ. Тоглоомын дүрмийг тодорхой болгож, дэлхий дахинд зарлаж өгнө гэсэн үг. Мөн ногоон хөрөнгө оруулалтыг татах боломж бүрдэж байгаа. Олон улсын санхүүжилт авах эрх зүйн орчин бүрдэж байгаа. Одоо Засгийн газрын хооронд хийгдээд байгаа 4 хэлэлцээрийг хэрэгжүүлэх эрх зүйн орчин, дүрэм журам, тооцооллууд тодорхой болно гэж хэлж болно.

Энэ хууль бол зөвхөн нүүрстөрөгчийн тухай хууль биш. Энэ бол эдийн засаг, хөдөө аж ахуй, мал аж ахуй, зам, тээвэр, эрчим хүч гээд Монгол орны бүхий л салбарын бүхий л үйл ажиллагааг ногоон технологийг нэвтрүүлэх, ногоон хөрөнгө оруулалтыг татах эрх зүйн орчныг тодорхой болгож байгаа маш том давуу талтай хууль гэж бид үзэж байгаа.

С.Бямбацогт: Гаднын хөрөнгө оруулалт, зээл тусламжаар ногоон буюу сэргээгдэх эрчим хүчний төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх, цөлжилтөөс хамгаалах, байгаль орчноо хамгаалах ийм боломжууд бий болох юм байна. Тийм үү. Өөр яг эдийн засгийн үр өгөөж юу байна. Сая карбон кредит гээд баахан ярилаа шүү дээ бид нар. Тэгэхээр гэр хороолол Улаанбаатар хотод бид нар чинь айл өрхүүд сэргээгдэх эрчим хүчний, нарны панел дэлгэц тавих юм бол 280 төгрөгөөр тогийг нь худалдаж авна гэж байгаа. Иргэд маань 140 төгрөгөөр өөрсдөө тогны тэгээд мөнгөө төлж байгаа мөртөө өөрсдийн сэргээгдэх эрчим хүчний тогоо 280 төгрөгөөр нийлүүлнэ гэж байгаа. Эрчим хүчний сүлжээнд. Ийм өрхүүдэд энэ чинь тодорхой бас бодитой дэмжлэг болж байгаа. Тэгвэл үүнтэй адилхан ямар дэмжлэг болох юм. Иргэд орлогоо нэмэгдүүлэх, зардлаа бууруулах, утаа, агаарын бохирдлыг бууруулах яг бодитой ямар үр дүнгүүд гарах вэ. Сая бол Улаанбаатар хотын агаарын бохирдол буурна л гээд байна шүү дээ. Ерөнхийдөө л буурна гээд байна. Тэгэхээр яг тодорхой 1 иргэн дээр, 1 аж ахуйн нэгж дээр жишээ авч байгаад яривал. 4 дүгээр микрофон.

Ш.Батбаяр: Гэр хорооллоос үүдэлтэй агаарын бохирдлыг бууруулах тал дээр бол сая хэлсэнчлэн 1 өрх өнөөдрийн байдлаар дулаан, цахилгаанаа сэргээгдэх эрчим хүчээр шийдэхэд бол ойролцоогоор 4-5 сая төгрөгийн хамгийн багадаа санхүүжилт хэрэгтэй болж байгаа. Тэгээд цаашлаад 15 сая төгрөгөөр иж бүрэн энэ асуудлыг шийдэх боломжтой болж байгаа. Гэтэл манай улсын хувьд 300-500 мянган төгрөгийн нүүрсийг түлсэн нь бол сар бүр хэрэгцээгээ хангасан нь бол иргэдэд илүү

амар байгаад байгаа. Тэгэхээр энэ карбон кредитийн тогтолцоо маань яг өрхийн хувьд бол кредит зарах гэхээсээ илүү энэ ногоон технологийг амьдрал ахуйдаа хэрэгжүүлж, нүүрсхүчлийн хийн ялгарлыг бууруулснаараа олон улсын зах зээлээс дэмжлэг авах юм. Тэгэхээр энэ нь юугаар үүсэх вэ гэхээр тухайн 15 сая хүртэлх төгрөгийн зээлээр гэртээ ногоон технологийн сэргээгдэх эрчим хүчний дулаан цахилгаанаар хангаж, уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг байгаль экологидоо ногоон төсөл хэрэгжүүлж, хотын агаарыг бууруулахад хувь нэмэр оруулсныхаа төлөө гадаадын хөрөнгө оруулагчдын хийж буй төслөөс тодорхой урамшууллыг авна л гэж тооцож болно шүү дарга аа.

Тэгэхээр яг иргэн бол карбоныг бол зарахгүй. Энэ хэрэгжүүлсэн төсөлд оролцсоноороо дэмжлэг урамшуулал авна. Сар бүр төлөх нөгөө зээлийнхээ төлбөрийг л энэ төлбөрөөсөө барагдуулна гэдэг ийм дэмжлэгийн асуудал байгаа. Ингэснээр иргэдийн утаа гаргаж байснаас ногоон технологи руу шилжье гэдэг ухамсрыг л нэмэгдүүлэх, тэгснээр зардлыг нь бууруулах ийм ач холбогдолтой байгаа юм. Энэ хууль батлагдаж, тодорхой болсноор.

С.Бямбацогт: Баярлалаа. Нэмж хариулах юм уу. Нэмээд хариулчихъя. 4 дүгээр микрофон ажлын хэсэг.

Б.Мөнх-Эрдэнэ: Эдийн засаг, хөгжлийн яам Мөнх-Эрдэнэ нэмж хариулъя. Дунд, урт хугацааны хөгжлийн бодлого төлөвлөлтийг хариуцдаг байгууллагын хувьд бид яаж харж байна вэ гэхээр бид нар сая төсвийн хүрээний мэдэгдэл, улсын хөгжлийн төлөвлөгөө хэлэлцсэн. Бид нар улсын төсвөөр цаашдаа төлөвлөж байгаа томоохон хөгжлийн том төслүүдээ хэрэгжүүлэхэд маш орон зай хумигдмал байгаа. Ялангуяа бид нар улсын хөгжлийн урт хугацааны хөгжлийн төслүүд дээр, сая өнгөрсөн намар батлуулсан төслүүд дээр санхүүжилт шаардлагатай төслүүдийн жагсаалт гэж байгаа. Үүн дотроо ялангуяа сэргээгдэх эрчим хүчний төслүүд, дээрээс нь энэ Орхон-Онги, Хэрлэн-Тооно гэдэг ийм усны төслүүд, бусад байгаль орчны ногоон хөгжлийн төслүүдэд хөрөнгө оруулалт татахад урт, дунд хугацаандаа бол суурь нэмэр болох ийм хуулийн төсөл юм. Өөрөөр хэлбэл энэ карбон кредитийн зах зээлийг ашиглан хөрөнгө оруулалт нэмэгдэх ач холбогдолтой. Өнөөдөр бид нар зөвхөн сайн дурын үндсэн дээр хувийн дэвшлүүд маань карбон кредит босгож байгаа. Энэ хууль батлагдсанаараа цаашдаа бид нар албан ёсны зах зээл дээр буюу бусад улсуудтай карбон кредитийн гэрээнүүдийг байгуулах өргөн боломж нээгдэнэ. Үүгээрээ албан ёсны байдлаар олон улсад тухайн төслүүдийнхээ кредитийг арилжааснаараа бид нар арай өндөр өртөгтэй кредитийн орлого олох боломжтой. Одоохондоо манай хувийн хэвшлийн зарим төслүүд маань нөгөө сайн дурын зах зээл дээр арилжиж байгаа учраас арай бага дүнтэйгээр арилжаалж байдаг. Тэгэхээр энэ бол ер нь хувийн хэвшлийн болон бусад төслүүдийн уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад үүсгэсэн кредитээ олон улсад арилжаалах байдлаараа 1 давуу талтай. Хөрөнгө оруулалт нэмэгдэх. Нөгөө талдаа манайх энэ хуультай улс учраас бусад улсуудтай гэрээ байгуулсныхаа үндсэн дээр ногоон санхүүжилтүүдийг хөрөнгө оруулагч нараас татахад нэмэр дэмжлэг болох ач холбогдолтой гэж харж байгаа юм. Баярлалаа.

С.Бямбацогт: Баярлалаа. Энэ юмнуудаа л сайн ярьж, иргэд, олон нийтэд бас ойлгуулж байх хэрэгтэй шүү.

Зочин танилцуулъя. Нийслэлийн ерөнхий боловсролын 30 дугаар сургуулийн Эрдэнэсоёл багштай 10^в ангийн сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Төрийн ордонтой танилцаж байгаа сургагч хүүхдүүддээ энэ өдрийн мэндийг хүргэж, сурлагын өндөр амжилт, хамгийн сайн сайхан бүхнийг Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс хүсэн ерөөе. Эрдэм номдоо сайн шамдаж суралцаад удахгүй анги дэвших шалгалтуудаа амжилттай өгөөрэй.

Хуулийн төсөлтэй холбогдуулж гишүүд асуулт асууж дууслаа.

Хуулийн төслүүдийн талаар Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг дэмжсэн, дэмжээгүй байр суурьтай намын бүлгийг төлөөлж болон бүлэгт харьяалагддаггүй гишүүдээс урьдчилсан ирүүлсэн нэрсийн дагуу үг хэлнэ. Пүрэвжавын Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Уур амьсгалын өөрчлөлтийн тухай энэ хуулийн төслийг зарчмын хувьд хэлэлцэхийг дэмжиж байна. Мэдээж сая бас Бямбацогт дарга ч бас үгэндээ хэлчихлээ. Тодруулах зүйлүүд бол нэлээн харагдана лээ. Тэгэхээр би бас эхлээд зохион байгуулалтын саналаа хэлчихье гэж бодож байна.

Ер нь бас яах вэ, манай гишүүд дунд бас энэ чиглэлээр мэргэшсэн хүмүүс нэлээн байдаг байх. Дэлхийнбанк Уур амьсгалын өөрчлөлтийн Ногоон санд бас ажиллаж байсан Энхбатын Болормаа гишүүнээр ахлуулаад энэ коп-ыг зохион байгуулахаас өмнө өөрсдөө бас энэ манлайллаа яг төрийн бодлогоороо бас харуулах нь зөв болов уу гэж бодож байна.

Тийм учраас бас энэ хаврын чуулгандаа багтаах үүднээс бас цаг алдахгүй энийг мэргэшсэн, энэ чиглэлийнх нь ажлыг нь ОУБ-д бас хийж явсан хүнээр ахлуулаад, бас энийгээ урагшлуулаад явах нь зөв болов уу гэсэн ийм бодолтой байна. Боломжтой бол бас ажлын хэсэгт орж ажиллая гэж 1 дүгээрт хэлмээр байна.

Тэгээд ер нь иргэд, олон нийт маань бас мэдэрч байгаа байх. Зун хаачив гээд л өөр өөрсдөөсөө л сүүлийн өдрүүдэд асууж байна шүү дээ. Хавар, намарт энэ зун шахагдаад байна л гэж байна. Энэ зүгээр бас үзэгдэл нь өөрөө эргээд энэ уур амьсгалын өөрчлөлт дэлхий дахинаа явагдаж байгаа. Монгол Улс ч гэсэн үүний нөлөөлөлд байна гэдэг зүйлийг бид хэд ч гэсэн ойлгож авах хэрэгтэй байгаа. Манай орны хувьд ч гэсэн сүүлийн 85 жилийн хугацаа дахь энэ үзүүлэлтээрээ 2.5 градусын хэмээр бас дулааралт явагдчихсан байна гэж зүйлүүд яригдаж байна. Бид хэд бол нэг их тийм аж үйлдвэрлэл сүртэй хөгжсөн орон бас биш болчихоод байгаа. Суурь эдийн засагт бол эд нар шууд нөлөөлнө. Мэдээж хүнс, хөдөө аж ахуйн салбарт. Тэгэхээр бид хэд цаашдын амьдралын гэдэг юм уу, тодорхой эдийн засгийн чиглэлээр ч гэсэн авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, бодлого бол бас энэ түвшиндээ өөрчлөгдөх ёстой гэдэг зүйлийг л харуулж байна. Нийслэлээс сонгогдсон гишүүний хувьд ч гэсэн энэ асуудал бас нийслэлчүүдэд хамаатай л болчихож байгаа юм. Үнэндээ хэлэхэд үйлдвэрлэсэн дулааныхаа 30 хувийг бид нар хүрэн орон сууц буюу хуучны орон сууцуудаар алдчихаж байгаа байхгүй юу. Угсармал орон сууцуудаар. Тэгээд энийг дулаалаад явна гэдэг бол бас энэ хүлэмжийн хийг бууруулаад л явж байна гэсэн үг. Автомашинаас ялгарах энэ хүлэмжийн хийг бид нар бууруулах л ёстой. Тэгэхдээ энийг зөрүүлээд нэг их ногоон гэдэг юм уу тийм цахилгаан автомашиныг дэмжих гээд байгаадаа биш. Илүү зүгээр эерэг сэтгэлгээгээр харвал масс нийтийн тээврийг дэмжих, энийгээ бий болгох ийм

амьдралын дадалтай болох, тэр 20 минут хотын концепцын асуудал яригдаад байгаа байхгүй юу. Хүн болгон шаардлагагүй зорчилт хөдөлгөөнийг хийж төрийн үйлчилгээ авдаг биш, орчин тойрондоо төрийн үйлчилгээг авах нь энэ хүлэмжийн хийг бууруулахад л хувь нэмрээ оруулж байгаа энэ зүйл байгаа. Тэгэхээр энэ бүхий л салбар дээр бид хэдийн хандлага ойлголтын олон зүйлүүдийг өөрчилнө.

Алсдаа энэ хүлэмжийн хийг бууруулах үйл ажиллагааг татвар төлөгчдийн мөнгөөр хийгээд баймааргүй байна. Ялангуяа ялгаруулагч нь, хэрэглэгч нь төлдөг энэ зүйл рүү явах ёстой. Энд яг илэн далангүй хэлэхэд малчдын маань ч асуудал хөндөгдөнө. Малын хөлийн татварыг бид хэд маш зөв болгох ёстой. Эргээд үр шим үр ашигтай эрчимжсэн мал аж ахуй, нүүдлийн мал аж ахуйтай хэрхэн яаж хослуулах вэ гэдгийг бид хэд одоо л бодох цаг болсон. Тэгэхээр энэ зүйлүүд ингээд хүссэн, хүсээгүй яригдана. Дэлхий нийтээрээ яригдаж байгаа. Түрүүчээсээ малын тоо толгой дээр бүр үхэр дээрээ хүртэл 100 долларын, жилийн 100 долларын такс тавьчихаж байгаа улс орнууд ч бас байна. Энэ өөрөө хамгийн их хүлэмжийн хий ялгаруулж байгаа амьтан гэдэг юм уу энэ чиглэлдээ бас ороод явчихдаг ийм зүйл байх юм. Тэгэхээр яг л энийг бид хэд бас бодитой хөрсөн дээрээ буух энэ зүйлүүд рүүгээ бас орох нь зөв байна гэдэг зүйлийг хэлмээр байна.

Түрүүн бас гишүүдийн асуултад ч гарлаа. Маш их хэмжээний нуур, горхи гадаргын ус ширгэж байна. Энэ зүйл .../минут дуусав/

С.Бямбацогт: Байхгүй. Мөнхбат гишүүн асуултаа асууя. Алга байна. Асуулт биш, үг хэлнэ. Жудагийн Баярмаа гишүүн үгээ хэлье. Индэр дээрээс.

Ж.Баярмаа: Энэ уур амьсгалын өөрчлөлтийн асуудал мэдээж Монгол Улсад бол бас асуудал мөн үү гэвэл мөн. Гэхдээ энийг бол цоо шинэ анхдагч хууль гаргаж шийдэх шаардлагатай эсэхийг бас сайн мэдэхгүй байна. Яагаад гэвэл Монгол Улсад асар олон байгаль орчин, уур амьсгалтай холбоотой хуулиуд байна. Жишээлбэл, Байгаль орчныг хамгаалах тухай хууль гээд байна. Агаарын тухай хууль гээд байна. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тухай хууль гээд байна. Усны тухай хууль байна. Гамшгаас хамгаалах тухай хууль байна. Ойн тухай хууль, Хот байгуулалтын тухай хууль гээд маш олон.

Тэгэхээр энэ хуулийн төслөөр бол мэдээллийн нэгдсэн сан үүсгэх юм байна. Хэмжилт хийх юм байна. Тайлагнал гаргах юм байна, баталгаажуулалт хийх юм байна. Карбоны зах зээлийн зохицуулалт гээд ийм шинэ юм бол бас орж байж мэдэхээр юм байна. Тэгээд ерөнхийдөө Үндэсний зохицуулагч байгууллага гэсэн ийм шинэ тогтолцоог бүрдүүлнэ гэсэн ийм юм байгаад байгаа юм. Гэтэл ООС-ын энэ 2024 оны энэ outlook-д гэж юу гэж заасан байна вэ гэвэл энэ уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой энэ асуудлыг шинэ зохицуулалтыг бий болгож хийхийн урьдаж одоо байгаа зохицуулалтуудаараа асуудлыг шийдэх гэж оролдох хэрэгтэй гээд ингээд заачихсан байгаа юм. Одоо байгаа хуулиудаараа зохицуул, заавал ч үгүй цоо шинэ зүйл бий болгох шаардлагагүй гээд энэ ООС-ын зөвлөмжид байна л даа. Тэгэхээр одоо байгаа энэ хуулиуд маань Монгол Улсын хувьд Парисын хэлэлцээрийн өмнө хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхэд боломжгүй болоод байгаа гэж үзэхгүй байна.

Дээрээс нь Монгол Улс бол хүлэмжийн хийн ялгаруулалтад бол маш бага хувь эзэлдэг. 0,09 хувь юм байна. Дээрээс нь Монголын нүүрстөрөгчийн ялгарлын 93,2

хувь нь эрчим хүч, мал аж ахуйгаас гардаг байхад яг энэ хууль бол яг энэ 2 асуудалтай нарийн тулж холбогдож, энэ асуудлыг шийдэх үү гэдэг асуулт байна.

Мэдээж дэлхийн дулаарлыг бол Монгол Улс дангаараа шийдэхгүй нь тодорхой. Эсрэгээрээ бид нарын хийж чадах ёстой юм юу вэ гэвэл Монгол Улсад тулгамддаг ган, зуд, усны хомсдол, цөлжилт, ой хээрийн түймэр гээд энэ зүйлүүд байна.

Дээрээс нь дахиад Дэлхийн банк, OCD-ын энэ тайлангуудад юу гэж заасан байна вэ гэвэл хамгийн өндөр өгөөжтэй хөрөнгө оруулалт нь ялгарлыг хэмжих шинэ байгууллага байгуулах огт биш. Харин усан хангамж, ус хуримтлуулах байгууламж, бэлчээрийн менежмент зэрэгт хөрөнгө оруулалт хийе гэж ингэж заасан байгаа юм. Гэтэл бид нарын энэ төсөл чинь нөгөө л тайлагнал. Өмнөх тайлангуудаа бид нарыг энэ цааснаасаа салах вэ гээд эхнээсээ тайлагналын бус ийм тогтолцоо руу шилжиж байж энэ нь дахиад баахан тайлагнал хийх ийм эрх зүйн зохицуулалт болоод, энэ нь төдий чинээ захиргааны зардлыг нэмэгдүүлж таарах гэж байгаа юм.

Дахиад л нөгөө баахан бүртгэл, баталгаажуулалт гээд ингээд явж байгаа юм. Тэгсэн мөртөө энэ хуульд нөгөө яг хийх ёстой хөрөнгө оруулалт, илүү ихийг шаардсан тэр усан сан, худаг, усалгааны систем, ган зудаас урьдчилан сэргийлэх энэ дэд бүтцийн асуудлууд огт тусгагдаагүй байна. Тэгээд энэ хууль батлагдсанаар 2030 онд Монгол Улсад жишээлбэл яг ямар хэмжигдэхүйц үр дүн гарах вэ, хэдэн тонн ялгаруулалт буурах вэ, хэдэн төгрөгийн хөрөнгө оруулалт татах вэ, хэдэн сумын усны хангамж сайжрах вэ, хэдэн хувийн эрсдэл буурах вэ гэдэг энэ талын ийм тодорхой яг бодит үр дүнгийн асуудлууд ерөөсөө байхгүй. Нөгөө л нэг захиргааны шинжтэй тайлан бүртгэл, журам гэсэн ийм л зүйлүүдийг тусгасан ийм хууль юм уу гэж бодож байна.

Дахиад энд бол маш тодорхой бүр ийм хууль гарчихсан байгаа шүү дээ. Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай гээд. Тэгээд ийм хууль батлагдчихсан, дээрээс нь энэ 93,2 хувийг нь эрчим хүч, мал аж ахуйгаас гардаг гээд ингээд заачихсан байхад .../минут дуусав/

С.Бямбацогт: Зочин танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Оюунсайханы Алтангэрэлийн урилгаар Өвөрхангай аймгийн Уянга сумын Засаг даргын Тамгын газрын албан хаагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Төрийн ордонтой танилцаж байгаа иргэддээ Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Манай Алтангэрэл гишүүн эмэгтэйчүүдтэй ойрхон ажилладаг байх.

Гишүүд үг хэлж дууслаа. Санал хураалтыг 16 цагаас нэгтгээд явуулна. Дагасан 13 хуультай юм байна.

15.36 цаг.

Дараагийн асуудалдаа оръё.

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулна.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Сайнбуянгийн Амарсайхан танилцуулна. Индэрт урьж байна.

С.Амарсайхан: Эрхэм Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг танилцуулж байна.

Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр хот, тосгоны өөрийн удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн үндсийг хуулиар тогтоох, мөн хот тосгонд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн зарим чиг үүргийг шилжүүлэх асуудлыг Улсын Их Хурал шийдвэрлэхээр зохицуулсан.

Энэхүү Үндсэн хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэх зорилгоор Улсын Их Хурлаас 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль, түүний шинэчилсэн үндсэн найруулгыг баталж, мөн өдрийн Хот байгуулах тухай 72 дугаар тогтоолоор улсын зэрэглэлтэй 6, орон нутгийн зэрэглэлтэй 43, дагуул 4 хот байгуулахаар шийдвэрлэсэн.

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль нь Монгол Улсын хот, тосгоны суурин газрын хөгжлийг зөвхөн засаг захиргааны зохион байгуулалтын хүрээнд улс, улсын болон бүс нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан эдийн засаг, дэд бүтэц, хөрөнгө оруулалт, үйлдвэрлэл, үйлчилгээний төв болгон хөгжүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүлж байгаагаараа онцгой ач холбогдолтой юм.

Өөрөөр хэлбэл энэ хууль бүс нутгийн хөгжлийг зөвхөн аймаг, сумын төвийн түвшинд хязгаарлахгүйгээр тухайн бүс нутгийн таталцлын төв, хүн амын төвлөрөл, үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ, тээвэр логистик, инженерийн дэд бүтцийн зангилаа болгон хөгжүүлэх боломжийг нээх юм.

Ингэснээр төрийн үйлчилгээ иргэдэд ойртож, хөрөнгө оруулалт тодорхой төвүүдэд чиглэж, бүс нутгийн эдийн засгийн идэвхжил нэмэгдэх Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах, орон нутагт амьдрах, ажиллах, хөрөнгө оруулах нөхцөлийг сайжруулах төрийн бодлогын чухал суурь бүрдэх юм.

Засгийн газраас боловсруулсан энэхүү хуулийн төслийн зорилго нь хот байгуулах бодлогыг Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн, бодит тооцоо судалгаанд суурилсан, эрх зүйн болон зохион байгуулалтын хувьд хэрэгжих боломжтой, үе шаттай арга хэмжээ хэлбэрээр хэрэгжүүлэхэд оршиж байгаа юм.

Хот байгуулах асуудал нь зөвхөн нэршил, статусын асуудал бус тухайн хотын эдэлбэр газар, хил зааг, удирдлагын бүтэц, чиг үүрэг, төсөв хөрөнгө, өмч санхүү, хүний нөөц, иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний зохион байгуулалттай шууд холбоотой цогц асуудал юм.

Энэ хүрээнд Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах явцад дараах хүндрэл, бэрхшээлүүд давхар үүсэж байна. Хот байгуулахад хүн амын тоо, эдийн засаг, нийгмийн ач холбогдол, дэд бүтэц, зам, харилцаа, инженерийн байгууламж, тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид үзүүлэх нөлөөлөл зэрэг олон шалгуурыг хамтад нь тооцох шаардлага үүссэн.

Гэвч өмнө нь батлагдсан шийдвэрүүдийг хэрэгжүүлэх явцад зарим хотын хүн амын тоо, эдэлбэр газар, хил зааг, өмч, төсөв, байгууллагын бүтэц бүрэн тодорхой болоогүй. Ийм нөхцөлд улсын зэрэглэлтэй, орон нутгийн зэрэглэлтэй болон дагуул хотуудыг нэгэн зэрэг олноор байгуулах нь чиг үүргийн давхардал, төсвийн нэмэлт ачаалал, зохион байгуулалтын хүндрэл үүсэх эрсдэлтэй гэж үзсэн тул хот байгуулах бодлогыг бодит нөхцөл бэлтгэл ажлын түвшинтэй уялдуулан үе шаттай хэрэгжүүлэх нь зүйтэй юм.

Иймд дээр дурдсан практик хүндрэл бэрхшээл, нөхцөл шаардлагыг харгалзан Хот, тосгон эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах хэрэгцээ шаардлага үүссэн болно.

Дээрх нөхцөл байдлыг харгалзан хуулийн төсөлд хот байгуулах бодлогыг эрх зүй, зохион байгуулалт, төсөв санхүүгийн хувьд бодитой хэрэгжүүлэхэд чиглэсэн дараах гол зохицуулалтуудыг хуулийн төсөлд тусгалаа.

1 дүгээрт, Багануур Налайх гэсэн улсын зэрэглэлтэй 2 хотын зохион байгуулалт, эдэлбэр газар, хил зааг, чиг үүргийн шилжилт, төсөв санхүү, хүний нөөцийн бэлтгэлийг ханган хэрэгжүүлэхээр тусгасан. Харин орон нутгийн зэрэглэлтэй болон дагуул хотуудын асуудлуудыг дээрх хотуудын хэрэгжилтийн явц, үр дүн, туршлага, гарсан хүндрэл, тэдгээрийг шийдвэрлэсэн арга зам, дараагийн үе шатад хэрэгжүүлж болох үе шаттай төлөвлөгөөгөөр шийдвэрлэхээр тооцож байна. Энэ зорилгоор хот байгуулах тухай Улсын Их Хурлын 2024 оны 72 дугаар тогтоолын улсын болон орон нутгийн зэрэглэлтэй болон дагуул хот байгуулахтай холбоотой холбогдох зохицуулалтыг хүчингүй болсонд тооцохоор Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулсан болно.

2 дугаарт, чиг үүргийн давхардал хариуцлагын зааг ялгааг тодорхой болгох зорилгоор шилжилтийн үеийн зохицуулалтыг мөн тусгалаа. Тодруулбал, улсын зэргэлдээ хотын зөвлөл, Захирагч хуулийн дагуу сонгогдох хүртэл хугацаанд тухайн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Засаг дарга нь хотын зөвлөл, Захирагчийн чиг үүргийг хэрэгжүүлэхээр хуулийн төсөлд тусгасан.

Ингэснээр шинэ бүтэц, шууд давхардал бий болохоос сэргийлж, төрийн үйлчилгээ тасалдахгүй байх, төсвийн нэмэлт ачааллыг бууруулах хотын удирдлагын тогтолцоог үе шаттай бүрдүүлэх нөхцөл бүрэлдэнэ.

Хуулийн төсөл батлагдсанаар Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг бодит нөхцөлд нийцүүлж зохион байгуулалттайгаар бэлтгэлийг хангаж, үе шаттай хэрэгжүүлэх эрх зүйн үндэс ч бас давхар бүрдэх юм. Ингэснээр хот байгуулах бэлтгэл ажлыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах, чиг үүргийн давхардал, төсвийн үр ашиггүй зардлаас урьдчилан сэргийлэх, орон нутгийн зэрэглэлтэй хот болон тосгоны хүн амын шалгуурыг бодит нөхцөлд нийцүүлэх ач холбогдолтой юм.

Иймд Монгол Улсын хот, суурин газрын хөгжлийг бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулж, иргэдэд хүрэх төрийн үйлчилгээг ойртуулах, орон нутгийн хөгжлийн төвүүдийг бодитоор бэхжүүлэхэд чиглэсэн энэхүү хуулийн төсөл, Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулан танилцуулж байна.

Та бүхнээс уг хуулийн төслийг хэлэлцэн дэмжиж өгөхийг хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

С.Бямбацогт: Баярлалаа. Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Сархадын Зулпхар танилцуулна. Таныг индэрт урьж байна.

С.Зулпхар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Засгийн газар 2026 оны 05 дугаар сарын 26-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Төрийн байгуулалтын байнгын хороо 2026 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн хуралдаанаараа явууллаа.

Хууль санаачлагч хот байгуулах бодлогыг Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн, бодит тооцоо судалгаанд суурилсан, эрх зүйн болон зохион байгуулалтын хувьд хэрэгжих боломжтой үе шаттай арга хэлбэрээр хэрэгжүүлэх зорилгоор хуулийн төслийг боловсруулсан байна.

Хуулийн төсөлд Багануур, Налайх гэсэн улсын зэрэглэлтэй 2 хотын зохион байгуулалт, эдэлбэр газар, хил зааг, чиг үүргийн шилжилт, төсөв санхүү, хүний нөөцийн бэлтгэлийг ханган хэрэгжүүлэх, чиг үүргийн давхардал, хариуцлагын зааг ялгааг тодорхой болгох зорилгоор улсын зэрэглэлтэй хотын зөвлөл, захирагч хуулийн дагуу сонгогдох хүртэлх хугацаанд тухайн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Засаг дарга нь хотын зөвлөл, Захирагчийн чиг үүргийг хэрэгжүүлэх шилжилтийн үеийн зохицуулалтыг тусгасан байна.

Хуулийн төсөлд иргэдийн оролцоог хангах санал авах зорилгоор Улсын Их Хурлын D-Parliament.mn цахим системд байршуулсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан төрийн зарим чиг үүргийг тосгонд шилжүүлэх, төсвийн асуудлыг хуулийн төслөөс шийдэх боломжтой эсэх, Хархорин хотыг улсын зэрэглэлтэй хот болгон хөгжүүлэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Л.Гантөмөр Дархан, Эрдэнэт, Зуунмодыг улсын зэрэглэлтэй хот болгоход тулгарч буй асуудлын талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал Улсын Их Хурлаас баталсан Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн зохицуулалтаас давсан эсэхийг шийдвэрлэх шаардлагатай талаар болон улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот байгуулахад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Үндсэн хууль болон Монгол Улсын Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн

хүрээнд засаг захиргаа, үндсэн нэгж буюу аймаг, сумыг хэрхэхийг тодруулах хэрэгтэй болох тул хуулийн төслийг дэмжих нь зүйтэй талаар үг хэлсэн болно.

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

С.Бямбацогт: Зулпхар гишүүнд баярлалаа.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Пүрэвийн Зоригтбаатар Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Орон нутгийн удирдлага, зохицуулалтын газрын дарга, Баттулгын Батбямба Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Ганзоригийн Эрдэнэбулган Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга, Доржийн Энхтөр Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын Нийтийн эрх зүйн хэлтсийн дарга, Анандын Энхманлай Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын дарга, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Сумьяагийн Даваасүрэн Багануур дүүргийн Засаг дарга, Дашзэвэгийн Наянбаяр Налайх дүүргийн Засаг дарга.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийн гишүүд, Засгийн газрын гишүүд Улсын Их Хурлын гишүүдийн асуултад үнэн зөв, бодитой, гүйцэд хариулах үүрэгтэй. Худлаа мэдээлэл, буруу мэдээлэл өгөхийг хориглодог. Мөн Улсын Их Хурлын үйл ажиллагаанд хүндэтгэлгүй хандах, ирэхгүй байх, бусад байдлаар хүндэтгэлгүй хандахыг хориглодог шүү. Хэрвээ дэг зөрчих юм бол холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцдог болохыг та бүхэнд сануулъя. Улсын Их Хурлын гишүүдийн асуултад аль болох үнэн зөв, бодитой гүйцэд хариулахыг хүсье.

Зочин танилцуулъя. Завхан аймгийн Цэцэн-Уул сумын ерөнхий боловсролын сургуулийн 1993 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэндээ Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Хуулийн төсөл болон Байнгын хорооны санал, дүгнэлт, хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү. Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн асуултаа асууя.

Д.Энхтүвшин: Үндсэн хуулийн 57.2 дээр зарим чиг үүргийг шилжүүлж, энэ хот байгуулах ийм заалт байдаг. Тэгэхээр одоо энэ шинээр үүсэж байгаа Багануур хот, Налайх хот маань яг ямар чиг үүргүүдийг, нийт дүүргийн чиг үүргүүдийнхээ хэдэн хувийг нь шилжүүлж байгаа вэ. Тэгэхээр энэ Багануур хотын захирагч болон зөвлөл тэгээд Багануур дүүргийн Засаг дарга болон иргэдийн Хурал 2-ын гол ялгаанууд нь яаж харагдах вэ. Ямар давхардлууд үүсэх вэ. Энэ талаар мэдээлэл өгөөч.

С.Бямбацогт: Тодорхой хариулъя. Амарсайхан сайд хариулъя.

С.Амарсайхан: Үндсэн хууль болон Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль, Засаг захиргааны нэгжийн тухай хууль гээд энэ холбогдох дүрэм журамтай уялдуулаад анх Улсын Их Хурлаар тогтоол батлагдахдаа, Засгийн газраас орж ирэхдээ Үндсэн хууль холбогдох зүйл заалтуудтай нийцүүлээд, хотын захирагч, захирагчийн зөвлөл байгуулагдтал тухайн чиг үүргийг хотын, дүүргийн Засаг дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал гүйцэтгэнэ гэсэн ийм заалттай байгаа юм. Тэгэхээр үндсэндээ бол энэ Үндсэн хуулийн зохицуулалтуудыг хэрэгжүүлэх зорилгоор баталсан 6 хот, улсын зэрэглэлтэй, орон нутгийн зэрэглэлтэй 43 хот, дагуул 4 хотыг байгуулахаар шийдвэрлэснээс улсын зэрэглэлтэй хотуудаас Налайх, Багануурыг ингэж үйл ажиллагааг нь цааш нь зохион байгуулалт, эдэлбэр газар, хил зааг, чиг үүргийн шилжилт, төсөв санхүү, хүний нөөцийн бэлтгэлийг хангахаар ингэж тусгасан байгаа юм. Тэгээд чиг үүргийн давхардал, хариуцлагын зааг ялгааг тодорхой болгох зорилгоор шилжилтийн үеийн зохицуулалтыг тусгасан байгаа.

Тухайлбал, улсын зэрэглэлтэй хотын зөвлөл, захирагч хуулийн дагуу сонгогдох хүртэл хугацаанд дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Засаг дарга нь Хотын зөвлөлийн Захирагчийн чиг үүргийг хэрэгжүүлэх энэ заалтыг хуулийн төсөлд тусгасан байгаа юм. Тэгэхээр ингэхээр энэ дээр ямар нэгэн давхардал гэдэг юм уу, хийдэл үүсэхгүй. Энэ үйл ажиллагаа нь таслахгүй явах боломж нөхцөл, өөрөөр хэлбэл хотын удирдлагын тогтолцоог үе шаттай бүрдүүлэх шат дараалсан алхмууд хийгдэнэ гэсэн үг.

С.Бямбацогт: Энхтүвшин гишүүн тодруулж асууя.

Д.Энхтүвшин: Үндсэн хуулийн 57.2 дээр болохоор хот тосгон, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын зарим чиг үүргийг шилжүүлэх байдлаар Улсын Их Хурал шийднэ гээд. Өөрөөр хэлбэл нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын зарим чиг үүргийг гэдэг нь шилжүүлээд, нийтдээ бараг 100 хувь шилжүүлж байгаа юм шиг харагдаад байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ нь өөрөө Үндсэн хуулийн зөрчил үүсэхгүй байгаа. Үндсэн хууль дээр болохоор зарим чиг үүргийг л гэж байгаа болохоос биш 99 хувийн ч юм уу, 99 хувь гэдэг чинь бараг ихэнх чиг үүргийг нь шилжүүлэх гээд байгаа. Тэгэхээр үүнтэй холбоотой зөрчил үүсэхгүй юү гэдэг үүднээс нь л асуугаад байна. Тэгэхээр практик дээр ямар зөрөөнүүд үүсэх юм. Тэгээд энэ ялгаанууд нь ямар чиг үүргийнх нь хэдэн хувь нь энэ хот руу шилжих гээд байгаа юм гэдэг ийм асуулт байгаад байгаа.

С.Бямбацогт: Амарсайхан сайд хариулъя.

С.Амарсайхан: Мэдээж Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хуулиар засаг төрийн бас төлөөллийн чиг үүргүүд, өөрөөр хэлбэл Засгийн газрын мөрийн хөтөлбөр, үйл ажиллагаа, мөн холбогдох хууль тогтоомжийг сурталчлах,

таниулах, иргэдэд төрийн үйлчилгээг хүргэх чиглэлийн ажлууд зохицуулагдаад явна. Үндсэндээ өдөр тутмын аж ахуйн болон хотын, хот нийтийн аж ахуйн ажил хотын захирагч руу шилжинэ гэсэн үг. Тэгэхээр энэ хуулиудаараа тухайн тухайн чиг үүргүүд нь зохицуулагдаад хэрэгжээд явна гэсэн үг. Ажлын хэсэг нэмэлт тайлбаруудаа өгчих.

С.Бямбацогт: Ажлын хэсэг хариулъя. 4 дүгээр микрофон.

Б.Батбямба: Энхтүвшин гишүүний асуултад нэмж хариулъя. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Батбямба байна. Үндсэн хуульд заасанчлан яг энэ чиг үүргийн шилжилттэй холбоотой зохицуулалтыг Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд тодорхой заагаад өгчихсөн байгаа. Өөрөөр хэлбэл тухайн засаг захиргааны нэгж дээр хийж байгаа ерөнхий чиг үүргүүд нь бол иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд байдаг. Энэ иргэдийн Төлөөлөгчдийн Хурлынхаа зарим чиг үүргийг нь нэгжийн хууль хуулийн 68 дугаар зүйлд заасны дагуу хотын зөвлөлд шилжүүлэх ёстой байж байгаа. Тэгэхээр энэ тохиолдолд бол зөвлөлийн чиг үүргийг иргэдийн Хурал хэрэгжүүлээд явахад бол ямар нэгэн давхардал, зөрчил үүсэхгүй болов уу гэсэн байр суурьтай байгаа ажлын хэсэг.

С.Бямбацогт: Энхтүвшин гишүүн тодруулж асууя. Хариулт хангалтгүй л байгаад байна гэнэ дээ.

Д.Энхтүвшин: Би нөгөө чиг үүрэг тавьж байгаад, уг нь ингээд ийм чиг үүргүүдийн хэдэн хувийг нь яг зарим гэдэг нь жишээлбэл хэдэн хувьд ороод байгаа юм. Хэдэн хувийг нь шилжүүлээд байгаа юм гэдэг л юм хүсээд байгаа юм. Эсвэл яах вэ, нөгөө талаас нь асуувал энэ дүүрэг дээр үлдэж байгаа Багануур дүүрэг, Налайх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга дээр нь яг ямар эрх үүргүүд нь үлдэх юм. Зэрэгцээд хот байх нь байна шүү дээ. Зөвлөл байх нь байна. Тэгээд иргэдийн Хурал, Дүүргийн иргэдийн Хурал, Дүүргийн Засаг дарга гэсэн ийм институцүүд ингээд байх нь байна. Тэгэхээр яг дүүргийн иргэдийн Хурал дээр нь ямар юм үлдэх гээд байгаа юм. Нөгөө талаас нь асуувал Засаг дарга дээр нь ямар эрх мэдэл үлдэх гээд байгаа юм гээд тэрийг асуугаад байгаа.

С.Бямбацогт: 4 дүгээр микрофон.

Б.Батбямба: Нэмж хариулъя. Яг тэдэн хувийг нь шилжүүлэх вэ гэдэг асуудал маань өөрөө тухайн дүүргийн орон нутгийн саналаар Засгийн газар дээр нэгтгээд, Монгол Улсын Их Хурлаас шийдвэрлэхээр хуулийн зохицуулалт байж байгаа. Одоо зөвлөл маань өөрөө хэрхэн яаж сонгох вэ гэдэг сонгуулийнх нь тогтолцоо нь хүртэл ер нь эрх зүйн хувьд бол бүрэн гүйцэд байхгүй байгаа. 2027 оны 01 сарын 01-ээс ажиллах ёстой. Энэ хугацаанд бас эрх зүйн хийдлийн асуудлыг бол бид нар хамтарч шийдвэрлэх шаардлагатай байгаа. Одоогоор зөвлөлийн чиг үүргийг нь иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь хэрэгжүүлээд явахад иргэдийн Төлөөлөгчийн Хурал нь уг нь зөвлөлдөө тодорхой чиг үүргээ шилжүүлэх ёстой байгаа юм. Энэ тохиолдолд яг өнөөдрийн ярьж байгаа кэйс дээр.

С.Бямбацогт: Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүн асуултаа асууя.

Д.Пүрэвдаваа: Өдрийн мэнд хүргэе. Энэ асуудал ингээд 2026 оны 06 сарын 01-ээс энэ хууль хэрэгжиж эхэлнэ гээд Их Хурал тогтоол баталчихсан санагдаад байх юм. Тэгээд өнөөдөр бид нар хэрэгжээд эхэлчихсэн хуулийг тодорхой хэсгийг нь үлдээгээд, тодорхой хэсгийг нь цуцалж байна гэж ойлголоо. Энэ дээр хууль зүйн хувьд тайлбар өгөөч Манай тамгын газрынхан. 1 дүгээрт.

2 дугаарт Багануур, Налайх дүүрэг маань хот болж байна. Дэмжиж байна. Ер нь Монгол Улсын нийт хүн амын 70 орчим хувь нь хот, суурин газар амьдарч байгаа. Зайлшгүй шинэчлэл, хууль зүйн хувьд шинэчлэл хийх нь бол зайлшгүй хэрэгцээтэй байгаа. Энэ дээр бол санал нийлж байгаа. Хүн амын тал орчим хувь нь амьдарч байгаа Улаанбаатар хот өмнөх төслөөр бол Улаанбаатар хот чинь 10 гаруй хот болж хуваагдах ёстой байсан. Энэ хэзээ хэрэгжих вэ. Жишээгээр Баянзүрх, Сонгинохайрхан гээд 2 том дүүрэг маань яг бараг хүн амын 10 хувь нь байдаг. 300, 400 мянган иргэнтэй болчихсон. Энэ дүүргүүдийг яаж төлөвлөж байгаа вэ, яаж тооцсон бэ. Ер нь ирээдүйд хот, тосгон болох асуудал нь яаж энэ холбогдох яамд ер нь төлөвлөсөн зүйлээ ингээд нийтэд ойлгомжтойгоор нэг илэрхийлээч гэж асуух байна. Тэгээд тодруулж асууя.

С.Бямбацогт: Тамгын газар бэлдэж байгаарай. Хууль санаачлагч хариулъя. Дараа нь Тамгын газар энэ хууль хэрэгжээд эхэлчихсэн байхад хүчингүй болгох гээд байгаа чинь ямар асуудал вэ гэж байна. Дээрээс нь бас Үндсэн хуулийн 57.2-т зарим чиг үүрэг гэж заасан. Зарим нь юу байх юм сая бас Энхтүвшин гишүүн асуугаад байна. Ажлын хэсэг хариулъя. Хэн хариулах юм. Амарсайхан сайд, дараа нь Тамгын газар.

С.Амарсайхан: Энхтүвшин гишүүний асуугаад байгаа дээр би тодруулаад хариулчихъя гэж бодож байна. Зарим чиг үүрэг, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хуульд заасан зарим чиг үүрэг захирагч руу шилжинэ гэдэг бол өөрөөр хэлбэл энэ сум, дүүргийн Засаг даргын хэрэгжүүлдэг өдөр тутмын энэ хотын эдэлбэр газар дотор өөрөөр хэлэх юм бол хотын өдөр тутмын удирдлага, үйлчилгээ, хөгжлийн асуудалд, аж ахуйн шинж чанартай дэд бүтцийн асуудлууд гээд зарим эрх, үүргүүд шилжих юм. Тухайлах юм бол Налайх хот байгуулагдлаа гэхэд дүүргийн Засаг даргын зарим чиг үүрэг Налайх хотын захирагчид шилжинэ гэсэн үг. Тэгэхдээ энэ өөрөө дүүрэг байхгүй болно ч гэдэг юм уу, бүх эрх хотын захирагчид очно гэсэн үг биш. Яагаад гэвэл, би түрүүн хэлсэн. Өнөөдөр яг нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч гээд нэг талаасаа хотын захирагчийн эдийн засаг, аж ахуйн чиг үүргийг хэрэгжүүлдэг, нөгөө талаасаа Засгийн газар төрийн төлөөллийн үүрэг чиглэлээ хэрэгжүүлдэг учраас энэ 2 бас давхар хэрэгжээд явах боломж нөхцөл нь бүрдэнэ гэж байгаа юм.

Пүрэвдаваа гишүүний асуултад хариулахад яагаад бусад хотууд үйл ажиллагааг нь эхлүүлэх боломжгүй байна гэж. Өмнө нь бид Их Хурлаар 2024 оны 06 дугаар сард батлахдаа улсын зэрэглэлтэй 6 хот, орон нутгийн зэрэглэлтэй 43 хот, мөн дагуул 4 хотыг байгуулна гэсэн. Ингээд Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ажлын хэсэг гарч, орон нутгийн удирдлагуудтай уулзалт яриа, санал солилцож, тэгээд яг энэ цаг үед бол ихэнх аймаг, орон нутаг ялангуяа аймаг орон нутагт энэ хэрэгжих боломж нөхцөл нь бүрдээгүй байна. Яагаад гэх юм аймгийн статус мөн хилийн зааг, ялгаа, газар нутгийн эдэлбэр газрын хэмжээ, мөн аймаг, сумын статустай холбоотой олон асуудлууд байгаа учраас гээд зарим орон нутгууд дээр ийм саналын зөрөлдөөнтэй асуудлууд гарч байгаа нэг талаараа. Нөгөө

талаараа бас эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулаад 1 зэрэг олон хот тосгоныг байгуулах нь өөрөө олон давхардсан нөхцөл байдлыг бий болгох гэж байгаа. Нөгөө талаараа олон орон тоо нэмэгдэх ийм нөхцөл байдал үүсэж байна гэж. Өөрөөр хэлэх юм 2000 гаруй орон тоо үүсэхээр байгаа учраас эхний ээлжид эдийн засгийн талаасаа чиг үүргийн бөгөөд зохицуулалтын, орон нутгийн болон зохион байгуулалттай холбоотой асуудлуудаас шалтгаалаад эхний ээлжид дэд бүтэц, хүн ам зүй, ажиллах хүч, эдийн засгийн нөөц бололцоо гээд Улаанбаатар хотод хамгийн ойрхон, хамгийн богино хугацаанд, бас хэрэгжих боломж нөхцөлөөр нь тооцоод Налайх, Багануурыг оруулах нь зүйтэй гэдэг асуудал Засгийн газар болон ажлын хэсэг дээр яригдсан учраас ингэж оруулж ирж байгаа юм. Тэгээд энэ 2 хот .../минут дуусав/

С.Бямбацогт: Тамгын газар хариулъя.

Б.Хатантуул: Пүрэвдаваа гишүүний асуултад хариулъя. Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 05 сарын 26-ны өдөр Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг өргөн мэдүүлсэн. Энэ нь өөрөө Хот, тосгоны эрх зүйн байдлын хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль маань өөрөө 06 сарын 01-ээс хэрэгжих байсан. Хэрэгжих хугацаанаас өмнө өргөн мэдүүлсэн байгаа учраас Хууль тогтоомжийн тухай хуулийн 41.10-д заасан хуулийг дагаж мөрдөж эхэлсэн өдрөөс хойш тухайн хууль болон түүний зүйл, хэсэг, заалт, дэд заалтыг дагаж мөрдөх хугацаанд өөрчлөлт оруулах хуулийн төсөл өргөн мэдүүлэхгүй гэсэн энэ зохицуулалттай зөрчилдөхгүй байгаа.

С.Бямбацогт: Зөрчилдөхгүй байгаа юм байна. Тийм үү. Хэрэгжээд эхэлчихсэн хуулийг хүчингүй болгох асуудал тэгээд хуультай зөрчилддөггүй юм байна. Тийм ээ. Пүрэвдаваа гишүүн тодруулъя.

Д.Пүрэвдаваа: 6 сарын 1. Өнөөдөр чинь 06 сарын 05 шүү дээ. Бид нар хэлэлцэх эсэхээ ярьж байгаа биз дээ дарга аа. Тэгээд Улсын Их Хурал баталчихсан. 6 сарын 1-ээс хэрэгжинэ гээд. Тэгэхдээ энэ чинь бүр 1 жил сунгаад шүү дээ. Тэгээд Улсын Их Хурал маань өөрөө ингээд нөгөө нэр хүнд нь унах ийм эрсдэл байгаа учраас дараа дараа ийм нөхцөл байдал үүсэхгүйн тулд манай Тамгын газар энэ дээр маш сайн тайлбар, ойлгомжтой нөхцөл байдлыг бий болгох ёстой шүү. Тэгэхгүй 06 сарын 01-ээс уг нь бол хууль хэрэгжээд, энэ чинь мөрдөгдөөд явж байхад 5-нд бид нар хэлэлцэх үү, үгүй юу гэдгийг ярьж байна гэхээр нэг л жоохон тодорхойгүй л тайлбар өгчихлөө гэж ойлгож байна. Хариулт авмаар байна. Ялангуяа Энхманлай даргаас. Нэгэнт Багануур, Налайх 2 орж ирж байгаа бол энэ хотын том .../минут дуусав/

С.Бямбацогт: Энэ зүгээр жижиг дүүрэг ороод ирлээ. Том дүүргүүдээ хэзээ хот болгох юм бэ гэж асууж байна. Гүйцээгээд.

А.Энхманлай: Пүрэвдаваа гишүүний асуултад хариулъя. Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын дарга Энхманлай. Улсын Их Хурлын 2024 оны 72 дугаар тогтоолоор улсын хэмжээнд 53 хот байгуулагдахаар шийдвэр гарсан. Энэ шийдвэрийг хэрэгжүүлэх үүднээс энэ тогтоолд бас Засгийн газарт тодорхой үүрэг даалгавар өгсөн. Энд бол хотуудын эдэлбэр газруудыг боловсруулж, Улсын Их Хурлаар батлуулах ийм үүрэг өгсөн. Энэ ажлын хүрээнд

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын тушаалаар ажлын хэсэг байгуулагдаж, холбогдох мэргэжлийн байгууллагууд мөн орон нутгийн удирдлагуудыг оролцуулсан ажлын хэсэг ажилласан байгаа. Энэ ажлын хэсэг 2, 3 удаа хуралдаж шийдвэрүүдийг гаргасан. Ингээд бол орон нутгийн зэрэглэлтэй аймгийн төвүүдийн нийтдээ бол 21 аймаг дээр 33 хот.../минут дуусав/

С.Бямбацогт: Хариултаа гүйцээчихье.

А.Энхманлай: 33 хотыг бол эдэлбэр газрыг тогтоохоор ийм шийдвэр байгаа. Үүнтэй холбогдуулаад бол аймгийн хэмжээ дэх хотуудын эдэлбэр газрыг тогтоох саналуудыг бол аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас бол бүрэн ирүүлсэн. Харин нийслэл Улаанбаатар хотын хэмжээнд орон нутгийн зэрэглэлтэй 14 хот байгуулахаар Улсын Их Хурлын тогтоол батлагдсан. Энэ ажлыг хийхэд нийслэл Улаанбаатар хотын хөгжлийн 2040 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө батлагдсаны хүрээнд хийнэ гэдгээр бас энэ ажил удаашралтай байгаа. Гэсэн хэдий ч нийслэл дээр бас ажлын хэсэг ажиллаж, нийслэлийн Иргэдийн Хурал дээр эдгээр 14 хотуудын эдэлбэр газрыг тогтоох асуудал хэлэлцэгдэж байгаад тодорхойгүй шалтгаанаар бас одоогоор шийдвэр гараагүй ингээд хойшлогдсон. Бидэнд энэ эдэлбэр газрыг тогтоох санал бол эцэслэж ирээгүй байна. Тийм учраас нийслэлийн хэмжээнд хотуудын эдэлбэр газрыг тогтоогоогүй. Харин энэ хуулийн өөрчлөлтөөр .../минут дуусав/

С.Бямбацогт: Минутдаа багтаагаад хариулж сурна шүү. Одоо дахиж сунгах боломж алга.

Зочин танилцуулъя. Завхан аймгийн Сантмаргаз сумын ерөнхий боловсролын сургуулийн 1993 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэндээ Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Улсын Их Хурлын гишүүн Пүрэвжавын Сайнзориг асуултаа асууя.

П.Сайнзориг: Баярлалаа. Энэ хуулийг хэрэгжүүлэх, дагаж гарсан тогтоолыг нь хэрэгжүүлэх асуудал энэ ойлголтын зөрүүнээс болоод ингээд л яваад байгаа юм. Энэ орж ирж байгаа хууль уг нь бас жоохон ухралтын шинжтэй л болчихлоо. Бид хэд энэ Үндсэн хуульдаа аваачаад улсын зэрэглэлтэй, орон нутгийн зэрэглэлтэй гээд ийм шал буруу нэр томьёо оруулчихсан. Улсын зэрэглэлтэй гэдгийн цаана улсаасаа салж, тусгаарлах гээд байгаа юм шиг агуулга яваад байгаа юм шиг ийм утгагүй юм орчихсон байхгүй юу. Бусад улс орнуудад бол нийслэл хот тэгээд special буюу тусгай статустай хот, бусад гээд ингээд явчихдаг юм байна лээ. Тэгээд манайд аваачаад улсын зэрэглэлтэй, орон нутгийн зэрэглэлтэй гээд ойлгомжгүй байдалд чихэж оруулсан. 1 дүгээрт. Үүнээс болж байгаа юм.

2 дугаарт бид хэд явж ирсэн энэ уламжлалаасаа ерөөсөө хотын удирдлага, төр засгийн удирдлага гэдгээ ерөөсөө ойлгохгүй байна. Дандаа хольж хутгадаг. Хот гэдэг бол тэр суурин газрынхаа амьдралын орчинд хот нийтийн аж ахуй энэ зүйлүүдээ хэрэгжүүлээд явах иргэдээсээ тэр захирагчийг сонгодог байх ёстой асуудал байхгүй юу. Засаг дарга бол төрийн төлөөлөл. Тэгээд энэ зүйлүүдийг хольж хутгасаар байгаад сүүлдээ ч мэдэхгүй ингээд их л сонин байдал руу орж байна. Одоо тэгээд Хэрэг эрхлэх газрын даргын чиг үүргийн асуудалд Хууль зүйн яам

ингээд хариулаад, бөөнөөрөө орж ирээд суучихсан л байх юм. Ямар ч учиртай юм. Энэ нэгдсэн бодлого нь тэгээд Хэрэг эрхлэх газрын дарга зангидаж чадахаа больчихсон юм уу. Мэдэхгүй байна. Гайхаад байх юм.

Тэгэхээр энэ том ухралт боллоо. Иргэд захирагчаа сонгодог байдлаас бид хэд ухарч байгаа юм байна. Налайх, Багануурыг бол хот болгон хөгжүүлэхийг бүрэн дэмжиж байгаа. Тэгэхдээ зөвхөн энэ 2-ыг биш байхгүй юу. Их л сонин зүйл рүү орчихлоо. Тэгээд энэ танилцуулга дээрээ хотын хүн амыг 30 мянгаас доошгүй хүн амтай байх шаардлага энэ тэрийг хангахгүй гээд дүгнээд биччихэж. Тийм юм байхгүй шүү дээ. Энэ хуулийн төслийн үзэл баримтлал танилцуулгыг бичиж байгаа хүмүүст би хэлчихье. 30 мянган хүнтэй байх, эсвэл 30 мянган доошгүй хүн амтай байхаар төлөвлөсөн гэж байгаа шүү. Та нар яагаад ингэж хууль зөрчиж Улсын Их Хурлыг ингэж төөрөгдүүлж хуулийн танилцуулга бичээд байгаа юм. Энэ хуулийг ерөөсөө бүтэн уншиж ойлгоогүй байгаа байхгүй юу. Тэрнээс биш 30 мянган хүн амьдрахаар хот болчихдог тийм зүйл байхгүй шүү дээ. 30 мянгаас доошгүй хүн амьдрах тэр төлөвлөлтийг хийгээд, үүний төлөө явах ёстой байхгүй юу. Хэрэвзээ энэ сумуудаараа үлдэх юм бол энэ дээр чинь хотын хот төлөвлөгч ажиллахгүй. Тэгээд бид хэд цааш .../минут дуусав/

С.Бямбацогт: Хариулъя. Амарсайхан сайд хариулъя.

С.Амарсайхан: Сайнзориг гишүүний хэлж байгаа асуудалтай ерөнхийдөө санал нэг байгаа. Яагаад Хууль зүйн яам энэ дээр оруулж ирж байна вэ гэхээр Ерөнхий сайдын захирамжаар энэ ажлын хэсгийг ахлах асуудлыг Хууль зүйн сайдад даалгасан учраас Хууль зүйн яамнаас оруулж ирж байгаа. Уг нь бол Хэрэг эрхлэх газрын эрхлэх асуудлын хүрээний асуудал. Гэхдээ Засгийн газар дээр яриад, энэ ажлын хэсгийг ахлах нь зүйтэй гэж шийдвэрлэсэн. 1 дүгээрт.

2 дугаарт уг нь бас санал 1 байгаа. Энэ хууль хэрэгжээд явах, ялангуяа энэ нийслэл хэмээх 1 төвтэй, түгжрэл бөглөрөл, агаарын бохирдол гээд эдийн засаг, нийгмийн нэг төв болсон төвлөрлөөс олон төвт суурьшмал газрыг бий болгох хот, тосгоны хөгжлийг хурдасгах зорилгоор 2024 онд энэ хууль батлагдсан. Харамсалтай нь зарим аймаг, орон нутгуудад эдэлбэр газрын асуудлууд, хилийн цэсийн маргаан, газар олголт, дээрээс нь эдгээр асуудлыг шийдвэрлэхэд хүндрэлтэй нөхцөл байдлууд бий болсон байна гэдэг шалтгаанаар энэ хуулийг хэрэгжүүлэх боломжгүй байна гэдэг асуудал Хэрэг эрхлэх газар дээр ажлын хэсэг дээр яригдсан байна. Тийм учраас хамгийн хэрэгжих боломжтой 2 газрыг цааш нь хот болгож хөгжүүлэх ажлыг үргэлжлүүлж явуулъя. Энэ хүрээнд судалгаа шинжилгээний ажлуудаа эрчимжүүлж, дараагийн хот байгуулах бэлтгэл ажлыг алдаа оноог мөн асуудал шийдлийн гарцыг гаргаж, бүсчилсэн хөгжлийн бодлогынхоо хүрээнд аймаг, орон нутгуудыг хот болгох ажлуудаа урагшлуулах ёстой гэж үзсэн. Тэгээд энэ өөрөө бас ялгаж салгаж, ойлгож ядах асуудал ерөөсөө биш. Ялангуяа хот нийтийн аж ахуй, хот тохижилт, тэгээд аж ахуй, дэд бүтцийн асуудлууд энэ хот байгуулагдсанаар өөрөө бие дааж шийдэх боломж нь бүрдэх юм байгаа юм. Хот төлөвлөлтөө ч хийх юм байгаа юм. Өнөөдөр дүүргүүд нийслэлээс хамааралтай, өөрсдөө хот төлөвлөлтөө хийж чаддаггүй, дүүргийн төлөвлөлтөө ч хийдэггүй, аймаг орон нутаг, сум ч мөн ялгаагүй ийм байгаад байгаа юм. Тийм учраас энэ хөгжлийн асуудлууд хойшилж, удааширч, гацаж байгаа зүйлүүд байгаа юм. Тэгэхээр тухайн оршин суугаа газрынхаа төлөвлөлт, хүндрэл, бэрхшээлийг өөрсдөө судалж, шийддэг, өөрсдөө тэр төлөвлөсөн ажлуудаа урагшлуулдаг байх

эдийн засаг, нийгмийн бие даасан байдлаа бий болгоход энэ хуулийн ач холбогдол уг нь оршиж байгаа юм. Тэгээд ямар ч байсан энэ 2 хотыг явуулаад цааш нь бол энэ хот байгуулах ажлуудаа ер нь эрчимтэй явуулахгүйгээр бид тулгамдсан асуудлуудаа шийдвэрлэх боломжгүй гэж үзэж байгаа учраас дараагийн шатанд энэ хуулийг .../минут дуусав/

С.Бямбацогт: Сайнзориг гишүүн тодруулж асууя.

П.Сайнзориг: Хууль зүй, дотоод хэргийн сайдад бас баярлалаа. Аль болохоор хэрэгжүүлчихье, зөв ойлгуулчихъя гээд явж байгаа юм байна. Яах вэ одоо тэгээд Налайх, Багануураараа жишээ болгоод нэг үзүүлээдхээч гэж би хүсэж байгаа юм. Удирдлагууд нь ирээд суучихсан байна. Энэ дээр сайд аа, ажлын хэсэг гаргаад, ядаж энэ Хүннү хотыг дагуул хотоор нь үлдээмээр байх юм. Энэ Хүннү хотын чинь төлөвлөлт шал өөр концепцоор явж байгаа. Газар олголт нь сонгон шалгаруулалтаар явж байгаа. Бие даасан хууль гарчихсан байхгүй юу.

Дээрээс нь энэ Улаанбаатар хотын төвлөрлийг дагаад Налайх, Багануур, Хүннү хотоос гадна Эмээлт аж үйлдвэрийн паркийг дагасан бас хот байгаа. Аргалант хот. Тэгээд энэ өөрөө ингээд Эмээлт аж үйлдвэрийн паркийг бас ингээд түлхэц болоод бас явж байгаа шүү дээ. Ийм зүйлүүдээсээ ингээд бид ухарч байна. Тэгээд энэ өөрөө эргээд засаг захиргааны нэгж буюу төрийн удирдлага, хотын аж ахуйн удирдлага 2-ыг ялгаж салгаж бид хэд ойлгохгүй бол нээрээ тун харамсалтай юм болж байна даа. Тэгээд энэнээсээ ингээд иргэдийн аятай тухтай байх, бизнес хөгжих, тэнд хүний .../минут дуусав/

С.Бямбацогт: Үг хэлчихлээ. Батын Батбаатар гишүүн алга байна. Одонгийн Цогтгэрэл гишүүн асуулт асууя.

О.Цогтгэрэл: Хотын хууль орж ирж байна. Энэ хууль батлагдаад, хуулийг хэрхэн яаж тооцоо судалгаагүйгээр яаран сандран батлуулдаг, баталсан хуулийг хэрэгжүүлэхгүй гээд сууж болдог, сунгаж болдог, сүүлд нь хэрэгжүүлэхгүй гээд ингээд байж болдог нэг л ийм завхарсан жишээ одоо явж байна. Тухайн үед ч гэсэн энэ яриа хөөрөө гарч л байсан. Энэ хууль яаран сандран, үндэслэлгүй том хэмжээний асуудлыг ингээд хэдэн хот ч билээ Улаанбаатарыг хуваана гээд л асуудал гараад л явж байсан.

Тэгээд сүүлийн үед энэ хот дээр болж байгаа үйл явцыг харахад нутгийн өөрөө удирдах ёс, орон нутгийн сонгууль, олон олон зүйл ерөөсөө хөл толгой гэдэг юм байхгүй ийм л юм болж хувирч байна. Үндсэн хуулийн үзэл санаа ч байхгүй. Хотын даргыг иргэд нь сонгодог, иргэдийн Хурлаараа дамждаг энэ тэр үзэл санаа аль нь ч байхгүй ийм л завхарсан л юм руу орчихлоо. Тэгээд энэ хуулийг Ерөнхий сайд танилцуулбал 1 юм асууя гэж бодож байсан юм. Одоо тэр том том зүйл ч бүр үзэл санаа ч бүр завхарсан юм.

Өнгөрсөн Засгийн газрын хурлаар билүү хажууд байгаа Улаанбаатар хотын хуучин барилгыг засаг захиргааны хуучин барилгыг Хүүхдийн ордон болгоно гээд нэг юм шийдвэр танилцуулж байна лээ. Бас энэ хоттой л холбоотой асуудал юм. Яг энэ төрийн ордны гэж хэлдэг энэ байран дотор парламент, Засгийн газар, Ерөнхийлөгч, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл ингээд бүгдээрээ байдаг. Тэгээд энийгээ шийдэх гэхээрээ хэдэн их наядаар мөнгө ярьдаг. Богд уулын урд талд

Кувейтийн аманд ч билүү хэдэн их наядаар төр захиргааны ордон барина. Хот шилжинэ, Засгийн газар шилжинэ гээд баахан юм. Одоо яг энэ асуудал гэхэд л бид нар асуудлыг хялбархан бөгөөд бас эвтэйхнээр шийдэж болох гарц гаргалгааг энэ Засгийн газар бас эрэлхийлээч. Тэр тусмаа хажууд байгаа энэ хотын захиргааны байр гэдгийг Хүүхдийн ордон болгоно гэж. Энэ зориулалт гэж юу ч байхгүй. Зогсоол талбай ч байхгүй зүйл дээр ийм юм ярихын оронд жишээ нь энэ Засгийн газрыгаа энэ Улаанбаатар хотын хуучин захиргаа руу, Засгийн газар биш ордонд байгаа Ерөнхий сайдын бүтэц бүрэлдэхүүн тийшийгээ шилжих боломж бололцоо байдаг уу, судалж үзсэн үү. Ингээд асуудлыг бага мөнгөөр шийдвэрлэх боломж бололцоог эрэлхийлбэл яасан юм бэ гэдэг саналыг ярих гэж байсан. Тэгээд энэ хуулийн төслийн танилцуулгыг Хууль зүйн сайд хийж байгаа юм байна. Хууль зүйн сайдаас бас асууя. Ийм зүйл яригдсан уу. Жишээ нь ингээд ийм хүүхдийн нэрээр, хүүхдэд л ээлтэй гэвэл аль эсвэл нэг өөр зүйлийн нэрээр ингэж нэг ийм дур зоргыг нь ямар ч нэг попрол гэдэг юм уу даа. Хотын захиргааны байранд хүүхдийг нь тоглоомын талбай оруулна ч гэнэ үү. Энийгээ саяын тэр Засгийн газрын ордонтой холбоотой харилцааг ингэж шийдвэрлэх гарц гаргалгаа боломж бололцоо байна уу. Та нарт ярилцаж хэлэлцсэн зүйл байна уу. Судалж үзсэн зүйл байна уу. Тийм юм байхгүй бол судалж үзэх, энэ дээр ийм шийдэл гарц байвал яасан юм бэ гэдгийг энэ дээр .../минут дуусав/

С.Бямбацогт: Амарсайхан сайд хариулъя.

С.Амарсайхан: Цогтгэрэл гишүүнтэй би 1 зүйл дээр санал 1 байгаа. Ер нь төр гаргасан бодлого шийдвэртэй тууштай байх ёстой. Тэр бодлого шийдвэр өөрөө нарийн судалгаа тооцоотой гарч байх ёстой. Тэгээд гарсан бол хэрэгждэг байх ёстой. Сэтгэлийн хөөрлөөр асуудалд хандаад өнөөдөр баталдаг, маргааш цуцалдаг, тэгээд хуулийн давхардлууд бий болдог. Эргээд хууль нь гууль болдог ийм асуудлууд хаа сайгүй бий. Тэр өнөөдөр манай улсын 930 гаруй хууль, 2750 гаруй дүрэм журам, тогтоолоос бүрдсэн 3500 гаруй хууль тогтоомжууд хэрэгжиж байгаа. Тэгээд энэ хуулийн давхардал хийдлүүд бий болсон. Тэгээд тэрний 1 тод жишээ бол өнөөдөр энэ хууль. Уг нь хэрэгжүүлээд явах ёстой. Гэхдээ энэ янз янзын шалтгаанууд аймаг, орон нутаг санал зөрөлдөх, улс төрийн байр суурь өөр байх, дээрээс нь болохгүй гэдэг талаас асуудал хардаг, болгоно гээд хийсэн шийдвэрээ цуцалдаг энэ буруу жишгийн нэг хэлбэр. Тэгээд ийм зүйл олон битгий давтагдаасай гэж хүсэж байгаа нэг талаар. Нөгөө талаараа ажлын хэсгийн ахлагчийн хувьд Хууль зүйн сайдын хувьд би 1 ч гэсэн хууль хэрэгждэг байгаасай гэж үзсэн учраас болохгүйг нь хойш нь тавина, болохгүй гэж байгаа бол тэрийг нь хойш нь тавиад, болно гэж байгаагаа урагшлуулъя гэж өнөөдөр энэ жишиг 1 ч гэсэн, 2 ч гэсэн хотыг явуулъя гэж. Энэ өөрөө хүн амын аюулгүй байдал, тэгээд эрүүл амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэхэд хамгийн чухал асуудал. Улсын нийслэл Улаанбаатар гэдэг ганцхан хоттой. Бусад нь Дархан, Эрдэнэт гээд орон нутгийн зэрэглэлтэй хот. Тэгээд хот, аймаг гээд дунд нь нэршил нь ч хүртэл асуудалтай. Энийгээ цэгцлэх ёстой ийм зүйлүүд бий. Тэгээд ер нь манай хууль зүйн бодлого алдагдсан гэдгийг бас бүгдээрээ ярилцах, хүлээн зөвшөөрөх ёстой. Энийг нэгдсэн маягаар цааш нь явуулахад анхаарах .../минут дуусав/

С.Бямбацогт: Амарсайхан сайд. Минутдаа багтааж хариулна шүү.

С.Амарсайхан: 2 дугаарт байр савтай асуудал. Ерөнхий сайд бас Засгийн газар дээр өөрөө санаачилга гаргаж ярьж байгаа. Ер нь Засгийн газрын болон яам,

Тамгын газруудын зардлыг багасгах, хэмнэлт хийх, үе шаттай ажлуудыг зохион байгуулж байгаа. Жишээ нь, төрийн өмчийн өмчийн аж ахуйн нэгжүүд өндөр түрээстэйгээр байр түрээсэлдэг, ихээхэн зардал гаргадаг асуудлыг цэгцэлж, төрийн өмчит барилгуудад байр саванд оруулах ажлууд эхнээсээ хийгдээд эхэлсэн байгаа. Цаашдаа төрийн өмчит аж ахуйн нэгжүүд байр түрээслэхгүй гэдэг. 1 дүгээрт.

2 дугаарт Засгийн газрын яам, тамга, агентлагийн газруудыг 1 дор байршуулах. Ингэхдээ хөрөнгө мөнгө, зардал хэмнээд, төсөвт өндөр ачаалал үүсгэхгүй, төсвийн зардлыг хэмнэх ийм судалгаа тооцоонуудыг Ерөнхий сайд өөрөө үүрэг даалгавар өгөөд, холбогдох байгууллагууд судлаад явж байгаа. Тэгээд ойрын хугацаанд бас энэ шийдлүүдээ танилцуулах байх.

С.Бямбацогт: Цэвэгдоржийн Туваан гишүүн асуултаа асууя.

Ц.Туваан: Тэгээд л хууль хэрэгжихгүй байна л гэдгийг давтаж хэлээд яах вэ. Бодит байдлыг ингээд харагдаж байна. Энэ Үндсэн хууль дээр байгаа заалтаа Налайх, Багануур гээд ярьж байгаа нь яаж, ямаршуу байдлаар тойрч хууль зөрчихгүй, Үндсэн хууль зөрчихгүй шийдэж байгаа вэ гэдэг дээр тодруулга авчихъя. Үндсэн хуульд аймаг, нийслэл, сум дүүргээс бүрдэнэ гээд заачихсан байгаа. Тэгэхээр энэ дээр хариулт авъя.

2 дугаарт энэ улсын зэрэглэлтэй хот, тэгээд энэ дээр нөгөө Дархан, Эрдэнэт чинь хасаж байна. Энэ ямар учиртай юм. Миний бодоход бол Дархан Эрдэнэтээс эхэлчихвэл бүр болохоор л санагдаад байх юм. Тэгээд энэ дээр Дархан, Эрдэнэт биш, тэрийг хасаж байгаад, Налайх, Багануур гээд явж байгаа нь ямар шалгуураар, ямар байдлаар энэ асуудлыг шийдчихэв гээд. Тэгээд одоо Налайх, Багануур дээр хэрэгжүүлж үзэж байгаад ингээд шийдье гээд одоо туршилт явуулах гэж байгаа юм уу. Ер нь яах нь вэ гэж харах гэж байгаа юм уу. Тэгэхээр саяхан Улсын Их Хурлын гишүүн Ганбатын Очирбат бас Налайхын иргэдтэй уулзсан чинь энэ хуулиудаа маш их хүлээлттэй байгаа юм байна лээ. Налайх, Багануурынхан дэмжиж байгаа юм байна лээ. Тэгсэн нөгөө Багахангай нь бас дагуул хот гээд явж байгаа бид нарыг бас яагаад ингээд орхичхов. Бид нар адилхан л 1 алслагдсан дүүрэг гээд ийм асуудал ярьж байна гээд надад бас үг дайж байна лээ. Тэгэхээр энэ дээр хэзээнээс хэрэгжих вэ, яах вэ гэдэг дээр тойм хариулт өгчхөөч.

Монгол улсад бас 10 гаруй тосгод байгаа. Тосгоны захирагчийн албатай ингээд ажиллаж байгаа. 1 сумын баг гээд ингээд явж байгаа. Тэгсэн чинь нөгөө сумаасаа том, сумаасаа олон хүн амтай болчихсон. Тэгээд тэр дээр нөгөө Захирагчийн ажлын албанд нь төрийн захиргаа төрийн чиг үүрэг хэрэгжүүлж байгаа албан тушаалтнууд нь бол байхгүй. Жишээлбэл Сэлэнгэ аймгийн Шаамар сумын Дулаан хаан тосгон дээр гэхэд татварын асуудал, газрын асуудал, малын эрүүл мэндийн асуудлаа шийдэх газар байхгүй. Ингээд сум руу оччихдог. Тэгээд суман дээр очихоор нөгөө тосгоны иргэд нь дургүй. Тэгээд асуудлаа шийдүүлэх гэж 1 шат дамжлага нэмэгдчихсэн ийм хүндрэлүүд үүсэж байгаа юм. Тэгэхээр энэ Сэлэнгэ аймгийн Рашаант, Хэрх, Түнхэл, Номгон, Бугант, Дулаан хаан энэ тосгод дээр яг энэ асуудал адилхан байгаад байна л даа. Тэгэхээр энэ хуулийн хүчингүй болгож байгаа заалтуудаасаа бусад хууль нь хэрэгжээд цаашаа явж байж болох уу. Энэ дээр нэг ийм албан хариулт авчихмаар байна. Тэгээд дараа нь тодруулъя.

С.Бямбацогт: Амарсайхан сайд хариулъя.

С.Амарсайхан: Туваан гишүүний асуусан энэ Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуульд яг нөгөө эрх, үүрэг шилжилтийг Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн нийцүүлж байна вэ гээд. Тэгээд Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль, тэр дундаа Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу чиг үүргээ шилжүүлэх юм байгаа юм. Тэгэхээр энэ дээр ямар нэгэн тийм зөрчил гарахгүй 1 дүгээрт.

2 дугаарт энэ хот байгуулах тухай хууль өөрөө бас зарим чиг үүрэг яаж хэрэгжих вэ, ямар эрх, үүрэг нээгдэж байгаа вэ гэдэг дээр бас тодорхой заагаад өгчихсөн байгаад байгаа юм.

2 дугаарт яагаад энэ Дархан, Эрдэнэт, Орхон, бусад хотууд хасагдчихав гээд. Яах вэ, түрүүн би хэлсэн. Ер нь энэ хууль явах ёстой гэж. Гэхдээ энэ аймаг, орон нутаг, засаг захиргаа нэгжүүдийн санал зөрөлдөөнтэй байдал, ялангуяа тэндээс сонгогдсон зарим орон нутгийн удирдлагууд, Улсын Их Хурлын гишүүдийн байр суурь бас хилийн цэцийн маргаантай асуудлууд, нутаг дэвсгэрийн нэгжийн хил, эдэлбэр газартай холбоотой асуудлуудыг цэгцлэхэд бас цаг хугацаа шаардлагатай байна гэж өөрсдөө саналуудаа гаргаж байгаа учраас энийг шууд хүчээр хийгээд явах боломж байхгүй байна. Энэ Налайх, Багануур хот бол өөрсдөө боломжтой гэж үзэж байгаа учраас туршилт гэхээсээ түрүүлээд ер нь хэрэгжүүлээд бид нэг жишиг болгоё гэж байгаа юм. Бүрэн боломж байна гэж харж байгаа юм. Ингээд дараа дараагийн хотууд явах ёстой.

3 дугаарт энэ Хархорин болон Хүннү хотууд өөрсдийн эрх зүйн орчин бүрдсэн хотын хуультай. Энэ хуулиудаараа өөрсдөө үйл ажиллагаагаа цааш нь бодлого төлөвлөгөөгөө хэрэгжүүлээд явах боломж бүрэн дүүрэн байна гэж үзэж байгаа. Мэдээж хот байгуулагдахаар эдэлбэр газрын асуудал яригдаж байгаа. Эдэлбэр газар бол засаг захиргааны нэгж, нутаг дэвсгэр дээр хил хязгаарт багтаж тодорхойлогдох ёстой учраас ямар нэгэн асуудал энэ 2 хот дээр байхгүй гэж үзэж байгаа.

Багахангай дүүрэг өөрөө дагуул хот болно гэдэг бол Улаанбаатар хотын эрх мэдлийн хүрээнд, өөрөөр хэлбэл нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хотын даргын оруулснаар шийдвэрлээд явах бүрэн боломжтой. Энэ ажлууд бол орон нутагт хийгдэхэд ямар нэгэн гацах, саатах асуудал байхгүй. Хамгийн сүүлд энэ байгаа тосгон, тосгоны захирагчийн эрх, үүргийг бүрэн хэрэгжүүлэх, ялангуяа төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэх, тасралтгүй хүргэхтэй холбоотой зохион байгуулалтын асуудлууд байгаа. Энэ зохион байгуулалтыг орон нутаг, аймаг тухайн хот, тосгоны төсөвт суулгаад, шийдвэрлээд явах боломж нь нээлттэй байгаа учраас энийг ирэх оны төсвүүд дээрээ суулгах .../минут дуусав/

С.Бямбацогт: Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Оюунсайханы Алтангэрэлийн урилгаар Өвөрхангай аймгийн Уянга сумын Засаг даргын Тамгын газрын албан хаагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Төрийн ордонтой танилцаж байгаа Өвөрхангай аймгийнхаа иргэддээ Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Манай Уянгынхан чинь 2 удаа ороод ирж байгаа юм уу. Их мундаг юм өдөрт 2, 3-аар нь оруулж ирж байна шүү Алтангэрэл гишүүн.

Туваан гишүүн тодруулъя.

Ц.Туваан: 2 тодорхой асуулт асуучихъя. Сэлэнгэ аймгийн Шаамар сумын Дулаан хаан тосгоны багийн даргын сонгууль болоод, Ардчилсан намын нэр дэвшигч ялаад, 2 шатны шүүхээр яваад ялсан чинь Дээд шүүх дээр анхан шат руу нь буцаасан шийдвэр гарсан байна лээ. Энэ дээрээ 1 асуулт ам шүү. Та хэд мэдээлэл байвал өгчхөөрэй. Энэ Дулаан хаан чинь ер нь баг юм уу, тосгон юм уу гэсэн маягийн асуулттай ийм салаа утгатай шийдвэр гаргасан гэсэн сураг байна лээ. Тэгэхээр энийг бас мэдээлэл байвал Хууль зүйн яамныхан хэлээд өгөөч.

2 дугаарт нь яг энэ газартай холбоотой асуудал Багануур, Налайх 2 дээр байгаа шүү. Энэ нөгөө Эрдэнэ сумтай хамгийн том бүр 60, 64 мянган га гэж ярьж байсан. Одоо сүүлдээ буугаад 50, 30 гээд л яригдаж байгаа. Тэгэхээр иймэрхүү асуудлууд дээрээ бас шийдвэрээ гаргачихсан юм уу.

С.Бямбацогт: Хэн хариулах вэ. Амарсайхан сайд хариулъя.

С.Амарсайхан: Орон нутгийн сонгуультай холбоотойгоор одоогоор бидэнд шүүх дээр явж байгаа асуудал дээр эцэслэж ирсэн гэдэг авсан мэдээлэл байхгүй байна. Энийг тодруулаад Туваан гишүүнд бас мэдээлэл хүргүүлье. 1 дүгээрт.

2 дугаарт Налайх, Багануур дээр бас газар нутгийн асуудлууд байгаа. Ялангуяа Төв аймгийн Эрдэнэ, Сэргэлэн сумтай холбоотой хилийн цэсийн маргаантай асуудлууд байдаг. Гэхдээ энэ хот байгуулах асуудал, эдэлбэр газрыг тодорхойлоход одоогийн байгаа аймаг, дүүргийн хилийн маргаан гэдэг юм уу бас зарим зөрчилдөөнтэй асуудалтай нэг их зөрчилдөхгүйгээр шийдвэрлэх бүрэн боломж нь байгаа юм. Ер нь цаашдаа энэ Улсын Их Хурал дээр бид нэг асуудлыг онцгой анхаарч шийдвэрлэх ёстой. Энэ олон 10 жил аймаг, сум, дүүрэг, Улаанбаатар хот, нийслэлийн гээд ер нь хилийн маргаангүй аймаг, орон нутаг байхгүй. Энийг Улсын Их Хурал дээр оруулж ирж нэг мөр цэгцлэхгүй бол..../минут дуусав/

С.Бямбацогт: Нанзадын Наранбаатар гишүүн асуултаа асууя.

Н.Наранбаатар: Тэгээд энэ хууль маань батлагдсанаасаа хойшоо хэрэгжиж өгдөггүй, хойшоо ухраад л яваад байдаг. Тэгээд энэ хуулийн хэрэгжилтийг хүлээсэн бас орон нутгууд байна л даа. Тэгээд энэ хуулийн дагалдаж орж ирж байгаа журам дээр Налайх, Багануур гэхихсэн. Аймгуудаасаа ядаж энэ хуулийнхаа шаардлагыг хангачихсан, төсөвтэй бол төсөвтэй, газар нутагтай бол газар нутагтай, бие даах чадвартай бол чадвартай ийм аймгуудаасаа яагаад бас оруулаад ингээд хот болгоод явах боломж байхгүй байгаа юм. Тухайлах юм бол, Өмнөговь аймгийн Даланзадгад сум бол бүх л шалгуур нөхцөлөө хангачихсан явж байдаг.

2-т гэвэл Цагаан хадны суурьшлын бүс гээд 30 гаруй жил ингээд эзэнгүй, засаг захиргаагүй, удирдлагагүй ингээд яваад байгаа. Тэгээд энэ хууль батлагдчихлаа. Ашгүй, одоо л бид нар ингээд эрх зүйн баримт бичигтэй болох нь гээд ингэж байсан чинь бас л эндээс хасагдаад ингээд явчихсан байх юм. Тэнд чинь 10, 20 мянган хүн явж байдаг. Төрийн үйлчилгээ байхгүй, удирдлага байхгүй, тэгээд л багийн статустай л явж байгаа шүү дээ. Тэгэхээр эдгээр яагаад орж болохгүй байгаа юм. Оруулахад ямар нөхцөл шаардлагууд нь биелэгдэхгүй байгаа юм бол. Судалж үзсэн барьсан юм байна уу.

Дархан, Эрдэнэтийн хувьд зарим хотуудын хувьд ингээд сумтайгаа хилийн зөрчилтэй энэ тэр асуудлууд бас байх шиг байгаа юм. Тийм зөрчил байхгүй, эдийн засгийн хувьд биеэ даагаад явчих бололцоотой ийм газруудаа оруулж яагаад болохгүй байгаа юм бол гэсэн шалтгааныг тодруулъя.

С.Бямбацогт: Хариулъя. Амарсайхан сайд хариулъя.

С.Амарсайхан: Наранбаатар гишүүний асуудал бас их чухал асуулт. Уг нь бол бид энэ боломжтой дүүрэг, аймаг, сумаа хотын статуст шилжүүлээд явах ёстой гэдэг саналтай нэг байгаа. Тэгээд Хэрэг эрхлэх газар энэ орон нутаг хариуцсан албан тушаалтнууд, удирдлагууд энэ дээр тодорхой хариулт өгөх байх.

Уг нь ажлын хэсэг дээр бол аймаг, орон нутагт алинд нь ч хэрэгжих боломжгүй гэдэг ийм асуудлыг энэ орон нутгийн асуудал хариуцсан Засгийн газрын хэрэг эрхлэхээс оруулж ирсэн. Тэгээд Өмнөговь ч болох боломжтой. Өөр олон аймаг, орон нутаг ч хот тосгон болоод цаашаа хөгжих бүрэн боломж нь бий. Тэгээд энүүгээр ингээд хааж болохгүй. Цааш нь дахиж үе шаттайгаар оруулж ирэх ёстой гэж үзэж байгаа. Энэ дээр дараагийн асуулттай нь манай ажлын хэсгээс Хэрэг эрхлэх газрынхан хариулчих.

С.Бямбацогт: Ажлын хэсэг. Индрийн 4 дүгээр микрофон.

П.Зоригтбаатар: Эрхэм Их Хурлын удирдлага, Их Хурлын гишүүдэд энэ өдрийн мэндийг хүргэе. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Орон нутгийн удирдлага, зохицуулалтын газрын дарга Зоригтбаатар байна.

Орон нутгийн зэрэглэлтэй хотууд байгуулах асуудал дээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газар дээр байгуулсан ажлын хэсэг дээр аймгуудын удирдлага, аймгуудын Засаг дарга, иргэдийн Хурал, сум, орон нутгийн удирдлага, тосгоны удирдлага, холбогдох яам, Хэрэг эрхлэх газрын удирдлагууд орсон ажлын хэсэг 2, 3 удаа хуралдсан. Энэ хотуудыг байгуулах асуудлыг Монгол Улсын Үндсэн хууль болон Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид нийцүүлж яаж байгуулж болох вэ гэдэг талаар нэлээн ярьсан. 72 дугаар тогтоолоор шууд байгуулаад явахаар нэгжтэйгээ хотын удирдлагууд зэрэгцэж байгуулагдах гээд олон давхацсан засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, иргэдийн Хурал, Засаг дарга, хотын зөвлөл, хотын захирагч гэсэн ийм зэрэгцсэн бүтцүүд бий болчих гээд байсан. Тэгэхээр бид .../минут дуусав/

С.Бямбацогт: Хариултаа гүйцээчихье. 4 дүгээр микрофон.

П.Зоригтбаатар: Тэгээд Наранбаатар гишүүний асуултад хариулахад бол саяын хэлдэг Даланзадгад, Өмнөговь аймагт гэхэд 3 хот байхаар байгаа. Даланзадгад, Ханбогд, Цогтцэций гээд. Тэгэхээр аймгийн төвийн суурьшлын бүс нь давхцаж байгаа сумуудтай нэгтгэж засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж байгуулах замаар 1 нэгжтэй нэгтгээд, 1 нэгжийг нь татан буулгаад, тэндээ хотоо байгуулах ийм хувилбарыг хийгээд явж байгаа юм. Энэ дээр бид нар засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн өөрчлөлт хийх Их Хурлын тогтоолоор батлагдсан журмын дагуу иргэдийн санал асуулга авах хугацаа 3 сарын хугацаанд явах юм. Тэгээд тэрийг ингээд одоо хийгээд явахаар оны сүүл болоод, зөвлөлийн сонгуулиуд, захирагчийн сонгуулийн хуультай зэрэгцээд энэ он дуусчих гээд байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ

он дуусчихаар зэрэг дараа жил Ерөнхийлөгч сонгуультай, дараа жил Их Хурлын Сонгуулийн хуультай гээд ингээд нөгөө сонгуулийн жилд нэгжийн өөрчлөлт хийж болохгүй гэдэг юман дээр цаг хугацааны хайчинд орчхоод байгаа юм. Тэгэхээр бид нар бол ямар ч байсан Үндсэн хууль, нэгжийн хуультай нийцүүлэх хувилбарыг бол ажлын хэсэг дээр тогтоогоод, энэ нь бол тогтсон цаг ../минут дуусав/

С.Бямбацогт: Сархадын Зулпхар гишүүн алга байна.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Хуулийн төслүүдийн талаар дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж гишүүд үг хэлнэ. 1 гишүүн байна Пүрэвжавын Сайнзориг гишүүн. Отгоны Саранчулуун гишүүн алга байна. Ренчинбазарын Сэддорж гишүүн алга байна. Пүрэвжавын Сайнзориг гишүүн. Цэндийн Баатархүү гишүүн алга байна. Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Яах вэ, тэгээд хэлэлцээд явъя энэ хуулийг. Мухардалд орчхоод байгаа юм бол. Тэгэхдээ цаг хугацааны хувьд бол Хэрэг эрхлэх газар энэ тэр дээр тийм ач холбогдол өгч энэ дээр анхаараагүй шүү. Ингээд л урсгалаараа явж байгаад цагийг нь тулгаж ирж байгаад, сайд, шийдвэр гаргадаг хүмүүст ер нь буруу зөрүү мэдээлэл өгч байгаад л ийм нөхцөл байдал руу ороод байгаа юм. Яг үнэндээ хэлэхэд Багануур, Налайхыг улсын зэрэглэлтэй хот болгоод, хөгжүүлэх энэ концепц нь явж байгаа шүү дээ. Төлөвлөлтийнхөө хувьд ч гэсэн энэ чиглэл рүүгээ явж байгаа. Эдийн засгаа аваад явах бүрэн хүчин чадал руу тэмүүлж байгаа. Энэ нийслэлээс бараг татаас авахгүй хэмжээнд Налайх дүүрэг маань хүртэл очиж байгаа байхгүй юу. Яг үүнтэй адилхан суурин газруудын бас хүний аятай тухтай амьдрах, бизнесийн орчин бүрдэх энэ зүйл рүү чинь нөгөө Хот төлөвлөлтийн хууль үйлчилж байж л хөгжинө шүү дээ. Тэгээд тэнд хот төлөвлөлтийн хууль үйлчлэхгүй нэг ийм орчин байгуулчхаад, иргэдийг битгий Улаанбаатар луу ирээч гээд байдаг ийм л зүйл рүү болчихоод байгаа байхгүй юу. Яг үнэндээ хэлэхэд энэ Монгол Улс чинь ерөөсөө 1 хоттой шүү дээ. Нийслэл Улаанбаатар хот, Бусад нь бүгд сумын статустай. Дархан, Эрдэнэтийн асуудал дээр уг нь бол Хот, тосгоны эрх зүйн байдал бол хууль жижигдээд байгаа юм. Зохицуулалтуудыг нь хийхэд боломжгүй. Тийм учраас уг нь Дархан, Эрдэнэт дээр бие даасан хууль гаргаад өгчихмөөр байгаа юм. Тэгээд бусад асуудлуудаа энэ Хот, тосгоны эрх зүйн байдлаар нь зохицуулаад уг нь явмаар байгаа юм. Түрүүн Наранбаатар гишүүн ч хэлж байна. Жишээ нь Өмнөговь дээр энэ Ханбогд сум бол сум гэхэд хэцүү бараг хотоор нь хөгжүүлэх ёстой байхгүй юу. Энэ хилийн боомтуудын суурин газрууд байна. Тосгон, багийн хэмжээнд л яваад байдаг. Эд нар чинь бараг үндсэндээ хот болчихмоор байгаа байхгүй юу. Нөгөө улсынхаа боомт хотуудтай харилцаж чаддаггүй, статус нь ойлгомжгүй ийм зүйлүүд ингээд нэлээн байна.

Тэгээд энэ хууль дээр ажлын хэсэг гаргаад, одоо зарим бие даагаад явчих бололцоотой Өмнөговь аймгийн зарим суурин газруудыг, магадгүй энэ зарим дагуул хотуудыг бас хэрэгжилтийг нь хангаад явах ёстой гэж бодож байна. Тэгэхээр энийг бас Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүд маань бас анхаарч өгөөч. Цаашдаа энэ орон нутгийн сонгуулийн асуудлыг ч гэсэн бид хэд нэг ултай суурьтай ажлын хэсэг гаргамаар байна Хурлын дарга аа.

Магадгүй хэдүүлээ бараг аймгийн, нийслэлийн сонгуулийг хиймээргүй байна. Дүүрэг, сумын сонгуулиа хийгээд, дүүрэг, сумын иргэдийн Хуралдаа сонгогдсон түвшинд хүмүүс нь нийслэл, аймгийнхаа иргэдийн Хурал дээр мандатаараа

хуваарилагдаад оччихдог энэ ротатын зарчимтай ч байж болохоор. Ингээд энэ олон шатлалтай, уялдаа багатай энэ бүтцийн нэгжүүдийг бас хамтарч ажиллах, ингээд энэ шат шатанд ингээд баахан улс төрждөг байдлаасаа гарчихмаар байна.../минут дуусав/

С.Бямбацогт: Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль бас чухал асуудал. 1992 онд бид нар шинэ Үндсэн хууль, ардчилсан Үндсэн хууль батлахдаа урьд нь байсан 21 аймаг, Дархан, Эрдэнэт хотуудыг бүгдийг нь хот биш болгочихсон. Үндсэн хуульдаа аймаг, нийслэл, сум дүүрэгтэй болчихсон. Хот байхгүй. Улаанбаатар хот нийслэлтэй болсон. Үүнээс хойш үндсэндээ 1992 оноос хойш аймгийн төвүүдийг хот гэхээ больсон. Дархан, Эрдэнэтийг хот гэхээ больсон. Аймаг болсон. Энэ иргэд маань хот болох ёстой, хотын статусаа буцааж сэргээе гэж олон жил хүсэлт тавьсан. 2019 онд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр энэ эрх зүйн үндсийг тогтоосон. 2024 онд Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан. Ингээд үндсэндээ 21 аймгийн төв, Дархан, Эрдэнэт хотынхон, томоохон Зүүнхараа, Хархорин, Замын-Үүд, Ханбогд, Ховдын Булган гээд сумын төвүүд чинь бүгдээрээ хот болно гээд бодчихсон явж байдаг. Энэ шийдэгддэггүй. Одоо Засгийн газар хэрэгжүүлэхийн оронд ингээд хэрэгжүүлэхийг хойшлуулъя. Харин Налайх, Багануур гэсэн 2 дүүргийг хот болгох гээд үзье. Энэ чинь аймаг, нийслэл чинь арай өөр түвшнийх, сум, дүүрэг гэхээр чинь Налайх, Багануур чинь дүүргийн түвшнийх ингээд ороод ирж байдаг. Энийгээ цаашдаа бас анхаарах ёстой шүү.

Ялангуяа тэр Үндсэн хуулийн 57 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан зарим чиг үүрэг гэж заасан энэ чиг үүргээ хэрхэн яаж шилжүүлэх юм. Энийгээ бас бүрэн шилжүүлэх юм уу, хэсгийг нь яаж шилжүүлэх юм гэдгийг илүү онцгой анхаарах ёстой. Тэгээд сая гишүүд хэлж байна. Анхаарах юмнууд зөндөө байна шүү гэж. Тэгээд хэлэлцүүлгийн дараагийн шатад боловсруулахдаа Засгийн газраас тодорхой тайлбаруудыг аваарай ажлын хэсэг. Мөн 2024 онд батлагдсан Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг хэрэгжүүлэх нэгдсэн зураглал, чиг үүргийн ангилал, шилжилтийг зохион байгуулах төлөвлөгөөг хамтад нь авч үзээрэй. Тэгэхгүй бол бас хууль хоорондын хийдэл, зөрчил гарчих вий. Энийг бас хэлэлцүүлгийн шатад анхаараарай гэдгийг бас хэлье.

Гишүүд үг хэлж дууслаа.

Зочин танилцуулъя. Завхан аймгийн Сонгино сумын ерөнхий боловсролын сургуулийн 1993 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Төрийн ордонтой танилцаж байгаа Завхан аймгийн Сонгино сумын иргэддээ Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс амьдралд нь аз жаргал, эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Манай Улсын Их Хурлын Тамгын газрын Лхагвасүрэн дарга чинь танай төгсөлт юм уу. Тэгвэл Лхагвасүрэн даргын төгсөлтийнх юм байна. Бас ингээд баруун бүсийн тойргийн бид нар чинь ингээд сууж байна шүү дээ. Бас баруун бүсийн танай тойргийнхон.

Санал хураалтад гишүүд бэлдье. Ганцхан асуудал байна. Энийгээ гялс санал, дүгнэлт, танилцуулгыг нь сонсчихоод санал хураалтад орчих уу. Тэгье. Энэ дээр асуулт, хариулт бараг байхгүй байгаа. Танхимдаа хүрэлцэн ирье. Тэр хооронд дараагийн асуудлын танилцуулгыг сонсчихъё.

16.42 цаг.

Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Энхбатын Болормаа танилцуулна. Индэрт урьж байна.

Э.Болормаа: Эрхэм Улсын Их Хурлын гишүүд ээ,

Өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэж байгаа Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл нь Монгол Улсын санхүүгийн зах зээлийн цаашдын хөгжил, санхүүгийн үйлчилгээний хүртээмж, иргэдийн эрх ашгийг хамгаалах тогтолцоонд чухал ач холбогдолтой хуулийн төсөл юм.

Сүүлийн жилүүдэд манай улсын санхүүгийн зах зээл өргөжин тэлж, банк, банз бус санхүүгийн байгууллага, даатгал, үнэт цаас, төлбөрийн үйлчилгээ, финтек болон цахим санхүүгийн үйлчилгээний хэрэглээ эрчимтэй нэмэгдэж байна.

Иргэд, өрх, жижиг, дунд бизнес эрхлэгчид өдөр тутамдаа олон төрлийн санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ авч, санхүүгийн гэрээ хэлцэлд оролцож байна. Гэвч санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээний төрөл нэмэгдэж, нөхцөл нь илүү нарийн төвөгтэй болохын хэрээр хэрэглэгчийн мэдээлэл авах, ойлгох, харьцуулан сонгох, эрсдэлээ үнэлэх боломж бодит амьдрал дээр хангалттай биш байна. Санхүүгийн байгууллага мэргэжлийн давуу байдалтай, харин хэрэглэгч мэдээллийн болон хэлэлцээрийн хувьд сул байр суурьтай оролцдог нь энэ салбарт түгээмэл байдаг.

Үүний улмаас зээлийн бодит өртөг, хүү, шимтгэл, хураамж, гэрээний нэмэлт нөхцөл, хугацаа хэтрүүлсний хариуцлага, эргэн төлөлтийн дарамт, санхүүгийн бүтээгдэхүүний эрсдэлийн талаар хэрэглэгч бүрэн ойлголтгүй шийдвэр гаргах нөхцөл үүсдэг. Ийм нөхцөлд хэрэглэгчийн эрхийг хамгаалах асуудлыг зөвхөн тухайн иргэний хувийн асуудал гэж үзэх боломжгүй. Энэ нь санхүүгийн зах зээлд итгэх олон нийтийн итгэл, шударга өрсөлдөөн, өрхийн санхүүгийн тогтвортой байдал, цаашлаад эдийн засгийн тогтвортой өсөлттэй шууд холбоотой бодлогын асуудал юм.

Монгол Улсын өнөөг хүртэл санхүүгийн салбарын зохицуулалтад голчлон байгууллагын төлбөрийн чадвар, зохистой харьцаа, эрсдэлийн удирдлага, санхүүгийн тогтвортой байдлыг хангах буюу макро зохистой зохицуулалтад төвлөрч ирсэн энэ чиглэл цаашид ч зайлшгүй чухал хэвээр байна. Гэхдээ санхүүгийн зах зээлийн хөгжил шинэ шатад шилжиж байгаа өнөө үед зөвхөн байгууллагын санхүүгийн үзүүлэлтээр хязгаарлагдахгүй тухайн байгууллага хэрэглэгчтэй хэрхэн харилцаж байгаа, бүтээгдэхүүнээ хэрхэн санал болгож байгаа, мэдээллээ хэрхэн ил тод хүргэж байгаа, гэрээний нөхцөл нь шударга эсэх, гомдол маргааныг хэрхэн шийдвэрлэж байгаа зэрэг асуудлыг тусгайлан зохицуулах шаардлага бий болсон. Өөрөөр хэлбэл санхүүгийн салбарт зах зээлийн зан төлөвийн зохицуулалт, хэрэглэгчийн эрхийг хамгаалах бие даасан тогтолцоотой эрх зүйн орчин бүрдүүлэх цаг болсон байна.

Энэхүү хуулийн төсөл нь дээрх хэрэгцээ шаардлагад үндэслэн дараах 5 үндсэн агуулгыг тусгаж байна.

1 дүгээрт, санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчээс хэрэглэгчтэй харилцахдаа баримтлах нийтлэл зарчим, үүргийг тодорхой болгож байна. Санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний нөхцөл, үнэ, хүү, шимтгэл, хураамж, эрсдэл, хэрэглэгчийн хүлээх үүрэг, хариуцлагыг хэрэглэгчдэд ойлгомжтой, бүрэн төөрөгдүүлэхгүй хэлбэрээр мэдээлэх нь энэ хуулийн үндсэн зарчмын нэг юм.

2 дугаарт, хэрэглэгчийг мэдээлэлтэй шийдвэр гаргах боломжоор хангах зохицуулалтыг тусгаж байна. Санхүүгийн гэрээ байгуулахаас өмнө гэрээний гол нөхцөлийг танилцуулах, хэрэглэгчийн эрх, үүргийг ойлгомжтой тайлбарлах, хэт нэг талд давуу байдал олгосон, хэрэглэгчийн эрхийг үндэслэлгүй хязгаарласан шударга бус нөхцөлийг хязгаарлах асуудал энэ хүрээнд хамаарна.

3 дугаарт, санхүүгийн хэрэглэгчийн гомдол маргааныг шуурхай, хүртээмжтэй, зардал багатай, мэргэшсэн байдлаар шийдвэрлэх тогтолцоог бүрдүүлэхээр тусгаж байна. Иргэн бүр бага дүнтэй эсхүл өдөр тутмын санхүүгийн маргаанаар шууд шүүхэд хандах нь цаг хугацаа, зардал, мэдлэг, мэдээллийн хувьд хүндрэлтэй байдаг. Иймээс шүүхийн өмнөх шатад хэрэглэгчийн гомдлыг үр дүнтэй шийдвэрлэх хараат бус мэргэшсэн механизм бий болгох нь хуулийн төслийн практик ач холбогдлын нэг юм.

4 дүгээрт, Монголбанк болон Санхүүгийн зохицуулах хорооны санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах чиг үүрэг, хяналт шалгалт, зохицуулалтын бүрэн эрхийг тодорхой болгож байна. Ингэснээр зохицуулагч байгууллагууд зөвхөн санхүүгийн байгууллагын төлбөрийн чадвар, зохистой харьцааг хянах бус тухайн байгууллагын хэрэглэгчтэй харилцах үйл ажиллагаанд ил тод, шударга, хариуцлагатай байдлыг хянах эрх зүйн үндэстэй болно.

5 дугаарт, санхүүгийн боловсрол хэрэглэгчийн мэдлэгийг дээшлүүлэх асуудлыг бодлогын түвшинд тусгаж байна. Хэрэглэгчийг хамгаалах нь зөвхөн санхүүгийн байгууллагад хориг, үүрэг тогтоох асуудал биш юм. Нөгөө талаас хэрэглэгч өөрөө санхүүгийн бүтээгдэхүүний нөхцөл, өртөг, эрсдэл хариуцлагаа ойлгож, хариуцлагатай шийдвэр гаргах чадвартай байх шаардлагатай. Иймээс санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх нь энэ хуулийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг юм.

Эрхэм Улсын Их Хурлын гишүүд ээ,

Энэхүү хуулийн төслийн эдийн засгийн ач холбогдлыг онцлон тэмдэглэх нь зүйтэй. Юуны өмнө санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тогтолцоо бүрдсэнээр санхүүгийн байгууллагуудад итгэх иргэдийн итгэл нэмэгдэнэ. Итгэл бол санхүүгийн зах зээлийн үндсэн суурь юм. Хэрэглэгч гэрээний нөхцөлөө ойлгодог, маргаан гарвал шударгаар шийдвэрлүүлэх боломжтой, эрх нь хамгаалагдана гэдэгт итгэх нь санхүүгийн зах зээлийн хүртээмж идэвхтэй оролцоог нэмэгдүүлнэ.

Мөн энэ хууль нь шударга өрсөлдөөнийг дэмжинэ. Хэрэглэгчид бүтээгдэхүүн, үйлчилгээний нөхцөлөө ил тод, ойлгомжтой танилцуулдаг, хариуцлагатай үйл ажиллагаа явуулдаг байгууллага зах зээл давуу байдалтай байх ёстой. Харин

мэдээллийн давуу байдлаа ашиглан хэрэглэгчийг төөрөгдүүлэх, далд шимтгэл, хураамж ноогдуулах, гэрээний тэнцвэргүй нөхцөл тулгах явдлыг хуулийн түвшинд хязгаарлах шаардлагатай. Түүнчлэн өрхийн санхүүгийн дарамт хэт өрийн дарамтын эрсдэлийг бууруулахад эерэг нөлөө үзүүлнэ. Хэрэглэгч зээлийн бодит өртөг, төлбөрийн хуваарь, хүү, шимтгэл, үүргийн гүйцэтгэл, хугацаа хэтрүүлсний үр дагаврыг ойлгож байж санхүүгийн зөв шийдвэр гаргах боломжтой. Энэ нь өрхийн санхүүгийн сахилга бат, төлөвлөлтөд чухал ач холбогдолтой.

Цаашлаад санхүүгийн зах зээлийн урт хугацааны тогтвортой байдалд хувь нэмэр оруулна. Мөн санхүүгийн байгууллага, хэрэглэгч 2-ын хоорондын харилцааг илүү тэнцвэртэй, ил тод, хариуцлагатай болгох замаар санхүүгийн салбарын тогтвортой хөгжлийг дэмжих бодлогын арга хэрэгсэл юм.

Эрхэм Улсын Их Хурлын гишүүд ээ,

Энэхүү хуулийн төсөл нь санхүүгийн байгууллагын үйл ажиллагааг хэт хязгаарлах, зах зээлийн хөгжлийг сааруулах зорилготой биш. Харин санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч болон хэрэглэгчдийн хоорондын харилцаанд шударга, ил тод, ойлгомжтой, хариуцлагатай, стандарт тогтоох зорилготой. Олон улсын сайн туршлагаас харахад санхүүгийн зах зээл хөгжихийн хэрээр хэрэглэгчийн эрхийг хамгаалах бие даасан эрх зүйн орчин зайлшгүй шаардлагатай болдог. Манай улсын хувьд энэ асуудлыг цаашид салангид зохицуулалт байгууллагын дотоод журам эсвэл ерөнхий иргэний эрх зүйн хүрээнд үлдээх нь хангалтгүй байна.

Банкны салбарын мэдээллээс үзэхэд сүүлийн жилд дотоод аудит болон хяналт шалгалтаар иргэн, аж ахуйн нэгжтэй холбоотой 47 мянган зөрчил илэрсний 99,2 хувь нь иргэдтэй холбоотой байсан боловч банканд иргэдээс 6,5 мянган өргөдөл буюу энэ маань нийт бүртгэгдсэн зөрчлийн 14 хувьтай тэнцэх хэмжээний гомдол гаргасан байна.

Мөн нийт өргөдөл гомдлын 0,6 хувь нь шүүхээр, 1,4 хувь нь эвлэрүүлэн зуучлагчаар шийдвэрлэгдсэн санхүүгийн хэрэглэгчийн хувьд шүүхийн болон бусад маргаан шийдвэрлэх суваг, цаг хугацаа, зардал, мэргэжлийн туслалцааны хувьд хүндрэлтэй болохыг нотолж байна.

Иймээс Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах хуулийн төсөл нь иргэдийн эрх ашгийг хамгаалахаас гадна санхүүгийн зах зээлийн сахилга бат, хариуцлагатай үйлчилгээ, шударга өрсөлдөөн, хөрөнгө оруулагчдын итгэл, эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжих ач холбогдолтой гэж үзэж байна.

Хууль батлагдсанаар санхүүгийн үйлчилгээний нөхцөл илүү ил тод, ойлгомжтой болж, хэрэглэгчийн гомдол, маргааныг шуурхай шийдвэрлэх боломж нэмэгдэнэ. Мөн зохицуулагч байгууллагуудын хэрэглэгчийн эрхийг хамгаалах чиг үүрэг, хяналт, арга хэмжээний эрх зүйн үндэс тодорхой болж, санхүүгийн байгууллагуудын хэрэглэгч төвтэй хариуцлагатай бизнесийн соёл төлөвшихөд бодитой түлхэц үзүүлнэ.

Иймд Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төслийг хэлэлцэхийг дэмжиж өгөхийг эрхэм Улсын Их Хурлын гишүүд та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсан явдалд баярлалаа.

С.Бямбацогт: Баярлалаа. Төслүүдийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Гончигдоржийн Уянгахишиг танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Г.Уянгахишиг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа нарын 19 гишүүн 2026 оны 05 дугаар сарын 21-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг Эдийн засгийн байнгын хороо 2026 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч Монгол Улсад санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалахтай холбоотой нарийвчилсан зохицуулалтыг бий болгох шаардлагын хүрээнд Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай анхдагч хуулийн төслийг боловсруулсан байна.

Хуулийн төсөлд санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчээс санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрэглэгчдэд хүргэхэд тавигдах нийтлэг шаардлагыг тогтоох, гомдол маргааныг хянан шийдвэрлэх, олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх, хамгаалахтай холбоотой харилцааг зохицуулах, үүнтэй холбогдуулан санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих чиг үүрэг бүхий бүтэц, орон тоог шинээр бий болгохтой холбоотой зардал гарахаар тусгасан байна.

Хуулийн төслийг D-Parliament.mn цахим хуудаст байршуулж, иргэд, олон нийтийн саналыг авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат санхүүгийн үйлчилгээ, ялангуяа цахим зээлийн гэрээнүүдэд хэрэглэгч талд хэт эрсдэл үүрүүлж, гэрээний тэнцвэр алдагдаж байгаа нөхцөл байдал, үүнээс үүдэн аппликэйшний зээлтэй холбоотой гомдол, шүүхийн маргаан, ачаалал нэмэгдэж буй бодит байдал, банк санхүүгийн байгууллагуудын ашигт ажиллагааны түвшин, зээлийн нөхцөлийн ижилсэл болон ахмад настны зээлийн хүртээмж бодитоор хязгаарлагдаж байгаа асуудлуудын талаар хийсэн судалгаа, дүн шинжилгээ, тооцоолол байгаа эсэх, мөн эдгээрт үндэслэн гэрээний зохицуулалт болон холбогдох хууль, эрх зүйн орчныг сайжруулах шаардлагыг хэрхэн тодорхойлсон талаар, Улсын Их Хурлын гишүүн Мандхай Санхүүгийн үйлчилгээний салбарт Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо болон хэрэглэгчийг хамгаалах байгууллагуудын чиг үүргийн уялдаа зааг тодорхой туссан эсэх, мөн финтек болон цахим зээл, даатгал зэрэг шинэ бүтээгдэхүүнд хэрэглэгчийн эрхийг хамгаалах зохицуулалт. Түүнчлэн малчин өрх, тариаланч, бичил бизнес эрхлэгч зэрэг улирлын орлоготой зээлдэгчдийн онцлог эрсдэлийг үнэлэх асуудлыг хэрхэн тусгасан талаар, мөн санхүүгийн хэрэглэгчийн гомдлыг шийдвэрлэхэд Омбудсмэны удирдах зөвлөлийг томилох, зохицуулалтын хараат бус байдал улс, төрийн нөлөөллийн эрсдэлийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг санхүүгийн маргаан шийдвэрлэх Омбудсмэны эрх зүйн зохицуулалт нь шүүхийн тогтолцоотой уялдах байдал, талуудын эрх тэгш хангагдах байдал болон хэрэг

маргааны харьяалал, шилжилтийн зохицуулалт тодорхой тусгагдсан эсэх, энэ зохицуулалтын талаар холбогдох мэргэжлийн байгууллагуудаас санал, дүгнэлт өгсөн эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар маргаан шийдвэрлэх байгууллагын Удирдах зөвлөлийг Эдийн засгийн байнгын хорооноос томилж, төсөв цалинг нь тогтоох зохицуулалт нь улс төрийн нөлөөлөл үүсгэх эрсдэлтэй эсэх, мөн үйлчилгээ үзүүлэгч талд маргалдах эрх олгоогүй байдал нь Монгол Улсын Үндсэн хуулийн тэгш эрхийн зарчимтай нийцэж байгаа эсэх талаар тус тус асуулт асууж, хариулт авсан бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүд санал хэлээгүй болно.

Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал хуулийн төсөлд Засгийн газраас өгсөн саналтай холбоотойгоор Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн Хуулийн дэгийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.4 дэх хэсэгт заасны дагуу Тамгын газраар дүн шинжилгээ хийлгэж, хууль зүйн зөвлөмж гаргуулах горимын санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.11 дэх хэсэгт заасны дагуу Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл тус бүрийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулахад Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа. баярлалаа.

С.Бямбацогт: Зочин танилцуулъя. Нийслэлийн ерөнхий боловсролын 38 дугаар сургуулийн Ариундарь багштай 9³ дугаар ангийн сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Төрийн ордонтой танилцаж байгаа хүүхэд багачууддаа Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс баяр хүргэж, амжилт хүсье. Эрдэм номдоо шамдан суралцаж, удахгүй болох анги дэвших шалгалтаа амжилттай өгөөрэй.

Хуулийн төслийн үзэл баримтлал, Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух гишүүдийн нэрс авъя. Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн, Батын Батбаатар гишүүн алга байна. Хассуурийн Ганхуяг гишүүн. Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн.

Д.Энхтүвшин: Хуулийг үзэл баримтлалыг бол дэмжиж байгаа. Тэгэхдээ энэ дотор 1, 2 зүйлийг тодруулахгүй бол санхүүгийн хэрэглэгчийн эрхээ буцаагаад

зөрчих, хязгаарлах иймэрхүү эрх зүйн үр дагаварт хүргэж магадгүй 2 зохицуулалт харагдаад байгаа юм.

Нэгдүгээрх нь болохоор энэ омбутсмэны шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй бол санхүүгийн хэрэглэгч 30 хоногийн дотор иргэний хэрэгт гомдол гаргахаар, тэгээд хэрвээ гомдол гаргаагүй бол энэ шийдвэр нь эцсийн бөгөөд дахиж шүүхэд гомдол гаргах эрхгүй байхаар ингээд 21.7, 21.8 дээр заачихсан байгаа юм. Өөрөөр бас тэгээд энэ судалгаан дээр болохоор танилцуулга дээр болохоор энэ хуулийн бас үндэслэлүүдийнх нь 1 нь болохоор санхүүгийн хэрэглэгч нарын 1/3 нь санхүүгийн мэдээлэлтэй танилцаагүй, тал нь бүтээгдэхүүний талаар ойлголтоггүй байдаг гээд иймэрхүү асуудлууд байгаа. Тэгэхээр яах вэ, энэ 30 хоногийн дотор жишээлбэл яг ийм санхүүгийн ойлголт, мэдээлэлгүй хүн жишээлбэл би гомдол гаргахгүй байна гээд өнгөрөөчхөж магадгүй. Тэгээд дараа нь илүү мэдлэгтэй, мэдээлэлтэй хүнтэй уулзаад ч юм уу энэ асуудлаа буцааж ярья гэхээр энэ 21.7, 21.8 хоёр чинь энэ эрхийг нь хязгаарлаад байгаа юм шиг. Тэгэхээр Үндсэн хуулийн 16.14-ийн эрх ч гэсэн шүүхэд хандах, гомдол гаргах эрх нь нээлттэй байгаа юмыг 30 хоног гэж хязгаарлах зайлшгүй тийм шаардлага байгаа юм уу. Энийг хэлэлцүүлгийн явцад засах бололцоотой юу гэдэг 1 дүгээр асуулт.

Хоёрдугаарх нь болохоор бас яг санхүүгийн хэрэглэгчийн зарим тодорхой бүлгийн санхүүгийн хэрэглэгчдийн эрхийг хязгаарлаж магадгүй заалт байгаа. Энэ 25.1 дээр. Банк, эрх бүхий хуулийн этгээд болон бусад зээлдүүлэгч этгээд нь зээлдэгчийн орлого, бусад төлбөрийн үүргийг харгалзан зээлдэгчийн төлбөрийн чадварт нийцүүлэн зээл олгоно гээд. Өөрөөр хэлбэл орлогоо нотлох боломжгүй, далд секторт ажилладаг, бага орлоготой малчид ч гэдэг юм уу гэх мэтчилэн ийм бүлгийн хүмүүс яг энэ албан сектороос зээл авч чадахгүй, албан бус өндөр хүүтэй хар зах зээл рүү шилжих бас ийм эрсдэл. Энийг жишээлбэл эрхийг нь хязгаарлаж байгаа юм шиг ийм хуулийн заалт харагдаад байна л даа. Тэгэхээр энэ 2 дээр хэлэлцүүлгийн явцад сайжруулах бололцоо боломж байгаа юу гэдэг асуулт байна.

С.Бямбацогт: Хариулъя хууль санаачлагч. Ажлын хэсгээс хариулъя. Нэрээ хэлээд, танилцуулаад хариулъя.

Н.Батсайхан: Батсайхан Монголбанкны Ерөнхий эдийн засагч. Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Омбутсмэны шийдвэр гараад, 30 хоногийн дараа гомдол гаргах гэж бол зохицуулагдсан байгаа. Гэхдээ ер нь бол санхүүгийн хэрэглэгч маань эхлээд тухайн санхүүгийн үйлчилгээ авсан байгууллагадаа бол эхэлж хандана. Тэр байгууллагаасаа авсан хариу нь өөрийнх нь хохирол нь барагдаагүй гэж үзэх юм бол омбутсмэнд бол хандахаар зохицуулагдсан байгаа юм. Тэгэхээр энэ хооронд бол өөрөө бол гомдол гаргах хангалттай хугацаатай. Харин Омбутсмэны шийдвэр гарсны дараа, 30 хоногийн дараа дараагийн шатын шүүхэд хандах эрхийг нь бол нээж өгсөн байгаа. Энэ хугацаагаар хязгаарласан нь бол ерөнхийдөө шүүхийн шийдвэр гарсны дараа манайд хэрэгжиж байгаа хуулиар бол 14 хоногийн дараа давж заалдах, гомдол гаргах бол эрхтэй байдаг. Энэ хугацааг бол 2 дахин уртасгаж өгөөд, 30 хоног болгосон байгаа.

Мөн иргэд өргөдөл гомдол төрийн байгууллагууд гаргаад ерөнхийдөө 30 хоногийн дотор бол хариугаа авдаг. Бас энэ практик хугацаатай уялдуулаад 30 хоног гэж бол хийж өгсөн байгаа.

Тэр 2 дахь асуулт болох орлого нотлох боломжгүй бол зээл авах боломжийг нь хааж байна гэсэн заалт байна. Ерөнхийдөө хуулийн гол зорилго бол бас энэ санхүүгийн үйлчилгээ олгогч, санхүүгийн хэрэглэгч 2-ын хооронд байгаа энэ тэгш бус мэдээллийн харилцааг аль болох тэгш болгох хуулийн гол зорилго байгаа. Мэдээж энэ талаас бид нар санхүүгийн хэрэглэгчийгээ хамгаалах талаар заалтууд орж өгсөн байгаа. Энэ заалт нь мөн бас санхүүгийн хэрэглэгч маань өөрөө бас хариуцлагатай байх ёстой. Тийм учраас санхүүгийн үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагадаа бас үнэн, зөв санхүүгийн мэдээллээ өгөх ёстой. Ингэснээрээ бол мэдээж аль аль тал нь аль болох ижил тэгш мэдээлэлтэй байж байж санхүүгийн харилцаанд орсноор санхүүгийн тогтвортой байдалд бид нар энэ бол эерэг нөлөөтэй гэж бол үзэж байгаа.

С.Бямбацогт: Энхтүвшин гишүүн тодруулъя.

Д.Энхтүвшин: Тэгэхээр яг нөгөө шүүхэд хандах эрхийн 1 хуулиар Үндсэн хуулийн эрхийг нь 30 хоног гээд хязгаарлачхаж байгаа нь л өөрөө заавал ингэж хязгаарлах хэрэгтэй байгаа юм уу гэдэг л асуулт байгаа юм. Гэхдээ саяын хариултаас бол тодорхой хариулт авч чадсангүй.

2 дахь тэр асуудлын хувьд болохоор санхүүгийн хэрэглэгч хариуцлагатай байх ёстой гэж хэлж байна. Тэгэхээр нөгөө хуулийн агуулга маань өөрөө сахилга бат ч гэдэг юм уу, жишээлбэл мэдээлэл, мэдлэг энэ санхүүгийн байгууллагатай харьцаж чадахгүй бас тодорхой хэмжээний бэрхшээлүүд ижил түвшинд биш байгаа учраас л энэ хуулийг хамгаалах үүднээс гаргаж байгаа. Тэгэхээр энэ тодорхой хэсгүүд байна. Одоо жишээ нь Монголд бол ажил хийдэггүй мөртөө амьдраад яваад байдаг хүмүүс байдаг шүү дээ. Тэгэхэд энэ хүмүүс бол жишээлбэл орлогоо нотолж чадахгүй учраас санхүүгийн байгууллагаас, албан секторуудаас жишээлбэл зээл, санхүүжилт авах бололцоогүй л болох гээд байна л даа. Яг энэ хуулийн заалтаар орлогоо нотолж чадахгүй учраас. Тэгэхээр энэ буцаад өөрөө хар зах зээл рүү шилжих .../минут дуусав/

С.Бямбацогт: Хариулъя. 4 дүгээр микрофон ажлын хэсэг.

Н.Батсайхан: Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. 30 хоног гээд хязгаарлаж байгаа нь бас нөгөө талаараа ер нь бол санхүүгийн энэ маргааныг аль болох богино хугацаанд маргаад мухарлах, богино хугацаанд шийдвэрлээд мухарлах нь бол нэлээн өөрөө нийгмийн ач холбогдолтой. Яагаад гэвэл өөрөө нийгмийн зардлыг бууруулах бол тийм үндэстэй бид нар хугацааг нь урт тавихлаар энэ өөрөө маргаан маань өөрөө сунжирсан байдалтай. Шийдвэр нь гарч өгдөггүй нийгмийн зардлыг улам нэмэгдүүлээд байгаа ийм асуудал байгаа. Тийм учраас энэ бас олон улсын практик дээр бол ерөнхийдөө 30 хоногоор бол хязгаарласан байдаг. Тэгээд энэ олон улсын жишиг болон бас манай улсад ашиглагдаж байгаа тэр өдрийн хязгаарлалтуудыг бол авч бид бүхэн тавьсан байгаа.

2 дахь асуулт болохоор орлого нотлох боломжгүй иргэдийн эрхийг хязгаарлаад байна гэдэг дээр бол мэдээж банк, санхүүгийн үйлчилгээ үзүүлж байгаа байгууллага маань бас .../минут дуусав/

С.Бямбацогт: Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн асуултаа асууя.

С.Эрдэнэбат: Санхүүгийн зах зээл дээр нөгөө өгөх хүн гэдгийг, авах хүн тонгойно гэдэг шиг л байгаа л даа. Тэгэхээр би Монголбанк болон Санхүүгийн зохицуулах хорооныхноос ер нь банк санхүүгийн байгууллагууд аппликэйшн гээд энэ зээлийн гэрээтэй холбоотой гэрээнүүдийн эрх тэнцвэртэй байдлын талаар ер нь ямар нэгэн хянаж дүгнэдэг ийм зүйл байна уу. Банк дээр ч очсон, банк бус дээр ч очсон бүр аппликэйшн зээл зөвхөн зөвшөөрөх, үгүй гэдэг л 2 сонголтыг тулгаж байгаа шүү дээ. Тэгэхээр энэ тал дээр манай Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах төв энэ дээр гаргасан тодорхой санал, дүгнэлт байна уу гэдэг ийм зүйлийг 1 дүгээрт тодруулж асуумаар байна.

2 дугаарт нь ялангуяа энэ хэрэглээний зээлүүдийг хязгаарлаж байгаа. Үүнтэй холбоотойгоор хүмүүс яаж байна вэ гэхээр хэрэглээний зээлээс хязгаарлахаар нөгөө талд нь яах вэ гэхээр санхүүгийн хэрэглэгчийн хүүгийн дарамт руу бид нар хоёрдогч, гуравдагч зах зээл буюу энэ хар захын зээл рүү орж байгаа. Банк бус санхүүгийн байгууллагын зээл 40, 50, 60 хувь байна. Аппликэйшний зээл бол ямар ч тохиолдолд шүүх дээр санхүүгийн үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагууд л ялахаар ингээд бараг программчилчихсан хууль, эрх зүй, гэрээ зүйлийг нь ингээд шууд тулган шаардсан ийм гэрээнүүд явж байгаа юм. Тэгэхээр шүүхийнхэн хүртэл аваад үзэхээр асар их ачаалал өгдөг юм байна. Зээлээ төлж чадахгүй бол шууд шүүхэд шилжүүлнэ. Тийм учраас энэ шүүхийн үйл ажиллагаанд хүртэл энэ баахан аппликэйшний зээлүүдийн хэрэг маргаан ирдэг. Хэрэглэгчдэд шийдэгдэж байгаа хэрэг бараг үндсэндээ байдаггүй гэж байна шүү дээ. Тэгээд бараг гэрээ байгуулахаас авхуулаад л тэр хүний хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах дээр дуугардаг, хянадаг ийм байгууллага та бүгдэд яг ямар тийм институц нэгж байгууллагууд байна вэ гэж.

2 дугаарт энэ омбутсманы зөвлөлийг уг нь болж өгвөл орон тооны болговол бас их зүгээр байгаа юм. Маш олон мянган хэрэглэгчийн асуудал орж ирнэ. Мэдээж хараат бус байх ёстой. Тийм учраас эргээд нөгөө Байнгын хороогоор бас томилчихоор янз бүрийн төлөөлөл орж ирээд бүр цаагуураа нөгөө санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын төлөөлөл гэж байгаа энэ лобби нь ороод, эсрэгээрээ юм болчих вий дээ гэдэг дээр би бол санаа зовж байгаа. Ялангуяа зарим зүйл дээр тухайлбал тэтгэвэрт гарчихсан хүн ер нь орон сууцны зээл авахад өгөхгүй гэдэг бараг бичигдээгүй хуультай л байна л даа. Үндсэндээ та тэтгэвэрт гарчихсан бол танд орон сууцны зээл олгохгүй гэж Үндсэн хууль зөрчсөн ийм зарчим яваад байгаа. Тэгээд энийг шийдвэрлэхэд энэ хуулиар зохицуулсан нарийн зохицуулалтыг яаж тусгасан бэ гэдэг тал дээр би энэ мэргэжлийн байгууллагуудаас нь бас тодруулж асуумаар байна.

С.Бямбацогт: 4 дүгээр микрофон. Ажлын хэсэг хариулъя.

Н.Батсайхан: Эрдэнэбат гишүүний асуултад хариулъя. 1 дүгээр асуулт банк, санхүүгийн аппликэйшн ашигласан зээл дээр яаж ажилладаг вэ гэж байна. Аппликэйшний зээл дээр бол санхүүгийн байгууллага маань ерөнхийдөө 2 зохицуулагчтай байгаа. Банкнуудыг бол Монголбанк, банк бус байгууллагуудыг бол Санхүүгийн зохицуулах хороо маань хянан зохицуулж яваа. Энэ хяналт зохицуулалтын хүрээнд бол аппликэйшнүүдийн зээл дээр Монголбанк иргэдийн өргөдөл, гомдлыг өөрсдийн шугамаар бол авч шийдвэрлээд явдаг. Мөн Санхүүгийн зохицуулах хороо ч гэсэн өөрсдийнхөө шугамаар өргөдөл гомдлыг бол шийдвэрлээд бол явж байгаа. Статистикийн хувьд бол өнгөрсөн оны байдлаар

Санхүүгийн зохицуулах хороо дээр 606 өргөдөл гомдлыг бол шийдвэрлэсэн байгаа. Монголбанк дээр бол энэ тоо бол 700, 70 хавьцаа өргөдөл гомдлыг бол ингээд тухайн үед нь шийдвэрлээд явж байгаа.

2 дугаар асуулт бол хүүгийн дарамт их байна, оруулж байна гэсэн асуулт байна. Яг энэ хуулийн хүрээнд бид бүхэн бол гэрээний үйлчилгээний стандартууд оруулж ирж байгаа. Тэгээд энэ дагуу ерөнхийдөө бол банкнууд өөрийнхөө хүү, шимтгэлийн үйлчилгээнийхээ нөхцөлийг ил болгож тавих ёстой болж ирж байгаа. Омбутсмэны сумын зөвлөл орон тооны байх, орон тооны бус байх уу гэдгийг бол яах вэ, энэ цаашдаа бол бид нар ажлын хэсэг дээр хэлэлцээд, энэ дээр шийдвэрлэж бол болох байх.

С.Бямбацогт: Жудагийн Баярмаа гишүүн асуултаа асууя.

Ж.Баярмаа: Энэ хуулийн төсөл зүгээр техник бичвэрийн хувьд гэх юм уу зүгээр эхний ээлжид нэг зүйл дурдахад энэ зорилгоосоо эхлээд санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчээс санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг санхүүгийн хэрэглэгчид хүргэхэд тавигдах нийтлэг шаардлагын гэж байснаа санхүүгийн боловсролыг дээшлүүлэх, санхүүгийн хэрэглэгчийн хууль, ёсны эрх ашгийг хамгаалах замаар санхүүгийн тогтвортой байдалд гээд энэ 1 өгүүлбэрт бараг хэдэн ч санхүүгийн гэдэг үг байгаад байгаа юм. Энэ чинь зүгээр монгол хэл талаасаа санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчээс бүтээгдэхүүн үйлчилгээг хэрэглэгчид хүргэхэд гээд ингээд бичихэд тэртээ тэргүй уг нь ойлгомжтой байхгүй юу. Тэр бүрийг санхүүгийн, санхүүгийн гээд. Энэ бол яах вэ техник шинжтэй зүйл байлаа.

Энэ хуулийн танилцуулга дотор байна л даа. Иргэний хууль, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль, Банкны тухай хууль, Зар сурталчилгааны тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль болон бусад салбарын хуулиудаар энэ санхүүгийн үйлчилгээ авагчдын эрх ашгийг зохицуулсан гээд заачихсан байгаа юм. Тэгээд энэ хүрээнд жишээ нь Монголбанкнаас 2020, 2025 онд банктai холбоотой 550 орчим өргөдөл гомдол хүлээн авсан гээд биччихсэн. Санхүүгийн зохицуулах хороонд бас 2024, 2025 онд гэхэд 1486 өргөдөл гомдол шийдвэрлэсэн гээд ингээд маш тодорхой заачихсан. Тэгээд энэ чинь юуг хэлж байна гэвэл гомдол хүлээж авах, өргөдлийг нь шийдвэрлэх ийм институц байгаа гэж харагдаж байна. Байгаа. Дээрээс нь энэ хуулиуд нь байдаг учраас энд ингээд тодорхой заачихсан байна л даа. Тэгэхээр энэ Монголбанк бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны эрх хэмжээний хүрээнд шийдэж болохгүй ямар асуудлууд байгаа учраас энэ хуулийг шинээр оруулж ирж байгаа юм бэ гээд. Өөрөөр хэлбэл нөгөө Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тухай хууль гэж бас байгаа. Тэгээд тэрүүгээр бас шийдэж болохгүй байгаа юм уу. Тэрэндээ тусгайлан заавал ч үгүй санхүүгийн хэрэглэгч гэдэг ийм тодорхойлолт, ийм субъектүүд байх ёстой бол тэр хуульд оруулж өгч болохгүй юм уу гэсэн ийм асуулт байна.

Дараа нь энэ хэрэглэгчийг хамгаалах нэрээр төрийн оролцоо дахиад л нөгөө хүнд суртлыг нэмэгдүүлэх юм биш үү гэсэн ийм болгоомжлол байна. Жишээлбэл энд ийм нэг ноцтой заалт байна л даа. 8.1.1-д санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч нь хэрэглэгчийн санхүүгийн чадамж, хэрэгцээнд үндэслэн үйлчилгээ үзүүлнэ гээд биччихсэн. Тэгээд хэрвээ энийгээ биелүүлээгүй бол Зөрчлийн тухай хуулиар шийтгүүлнэ, хариуцлага хүлээнэ гээд биччихсэн. Гэтэл өнөөдөр банк бол зээлээ юун дээр үндэслэж олгодог вэ гэвэл мэдээж тухайн иргэний орлого, барьцаа

хөрөнгө, зээлийн түүх, эрсдэлийн үнэлгээ гээд байдаг. Гэтэл энэ хэрэгцээнд .../минут дуусав/

С.Бямбацогт: Асуултаа гүйцээчихье Баярмаа гишүүн.

Ж.Баярмаа: Тэгэхээр энэ хэрэгцээнд нийцнэ гэдэг нь асар тийм субъектив юм биш үү. Юуг нийцсэн, юуг нийцээгүй гэж үзэх вэ. Энийг юун дээр үндэслэж үнэлэх вэ. Тэгээд хариуцлагыг нь хэн хүлээх вэ. Би нийцээгүй байхад надад зээл өгчихсөн гээд хэрвээ асуудал үүсвэл тэр хэрэглэгч тэгэх юм уу бас тэгэх боломжтой нөгөө талдаа. Эсвэл энэ нийцээгүй хүнд зээл өгсөн гээд нөгөө зээл олгогч байгууллагуудыгаа ингэж дахиад ийм дарамтлах юм үүсэх юм биш үү гэсэн ийм болгоомжлол байгаа юм. Тэгээд өөрөөр хэлбэл төрийн байгууллагууд нь банкны бүтээгдэхүүн, зээлийн шийдвэр, тэр тухайн гэрээний нөхцөл рүү ингэж орох ийм боломж бас нөгөө талдаа эрсдэл бас дарамт үүсэх юм биш биз дээ энэ хуулиар чинь гэсэн ийм асуултууд байгаа юм.

Өөрөөр хэлбэл санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нэрийн дор аль алиных нь эрх ашгийг хумих ийм эрсдэл, дарамт болох ийм хуулийн төсөл болчих юм биш байгаа гэсэн болгоомжлол байна.

С.Бямбацогт: Ажлын хэсэг хариулъя 4 дүгээр микрофон.

Н.Батсайхан: Баярмаа гишүүний асуултад хариулъя. 1 дүгээр асуулт техникийн бичвэр дээр ажлын хэсэг цаашдаа анхаараад засаад явъя.

2 дугаар асуулт болох олон хуулиудад зохицуулсан байна. Хянан зохицуулагч байгууллагууд болох Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо хянаж болж байгаа зүйлсийг яагаад дахиж хуульчилж байгаа юм бэ гэсэн асуулт байна. Зорьж байгаа асуудал бол санхүүгийн маргааныг шуурхай шийдвэрлэх, богино хугацаанд шуурхай шийдвэрлэх 1 дүгээрт зорилготой байгаа.

2 дугаарт мэргэжлийн ийм хараат омбутсмэн гэдэг маань өөрөө маш өндөр мэргэжлийн хүн байна. Тэгээд өөрөө ийм хараат бус, шуурхай шийдвэрийг гаргаж, төрийн бусад байгууллагуудад байгаа хүнд суртлыг хамгийн бага байлгах ийм зориулалттай. Тэгээд ерөнхийдөө бас судалгаан дээр үндэслээд ерөнхийдөө ийм санхүүгийн маргааныг мэргэжлийн хараат бус байгууллага богино хугацаанд шийдсэнээр бол ерөнхийдөө нийгмийн зардлыг бол бууруулж чаддаг гэсэн судалгааны үндэслэл дээр бид бүхэн бол энийг ийм тусгай онгирчихсон байна гэдэг субъект гарч ирж байгаа. Мөн нөгөө талаас бас манай шүүхийн ачааллыг бас нэлээн хэмжээгээр бууруулж өгч байгаа.

3 дугаар асуулт бол төрийн хүнд суртал бий болох вий гэсэн. Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч болон хэрэглэгч талдаа аль аль талд нь дарамт болох вий гэсэн асуулт байна. Энэ заалт нь бол мэдээж гол санаа нь ерөнхийдөө бас тухайн зээлдэгчийн өөрийнх нь санхүүгийн чадварыг нь мэдсээр байж түүнээс илүү санхүүгийн үүрэг хүлээлгэх замаар хүүлэлт явуулахаас сэргийлсэн тийм заалт байгаа. Өөрөөр хэлбэл энэ бол санхүүгийнхээ хэрэглэгчийнхээ эрх ашгийг хамгаалсан утгатай заалт байгаа юм.

С.Бямбацогт: Хассуурийн Ганхуяг гишүүн асуултаа асууя.

Х.Ганхуяг: Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тухай хуулийг хэлэлцэж байна. Энэ дээр 1 санхүүгийн маргаан шийдвэрлэх байгууллага байгуулах талаар энэ хуулийн үзэл баримтлалд орсон байна. Омбутсмэн гэдэг нэртэй байх юм байна. Эдийн засгийн байнгын хорооноос байгуулах юм байна. Хуучин бол 3 шатын шүүхээр явдаг байсан бол 4 шатын шүүхээр явдаг болно л гэсэн үг шүү дээ үндсэндээ. Тэгэхээр энэ чинь асуудал нь юу болох вэ гэхээр нөгөө зээл олгогчийн гаргаж байгаа зардал тэр хэмжээгээр нэмэгдэнэ л гэсэн үг. Тэгээд тэр нь юу гэсэн үг вэ гэхээр нөгөө зээлийн хүү дахиад нэмэгдэнэ л гэсэн үг байхгүй юу. Яг зүгээр муйхарлан ойлговол. Тэгэхээр миний асуух гээд байгаа нь гэхээр яагаад энийг байгуулах болсон шалтгаан нь юу байх вэ. Тэгээд яагаад хараат бус байж хараат бусаар үйл ажиллагаа явуулна гэж итгээд байгаа юм. Хэдэн улс төрч нар тэрийг нь ингээд байгуулаад явчихаар хараат бусаар ажиллана гэдэгт яагаад та хэд тийм итгэлтэй байгаа юм. 1 дүгээр асуулт.

2 дугаар асуулт энэ хууль батлагдсанаар өрсөлдөөнт орчныг бэхжүүлнэ гээд ярьсан байх юм. Тэгээд энэ яаж өрсөлдөөнт орчныг нь бэхжүүлэх гээд байгаа юм. Энэ чинь харин ч 1 шатны шүүх, 1 шатны маргаан шийдвэрлэх асуудал нэмэгдүүлчихээр эргээд олгосон зээлээ олж авах хугацаа нь тэр хэмжээгээр нэмэгдээд явна гэсэн үг. Тийм ээ. Тэгэхээр нь эргээд нөгөө зээлийн хүү, алданги, юу байдаг юм энэ зардлууд чинь бүгдээрээ нэмэгдээд явна гэсэн үг. Тэгээд яаж энэ өрсөлдөөнт орчныг нэмэгдүүлэх гээд байгаа юм гэдэг 2 дугаар асуулт байна.

Тэгээд 3 дахь асуулт нь бол сүм, банк 2 нэг зүйлээр ижил гэж ярьдаг. Тэр нь юу вэ гэхээр итгэл дээр тулгуурладаг бизнес. Тэгээд энэ хууль батлагдсанаар энэ хэрэглэгчийн эрх ашиг, хэрэглэгчийн итгэл яаж нэмэгдэх гээд байгаа юм. Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашиг яаж хамгаалагдах гээд байгаа юм гэдэг асуултууд байна. Энэ дээр хариулт авчхаад эргээд тодруулъя.

С.Бямбацогт: Хариулъя. Ажлын хэсэг 4 дүгээр микрофон.

Н.Батсайхан: Ганхуяг гишүүний асуултад хариулъя. Санхүүгийн маргааныг шийдвэрлэх ийм байгууллага байгуулах яагаад хараат бус байна гэж бодож байгаа вэ гэсэн асуулт байна. Олон улсын туршлагаар бол ерөнхийдөө энэ санхүүгийн маргааныг шуурхай ингэж шийдвэрлэдэг бол олон улсын жишиг байна. Тэгээд энэ бол нэлээн олон улсад амжилттай хэрэгжсэн. Тэгээд маш олон судалгаагаар ерөнхийдөө энэ өөрөө санхүүгийн тогтвортой байдал болон хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалахад бол эерэг нөлөөтэй байна гэсэн үр дүнтэй байгаа. Энэ олон улсын жишгийн дагуу хянан зохицуулагч байгууллагууд санхүүгийн системийг хянан зохицуулж байгаа байгууллагуудын хувьд бид бүхэн энэ байгууллагыг байгуулах нь бол зүйтэй гэж үзээд энэ хуулийг бол оруулж ирж байгаа.

2 дугаар асуулт бол яаж өрсөлдөөн нэмэгдэх вэ гэсэн асуулт байна. Ерөнхийдөө хуулийн хамгийн гол зорилго бол санхүүгийн үйлчилгээ олгогч болон санхүүгийн хэрэглэгч 2-ын хооронд байгаа тэгш бус мэдээллийн байдлыг бид бүхэн аль болох хамгийн бага түвшинд аваачиж, ижил түвшинд аваачна гэж байгаа. Ингэж ижил түвшинд аваачиж зах зээл дээр илүү их мэдээлэл бий болсноор ерөнхийдөө өрсөлдөөнт түвшинд эерэг нөлөө үзүүлнэ гэж бид бүхэн харж байгаа. Энэ ч гэсэн олон улсын бас судалгаанууд дээр өөрөө нотлогдсон зүйл байгаа.

3 дугаар асуулт бол харилцагчийн итгэл бас яаж нэмэгдэх вэ гэсэн байна. Энэ асуулт бол бас мөн 2 дахь асуулттайгаа холбогдож байгаа. Ер нь зохицуулагч байгууллагын үүрэг бол аль болох зах зээл дээр байгаа тэгш бус мэдээллийн байдлыг л арилгах зорилготой. Тэгээд аль болох бид нар энэ тэгш бус мэдээллийг бага болгох тусам ерөнхийдөө бол тухайн зах зээл дээр өрсөлдөөн нэмэгдэнэ. Мөн тухайн системд итгэх итгэл бол нэмэгдэнэ гэсэн ийм итгэл үнэмшилтэйгээр энэ хуулийн төслийг бид бүхэн оруулж ирж байгаа юм.

С.Бямбацогт: Сайнхүүгийн Ганбаатар гишүүн асуултаа асууя. Хассуурийн Ганхуяг гишүүн тодруулъя.

Х.Ганхуяг: Би яагаад ингээд байна гэхээр одоо жишээлбэл бүх банк санхүүгийн байгууллагын зээлийн хүү энэ шүүхийн шийдвэрлэгддэг тэр хугацаатай холбоотойгоор зардал гээд, эрсдэлийн зардал гээд ороод явж байдаг байхгүй юу. Тэгээд л үндсэндээ манайх чинь шүүхээр явлаа гэхэд хамгийн багадаа 1 жил, 1 жил 6 сар, зарим нь 2 жил шийдвэр гүйцэтгэл дээр очвол дахиад л тэр хэмжээний хугацаа нэмэгддэг. Тэгээд омбутсмэн ингээд наана нь дахиад л 1 сарын хугацаатай юм оруулчихдаг. Тэгээд энэ асуудал чинь юу вэ гэхээр тэр омбутсмэн дээр эцсийн шийдвэр гарахгүй байхгүй юу. Тэгээд дахиад л нөгөө бүх юмыг чинь зардлыг нь нэмэгдүүлээд л үүнтэй холбоотойгоор зээлийн хүүгийн зардал нэмэгдэх л юм хийчхээд байна л даа. Тэгээд л би асуугаад байгаа юм. Тэгээд яагаад та энэ дээр тийм итгэлтэй байгаа юм. Энэ чинь зүгээр дахиад 1 байгууллага байгуулаад, тэн дээр улс төрчид 1 томилгоо хийдэг л ийм юм болчих вий гэдэг санаа зовнил байгаа байхгүй юу.

С.Бямбацогт: Болормаа гишүүн хариулъя.

Э.Болормаа: Ганхуяг гишүүний асуултад хариулъя. Таны санаа зовниж байгаа, улс төрчдийн хараат байх вий гэдэг дээр бол санал 1 байна. Санаа зовнил байна. Гэхдээ бид нар эрсдэлийг хаах талаас нь бол энэ дээр ажлын хэсэг дээр нэмж бас гишүүдтэй ярилцаж ажиллана гэсэн. Бид нар хамгийн сайн туршлагаараа байж болох хамгийн сайн хувилбарыг оруулж ирсэн. Хүү нэмэгдэхгүй гэдгийг би бас албан ёсоор хэлье. Хариуцлагатайгаар. Энэ хүү нэмэгдэх юм хийх гэж байна гэдэг ийм буруу ойлголт битгий хэлээрэй. Одоо жилд зөвхөн банкны дотоод аудитаар 47 мянган гомдол гарчихсан байхад, түүний арван 14 хувь нь албан ёсоор гомдол болдог. Зөрчлийнх нь 14 хувь. 0,6 хувь нь шүүхээр шийдэгддэг. Тэгэхээр энэ нэмэлт шүүх байгуулах бус, харин яг албан ёсны энэ мэргэжлийн гомдлуудынх нь маргааныг нь тасалдаг ийм байгууллага олон улсын туршлагаар бий болж байгаа. Ингэснээр харин шууд бусаар бол хүү буурах төлөвтэй гэсэн ийм судалгаатай байгаа.

С.Бямбацогт: Сайнхүүгийн Ганбаатар гишүүн асуултаа асууя.

С.Ганбаатар: Энэ хуулийг бол дэмжих 1 шалтгаан байгаа. Үндсэн хуулийн 5.4-д заасан байгаа бүх хэвшлүүд хувийн хэвшил, хувьсгалын хэвшил, хувь хүмүүсийн сайн сайхны төлөө төрөөс эдийн засгийг зохицуулна гэж заасан. Бид чинь төрийн зохицуулалттай эдийн засагтай амьдарч байгаа хүмүүс шүү дээ. Тэгэхээр 2007 онд Хадгаламж, зээлийн хоршооны зохицуулалтгүй байдлаас болж олон 100 хүний тэрбум, тэрбум төгрөгөөр хохирсон, хүний амь нас ч хүртэл эрсэдсэн. Энэ юу гэсэн үг вэ гэвэл төрөөс зохицуулалт хийгээгүйгээс болж. Regulate гэж байгаа юм шүү дээ.

Төрийн зохицуулалт дутсанаас болж. Тэгэхээр энэ утгаараа бол энэ орж ирнэ. Өнөөдөр орон сууцын захиалга хийж байгаа, төлбөрөө төлсөн олон 100 иргэд бас хохироод л гудамд маш хэцүү байдалтай байгаа. Энэ зохицуулалтуудыг бас төрөөс хийхгүй бол тэгээд зах зээлийн эдийн засаг, чөлөөт эдийн засаг гээд л хаяад байж бас болдоггүй юм.

Тэгэхээр миний тодруулах асуулт энд байна. Төсөлд Засгийн газраас 26 зүйлээр 45 орчим санал ирүүлсэн. 45 санал ирүүлсэн. Хэдэн хувь нь энэ дотор тусгасан бэ. Тусгаагүй санал юу вэ. Яагаад. Миний 1 дүгээр асуултад хариулна уу.

2 дугаарт энгийн л асуулт юм даа. омбутсмэн маань гэдгээ монгол хэлний аятайхан үгээр зохицуулах боломж байсангүй юу. Дээр нь бүгдийг нь шүүх рүү аваачиж хаяхаасаа илүү дунд нь ийм зохицуулалт хийе л гэсэн санаа шүү дээ. Бүгдийг нь шүүх дээр аваачих юм бол мөнгөгүй, боломжгүй, өөрийгөө өмгөөлөх чадваргүй хүмүүсийг л гудамд гаргаж байна гэсэн үг. Энэ утгаараа бол энэ хуулийн цаад мөн чанар нь энэ омбутсмэн гэж анх баруунд бол тэгж л гарч ирсэн. Тэгэхээр энэ 2 дугаар өнцөг дээр бас би тодруулж асууя.

3 дугаар зүйл, Удирдах зөвлөл нь 7 гишүүнтэй байх бөгөөд Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооноос томилж, чөлөөлнө гэж байгаа. Энэ дээр хууль, эрх зүйн тайлбар байгаа юу. Нийгмийн даатгал, ЭМД-ыг томилдог энэ Улсын Их Хурлын Байнгын хорооноос. 2 дугаарт Удирдах зөвлөлийн дарга нь орон тооны байна гэж байгаа. Хэний харьяа вэ. Тэр ямар байгууллагын харьяа байх вэ. Энийг надад тодруулж өгнө үү.

4 дүгээр асуулт. 19.2.1-д энэ хуульд заасан шаардлагыг хангаагүй бол гээд 1 үг байгаа. Тэгээд нөгөө хуулийн заалтуудыг нь заагаагүй байна. Энэ дээр яг аль аль заалтуудыг нь хэлж байгаа юм бэ. 19.2.1-ийг ярьж байгаа юм шүү, хуудас 13.

21.9 дээр омбутсмэны шийдвэрт гомдол гаргаж болно гэж байгаа. Омбутсмэн хохирсон гомдол гаргахаар тохиолдол энэ барууны орнуудад их байдаг. Омбутсмэн өөрөө гомдол гаргах боломж байгаа юу. 21.9-тэй холбогдуулж асууж байна шүү, хуудас 15.

С.Бямбацогт: Ажлын хэсэг хариулъя. 4 дүгээр микрофон.

Н.Батсайхан: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Төсвийн талаар ирүүлсэн саналыг бид бүхэн хуульдаа ирүүлсэн саналын 90 гаруй хувийг бол тусгасан байгаа. Тэгээд яг ямар, ямар саналууд тусгагдаагүйг танд дараа нарийн мэдээллийг өгье.

2 дугаар асуулт Омбутсмэн гэж монгол үг орчуулж болоогүй гэж байна. Яах вэ олон улсын практикт бол ерөнхийдөө энэ Омбутсмэн гэдэг үгээр бол явдаг юм байна лээ. Өөрөө бол Скандинав, Норвегоос гаралтай үг юм байна лээ. Тэгээд маш олон улс энэ үгийг бол ерөнхийдөө өөрийнхөө улсад бол энэ омбутсмэн гэдгээр нь бол нутагшуулж хэрэглээд заншсан юм байна лээ. Тэгэхээр бид бүхний сайн мэдэх Арбитр ч гэдэг юм уу, концесс ч гэдэг юм уу олон улсад 1 ойлголтоор хэрэглэгддэг ийм үг байгаа учраас бид бүхэн омбутсмэн гэдэг үгээр нь бол авсан байгаа.

3 дахь асуулт болох Удирдах зөвлөл 7 гишүүнтэй байна. Энэ талаар хуулийн тайлбар байгаа юу гэж байна. Хуулийг ер нь анх бид бүхэн бол ажлын хэсэг, хийж эхэлж байхдаа бол ерөнхийдөө бол Шүүхийн ерөнхий зөвлөлтэй зөвшилцөж тайлбар бол авч байсан. Тэр хэмжээндээ бол байгаа. Дарга бол орон тооны байна. Тайлагнах газар нь бол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороонд бол тайлагнана гэж үзэж байгаа.

4 дүгээр асуулт болох 19.1.2 дээр байгаа бичвэрийг бид бүхэн ажлын хэсэг дээр засаж сайжруулаад явъя.

5 дугаар асуулт болох Омбутсмэн өөрөө гомдол гаргаж болох уу гэж асуусан байна. Яг одоогийн хуулийн төслөөр бол Омбутсмэны шийдвэрт гомдол гаргаж болно гэж зохицуулсан байгаа. Харин Омбутсмэн өөрт нь бол яах вэ имунити буюу өөрт нь хамгаалах зохицуулалтыг бол хуульд зааж өгсөн байгаа. Харин өөрөө Омбутсмэн маань өөрөө гомдол гаргах гэдэг зүйл бол зохицуулагдаагүй байгаа..

С.Бямбацогт: Баярлалаа. Ганбаатар гишүүн тодруулъя.

С.Ганбаатар: Би нэг дутуу асуусан асуултаа тодруулъя. 23.1 дээр иргэдийн санхүү эдийн засгийн боловсролыг дээшлүүлэх стратегийг санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл болон боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батална гэж байна. Яг хэн нь батлах юм бэ. Хэн нь хариуцах юм бэ. Энэ дээр лизинг орон сууцны урьдчилгаа ер нь энэ хуульд хамаарах уу. Энэ үйлчилгээнд хамаарах уу.

С.Бямбацогт: Ажлын хэсэг хариулъя 4.

Н.Батсайхан: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. 23.1-д олон нийтийн боловсролын асуудлыг хамруулсан байгаа. Хөтөлбөрийг хамгаалах субъект нь бол санхүүгийн тогтвортой байдал болон боловсролын асуудал эрхэлсэн төрийн байгууллага байгаа. Энэ санхүүгийн тогтвортой байдал гэдэгт бол Монголбанк, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, Хадгаламжийн даатгалын корпорац байдаг. Боловсрол хариуцсан яам нь бол Боловсрол, шинжлэх ухааны яам байгаа. Тэгэхээр энэ төрийн байгууллагууд маань нийлээд, энэ санхүүгийн боловсролын хөтөлбөрийг бол батална. Энэ хөтөлбөрийг энэ байгууллагууд маань өөрийнхөө үйл ажиллагаанд мөрдөж ажиллах болно.

Дараагийн асуулт болох лизинг, орон сууцны зээл гэсэн зүйлүүд энэ хуульд хамаарагдах уу гэхээр хамрагдана. Ерөнхийдөө бол санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч, санхүүгийн хэрэглэгч 2-ын хооронд үүсэж байгаа аливаа нэгэн .../минут дуусав/

С.Бямбацогт: Минутдаа багтаагаад хариулаад сурчхаарай. Дараа нь бас Монголбанкны Ерөнхий эдийн засагч олон асуудалд орж ирж, гишүүдийн асуултад хариулах байх. Тийм болохоор товчхон, тодорхой яг дэгийн хуульд заасан минутад багтааж хариулж сурна шүү.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж гишүүд үг хэлнэ. Урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу Туваан гишүүн, Саранчулуун гишүүн, Саранчулуун гишүүн

алга байна. Цэвэгдоржийн Туваан гишүүнээр тасаллаа. Байхгүй байна. Ганцхан гишүүн байна. Туваан гишүүний дараа санал хураалт эхэлнэ шүү гишүүд ээ. Танхимдаа хүрэлцэн ирээрэй. Одоо санал хураалт явагдана. Туваан гишүүн саналаа хэлье. Туваан гишүүн 2 дугаар индэр дээрээс. Үүний дараа санал хураалт явагдана. Гишүүдийг танхимдаа хүрэлцэн ирэхийг урьж байна. Хуулийн төслүүд эцэслэн батална.

Ц.Туваан: Энэ хуулийг дэмжиж байгаа. Дэмжсэн үг хэлье. Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах гээд энэ өөрөө иргэнийг хамгаалах гэдэг ойлголт байгаа учраас маш чухал. Энэ дээр иргэн өөрөө энэ санхүүгийн байгууллага буюу банк, Хадгаламж, зээлийн хоршоо, даатгал, Үнэт цаасны компани гээд маш олон санхүүгийн байгууллагуудтай харьцаж байгаа. Тэгээд хэрэглэгч өөрөө санхүүгийн мэдээлэлгүй байдлаасаа болоод нэлээн их хохирол амсах ийм зүйлүүд байдаг. Тэгэхээр иргэний эрх ашгийг хамгаалах гэж байгаа учраас энэ хуулийг дэмжиж байгаа.

Энэ дээр бас танилцуулгыг нь нэлээн үзэж харсан. Тэгээд энэ нөгөө Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо энэ тэр гээд байгууллагуудаас гадна дахиад бие даасан ийм байгууллага байгуулж, дарга удирдлагатай байх ийм асуудал бас яригдаж байгаа. Тэгэхээр энэ дээр бас хараат бусаар энэ асуудлаа шийднэ гэдэг ийм агуулгаар явж байгаа. Дээрээс нь энэ дээр маш олон иргэн, ялангуяа банк, банк бус, хадгаламж, зээлийн хоршоо, аппликэйшний зээл энэ тэр гээд санхүүгийн мэдлэг дутмаг байдлаасаа болоод хохирчхоод байгаа. Тэгэхээр энэ хуулийн бас 1 зорилго нь бол иргэддээ бас ийм мэдээлэлжүүлэх, сургалт явуулах, мэдээлэн таниулах үйлчилгээ үзүүлэх гэдэг талаасаа бол маш их зөв зүйтэй байгаа юм.

Дээрээс нь манай иргэд бас нэлээн их ярьдаг шүү дээ. Банк зээл олгоод зээлээ авангуут хүүгээсээ гадна банкны 1 хувийн шимтгэл гээд л авчихдаг. Энэ ямар учиртай юм бэ гэхээр банк авах ёстой гээд л ингээд авдаг гэх мэтчилэн маш олон зүйл дээр иргэдийн эрх ашиг хохирдог байдал дээр хамгаалж шийдвэр яаралтай гаргах ийм байгууллага учраас дэмжиж байна.

Өшөө бас энэ омбутсмэн гэдэг нэршил нь удахгүй ингээд хууль батлагдаад яваад ирэхээр бас ингээд арбитр энэ тэр гэдэг шиг ингээд суугаад хэрэгжээд явах байх. Тэгэхээр энэ дээр бас нэлээдгүй хүмүүс асууж байна лээ. Энэ ямар учиртай үйл ажиллагаа явуулах ёстой юм бэ гээд.

Мөн энэ хүмүүс хохирсон асуудал дээр, иргэд хохирсон асуудал дээр 1 кэйсийг би бас хэлье гэж бодож байна. Сая Дархан-Уул аймаг Шарын гол суманд ажиллаж байхад Дархан-Уул аймгийн эрүүл мэндийн салбарын 70 гаруй иргэд нөгөө байрны залилан гэдэг юманд бас хамрагдчихсан байж байгаа юм. Өртчихсөн байж байгаа юм. Тэгээд энэ хүмүүс хаана хандах вэ, ямар асуудлаар шийдүүлэх вэ гээд асууж байгаа юм. Тэгэхээр энэ дээр бол Сайнзориг нарын 30 гаруй гишүүд миний бие бас орсон. Энэ дээр хуулийн төсөл өргөн барьчихсан байгаа. Энэ бол шийдсэнээсээ хойших асуудал болчхож байгаа юм. Тэгэхээр урьдчилан сэргийлж нэгэнт үүсчихсэн нөхцөл байдлыг шийдэхэд бас гаргалгаа дутаж байгаа юм. Тэгэхээр энэ үйлдвэрчний эвлэлийн байгууллага нь уриа .../минут дуусав/

С.Бямбацогт: Туваан гишүүн дэмжиж үг хэллээ. Гишүү хуулийн төсөлтэй холбогдуулж үг хэлж дууслаа. Одоо санал хураалт явуулъя. Энэ асуудлаасаа эхлээд саналаа хураачихъя.

Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтдаа бэлтгэе. Хураагаа уншуулна уу. Танхимд хэдэн гишүүн байна. Танхимд 61 гишүүн байна. Санал хураалтдаа одоогоор бэлдсэн 61 болчихсон байна. Ирц бүртгэлийн санал хураалт явуулна шүү гишүүд ээ. Одоогоор Алдаржавхлан, Алтанхуяг, Амгаланбаатар, Баатархүү, Бат-Амгалан, Батбаяр, Баттулга, Батцэцэг, Батчимэг, Бямбасүрэн, Галбадрах, Ганбат, Гантөмөр, Жаргалан, Жаргалсайхан, Заяабал, Золжаргал, Лодойсамбуу, Мөнхбаатар, Мөнхтулга, Мөнхтуяа, Одбаяр, Одонтуяа, Очирбат, Пунсалмаа, Саранчулуун, Тэмүүжин, Цогтбаатар, Цогтгэрэл, Чинбүрэн, Шижир, Эрдэнэболд гэсэн гишүүд алга байна шүү. Галбадрах гишүүн орж ирж байна. Одоо ирц бүртгэлийн санал хураалт дээр татгалзсан гарч байгаа хүмүүс бол ажилдаа байхгүй байна гэж ойлгогдоно. Чинбүрэн гишүүн орж ирлээ. Галбадрах гишүүн орж ирлээ. Ирц бүртгэлийн санал хураалт. 63 гишүүн байна. Цогтгэрэл гишүүн, Мөнхтулга гишүүд орж ирж байна. Отгонбаяр гишүүн байгаа мөртөө эсрэг гарч байна. Заяабал гишүүн бас байна. Эндээс эхлээд саналаа хурааж байж нөгөө 64-өөр эцэслэн батлах саналууд байгаа шүү гишүүд ээ бас анхааралтай байцгаана уу. Хэлэлцэх эсэх хуулиудыг явуулаад, нөгөө Хөдөө аж ахуйн хууль хамгийн сүүлд нь хэлэлцэнэ. Тэр л 20-оод саналтай. Бусад нь гайгүй.

Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 93 гишүүн оролцсоноос 65 гишүүн буюу 69,9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн:

Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 93 гишүүн оролцож, 66 гишүүн буюу 71 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 93 гишүүнээс 68 гишүүн 73,1 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

4.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 93 гишүүн оролцож, 67 гишүүн буюу 72 хувийн санал энэ санал дэмжигдлээ.

5.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 93 гишүүн оролцож, 68 гишүүн буюу 73,1 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

6.Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

17.35 цаг.

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Гишүүд санал хураалтдаа бэлтгэнэ үү. Санал хураалт явуулъя. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 93 гишүүн оролцож, 53 гишүүн буюу 57 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн:

“Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 93 гишүүнээс 53 гишүүн буюу 57 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг санал хураалтад оролцогчдын олонх дэмжсэн тул төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүллээ.

17.39 цаг.

Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулъя.

Гишүүд санал хураалтдаа бэлтгэе. Санал хураалт.

Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 93 гишүүн оролцсоноос 65 гишүүн буюу 69,9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн:

2.Агаарын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя аа. Санал хураалтад 93 гишүүн оролцож 62 гишүүн буюу 66,7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

3.Автозамын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 93 гишүүн оролцсоноос 64 гишүүн буюу 68,8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

4.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Дагасан хууль юм уу. Санал хураалтад 93 гишүүн оролцсоноос 21 гишүүн зөвшөөрч, 22,6 хувийн саналаар энэ санал дэмжигдсэнгүй.

Саяын санал хураалтад дэмжигдээгүй тул санал хураалтад оролцсон гишүүдийн олонх хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжээгүй тул хуулийн төслийг хууль санаачлагчид буцаасан тогтоол баталсанд тооцлоо./17:42/

5.Барилгын тухай нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 93 гишүүн оролцсоноос 67 гишүүн буюу 72 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

6.Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 93 гишүүн оролцож, 67 гишүүн буюу 72 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

7.Гамшгаас хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 93 гишүүн оролцсоноос 63 гишүүн буюу 67,7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

8.Олон улсын гэрээний хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 93 гишүүн оролцсоноос 17 гишүүний 18,3 хувийн саналаар энэ санал дэмжигдсэнгүй.

Дэгийн тухай хуулийн 36.15 санал хураалтад оролцсон гишүүдийн олонх хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжээгүй бол хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаасанд тооцох заалтын дагуу буцаалаа./17:43/

9.Тариалангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 93 гишүүн оролцсоноос 64 гишүүн буюу 68,8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

10.Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 93 гишүүн оролцож, 65 гишүүн буюу 69,9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

11.Статистикийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 93 гишүүнээс 28 гишүүн буюу 30 хувийн саналаар энэ санал дэмжигдсэнгүй.

Чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 36.14-д заасны дагуу хуулийн төслийг олонх дэмжээгүй тул хууль санаачлагчид нь буцаалаа./17:45/

12.Эрчим хүчний хэмнэлтийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 93 гишүүн орсны 63 гишүүн буюу 67,7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

13.Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийг. Дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 93 гишүүн оролцсоноос 62 гишүүн буюу 66,7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүллээ.

17.46 цаг.

Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай хэлэлцээр соёрхон батлах тухай асуудал.

Гишүүд ээ, Батбаатар гишүүнээ сууж байгаарай. 64 гишүүнээс санал хураагдана. Цагдаагийн олон улсын хэлэлцээр байгаа. Одоо Байнгын хорооны саналаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтдаа бэлтгэе. 64 гишүүний саналаар эцэслэн батлагдах учраас гишүүд танхимдаа хүрэлцэн ирээгүй гишүүд хүрэлцэн ирнэ үү. Энэ олон улсын хэлэлцээр байгаа.

“Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай” Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээрийг соёрхон баталъя гэсэн ийм хэлэлцээр байгаа. Бас цагдаагийн байгууллагын ажлыг дэмжих, Алтангэрэл сайдын үед хийгдсэн билүү. Алтангэрэл сайдын үед зурагдсан хэлэлцээр. Бүртгэлийн санал хураалт. Татгалзсанаар гарч байгаа гишүүд ажилдаа ирээгүй, ажлаа хийхгүй байна гэж харагдана. Энэ татгалзсанаар гарч байгаа гишүүдийн зөвлөх, туслахууд гишүүдээ танхимын хуралдаан, чуулганы хуралдаан руу явуулаарай. Нэрийг нь харж байгаад Ирц бүртгэлийн санал хураалт. Танхимд 68 гишүүн байна. Ирээгүй Алдаржавхлан, Алтанхуяг, Амгаланбаатар, Баатархүү Батбаатар, Батбаяр, Батболд, Баттулга, Батцэцэг, Батчимэг, Бямбасүрэн, Ганбат, Гантөмөр, Жаргалсайхан, Лодойсамбуу, Мөнхбаатар, Мөнхтуяа, Одбаяр, Одонтуяа, Очирбат, Пунсалмаа, Саранчулуун, Тэмүүжин, Шижир, Эрдэнэболд нарын гишүүд чуулганы хуралдаан танхимд хүрэлцэн ирж, ажлаа хийнэ үү. Гишүүдийн зөвлөх туслахууд бас гишүүдээ ажилд нь ирүүлнэ үү.

Санал хураалт. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууссан. Санал хураалтдаа сая бэлдчихсэн. Сая бүртгэлийн санал хураалт явчихсан биз дээ. Батболд гишүүн орж ирлээ. Баярлалаа. Гишүүд санал хураалтдаа бэлтгэе. Санал хураалтад бэлэн болсон 69 гишүүн, бэлэн бус 24 гишүүн байна.

Алдаржавхлан, Алтанхуяг, Амгаланбаатар, Баатархүү, Батбаатар, Батбаяр, Баттулга, Батцэцэг, Батчимэг, Бямбасүрэн, Ганбат, Гантөмөр, Жаргалсайхан, Лодойсамбуу, Мөнхбаатар, Мөнхтуяа, Одбаяр, Одонтуяа, Очирбат, Пунсалмаа, Саранчулуун, Тэмүүжин, Шижир, Эрдэнэболд гэсэн.

Санал хураалтын томъёоллыг уншиж танилцуулъя. Санал хураалт явуулъя.

“Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 93 гишүүн орсноос 69 гишүүн буюу 74,2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын нийт гишүүдийн олонх дэмжсэн тул Хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийг эцэслэн баталсанд тооцлоо.

Улсын Их Хурлын гишүүдэд, ажлын хэсэгт талархлаа илэрхийлье.

17.52 цаг.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

Хуулийн төслүүдийг эцэслэн батлах.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцогдох хуулийн төслийг эцэслэн батална. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлэг 2026 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 14 цаг хүртэл завсарлага авсан. Завсарлагын хугацаа дууссан байна. Үг хэлэх үү. Үг хэлэхгүй.

Хуулийн төслүүдээ эцэслэн батлах хувилбарыг холбогдох Байнгын хороо бэлтгэн гишүүдэд тараасан байгаа. Гишүүд санал хураалтдаа бэлтгэе. 63 гишүүн бэлэн болсон байна. Түрүүн 69 гишүүн бэлэн байсан. Хуруугаа уншуулаад гишүүд санал хураалтдаа бэлтгэе. Ундрам гишүүн бэлэн болоогүй байна. Бүгд бэлэн болсон уу. Гишүүд санал хураалтдаа бэлэн болсон байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44.2-т нэгдсэн хуралдаанд оролцсон ... хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулах бөгөөд Улсын Их Хурлын нийт гишүүдийн олонх дэмжсэн бол хууль эцэслэн батална гэж заасан байгаа. Үүний дагуу 64 гишүүнээс дээш гишүүд дэмжиж байж батлагдахыг та бүхэндээ бас сануулъя.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг

эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Болормаа гишүүний микрофон өгье.

Э.Болормаа: Төхөөрөмж дээр техникийн асуудал гарсан тул саяын санал хураалтыг хүчингүй болгож өгнө үү.

С.Бямбацогт: Болормаа гишүүний гаргасан горимын саналаар саяын санал хураалтыг хүчингүй болгох санал хураалт явуулъя. Санал хураалтад 93 гишүүн оролцож, 56 гишүүн буюу 60 хувийн саналаар саяын санал хураалт хүчингүй боллоо. Гишүүд ээ, энэ бас төрийн ажил юм чинь бас явуулчих нь зөв байх. Саналын томьёоллыг сая уншиж танилцуулсан.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 93 гишүүн оролцсоноос 65 гишүүн буюу 69,9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Дахиад 1 санал байгаа. Холбогдуулан боловсруулсан Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 64 шүү дээ гишүүд ээ. Баасанжаргал гишүүн.

Горимын санал Баасанжаргал гишүүний микрофон өгье.

Х.Баасанжаргал: Миний товчлуур дээр алдаа заагаад эсрэг гарсан байна. Тийм учраас санал хураалтыг хүчингүйд тооцож өгнө үү.

С.Бямбацогт: Баасанжаргал гишүүний гаргасан горимын саналаар саяын санал хураалтыг хүчингүй болгох санал хураалт явуулъя. Санал хураалтад 93 гишүүнээс 63 гишүүн буюу 67,7 хувийн саналаар саяын санал хураалт хүчингүй боллоо.

Эцэслэн батлах санал хураалт 64-өөс дээш батлагдах ёстой. Эцэслэн баталъя гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 93 гишүүн орсноос 65 гишүүн буюу 69,9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Хуулийн төслүүдийг эцэслэн баталлаа.

Улсын Их Хурлын гишүүд, ажлын хэсэгтээ талархлаа илэрхийлье.

18.00 цаг.

Дараагийн асуудлын санал хураалт байгаа шүү.

Одоо Хөдөө аж ахуйн тухай хуулийн анхны хэлэлцүүлэг.

10-аад санал хураалттай. Нэгмөсөн дуусгачихъя гишүүд ээ.

Хөдөө аж ахуйн тухай хууль. Манай Мандхай нарын гишүүд өргөн барьсан. Туваан гишүүн бас өглөөжин ярьсан даа. Тийм ээ. Зарчмын зөрүүтэй 20-иод санал байгаа. Санал хураалтад бэлтгэе гишүүд ээ. Санал хураалт сүүлийн асуудал шүү.

Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дэмжсэн санал

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.1.Энэ хуулийн зорилт нь төрөөс хөдөө аж ахуйг тогтвортой хөгжүүлэх бодлогын дэмжлэгтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Бат-Эрдэнэ, Жаргалсайхан, Замира, Лүндэг Наранбаатар, Сэддорж /цаашид “ажлын хэсэг” гэх/. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 93 гишүүн орсноос 66 гишүүн буюу 71 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Малын тоо толгойн албан татварын хууль” гэсний өмнө “Гамшгаас хамгаалах тухай хууль,” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 93 гишүүн орсноос 66 гишүүн буюу 71 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Төслийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн өртгийн гэснийг үйлдвэрлэлийн гэж өөрчлөн, цаашид тохиолдол бүртгэж, өөрчлөх санал гаргасан. Ажлын хэсэг санал. 93 гишүүнээс 66 гишүүн буюу 71 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

4.Төслийн 4 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“хөдөө аж ахуйн үйлдвэрлэл” гэж хөдөө аж ахуйн газарт байгалийн болон биологийн нөөцөд тулгуурлан мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэл дагнан, эсхүл хослуулан эрхлэх үйл ажиллагааг;

4.1.2.“мал аж ахуйн үйлдвэрлэл” гэж мал, амьтныг өсгөн үржүүлж, тэдгээрээс гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг бэлтгэн нийлүүлэх, үйлдвэрлэх үйл ажиллагааг;

4.1.3.“тариалангийн үйлдвэрлэл” гэж Тариалангийн тухай хуулийн 16.1-д заасныг;

4.1.4.“бэлчээрийн мал аж ахуй” гэж мал сүргийг бэлчээрт жилийн туршид улирлын хуваарьтайгаар идээшлүүлэн маллаж, ашиг шимийг нь хүртдэг, нүүдлийн өв соёлыг хадгалсан уламжлалт мал аж ахуйн үйлдвэрлэлийг;

4.1.5.“эрчимжсэн мал аж ахуй” гэж Тариалангийн тухай хуулийн 3.1.7-д заасныг;

4.1.6. “хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн” гэж хүнсний болон аж үйлдвэрийн зориулалтаар ургамал, мал, тэжээвэр амьтны аж ахуйгаас үйлдвэрлэсэн түүхий эд, бүтээгдэхүүнийг;

4.1.7. “агро-ойн аж ахуй” гэж ойжуулалтыг хөдөө аж ахуйн үйлдвэрлэлтэй зориудаар хослуулсан, нийгэм, эдийн засаг, байгаль орчны ашиг тустай аж ахуйн зохион байгуулалтыг;

4.1.8. “хөдөө аж ахуйн аялал жуулчлал” гэж мал аж ахуй, газар тариалан, уламжлалт нүүдлийн ахуйн хэв маяг, үндэсний соёл, өв уламжлалыг хадгалах, сурталчлан таниулах аялал жуулчлалын төрлийг;

4.1.9. хөдөө аж ахуйн үйл үйлдвэрлэл эрхлэгч” гэж энэ хуулийн 4.1.1-д заасан үйл ажиллагааг эрхэлж, эдийн засгийн өгөөж хүртэж байгаа хувь хүн, хуулийн этгээдийг;

4.1.10. “тогтвортой хөдөө аж ахуй” гэж хүн, байгаль орчинд ээлтэй, нийгмийн хариуцлагатай, байгалийн нөөцийн зохистой ашиглалт, эдийн засгийн өгөөжтэй, урт хугацаанд үргэлжлэх, бүтээмжтэй хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг;

4.1.11. “хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн сүлжээ” гэж Хөдөө аж ахуйн түүхий эд, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, бэлтгэн нийлүүлэх, анхан шатны боловсруулалт хийх, хадгалах, тээвэрлэх, борлуулах цогц үйл ажиллагааг.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 93 гишүүнээс 64 гишүүн буюу 68,8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

5.Төслийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн “хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн тогтвортой хөгжлийг хангах,” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 93 гишүүнээс 63 гишүүн буюу 67 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

6.Төслийн 5 дугаар зүйлийн 5.2.4 дэх заалтын “инновац, дэвшилтэт шинэ технологи” гэснийг “инновацыг” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. 93 гишүүнээс 65 буюу 69.9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

7.Төслийн 5 дугаар зүйлийн 5.2.5 дахь заалтыг “хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд” гэснийг, 5.2.6 дахь заалтын “хөдөө аж ахуйн хөдөлмөрийн үнэлэмж,” гэснийг, 5.2.7 дахь заалтын түүхий эд” гэсний өмнөх “хөдөө аж ахуйн” гэснийг, 5.2.8 дахь заалтын “залгамж халааг тасралтгүй бэлтгэх тогтолцоог бэхжүүлэх” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 93 гишүүнээс 66 буюу 71 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

8.Төслийн 5 дугаар зүйлийн 5.2.9 дэх заалтын “хувийн хэвшил,” гэснийг “хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан,” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. 93 гишүүнээс 66 буюу 71 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

9.Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалтын “тариалан” гэсний өмнө “газар” гэж, 6.3 дахь хэсгийн “тариалангийн” гэсний өмнө “газар” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 93 гишүүнээс 64 буюу 68,8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

10.Төслийн 6 дугаар зүйлийн 6.2.5, 6.2.6 дахь заалтыг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 93 гишүүнээс 63 буюу 67,7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

11.Төслийн 6 дугаар зүйлийн 6.4, 6.5 дахь хэсгийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 93 гишүүнээс 63 буюу 67 хувийн саналаар санал дэмжигдлээ.

12.Төслийн 7 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7 дугаар зүйл.Хөдөө аж ахуйг төрөлжүүлэн хөгжүүлэх

7.1.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд газар зүйн байршил, экологийн онцлог, дэд бүтцийн хөгжил, хүн амын нягтрал болон биологийн бусад нөөц, зах зээлийн эрэлтэд тулгуурлан төрөлжүүлэн хөгжүүлнэ.

7.2.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг төрөлжүүлэн хөгжүүлэх тэргүүлэх чиглэлд бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуй, тэжээл үйлдвэрлэл, жимс жимсгэнэ, хүнсний ногоо, үр тариа хамгаалагдсан хөрсний тариалан, үржлийн аж ахуй, агро-ойн аж ахуйг хөгжүүлэх асуудлыг тусгайлан хамааруулна.

7.3.Хөдөө аж ахуйг төрөлжүүлэн хөгжүүлэх асуудлыг Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тодорхойлж, орон нутгийн хөгжлийн бодлого, Засаг даргын мөрийн хөтөлбөрт тусган хэрэгжүүлнэ.

7.4.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг хоршоо, кластерын зохион байгуулалтаар болон хөдөө аж ахуйн захиалгат бүтээгдэхүүн үйлдвэрлэлээр төрөлжүүлэн хөгжүүлж болно.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 93 гишүүнээс 65 буюу 69 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

13.Төслийн 8 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8 дугаар зүйл.Хөдөө аж ахуйн түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоо

8.1.Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг төвлөрүүлэх, хадгалах, чанар хамгаалалт хийх, худалдан борлуулах төвийг аймаг, суманд байгуулна.

8.2.Энэ хуулийн 8.1-д заасан төвийн үйл ажиллагааг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлнэ.

8.3.Энэ хуулийн 8.1-д заасан төвд нийлүүлж, худалдан борлуулж байгаа түүхий эд, бүтээгдэхүүний талаарх мэдээлэл нь хөдөө аж ахуйн биржийн болон энэ хуулийн 10.1-д заасан цахим сантай холбогдсон байна.

8.4.Энэ хуулийн 8.1-д заасан төв нь түүхий эд, бүтээгдэхүүнийг худалдан авах, холбогдох стандарт, техникийн зохицуулалтын шаардлагын дагуу чанараар ангилах, шаардлагатай анхан шатын тордолт хийж, багцлах, савлах, шошголох, хадгалах, худалдан борлуулах үйл ажиллагааг хариуцан гүйцэтгэнэ.

8.5.Энэ хуулийн 8.1-д заасан төвийг байгуулах санхүүжилтийн эх үүсвэрийг улсын болон аймаг, сумын төсөв, хувийн хэвшлийн санхүүжилтээр шийдвэрлэнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 93 гишүүнээс 65 буюу 69 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

14.Төслийн 9 дүгээр зүйлийг доор дурдсанаас өөрчлөн найруулах:

“9 дүгээр зүйл.Хөдөө аж ахуйн түүхий эд, бүтээгдэхүүний чанарын үнэлгээ, баталгаажуулалт

9.1.Хөдөө аж ахуйн түүхий эд, бүтээгдэхүүний чанарыг холбогдох стандартын дагуу үнэлж, баталгаажуулна.

9.2.Аймаг бүр хөдөө аж ахуйн гаралтай хүнсний бус түүхий эд, бүтээгдэхүүний чанарыг шинжлэн судалдаг зориулалтын тоног төхөөрөмж, мэргэшсэн шинжээч бүхий лабораторитой байна.

9.3.Хөдөө аж ахуйн гаралтай хүнсний эрүүл ахуй, чанарын шинжилгээг холбогдох хуулиар зохицуулна.” Санал гаргасан ажлын хэсэг санал хураалт. 93 гишүүнээс 63 буюу 67 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

15.Төслийн 10 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“10 дугаар зүйл.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн сүлжээний бүртгэл, мэдээлэл

10.1.Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хүнсний бүтээгдэхүүний, зөвшөөрлийн мал аж ахуй, газар тариалангийн, малын генетик нөөц, мал, амьтан, ургамлын эрүүл мэндийн, түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүслийн, дотоодын болон олон улсын худалдаа, үйлчилгээний цахим сан /цаашид “цахим сан” гэх/-тай байна.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 93 гишүүнээс 64 буюу 68 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

16.Төслийн 12 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12 дугаар зүйл.Тогтвортой хөдөө аж ахуйн төлөвлөлт

12.1.Тогтвортой хөдөө аж ахуйг хөгжүүлэх Хөгжлийн зорилт хөтөлбөртэй байна.

12.2.Хөдөө аж ахуйн хөгжлийн зорилт хөтөлбөрт дараах асуудлыг тусгана:

12.2.1.хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг төрөлжүүлэн хөгжүүлэх;

12.2.2.хөдөө аж ахуйн үйлдвэрт шаардагдах мэргэшсэн хүний нөөцийн хэрэгцээг мэргэжил, мэргэшлийн түвшнээр тодорхойлж, хангах арга хэмжээ;

12.2.3.дотоодын хүнсний хангамж, экспортын бүтээгдэхүүн нийлүүлэлт, борлуулалт;

12.2.4.түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлт;

12.2.5.хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн экспортын зах зээлийг судалж, экспортын голлох бүтээгдэхүүн тус бүрээр бодлого, стратеги;

12.2.6.хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг ашигтай эрхлэх зах зээлийн болон нийгмийн таатай орчин бүрдүүлэлт.

12.3.Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн энэ хуулийн 12.1-д заасан зорилтот хөтөлбөрийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэн батлуулж, хэрэгжилтийг хангана.

12.4.Хөдөө аж ахуйн салбарт хэрэгжүүлж байгаа олон улсын төсөл, хөтөлбөрт энэ хуулийн 12.1-д заасан хөгжлийн зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр тусгана.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 93 гишүүнээс 64 буюу 68 хувийн саналын санал дэмжигдлээ.

17.Төслийн 13 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13 дугаар зүйл.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн газар

13.1.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх баталгааг дэмжих зорилгоор төрөөс холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчид газрыг ашиглах, эзэмших нөхцөлийг бүрдүүлнэ.

13.2.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах уст цэг, худгийн хоорондох зайг усны нөөц, уст цэгийн хайгуулын дүн, бүс нутгийн газар зүйн онцлогт үндэслэн аймаг, нийслэлийн Засаг дарга тогтооно.

13.3.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хэрэгцээний усны нөөц, уст цэгийн хайгуул, судалгаа хийх хэрэгжүүлэхтэй холбогдох харилцааг Усны тухай хуулиар зохицуулна.

13.4.Хөдөө аж ахуйн газрын ангиллыг өөрчлөх, ангилал шилжүүлэх тохиолдолд Газрын тухай хуулийн 23.2.9-д заасныг баримтлах бөгөөд улсын хөгжлийн бодлогын зайлшгүй шаардлагатайгаас бусад тохиолдолд хөдөө аж ахуйн газрыг нэгдмэл сангийн өөр ангилалд шилжүүлэхгүй.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 93 гишүүнээс 63 гишүүн буюу 67 хувийн санал санал дэмжигдлээ.

18.Төслийн “Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хүний нөөц” гэсэн 14 дүгээр зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 93 гишүүнээс 60 буюу 64,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

19.Төслийн 15 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“15 дугаар зүйл.Хөдөө аж ахуйн судалгаа ба хөгжүүлэлт

15.1.Хөдөө аж ахуйн судалгаа ба хөгжүүлэлтийн тогтолцоо нь дэвшилтэт технологи, инновацыг нэвтрүүлэх, оюуны өмчөөр хамгаалагдсан мэдлэгийг эргэлтэд оруулах, зах зээлд гарах, энэ хуулийн 12.1-д заасан зорилтот хөтөлбөрт тусгасан судалгаа, хөгжүүлэлтийг гүйцэтгэхэд чиглэнэ.

15.2.Хөдөө аж ахуйн салбарын шинжлэх ухаан, технологи, инновацын судалгааны үр дүнг нэвтрүүлэх, зөвлөх үйлчилгээ үзүүлэх, сургалт, сурталчилгаа зохион байгуулах чиг үүрэгтэй төрийн үйлчилгээний байгууллага хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд ажиллана.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 93 гишүүнээс 61 буюу 65 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

20.Төслийн 16 дугаар зүйлийг доор дурдсан өөрчлөн найруулах:

“16 дугаар зүйл.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн эрсдэл, түүнээс урьдчилан сэргийлэх

16.1.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээний нэгдсэн удирдлагыг хэрэгжүүлнэ.

16.2.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн эрсдэлийг доор дурдсан ангиллын дагуу үнэлэх, урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

16.2.1.байгаль орчны;

16.2.2.эдийн засгийн;

16.2.3.нийгмийн;

16.3.Энэ хуулийн 16.2.1-д заасан нөлөөллийн эрсдэлд бэлчээрийн болон тариалангийн газрын доройтол, усны хомсдол, генетик нөөцийн төлөв, уур амьсгалын өөрчлөлт, хүлэмжийн хийн ялгаруулалт, хог хаягдлын менежмент хамаарна.

16.4.Энэ хуулийн 16.2.2-т заасан нөлөөллийн эрсдэлд хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэр, бүтээмж, өрсөлдөх чадвар, эдийн засгийн өгөөж, түүхий эд, бүтээгдэхүүний үнийн хэлбэлзэл, санхүүжилтийн хүртээмж, төрийн дэмжлэгийн үр дүн хамаарна.

16.5.Энэ хуулийн 16.2.3-д заасан нөлөөллийн эрсдэлд хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчийн тогтвортой ажлын байр, ажиллах орчны аюулгүй байдал, нийгмийн баталгааны өөрчлөлтөд дасан зохицох чадамж хамаарна.

16.6.Хөдөө аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах, байгалийн эрсдэлээс сэргийлэх, хамгаалах арга хэмжээг Засгийн газар, бүх шатын Засаг дарга авч хэрэгжүүлж, биелэлтийг хангаж ажиллана.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 93 гишүүнээс 63 буюу 67 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

21.Төслийн 18 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“18 дугаар зүйл.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн дэмжлэг

18.1.Хөдөө аж ахуйн дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, импортыг орлох болон экспортын баримжаатай түүхий эд, бүтээгдэхүүн үйлдвэрлэх бодлогын хүрээнд төрөөс дараах дэмжлэгийг үзүүлж болно:

- 18.1.1. шууд болон шууд бус татаас;
- 18.1.2. тарифын болон тарифын бус зохицуулалт;
- 18.1.3. хөнгөлөлттэй зээл, зээлийн хүүгийн хөнгөлөлт;
- 18.1.4. бусад

18.2. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжлэг үзүүлэх үйлдвэрлэлийн сүлжээний оролцогч нь дараах шаардлагыг хангасан байна:

- 18.2.1. зохистой дадал нэвтрүүлсэн, баталгаажуулсан;
- 18.2.2. стандарт, техникийн зориулалтын дагуу зохицуулалтын шаардлага хангасан, баталгаажуулсан;
- 18.2.3. чанараас хамаарсан үнийн тогтолцоог нэвтрүүлсэн;
- 18.2.4. үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлсэн байх;
- 18.2.5. импортыг орлох, экспортын баримжаатай үйлдвэрлэл байх;
- 18.2.6. нэмүү өртөг шингээсэн байх;

18.3. Энэ хуулийн 18.2-т заасан шаардлагыг хангасан эсэхийг тодорхойлоход мэргэжлийн холбоодын оролцоог хангана.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 93 гишүүнээс 61 буюу 65 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

22. Төслийн 19 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“19 дүгээр зүйл. Хөдөө аж ахуйн салбар дахь төрийн удирдлага, зохицуулалт,

19.1. Хөдөө аж ахуйн салбарын төрийн бодлого нь төвлөрсөн байх бөгөөд улсын хэмжээнд хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлд хүнс, хөдөө аж ахуйн асуудлыг хариуцсан төрийн захиргааны байгууллага, сум, дүүрэгт хөдөө аж ахуйн тасаг болон бусад харьяа байгууллагаас бүрдэнэ.

19.2. Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний эрхлэх асуудлын хүрээнд мал, таримал ургамлын генетик нөөц, ургамлын болон мал, амьтны эрүүл мэнд, гений сан, малын эм үйлдвэрлэл, лаборатори, аймаг дундын отрын бэлчээр, шинжлэх ухаан, инновац, судалгаа, шинжилгээ, нэвтрүүлэлт хариуцсан төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний байгууллага, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд тус тус ажиллана.

19.3. Аймаг, нийслэлийн хүнс, хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, хөдөө аж ахуйн тасгийн бүтцийг Засгийн газраас тогтоосон орон тооны хязгаарт багтаан хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

19.4. Энэ хуулийн 19.2, 19.3-д заасан байгууллага нь энэ хуульд болон холбогдох бусад хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 93 гишүүнээс 64 буюу 68 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

23.Төслийн 20 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 93-аас 51 хувийн 54,8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

24.Төслийн 22 дугаар зүйлийн хуулийг дагаж мөрдөх хугацааг “2027 оны 01 дүгээр сарын 01” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Гуравхан санал үлдсэн шүү. Санал хураалтад 93 гишүүн орсноос 61 гишүүн буюу 65,6 хувийн саналаар дэмжигдлээ.

25.Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах /6 дугаар зүйлийн 6.5 дахь хэсэгт “6.5.9.хөдөө аж ахуйн зорилтот хөтөлбөр.” гэсэн заалт нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Энэ дунд хугацааны зорилтот хөтөлбөрүүд бүгд байхгүй болох гэж байгаа. Тэгээд нэмж орох гэж байгаа юм байх даа. Дунд хугацааных уу. Ингээд л нөгөө баахан бодлого, зорилт тус тусдаа болдог, салангид энэ рүү л явах нь дээ. Бид нар чинь 400, 500 бодлогын бичиг баримтыг хүчингүй болгосон. 8 болгосон. Одоо ингээд 9 болох гээд байгаа юм биш үү. Санал хураалт. Санал хураалтад 93 гишүүн буюу 57 хувийн 61 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

26.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн нэр томьёог жигдлэх, зүйл, хэсэг, заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх, бүтэц найруулга, хууль зүйн техникийн засварыг хийх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. Санал хураалтад 93 гишүүнээс 66 гишүүн буюу 71 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүллээ.

18.20 цаг.

Баталсан хууль, тогтоолын эцсийн найруулгыг сонсоно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 46.1.3-д “Улсын Их Хурал энэ хуулийн 46.1.2-т заасан хууль, тогтоолын эцсийн найруулгатай танилцаж, ёсчлохыг зөвшөөрөх” гэж заасны дагуу хууль, тогтоолын эцсийн найруулгыг холбогдох Байнгын хороо бэлтгэж, Улсын Их Хуралд танилцуулах бэлэн болсон байна.

1.Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Алга байна. Эцсийн найруулга сонссонд тооцлоо./18:21/

2.Эрүүгийн хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Алга байна. Эцсийн найруулга сонссонд тооцлоо./18:21/

3.Конвенц соёрхон батлах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Эцсийн найруулга сонссонд тооцлоо./18:21/

4. “Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 04 дүгээр дүгнэлтийн тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Алга байна. Эцсийн найруулга сонссонд тооцлоо. /18:21/

5. “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Алга байна эцсийн найруулга сонссонд тооцлоо. /18:22/

6. “Хуулийн төсөл буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Алга байна. Эцсийн найруулга сонссонд тооцлоо. /18:22/

Өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлаа хэлэлцэж дууслаа.

2026 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаандаа идэвхтэй оролцсон 93 гишүүн өнөөдрийн чуулганы хуралдаанд хүрэлцэн ирснээс хамгийн сүүлд 70 орчим гишүүн чуулганы хуралдаанд 18 цаг 20 минут хүртэл ажиллалаа. Тэгээд идэвхтэй оролцсон гишүүддээ баярлалаа. Ажлын хэсэг, Тамгын газрынхандаа баярлалаа.

Чуулганы нэгдсэн хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

18.22 цаг

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ